



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-113
<hr/>	
1.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	9-17
2.Улсын Их Хурлын даргыг сонгох тухай /үргэлжлэв/	17-21
3.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох	21-108
4.Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа	108-113

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
4 дүгээр сарын 03-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 90 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 24 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Баттулга, Б.Баярбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, А.Ганбаатар, Ж.Ганбаатар, Б.Уянга, Л.Энхнасан;

Тасалсан: Д.Амарбаясгалан, П.Мөнхтулга;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-44 минут, С.Амарсайхан-54 минут, Х.Баасанжаргал-08 минут, М.Бадамсүрэн-32 минут, Х.Болормаа-33 минут, Э.Болормаа-32 минут, Д.Ганбат-05 минут, Л.Гантөмөр-15 минут, Ц.Даваасүрэн-27 минут, Б.Жаргалан-15 минут, Д.Жаргалсайхан-11 минут, Ч.Лодойсамбуу-17 минут, З.Мэндсайхан-32 минут, П.Наранбаяр-32 минут, М.Нарантуяа-Нара-54 минут, Ч.Номин-35 минут, О.Номинчимэг-32 минут, Н.Номтойбаяр-14 минут, С.Одонтуяа-32 минут, Л.Оюун-Эрдэнэ-37 минут, Ц.Сандаг-Очир-19 минут, О.Саранчулуун-12 минут, Б.Түвшин-05 минут, А.Ундраа-32 минут, Ч.Ундррам-33 минут, Ж.Энхбаяр-12 минут, Р.Эрдэнэбүрэн-23 минут.

Нэг.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга С.Баярмаа, мөн газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн дарга Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Төрмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам нар хариулж, тайлбар хийв.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны саналаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 43
Бүгд: 103
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 32 минут үргэлжилж, 10 цаг 56 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 01 минутад эхлэв.

Улсын Их Хурлын даргыг сонгох тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан ажлын 1 өдрийн завсарлага 2026.04.03-ны өдрийн 16 цаг 13 минутад дуусах тул завсарлага дуусах хүртэл хуралдаан түр завсарлав./14:01/

Хуралдаан 16 цаг 13 минутаас үргэлжлэв.

Хоёр.Улсын Их Хурлын даргыг сонгох тухай /үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Захиргааны удирдлага, хүний нөөцийн газрын дарга П.Баттөр, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Болормаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Улсын Их Хурлын даргыг сонгох тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссан тухай мэдэгдэв./16:14/

“Их хуралдай” танхим дахь Монгол Улсын Төрийн далбааны дэргэд Хүндэт харуул зогсож, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал суудлаа эзэлсэн байлаа.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын даргаар Сандагийн Бямбацогтыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 87
Татгалзсан: 27
Бүгд: 114
76.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын даргаар Сандагийн Бямбацогтыг сонгохыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ “Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:19/

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан Төрийн ордны хамгаалалтан дор Улсын Их Хурлын тамгыг хадаг дээр залан танхимд орж, хуралдаан даргалагчийн ширээний зүүн хэсэгт байрлуулахад, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ хүлээн авч, шинээр сонгогдсон Улсын Их Хурлын дарга С.Бямбацогтод гардуулж, суудалдаа залрахыг урив./16:21/

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт суудалдаа суусны дараа үг хэлж, Төрийн далбаанд мэхийн ёслов./16:34/

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт хуралдааныг үргэлжлүүлэн даргалав.

Уг асуудлыг 16 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 16 цаг 34 минутаас 19 цаг 42 минутад завсарлав.

Гурав.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Ж.Энхбаяр, Н.Номтойбаяр, Т.Доржханд, Б.Энхбаяр, Б.Батцэцэг, З.Мэндсайхан, С.Амарсайхан, Г.Дамдинням, Д.Батлут, Ц.Сандаг-Очир, Л.Энх-Амгалан, Т.Аубакир, Б.Дэлгэрсайхан, Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Ц.Идэрбат, Ч.Номин, Б.Найдалаа, Э.Батшугар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх тухай болон Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр томилохоор Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад нэр дэвшигч Жадамбын Энхбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдад нэр дэвшигч Нямтайширын Номтойбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдад нэр дэвшигч Тогмидын Доржханд, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдад нэр дэвшигч Батмөнхийн Батцэцэг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдад нэр дэвшигч Загджавын Мэндсайхан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдад нэр дэвшигч

Сайнбуянгийн Амарсайхан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад нэр дэвшигч Гонгорын Дамдинням, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдад нэр дэвшигч Дамбын Батлут, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад нэр дэвшигч Цэндийн Сандаг-Очир, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайдад нэр дэвшигч Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад нэр дэвшигч Тилеуханы Аубакир, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдад нэр дэвшигч Борхүүгийн Дэлгэрсайхан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад нэр дэвшигч Жуковын Алдаржавхлан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад нэр дэвшигч Энхтайваны Бат-Амгалан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад нэр дэвшигч Цагаанхүүгийн Идэрбат, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад нэр дэвшигч Чинбатын Номин, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдад нэр дэвшигч Бадрахын Найдалаа, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдад нэр дэвшигч Энхбаярын Батшугар нарыг тус бүр танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулга болон нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Ө.Шижир, С.Цэнгүүн, Б.Батбаатар, Да.Цогтбаатар, А.Ариунзаяа, Л.Мөнхбаясгалан, О.Батнайрамдал, Б.Бейсен, П.Батчимэг, Г.Очирбат, С.Замира, Ж.Баярмаа, Н.Алтаншагай, П.Сайнзориг, Б.Пунсалмаа, Ц.Баатархүү, С.Эрдэнэбат, Г.Ганбаатар, Д.Ганбат, Х.Баасанжаргал, Л.Гантөмөр, Р.Эрдэнэбүрэн, Э.Болормаа, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, нэр дэвшигч С.Амарсайхан, Г.Дамдинням, Б.Энхбаяр, З.Мэндсайхан, Э.Батшугар, Л.Энх-Амгалан, Ц.Сандаг-Очир, Ч.Номин, Ж.Энхбаяр, Т.Доржханд, Ж.Алдаржавхлан, Б.Дэлгэрсайхан, Э.Бат-Амгалан, Ц.Идэрбат, Т.Аубакир, Б.Найдалаа, Н.Номтойбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Н.Наранбаатар, Д.Ганмаа, Ж.Золжаргал, О.Номинчимэг нар үг хэлэв.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал Улсын Их Хуралд танилцууллаа.

Уг асуудлыг 2026 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 01 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 01 цаг 22 минутаас 01 цаг 52 минутад завсарлав.

Дөрөв.Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Ж.Энхбаяр, Н.Номтойбаяр, Т.Доржханд, Б.Энхбаяр, Б.Батцэцэг, З.Мэндсайхан, С.Амарсайхан, Г.Дамдинням, Д.Батлут, Ц.Сандаг-Очир, Л.Энх-Амгалан, Т.Аубакир, Б.Дэлгэрсайхан, Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Ц.Идэрбат, Ч.Номин, Б.Найдалаа, Э.Батшугар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга Б.Төгсбаяр, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

“Их хуралдай” танхимын индрийн баруун талд Төрийн далбаа, танхимын голд Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт байрлуулж, Төрийн сүлдний баруун талд Хүндэт харуул зогссон байлаа.

Танхимын баруун болон зүүн хойно байрлах дэлгэцүүд дээр “Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” гэсэн Засгийн газрын гишүүний тангаргийн үг гарч байв.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулга дуусмагц Засгийн газрын гишүүд танхимын голд, Монгол Улсын Төрийн сүлд рүү харан зогсов.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын 10-т “Засгийн газрын гишүүд тангаргийг хамтаар өргөх бөгөөд насаар хамгийн ахмад гишүүн тангаргийг уншиж, бусад гишүүн давтан хэлнэ.” гэсний дагуу Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тангаргийг уншин бусад Засгийн газрын гишүүд давтан хэлж дууссаны дараа Засгийн газрын гишүүд Төрийн сүлдэнд мэхийн ёслол.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллын дагуу Засгийн газрын гишүүдийн нэрийг дуудав.

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд Нямтайширын Номтойбаяр;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд Загджавын Мэндсайхан;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд Сайнбуянгийн Амарсайхан;

8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Цэндийн Сандаг-Очир;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Тилеуханы Аубакир;

13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан;

14/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Жуковын Алдаржавхлан;

15/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан;

16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Цагаанхүүгийн Идэрбат;

17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Чинбатын Номин;

18/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд Бадрахын Найдалаа;

19/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайд Энхбаярын Батшугар.

Нэр дурдагдсан Засгийн газрын гишүүн Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис авч, тусгайлан бэлтгэсэн ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зуран Улсын Их Хурлын даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулсны дараа танхимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэхэд Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд болон ёслолын ажиллагаанд оролцогсад босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслолын газар, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газар хамтран хариуцав.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа 02 цаг 23 минутад өндөрлөв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын референт Б.Мөнгөншагай, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 05 минут үргэлжилж, 126 гишүүнээс 117 гишүүн хүрэлцэн ирж, 92.9 хувийн ирцтэйгээр 2026 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 02 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 24 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 2 асуудлыг хэлэлцэнэ. Үдээс өмнөх хуралдаанаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж нарын 4 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. Асуулт асуух хугацаа 120 минут байгаа. Үдээс хойших хуралдаан дээр Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох асуудал үргэлжилнэ.

Нэг.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудалдаа орёе. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг явуулъя. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Пүрэвдорж даргыг индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэж хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Тэгэхээр хуурамч шатахууны тухай ойлголт нь 2015 оны 1 дүгээр сараас эхлэн, 11 дүгээр сараас эхлэн татварын хувь хэмжээг 400 мянган төгрөг, дизель түлшийг 520 мянган төгрөг болгон тогтоосон үеэс эхлэлтэй. Түүнээс хойш завсрын бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн байдаг. Урьд нь 20, 30 мянган тонн орж ирдэг байсан бол 2016 онд 100 мянган тонн, 2017 онд 150 мянган тонн зэрэг нэмэгдсээр байгаад сүүлдээ 200 мянга орчим тонн жилдээ орж ирдэг ийм болсон. Завсрын бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд ямарваа нэгэн онцгой татвар, тусгай зөвшөөрөл шаарддаггүй.

Тэгэхээр энэ хууль, эрх зүйн зүгээс ямарваа нэгэн зөрчилгүй мэт харагдаж байгаа. Нефть үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа явуулдаг манай зарим компаниуд хуурамч шатахуун үйлдвэрлэж, иргэдийг хохироосоор байна. Албаныхан төдийгүй хууль хяналтынхан үүнийг мэдэж байгаа боловч тодорхой шийдвэртэй алхам хийхгүй байна. Тэдгээр компаниудын хууль бус үйл ажиллагаа сүүлийн хэдэн жил үргэлжлэн иргэдийг хуурамч шатахуунаар хохироож ирсэн байна. Тухайлбал керосиныг гэрэлтүүлэгт ашигладаг, 19 дүгээр зуунд тракторын хөдөлгүүрт ашиглаж байсан нафтаг өдгөө зөвхөн нисдэг тэрэг онгоцны сэнс цэвэрлэхэд л ашигладаг. Химийн үйлдвэрлэлийн тодорхой бага хэрэглээгээр хэрэглэдэг ийм байна.

Гэтэл олон улсад хэрэглээ нь хэдийн хумигдсан бүтээгдэхүүний импорт манайд өссөөр байгаад байгаа юм. Энэ төрлийн түүхий эдийн хольцтой хуурамч шатахуун нь автомашины эд ангиас эхлээд агаарын бохирдолд хүртэл сөргөөр нөлөөлдгийг та бүхэн мэднэ. Мөн түүнчлэн шударгаар татвар төлөөд бизнес эрхэлж байгаа тэр хүмүүсийн үйл ажиллагаанд ч халтай байгаа. Шатахуун импортлогчид хуурамч шатахуун нийлүүлснээс тээврийн хэрэгсэл, техник хэрэгсэл эвдэрч, иргэд, аж ахуйн нэгж /ААН/-үүд жилд хэдэн зуун тэрбум төгрөгөөр хохирч байгаа статистик үзүүлэлт байна. Энэ асуудлыг Засгийн газар /ЗГ/-ын хэмжээнд судалж шалгах ажлын хэсэг байгуулсан ч өнөөдрийг хүртэл дүгнэлт гараагүй, тодорхой шийдэлгүй байгаагаас хуурамч шатахуун зах зээлд борлогдсоор байна. 2018 онд хуурамч шатахууны шатахууны эсрэг энэ Онцгой албан татварт өөрчлөлт оруулах тухай энэ хуулийг өргөн барьж, 3 жилийн туршид хөөцөлдөж, 2021 онд батлуулсан, 2023 онд Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/-ийн дүгнэлтээр энэ хуулийг Үндсэн хууль зөрчсөн байна гэж шатахуун яахлаараа Үндсэн хууль зөрчдөгийг ерөөсөө ойлгоогүй. Ийм байдлаар энэ ҮХЦ-ийн дүгнэлт гарч, энэ дүгнэлтийн дагуу УИХ хүлээж авч энэ хуурамч шатахууныг дахин импортлох ийм боломжийг нээж өгсөн байгаа юм. Тэгэхээр энэ 2023 оноос дахин энэ хуурамч шатахууны хольц бүтээгдэхүүн Монгол Улсад импортлогддог болж, өнөөдрийн байдлаар 100 гаруй мянган тонн хуурамч шатахууны хольц бүтээгдэхүүн хамгийн ашигтай төмөр замын, төмөр зам дээр байрлаж байгаа шатахууны савд хадгалагдсаар байна.

Зөвхөн ганц компани л гэхэд өдөрт 280 вагон керосин хийн конденсатын нэрмэл дисцилляци, хөнгөн фракцын бензин буюу нафта хэмээх бодисуудыг хольж найруулан чанаргүй хуурамч шатахуун болгоод, зах зээлийн үнээр хямдаар түгээх станцуудад нийлүүлдэг болсон байна. Мөн ийм үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд дээрх бодисуудыг ашигласныхаа төлөө улсад нэг ч төгрөгийн татвар төлөхгүй байна. Ийм учраас Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар танилцуулна. Ганбаатар гишүүнийг индэрт урьж байна.

Г.Ганбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 25 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн. Хууль санаачлагч газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүнд онцгой албан татвар ноогдуулснаар хуурамч шатахууны үйлдвэрлэлийг хязгаарлаж, иргэдийг чанартай шатахуун хэрэглэх боломжоор хангах, мөн албан татварын, мөн татварын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хуулийн төслийн талаарх ЗГ-ын байр суурийг тодруулж, өргөн мэдүүлсэн төсөл нь ҮХЦ-ийн дүгнэлтээр түдгэлзүүлсэн зохицуулалтаас өөрчлөгдсөн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Г.Ганбаатар нар хуурамч шатахууны нийлүүлэлттэй холбоотойгоор иргэд, ААН-

үүдэд учруулсан хохирлыг тооцсон судалгаа байгаа эсэх талаар болон газрын тосны дайвар бүтээгдэхүүнд онцгой албан татвар ноогдуулснаар Дорноговь аймагт баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд газрын тосны дайвар бүтээгдэхүүнд онцгой албан татвар ноогдуулах нь үндэсний бусад үйлдвэрийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Жаргалсайхан нар стандартын шаардлага хангаагүй шатахуунаар үйлчилж байгаа ААН-үүдийг олон нийтэд зарлан, иргэдэд учруулсан хохиролд нь хариуцлага хүлээлгэх боломжтой эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Ж.Алдаржавхлан нар хуулийн төслийн тооцоо судалгааг дахин нягтлах, хуурамч шатахууны үйлдвэрлэлд төрөөс тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй гэсэн саналыг хэлж, газрын тосны дайвар бүтээгдэхүүнийг түүхий эд болгон ашигладаг үйлдвэрүүдийн талаар болон хуулийн төсөл батлагдвал ҮХЦ-д дахин маргаан үүсэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр хуурамч шатахуун болон импортоор орж ирж байгаа шатахууны чанарын ялгааны талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хуурамч шатахууны борлуулалтыг зах зээлээс гаргаж, үйлдвэрлэлд хяналт тавих хариуцлагын тогтолцоог сайжруулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг газрын тосны үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүнд онцгой албан татвар ноогдуулбал дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний өртөг өсөх магадлалтайг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан стандартад нийцээгүй шатахуун үйлдвэрлэж, иргэдийн өмч хөрөнгөд учруулсан хохиролд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг нарийвчлан зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь хуурамч шатахууны нийлүүлэлтээс болж орон нутгийн иргэд хохирч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын Тамгын газраар хууль зүйн зөвлөмжийг гаргуулах, мөн газрын тосны дайвар бүтээгдэхүүнийг хуурамч шатахуунаас гадна бусад үйлдвэрлэлийн салбарт ашиглаж, ашигладаг тооцоо судалгааг нарийвчлан тооцох нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.9 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас хууль зүйн зөвлөмж гаргуулах горимын санал гаргаж, санал хураалгахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Улсын Их Хурлын чуулганаар нэгдсэн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чулууны

Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газар /ГЕГ/-ын Татвар, орлогын газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл ГЕГ-ын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Нэрсийг өгчихсөн байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн алга байна. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Ерөөсөө би бензин шатахууныг бол нэг химийн л нэгдэл гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэр яг стандарт шаардлагаа тэр химийнхээ бүтээгдэхүүнийхээ шаардлагыг хангаж л байвал болдог гэж ойлгож байна. Өнөөдөр манай хэрэглээд байгаа А92 бензин бол яг дэлхий нийтийн тийм жишиг стандарт хангасан бензин биш л дээ. Монгол манайд л хэрэглэж байгаа байх, бусад тийм хөгжил буурай орнууд л хэрэглэдэг ийм бензин. Ганцхан Оросын Холбооны Улс /ОХУ/-ын Ангарск орчим л үйлдвэрлэж байгаа байх. Тэгээд шалгуураараа бол тэр хар тугалгатай юутай энэ тэр гээд ийм юмнууд байдаг л даа. Одоо энэ тэр химийн нэгдлийг нь нийлүүлээд тэр гаргаж байгаа тэр бензин тос нь яг ямар шаардлага, юуг хангаад байгаа юм бэ тэрийг мэдчихмээр байх юм. Тийм үзүүлэлтүүдийг нь хардаг уу, үздэг үү? Хэрвээ тэр шаардлагыг нийцүүлж л байгаа бол зохих хэмжээний татварыг нь аваад, энэ бензин, тос олдоц муутай байгаа ийм үед бол хэрэглэж байх нь бол нийцэх юм, нийлэх юм л гэж бодох юм. Тийм бас л нэг ялгаагүй үйлдвэрлэл л байлгүй дээ. Би хэд хэдэн тийм үйлдвэр байдаг гэж сонссон. Тэр нь яаж ажиллаад, ямар байдгийг нь мэдэхгүй, тэрийг нэг сонсчихмоор байх юм.

Нөгөө талаар бол аль болохоор л нэг ганц улсаас, ганц компаниас хамааралтай болох тал руугаа төр засгийн бодлого шахагдаж явж болохгүй. Ганц онгоцны буудалтай болсон тэр онгоцны буудлынхаа ашиглах, эзэмших энэ бүх юмаа хүртэл тэр шатахуунаас болоод хамтад нь өгчих тийм гэрээ хүртэл явж байна лээ шүү дээ. Тэгээд тэр арбитрыг нь нэг хүн олон жил удирдсан тийм улс орны тэндэх арбитраа шийдүүлнэ ч гэх шиг. Өдрөөс өдөрт л ийм муухай юм хийгээд яваад байх юм та нар. Тэгээд ярьж байгаа хэлж байгаа үгнүүд нь аягүй гоё, тэгээд хэрэгцээ юун дээр нь ингэчихсэн, тэгээд улс эх орныхоо, төлөө ард түмнээ боддог ийм шийдвэрүүд олигтой гарч өгөхгүй юм. Энэ дээр нэг анхаармаар байх юм. Энэ дээр нэг хариултыг нь сонсьё.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя, 4 номер.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Монгол Улсад болбол евро 2, евро 3, евро 4 евро, 5 стандартын авто бензинийг аль аль нь хэрэглэж болох стандарттай. Евро 2 стандартын авто бензин бол жишээ нь 500 PPM хүхрийн хүчил агуулдаг. Евро 2 стандартын дизель түлш бол 2 мянган PPM хүхрийн хүчил агуулах стандартчилалтай. Евро 5 стандартын дизель түлш бол 10 PPM хүхрийн тоосонцор агуулах стандарттай. Энэ орж ирээд байгаа энэ дайвар бүтээгдэхүүнүүд бол 5, 6 мянган PPM, тэрнээс ч өндөр хүхрийн тоосонцрыг агуулдаг учраас байгаль орчин, хүний бие эрүүл мэндэд хортой гэж үздэг.

Энэ бүтээгдэхүүнийг дахин боловсруулахад маш өндөр хэмжээний зардал өртөгтэй байдаг учраас тэр үйлдвэрлэлтийн зардал өртгийг шингээхгүйн тулд хямд

үнээр худалдаж борлуулдаг тухайн бүтээгдэхүүнийг оруулж ирээд өндөр үнэтэй дизель түлш, авто бензинтэй нэгэн адил үнээр зараад байгаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортойгоос гадна, дээрээс нь татваргүй оруулж ирж байгаа нь нэг талаар буруу. Бусад бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх боломжийг хязгаарлаад байгаа. Ийм учраас энэ асуудлыг онцгой албан татвар тавих нь зүйтэй гэж үзэж байгаа.

Уг бүтээгдэхүүнийг бол шууд керосин, усан онгоцны түлш, алкалит-г шууд боловсруулж бүтээгдэхүүн боловсруулна гэсэн үйлдвэр бол манай улсад байхгүй. Газрын тосны бүтээгдэхүүн болон нефтийн конденсацыг боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх 2 тусгай зөвшөөрөлтэй ААН яг одоо байгаа. Нэг нь Замын-Үүдэд үйл ажиллагаа явуулдаг, нэг нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй ийм 2 үйлдвэр байгаа. Ер нь тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт оруулаад, технологийн шинэчлэл хийгээд, Монгол Улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлээд явахад бол бид бодлогоор дэмжиж ажиллахад бэлэн.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Тэгээд тодорхой шаардлага хангачихсан, татварыг нь зохих хэмжээнд авчихсан ийм бүтээгдэхүүнийг хэрэглэж болох юм уу, болохгүй юм уу? Эсвэл нэг мөсөн энийг нь хааж байгаа юм уу? Зорилго нь яг ямар байгаа юм бэ? 2 үйлдвэр байгуулчихсан, тэгээд ажлаа яаж байгаа бол нэлээн хөрөнгө оруулалт хийгээд ингээд явж байгаа байх л даа. Бас гадных ч бай, дотных ч бай ийм юмыг нь ингээд таслан зогсоогоод ингээд байвал нөгөө үйлдвэрлэл явуулах ажиллах энэ боломж бололцоог нь бид хаасан боосон болох вий дээ. Энэ дээр ямар бодолтой байгаа юм бэ?

Нөгөө тал нь бол урд хөршөөс бид бензин, тосоо авах боломж бололцоо байгаа юу? Тийм. Тэндээс манайх чинь нефтиэ гаргаад байдаг байх, тийм нефтиэ гаргаж байгаа юм чинь эргүүлээд жоохон бензин, тос авчих ийм боломж бололцоо баймаар байх юм. Тийм боломж бололцоогоо хайдаг уу?

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя 4 номер.

Ч.Хишигдалай: Дайвар бүтээгдэхүүнийг олон улсын стандарт шаардлага хангасан технологиор боловсруулаад, бүтээгдэхүүн гаргаад, худалдаж борлуулахад бидний зүгээс ямар нэгэн хориг байхгүй. Онцгой албан татваргүйгээр орж ирж байгаа бүтээгдэхүүнийг дараагийн шатны боловсруулалт хийхгүйгээр хольж, найруулах замаар худалдан борлуулж байгаа нь маш их хэмжээний машин, техник технологийг эвддэг, хүн ардад маш их хохиролтой байдаг учраас бид энэ дээр тодорхой хэмжээний онцгой албан татвартай байх нь зүйн хэрэг гэдэг байдлаар энэ асуудлыг дэмжиж байгаа.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс /БНХАУ/-аас бол бид тодорхой хэмжээний газрын тосны бүтээгдэхүүн тогтмол худалдаж авч байгаа. Харамсалтай нь энэ 3 сарын 1-нд үүссэн нөхцөл байдалтай холбоотой БНХАУ бол 2 сарын хугацаанд газрын тосны бэлэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах хоригийг ЗГ-аас нь тавьчхаад байна. Бид бол Замын-Үүд боомтоор Булган-Такашикен боомтоор худалдаж авдаг байсан. Сүүлд Шивээхүрэн боомт дээр бид хүлээн авах, шилжүүлэн ачих.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүн нэмж хариулах уу? Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Би бүтэн хариулчихъя тэгэх үү? Энэ хууль санаачлагчийнхаа хувьд 3 минутаар. Тэгэхээр Ганбат гишүүнээ энэ бүтээгдэхүүнүүдийн чинь ихэнх нь жишээ нь Чойрын ч юм уу, аль эсвэл энэ Улаанбаатар хотыг тойрсон томоохон шатахууны агуулахууд дээр буулгаад, тэн дээрээсээ дахиад юу байдаг юм нэг тэр сав нь 100 хувь байлаа гэхэд 25 хувиас оригинал дизелийнх нь 25 хувийг нь соруулж авчхаад, үлдсэн 25 хувьд нь энэ хольцыг дээрээс нь холиод доор нь нэг сэнс байж байдаг юм. Тэр сэнсээр эргүүлээд л холиод байж байдаг байхгүй юу даа. Энэ чинь стандарт биш. Хэрвээ ингээд солиод энэ нэг энэ үйлдвэр энэ Монгол Улсад байна гэж үзээд байвал тэр Алтанширээгийн хэдэн тэрбум, хэдэн их наядаар барьж байгаа тэр үйлдвэр чинь ямар хэрэг байгаа юм бэ? Энэ үйлдвэрүүд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүнд минут нэмж өгье.

Б.Пүрэвдорж: Тэр сэнсээр холигдсон тэр дизель түлшнүүд ихэвчлэн энэ Улаанбаатар хотын төрийн өмчийн компаниуд дээр хэрэглэгддэг, автобуснууд явдаг. Энэ өвөл болохоор энэ цахилгааны замын хажууд байгаа цахилгааны шон хав хар болчихдогийг та мэдэж байгаа. Энэ чинь хүнд металлууд нь бүгдээрээ тэр доороо тунаж үлдээд, тэр хүүхдүүд тэрүүгээр амьсгалдаг байхгүй юу даа. Энэ чинь маш хортой бүтээгдэхүүн. Ийм ингээд холиод л хийчихдэг байсан бол бид маш хямдхан шатахуун хэрэглэж байгаа шүү дээ. Өнөөдөр энд чинь бүгдээрээ 100 гаруй мянган тонн Монголын олон, олон газруудад хадгалагдсан, тэрнээсээ тэрийг нь бүүр борлуулалт хийгээд ингээд л байж байдаг ийм замбараагүй, ийм хууль бус ийм зүйлүүдийг бид тодорхой хэмжээгээр хорих нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Мэдээж хэлэлцүүлгийн явцад тодорхой бусад хими химийн үйлдвэрлэлд хэрэглэгдэх.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Банзрагчийн Түвшин гишүүн, Банзрагчийн Түвшин гишүүн алга уу? Хүрэлбаатарын Баасанжаргал.

Х.Баасанжаргал: Би цэвэр энэ хуулийн төсөл дээр жаахан хууль зүйн талаас нь асуух гээд байгаа шүү. Яг энэ заалтыг ҮХЦ 2023 оны 6 сарын 16-ны өдөр 04 дүгээр дүгнэлтээрээ Үндсэн хууль зөрчсөн байна гэж дүгнээд, түүнийг нь УИХ хүлээж аваад, хүлээж авч байсан байна. Гэхдээ холбогдох кодификацийг нь ерөөсөө хийгээгүй ийм зохицуулалт байгаад байна. Тэгэхээр нэгэнт ҮХЦ-ээр Үндсэн хууль зөрчсөн гэдэг заалтыг бид одоо ингээд хэлэлцэх нь өөрөө зөв үү Хурлын дарга аа? Энийг нэг нягталж шалгаж, энэ дээр хууль санаачлагч хариулт хэлэх байх. Гэхдээ би хууль зүйн талаас нь жоохон эргэлзээд гайхаад байна 1 дүгээр асуулт нь энэ.

2 дугаар асуулт нь юу вэ гэхээр энэ хуулийн төсөл дээр хэрвээ татвартай болох гэж байгаа юм бол урьд нь татвартай байсан керосин нь орж ирээгүй байна. Тэгээд керосин нь нэг татваргүй хэвээрээ орж ирж байгаа гэсэн үг үү? Татваргүй байгаа гэсэн үг шүү дээ. Тэгэхээр керосин гэдгийг яагаад хасчхав? Жинхэнээсээ нөгөө хуурамч бензин үйлдвэрлэх гол түүхий эд чинь керосин биш юм уу? Тэгэхээр үзэл баримтлалаасаа яг хуулийн төсөл 2 нь үг, үсгийн хувьд зөрөө гараад байна л даа. Тэгэхээр энийгээ нэгд. 2 дугаарт энэ керосин дээр тайлбар хэлээч.

3 дугаарт, хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр 4.1.1-д заасан гээд дараах албан татварыг ноогдуулна гэххээд, энэ дотор 4.1.2 тамхитай холбоотой зохицуулалт, 4.1.5 гээд энэ 2 зохицуулалтыг нь хасаад бас биччихсэн байна. Тэгэхээр яг хууль зүйн техник талаасаа яг энэ агуулгаар заалт нэмэгдвэл тамхи онцгой албан татваргүй болж байгаа юм шиг ингэж харагдаад байна. Тэгэхээр энэ

эсвэл хууль зүйн техникийн алдаа юу, ямар учиртай вэ? Тэгээд яг энэ хуулийг хэлэлцэх гэхээр бүхэл бүтэн ҮХЦ-ийн дүгнэлттэй ийм асуудал байгаад байдаг. Тэгээд энийг бүрдүүлбэрийн хувьд, өөр бусад агуулгын хувьд Их Хурал Тамгын газар шалгасан байх ёстой байлгүй, энийг яах ёстой юм бэ? Энийг нэг хариулт өгөөч. 3 асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: Эхлээд ажлын хэсэг хариулах уу? 4 номер, дараа нь Тамгын газрынхан хариулъя.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Газрын тосны бодлогын газар. Үндсэн хуулиас, ҮХЦ-ээс буцаасан дүгнэлтийг харсан. Тухайн дүгнэлт дээр бол шууд хатуу тогтоосон байна, ямар нэгэн дээш, доошоо бусад онцгой татвар тогтоож байгаа газрын тосны бүтээгдэхүүнтэйгээ нэгэн адилаар тэдээс тэд гэсэн хязгаарыг тогтоож өгөх ёстой гэдэг үндэслэлээр буцаасан дүгнэлтийг би бол уншиж байсан. Бусад хууль зүйн бичиглэлтэй холбоотой асуудлыг хууль санаачлагчийн зүгээс хариулах байх.

Ж.Бат-Эрдэнэ: Тамгын газраас түрүүний тэр хуультай холбоотой асуудлыг.

Ж.Бямбадулам: Энэ асуудал, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Бямбадулам. Энэ асуудлаар 2023 онд ҮХЦ-ийн 04 дүгээр дүгнэлт гарсан. Дүгнэлттэй холбоотойгоор Онцгой албан татварын хуульд УИХ-аас хүлээж аваад өөрчлөлт орсон. Гэхдээ хуулийн төслийн, өргөн мэдүүлсэн хуулийн төслийн асуудлаар Байнгын хороон дээр Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяагаас Улсын Их Хурлын Тамгын газраар хууль зүйн зөвлөмж гаргуулъя гээд санал гарсан боловч Байнгын хороон дээр энэ асуудал дэмжигдээгүй байгаа. Бүрдлийн хувьд бол Улсын Их Хурлын Тамгын газар өргөн мэдүүлсэн хуулийн төслийн агуулга руу биш, бүрдэл баримт бичгийн бүрдэл дээр хяналт тавьж, тов тогтоох зөвшөөрөл өгдөг. Тэгэхлээр.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Тодорхой хариулт өгсөнгүй дээ энэ чинь. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ Онцгой албаны татварын хууль бол тодорхой хэмжээгээр байнга өөрчлөгдөж байдаг. Тийм учраас энэ 2 мянга, миний энэ өргөн барьсан хууль бол 2021 онд батлагдаад, 2023 онд хүчингүй болсон. Үүнийг бол 23 ондоо дахин өргөн барьсан, 23 онд дахиад парламент урд талын парламент тарсантай холбоотойгоор 24 онд дахин шинээр сонгогдоод энэ хуулийг өргөн барьсан байгаа. Тэгээд энэ хугацаанд тодорхой хэмжээгээр тэр, энэ бол татвар ноогдуулах тухай л асуудал яригдаж байгаа, татвараас чөлөөлөх тухай асуудал ерөөсөө байхгүй. Тийм учраас энэ тамхины асуудалтай ерөөсөө холбоогүй шүү гэдгийг хэлье. Энэ нь тодорхой Их Хурлын гишүүдэд тараагдсан материалтай зөрөөтэй зүйл байж магадгүй. Яагаад гэвэл энэ хууль бол асар их тэмцэл, асар их эсэргүүцэл дунд явдаг. Тийм учраас миний өргөн барьсан хуулиас зөрөөтэй өөр зүйл хийсэн байхыг.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Миний гол тодруулаад байгаа юм 1 дүгээрт тэр керосиныг яагаад эргээд татвартай болгохоор орж ирэхгүй байгаа юм бэ 1?

2 дахь асуулт яг энэ асуудал дээр ҮХЦ-ийн дүгнэлттэй асуудлыг дахиж орж ирэх нь өөрөө боломжтой юм уу? Хууль зүйн талаасаа тэрийг нь асуугаад байгаа гэсэн үг. Их Хурал тэгэхээр ҮХЦ-ийг хүлээж авсан хэр нь хуулиасаа тэр заалтыг нь одоо болтол хасаагүй хэвээрээ хүчин төгөлдөр ингээд яваад байна. Хэвлэмэл хууль дээрээ ч хэвээрээ явж байна. Тэгэхээр энэ чинь өөрөө хууль зүйн талаасаа болох юм уу гэдэг асуулт байхгүй юу. Тэгэхээр керосин болоод яг энэ ҮХЦ-ийн дүгнэлттэй холбоотой Цэцийн дүгнэлт гарчихсан асуудлаар дахиж хуулийн төсөл яг тэр үг, үсэг нь хэвээрээ, тоо дүн нь хэвээрээ орж ирж болж байгаа юм уу? Яг ийм 2 асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Керосин хасагдана гэж ерөөсөө байхгүй. Яагаад гэвэл нийтдээ энэ бүтээгдэхүүн чинь нийтдээ 101 мянган тонн өнөөдрийн байдлаар Монгол Улсад байгаа. Тэрний 96 орчим мянган тонн нь бол керосин байгаа, 4 мянган тонн л бусад бүтээгдэхүүн байж байгаа. Тийм учраас энэ бол энэ керосин бол заавал орсон байх ёстой. Яагаад гэвэл энэ бичиг баримт дээр чинь өөр зөрөөтэй зүйл байгаад байж магадгүй. ҮХЦ дээр бол энэ асуудал шатахууныхаа асуудлаар ерөөсөө ороогүй, энэ бол тодорхой хэмжээгээр энэ бизнесийн өрсөлдөөнийг хэтэрхий хязгаарласан байна гэдэг ийм л зүйлээр орсон болохоос биш энэний хортой, хоргүй энэ бүх зүйл нь бүгдээрээ үндсэндээ луйврын аргаар авлигадаж, ҮХЦ-ийг энэ авлигадаж хийсэн. Дээрээс нь энэ өнгөрсөн парламент 23 онд увайгүйгээр энэ миний энэ хуулийг унагаасан ийм зүйл болсон гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүнд минут нэмж өгье.

Х.Баасанжаргал: Би яагаад керосин хасагдчихсан юм биш үү гэж хэлээд байгаа вэ гэхээр одоогийн хуулийн төсөл дээр, одоогийн хууль дээрээ хүчин төгөлдөр хууль дээрээ газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн яг таны бичвэрээр таслал тавиад керосин гэдэг үг нь одоо бол байгаа юм. Гэтэл таных дээр керосин гэдэг үг нь байхгүй болохоор, керосин нь татваргүй болж байгаа гэж харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь өөрөө зөв ойлгоод байна уу, яагаад энэ ингэж орж ирээд байна вэ? Эсвэл керосин байгаа бол энэ дээр яагаад керосин гэдэг үг нь орж ирэхгүй байгаа юм бэ гэсэн асуулт байхгүй юу?

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүн хариулъя.

Б.Пүрэвдорж: Би энэ хууль бол маш их эсэргүүцэлтэй тулгардаг гэдгийг түрүүн хэлсэн. Миний өргөн барьсан дээр бол таслал керосин гэж байгаа. Нэгэнт л энэ бид зүйл, заалтыг хөндсөн учраас энэ керосин гэдэг үгийг бид хэрвээ энэ Их Хурлын тараагдсан материал дээр байхгүй энэ байгаа бол би энийг нэгэнт хөндөгдсөн асуудал учраас керосин гэдгийг нэмээд бичээд оруулахад ямар ч асуудал байхгүй гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Ренчинбямбын Сэддорж гишүүн. Үг хэлэхээргүй байна. Гишүүд, үг хэлэх гишүүн алга байна. Байнгын хорооны саналаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 103 гишүүнээс 60 гишүүн оролцон дэмжиж, 58,3 хувиар санал дэмжигдлээ. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.56 цаг

Үдээс өмнөх хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдааныг завсарлуулж байна.

*2026 оны 4 дүгээр сарын 03, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 01 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: 14 цаг болсон тул үдээс хойших чуулганы хуралдааныг нээж байна. Улсын Хурал дахь Ардчилсан нам /АН/-ын бүлэг өчигдөр нэг хоногийн завсарлага авсан. Завсарлага өнөөдрийн 16 цаг 13 минутад завсарлага дуусна. Тийм болохоор энэ хүртэл үдээс хойших чуулганы хуралдааныг завсарлуулж байна.

14:01 цаг

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье. Ингээд цаг 16 цаг 13 минут болж байна. УИХ дахь АН-ын бүлгийн нэг өдрийн завсарлагын хугацаа дуусаж байна. Завсарлагатай холбоотойгоор үг хэлэх үү? Цогтгэрэл дарга.

О.Цогтгэрэл: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. АН-ын бүлэг завсарлага авсан. Энэ хугацаанд бид нэр дэвшигчидтэй уулзаж, их ярилцсан. Мөн тодорхой хэмжээний ойлголцлууд хийгдэж, өнөө өглөө /Төрийн байгуулалтын байнгын хороо /ТББХ/ хуралдаж, бид бүгдийн өргөн барьсан ардчилсан парламентыг бэхжүүлэх, парламентын дархлааг дээшлүүлэх, нэмэгдүүлэхэд чиглэсэн, улс төржилтөөс ангид болгоход чиглэсэн үзэл санаа бүхий хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үзэл баримтлалынх нь түвшинд хэлэлцэх эсэх нь ингээд хэлэлцэгдээд дэмжигдсэн. Ийм учраас АН-ын бүлгийн зүгээс энэ парламентын болоод ЗГ-ын дараа дараагийн үйл ажиллагааг явуулахад тодорхой хэмжээний бид гарц гаргалгааг нь гаргаж ажиллах ёстой гэж үзэж байна. Ийм учраас АН-ын бүлгийн завсарлагыг ингээд өндөрлөж байгааг мэдэгдье. Завсарлагыг цааш сунгахгүй гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Өчигдөр андуураад цохисон ч юм биш, ер нь бол нэг өдрийн завсарлага бол өгсөн. Тэгээд энэ хугацаанд мэдээж нэр дэвшиж байгаа Бямбацогт даргатай хоорондоо зөвшилцөж нэлээн зүйлүүдийг ярьж тохирсон байх, зөвшилцсөн байх гэж бодож байна.

Хоёр.Улсын Их Хурлын даргыг сонгох тухай /үргэлжлэв/

Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье. Гишүүдээ танхимд урьж байна. Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох асуудалтай холбогдуулан УИХ дахь ардчилсан, тийм Улсын Их Хурлын АН-ын дарга үгээ хэлчихлээ. Монгол Ардын нам /МАН/-аас Улсын Их Хурлын даргад Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтыг нэр дэвшүүлсэн тухай Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал танилцуулна, танилцуулга өчигдөр явчихсан. Монгол Улсын Их Хурлын даргаар Сандагийн Бямбацогтыг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүдийг танхимд урьж байна. Яах юм бэ, ирцийн санал хураалт явуулах юм уу? Санал хураалтдаа бэлдье. Ирцийн санал хураалт явуулъя. Санал хураалт. Ирцийн санал хураалтаар 113 гишүүнээс 74 гишүүн дэмжиж, 65,5 хувиар ирц бүртгэгдэж байна.

Монгол Улсын Их Хурлын даргаар Сандагийн Бямбацогтыг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 114 гишүүнээс 87 гишүүн дэмжиж, 76,3 хувиар санал дэмжигдлээ. Ганбат гишүүн, энэ хоцорч ирсэн гишүүдийг дэмжсэнээр авахад чинь юунд байх билүү. Байхгүй байх.

Монгол Улсын Их Хурлын даргаар Сандагийн Бямбацогтыг сонгохыг хуралдаанд орсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр, Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтыг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд Улсын Их Хурлын тамгыг шинээр томилогдсон Монгол Улсын Их Хурлын даргад гардуулахад бэлтгэе. Улсын Их Хурлын тамгыг хүндэтгэлтэйгээр залж ирүүлнэ үү. Харин тийм байгаа биз.

Шинээр сонгогдсон Монгол Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт таныг ширээндээ залрахыг урьж байна.

С.Бямбацогт: Картаа хийх үү? Монгол Улсын эрхэм хүндэт иргэд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын төлөөлөгчийн дээд байгууллага Улсын Их Хурлын даргын хариуцлагатай албанд итгэл хүлээлгэн сонгосон та бүхэндээ чин сэтгэлийн талархлыг илэрхийлье. Улсын Их Хурлын даргын үүрэг нь ард түмнийг төлөөлөх бүрэн эрхээ баталгаажсан парламент ёсны эрхэм чанарыг хэрэгжүүлэхдээ төв,

голч, тэнцвэртэй байр суурийг баримтлан, хууль дээдлэх ёсыг хүндэтгэн сахиулахад оршино.

Улсын Их Хурал бол улс орны хөгжлийн төлөөх бодлогын мэтгэлцээний нэг чухал талбар мөн. Гэвч энэ нь Улсын Их Хурлын үйл ажиллагаа, цаашлаад төрийн үйл ажиллагаа, ард иргэдийн аж амьдралыг гацаах хэмжээнд хүрч хэрхэвч болохгүй. Монгол Улс олон намын тогтолцоотой, олон намын оролцоотой парламенттай. Тиймээс бодлого, шийдлийн ялгаа байх нь зүйн хэрэг. Харин тэрхүү ялгаатай байр суурийг хуулийн гадуур шийдэх тоглолт хийх ёсгүй. Энэ бол парламент ёсны мөн чанарт нийцэхгүй. Тиймээс хууль ёсыг чанд сахих, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, хариуцлагатай, ёс зүйтэй парламентыг төлөвшүүлэхийн төлөө тууштай ажиллах болно гэдгээ энэхүү индрээс илэрхийлье.

Энэ ташрамд миний бие Улсын Их Хурлын даргын суудлыг дараагийн албан тушаалд хүрэх шат гишгүүр болгож ашиглахгүй гэдгээ хариуцлагатайгаар мэдэгдье. Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол эрх мэдэл гэхээс илүүтэй үүрэг хариуцлага. Та бидний хэлсэн үг, гаргасан авир өдөр бүр Монгол айлын хойморт урилгагүй нэвтэрч, төрдөө итгэх итгэлийнх нь галыг бадрааж, эсхүл унтрааж, урмыг нь хугалж байдгийг байнга санаж байгууштай. Өнөөдөр Монголын ард түмэн, Улсын Их Хурлын гишүүдээсээ өдөр бүр ёс зүй шаардаж, хууль дээдлэх зарчмыг нэхэж, шударга ёсыг хүсэмжилж байгаа нь зүй ёсны хэрэг. Би түмнийхээ төлөө зүтгэнэ гэж төрдөө тангараг өргөсөн аавын хүүхдүүдийг үзэл бодол, итгэл үнэмшил, нам, эвслээр нь алагчилж үзэхгүй. Ард түмнийхээ итгэлийг дааж, Монгол төрийн нэр хүндийг өндөрт өргөж, хүлээсэн үүрэг, үүрсэн ачаандаа эзэн болж, ажлаа хариуцлагатай сайн хийж байгаа төрийн түшээдээ түшин дэмжиж ажиллах болно.

Харин Улсын Их Хурлын гишүүний ажлаа хийдэггүй, хууль тогтоох ажилдаа хайхрамжгүй хандаж, хурлаа тасалдаг, ёс зүйгүй авирладаг гишүүдийг толгой илэхгүй гэдгээ ч бас хэлье.

Парламент ёс, парламентын ардчилал бол Монголын ард түмний Үндсэн хуулиараа хийсэн сонголт. Энэ сонголтыг бид ямагт хүндэтгэх, бататгах, хамгаалах, парламентын дархлааг бэхжүүлэх үүрэгтэй.

Эрхэм хүндэт гишүүд ээ, Монгол Улсад тулгамдаж байгаа нийгэм, эдийн засгийн олон асуудлыг шийдвэрлэх оновчтой, зөв арга бол хувь улс төрчдийн хүсэл зоригийг хуулиар хязгаарлах, улс орныг хуулиар удирдах, гагцхүү хууль засаглах, хууль хэрэгждэг нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Харамсалтай нь өнөөдөр хариуцлага нэхдэг, дэг журам төрийн бүх шатанд суларсан байна. Хууль батлаад мартдаг явдал одоо бараг зуршил болжээ. Монголын хууль 3 хоног гэсэн өөр цаг үед, өөр утгаар үүссэн муухай хэллэг өдгөө бидний бодит байдал болж байгаад та бид дүгнэлт хийх цаг болсон байна. Бид олон жил хүн засаглахгүй, хууль засаглах ёстой гэж хоосон ярилаа. Гэтэл хууль засаглахын нэг чухал эх үндэс болсон хууль өөрөө хэрэгжихүйц байх ёсыг тогтоож чадаагүй байна. Хуулийн хэрэгжилт муу байгаагийн нэг ноцтой шалтгаан та бидний баталж байгаа хуульд өөрт нь байна гэсэн үг.

Хүмүүсийн эрхийг хамгаалсан хуулийг хүмүүс хэрэгжүүлэх төдийгүй хамгаалалтдаа авдаг учраас хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлахдаа хүний эрх, эрх чөлөөнөөс эх үндсээ авсан эсэхийг нягтлан шалгах, улс орны нийтлэг эрх ашгийг чухалчлах, ард түмний өмнө тулгарсан асуудлыг оновчтой, шуурхай шийдвэрлэхэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа чиглэх ёстой.

Эрхэм хүндэт гишүүд ээ, дэлхийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдал нэн ээдрээтэй, түүнээс улбаалсан хүндрэл сорилтууд манай улсын нийгэм, эдийн засагт нөлөөлж эхлээд байна. Ийм эгзэгтэй үед үндэсний сөрөн тэсрэх чадавхаа бэхжүүлж, урьтаж мэдэх, тосож бэлдэх, тэсэж давах стратегийг цаг алдалгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага урган гарч байна. Ийм цаг үед төрийн гадаад, дотоод бодлогын үндсийг тодорхойлдог Монгол Улсын төлөөлөгчдийн дээд байгууллага болох Улсын Их Хурлын үүрэг, хариуцлага онцгой өндөр байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Эрхэм гишүүд ээ, миний бие олон Монголчуудынхаа адил эгэл боргил амьдралд өсөж, хагацал зовлонд хат сууж, хайр энэрэлд хүмүүжин бойжиж, хүн болсон эгэл нэгэн. Хар залуу наснаасаа хувийн хэвшилд хүчин зүтгэж, ар гэрээ засаж, ажил бизнесээ босгож, Монгол хүн хичээвээс хийж бүтээж чаддаг гэдгийг эрчим хүч, авто замын салбарт бүтээн байгуулалт хийж явахдаа яс махандаа тултал ойлгож, ухаарсан мянга мянган Монгол хүний нэг. Тийм учраас эгэл амьдрал, хувийн хэвшлээс төрд орж ирсэн хүний хувьд амьдралын төлөө хичээн зүтгэж буй ард олныхоо, ажлын байр бий болгож, татвар төлж, баялаг бүтээж буй хувийн хэвшлийнхний өмнө тулгамдаж буй асуудал, тулгарч буй зовлон, жаргалыг хэнээс ч дутахгүй мэдэх учраас татвар төлөгчдөө, ажлын байр бий болгон, баялаг бүтээж байгаа бүтээлч иргэдээ байнга дэмжин ажиллах болно.

Энэ цаг үед малчид маань мал сүргээ мэнд хаваржуулж, төл бүрэн хүлээн авахаар идэх хоол, унтах нойроо умартан зүтгэж байна. Тариаланчид хаврын нэг өдөр намрын арван өдөртэй тэнцдэг хэмээх үгийг санаж, удахгүй эхлэх хаврын тариалалтын бэлтгэлээ базаан цаг завгүй хөдөлмөрлөж байна. Улс орныхоо эдийн засгийг нуруундаа тээж яваа баялаг бүтээгчид, хувийн хэвшлийнхэн маань гадаад орчин нөхцөл, геополитикийн байдалд санаа зовнин ажил бизнест нь хүндрэл бэрхшээл тулгарах вий хэмээн сэтгэл түгшин суугаа. Ийм үед иргэд, аж ахуйн нэгжүүддээ ээлтэй бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн эрх чөлөө олгож, хүнд суртлын хүлээс дарамтаас тэднийг чөлөөлж, төр улсаа цэгцэлж, засгийн бодлогоо зөв залж, иргэд, сонгогчдоо төлөөлсөн шиг төлөөлж, түмэн олноо түшиж ажиллах нь та бидний өргөсөн тангаргаараа хүлээсэн үүрэг, үүрэх ёстой ачаа гэдгийг цохон тэмдэглэж хэлье.

Эрхэм гишүүд ээ, энэ хаврын чуулганаар Монгол хүн баялгийнхаа эзэн байх эрх зүйн шинэтгэлийг хийж, баялгийн өгөөжийг ард түмэндээ ахиу хүртээх бодитой шийдлийг хуульчлан баталгаажуулах их ажил хүлээгдэж байна. Олон улсын байдал, гадаад орчин нөхцөлөөс шалтгаалан импортын зарим бараа бүтээгдэхүүн, тэр дундаа шатахууны үнийн өсөлтөөс үүдэлтэй эрсдэлийг хязгаарлахад Улсын Их Хурал, Засгийн газар хурдтай хамтын ажиллагаа нэн чухал байгааг анхаарч ажиллавал зохино.

Манай Улсад Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал хөдөлгөөний үр дүнд сүүлийн 2 жилийн хугацаанд 53 хүнсний үйлдвэр шинээр ашиглалтад орж, хүнсний гол нэрийн, гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох мах, махан бүтээгдэхүүн, сүү, гурил, төмс, өндөгнийхөө хэрэгцээг дотоодоосоо 100 хувь бүрэн хангадаг болсон нь сайшаалтай. Гэхдээ энэ хавар төв суурин газар махны үнэ өдрөөс өдөрт өсөж, иргэдийн амьжиргаа, инфляцын тогтворгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх бодитой эрсдэл нүүрлээд байна. Энэ бүх сорилт, бэрхшээлд хурдтай, зөв шийдэл гаргаж, асуудлыг бага дээр нь алгуурлалгүй шийдэх нь чухал гэдгийг дахин сануулъя.

Татварын ачааллыг бууруулж, засаг төрийн гар харахгүй ажил, амьдралаа авч яваа хүмүүсээ дэмжиж, төрийн оролцоог багасгаж, зах зээл дэх шударга өрсөлдөөнийг тэлэх нь эдийн засгийн тусгаар тогтнолын үндэс гэдгийг дор бүрнээ санан хичээн зүтгэхийг уриалж байна.

Эрхэм хүндэт гишүүд ээ, ард түмэн хаана байна тэнд Улсын Их Хурал байх ёстой. Ард түмнээ төлөөлөн хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хариуцлагатай, өндөр ёс зүйтэй, сахилга дэг журамтай, Үндсэн хуулиа дээдлэн ажиллахыг та бүхнээс хүсье. Энэ цаг үед Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалаас үндэсний язгуур эрх ашгаа эрхэмлэн улс төрийн тогтвортой байдал, өндөр ёс зүй, ажлын хариуцлага, эв эеийг байнга сануулан шаардаж байгаа Монгол Төрийн тэргүүн Ерөнхийлөгчдөө баярлалаа.

Төр засгийн хүнд суртлын чөдөр тушааг тасчиж, иргэддээ эдийн засгийн эрх чөлөөг бодит утгаар нь олгохын төлөө “Чөлөөлье” санаачилгыг дэвшүүлэн хурдтай ажиллахыг эрмэлзэж буй Ерөнхий сайдаа дэмжин ажиллах болно.

Иргэдийн, олон нийтийн дуу хоолой, ард түмэн засаглах ардчилсан нийгмийн индэр болсон Улсын Их Хурлын гишүүддээ дахин талархлаа илэрхийлье.

Бид Монгол гэсэн нэг л эх оронтой, Монголын төлөө цохилох халуун зүрхтэй ард түмэн. Саруул ухаан, гэгээн оюунаар Монгол хүний нэр төрийг дэлхий дахинд өргөж, өнөөгийн Монголоо ирээдүйн сайн сайханд хөтлөн дагуулж яваа Монгол түмэндээ эрхэм сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Энэ цагийн түүчээ хүчирхэг Монголыг цогцлоон зүтгэх хүч нь болсон Монгол хүний суу алдар бадартугай.

16:33 цаг

Чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулж байна. Цагийг жич зарлана. Эргээд Засгийн газрын гишүүдийг томилох асуудал, танилцуулах асуудал хэлэлцэгдэнэ. Тийм болохоор Их Хурлын гишүүдийг өрөө өрөөндөө хүлээж байхыг урьж, хүсэж байна.

Хуралдаан 16 цаг 34 минутаас 19 цаг 42 минутад завсарлав.

С.Бямбацогт: Үүдээр байгаа гишүүдийг танхимдаа орж ирэхийг урьж байна. Чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ. Хэлэлцэх асуудал Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Гурав.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох

Монгол Улсын ЗГ-ын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно. ЗГ-ын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Н.Учрал: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн дөрөв дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 2 дахь заалтад Загийн газрын гишүүнийг Улсын Их Хурал Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд миний бие бүрэн эрхийнхээ хүрээнд ЗГ-ын гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж байна. ЗГ-ын гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч болон УИХ-д өргөн мэдүүлсэн.

Ойрх Дорнодод дэгдсэн дайны улмаас дэлхий даяар үүссэн эрчим хүч, газрын тосны үнийн өсөлт, хомсдол, тээвэр логистикийн хямрал, нүүрс, зэсийн үнээс хамааралтай эдийн засгийн эмзэг байдал, төрийн тогтвортой, тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг тасалдуулсан улс төрийн явц гэсэн 3 том эрсдэлийн огтлолцол дунд шинэ ЗГ бүрэлдэж байна. Эгзэгтэй нөхцөлд ЗГ-ын бүтцийг өөрчлөх нь халаа сэлгээ, шилжилт хөдөлгөөн, татвар төлөгчдийн хөрөнгө мөнгө, үнэтэй цаг хугацааг үрж, төрийн байгууллагуудын шуурхай тасралтгүй үйл ажиллагааг алдагдуулах өндөр эрсдэлтэй байна. Санал суудал биш, санал шийдэл боловсруулж хэрэгжүүлэх, улс төрийн зөрчлөө хойш тавьж, улс орны төлөө ажил хийх олон түмний нэхэл хатуутай шаардлага ч өдөр бүр өсөн нэмэгдэж байна.

Иймд бодлогын залгамж чанар, тогтвортой байдал, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах болон цаг үеийн онцгой нөхцөлийг харгалзан Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нийцүүлэн Засгийн газраа байгууллаа. Үүний хамт төрийн байгууллагын хийдэл, давхардлыг иж бүрэн тодорхойлох чиг үүргийн иж бүрэн дүн шинжилгээ хийж, төрийн үйлчилгээ, зөвшөөрлийг цааснаас цахимд шилжүүлнэ. Эрх зүйн үр дагавар багатай зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлж, чиг үүрэг нь давхардсан агентлаг, хөгжлийн төвүүдийг татан буулгаж, төсвийн хөрөнгө хэмнэж, төрийн албыг цомхон, хурдтай, бүтээмжтэй болгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Төрийн өмчит компани /ТӨК/-ийг татан буулгах, нэгтгэх, өөрчлөх, зохион байгуулах, олон нийтэд нээлттэй болгох, үр ашиг, бүтээмжийг нь өсгөх, төрийн зах зээл дэх хэт оролцоог хазаарлаж, хувийн хэвшил, хийж бүтээх хүсэлтэй хэн бүхэн, хүн бүрд өсөж өндийх орон зай, шинэ замыг нээж, хүнд суртал, хууль журам, татварын дарамтаас чөлөөлнө. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн арга зам нь иргэн, хувийн хэвшилдээ итгэж, эдийн засаг, эрх зүй, ногоон хөгжил, авлигын эсрэг эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлтийн бодлого, Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан төрийн хүнд суртлын чөдөр тушааг тайлах, чөлөөлье санаачилга байх болно.

Эдийн засгийн чөлөөлөлтөөр зах зээлд хуруу гараа дүрсэн төрийн зуршлыг халж, хувийн хэвшил, иргэний эрх чөлөөг хамгаалах нь өсөлтийн тооноос хүртээмжийн чанар, өрхийн үүд иргэний хаягаар хүргэх бодит орлогыг нэмэхийг зорьж байна. Эрх зүйн чөлөөлөлтөөр хууль, журмын хийдэл, давхардал, гох дэгээг тайлж, хүний эрх, эрх чөлөөг хамгаална. Ногоон хөгжлийн чөлөөлөлтөөр эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрх, хариуцлагатай уул уурхай, ил тод байдлын санаачилга, байгалиа хамгаалж, баялгаа байгальдаа ээлтэй ашиглах, нар, салхи тархмал эх үүсвэрийн дундаршгүй нөөцөөр эрчим хүч орлого бүтээх зорилтыг хэрэгжүүлнэ. Авлигын эсрэг чөлөөлөлт нь нотлогдоогүй хууль бус, нотлогдоогүй орлогыг хураах, эрүүл мэнд, боловсролд зориулж хохирол барагдуулах, хээл

хахуулийн хорт хөрс болсон цаасан хүнд суртлыг цахим дэвшилтэт технологийн хамтаар халах зэрэг бодлогын шийдлүүд байх болно.

Шинэ ЗГ шударга ёс, эв нэгдлийн гагнаас болсон иргэнийхээ эрх чөлөө, баялаг бүтээгчдийнхээ хүсэл зорилгод бүрэн дүүрэн итгэж, дэлхийн хурцадмал байдлаас үүдсэн энерги, эрчим хүчний эх үүсвэр, эдийн засгийн хямралыг сөрж туулах болно. ЗГ-т ажиллах сайд нарыг тохоон томилохдоо салбараа шууд удирдан зохион байгуулах мэдлэг, туршлага, асуудлыг шийдэл болгох улс төрийн капитал, ёс зүй, хүлээсэн хариуцлагаа үүрэх чадамжийг үндсэн шалгуур болголоо.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын онцгой бүрэн эрхийнхээ дагуу ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуульд заасан ЗГ-ын гишүүдийг томилохоор УИХ-д танилцуулж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103.1, Монгол Улсын ЗГ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад тус тус заасны дагуу Монгол Улсын ЗГ-ын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх болон ЗГ-ын гишүүнээр томилох асуудлыг Их Хуралд танилцуулж байна.

Нэг.Монгол Улсын ЗГ-ын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх.

Жадамбын Энхбаярыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын, Хассуурийн Ганхуягийг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын, Тогмидын Доржхандыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын, Сандагийн Бямбацогтыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/-ын даргын, Батмөнхийн Батцэцэгийг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гадаад харилцааны сайдын, Болдын Жавхланг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Сангийн сайдын, Баттөмөрийн Энхбаярыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн /ХЗДХ/-ийн сайдын, Гонгорын Дамдиннямыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын, Дамбын Батлутыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайдын, Батын Батбаатар Батбаатарыг Монгол улсын ЗГ-ын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын, Пүрэвсүрэнгийн Наранбаярыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Боловсролын сайдын, Тилеуханы Аубакирыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын, Борхүүгийн Дэлгэрсайханыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Зам, тээврийн сайдын, Чинбатын Ундрамыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын, Энхтайваны Бат-Амгаланг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын, Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр /ХХААХҮ/-ийн сайдын, Энхбаярын Батшугарыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын, Баттогтохын Чойжилсүрэнг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрчим хүчний сайдын, Жигжидсүрэнгийн Чинбүрэнг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрүүл мэндийн сайдын.

Хоёр.Монгол Улсын ЗГ-ын гишүүнээр томилох тухай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад Жадамбын Энхбаярыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдад Тогмидын Доржхандыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдад Нямтайширын Номтойбаярыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад Баттөмөрийн Энхбаярыг, Монгол

Улсын ЗГ-ын гишүүн, Гадаад харилцааны сайдад Батмөнхийн Батцэцэгийг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Сангийн сайдад Загджавын Мэндсайханыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайдад Сайнбуянгийн Амарсайханыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад Гонгорын Дамдиннямыг, Монгол улсын ЗГ-ын гишүүн Батлан хамгаалахын сайдад Дамбын Батлутыг, Монгол улсын ЗГ-ын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын сайдад Цэндийн Сандаг-Очирыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Боловсролын сайдад Лувсанцэрэнгийн Энх-Амгаланг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдад Тилеуханы Аубакирыг, Монгол улсын ЗГ-ын гишүүн, Зам, тээврийн сайдад Борхүүгийн Дэлгэрсайханг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад Жуковын Алдаржавхланг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад Энхтайваны Бат-Амгаланг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, ХХААХҮ-ийн сайдад Цагаанхүүгийн Идэрбатыг, Монгол улсын ЗГ-ын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад Чинбатын Номинг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрчим хүчний сайдад Бадрахын Найдалааг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрүүл мэндийн сайдад Энхбаярын Батшугарыг танилцуулж байна. Танилцуулгаа унших уу?

С.Бямбацогт: Унших байх, уншина тийм ээ.

Н.Учрал: Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд албан тушаалд томилуулахаар Жадамбын Энхбаярыг танилцуулж байна. Жадамбын Энхбаяр 1973 онд Улаанбаатар хотод төрсөн, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1990 онд 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 1999 онд Монгол Улсын Их сургууль /МУИС/-ийн Хууль зүйн дээд сургууль, 2005 онд Маастрихтын их сургуулийг тус тус төгссөн. Бизнесийн удирдлагын магистр, Үндэсний батлан хамгаалахын их сургууль /ҮБХИС/-д докторант, хуульч мэргэжилтэй. 2000-2006 онд ГЕГ-т Зөвлөх, газрын дарга, 2006-аас 2008 онд МХЕГ-ын Тамгын газрын дарга, дэд дарга, 2008-аас 2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд, Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, 2020-оос 2021 онд Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, 2021-ээс 2024 онд Монгол Улсын /Үндэсний аюулгүй байдлын зөвлөл/ ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдал, улс төрийн бодлогын зөвлөх, 2024-өөс 2025 онд ХХААХҮ-ийн сайд, 2025-аас 2026 онд Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар ажилласан. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Улсад 32 жил ажилласан.

ЗГ-аас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх чадвар, тухайн ажил үүргийг гүйцэтгүүлэхэд хуримтлуулсан туршлага, мэдлэг, танхимын зарчмаар ажиллах чадварыг үндэслэж томилох саналыг та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын албан тушаалд Тогмидын Доржхандыг томилохоор танилцуулж байна. Тогмидын Доржханд 1977 онд Улаанбаатар хотод төрсөн, 49 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1995 онд нийслэлийн 10 жилийн 2 дугаар дунд сургууль, 1999 онд МУИС, 2004 онд Япон улсын Хитоцубаши их сургууль, 2010 онд АНУ-ын Харвардын их сургуульд дэд бүтэц дэх төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны чиглэлээр, 2012 онд Их Британи улсын Оксфордын их сургуульд санхүүгийн онол чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн. Төрийн санхүүч мэргэжилтэй, төрийн эдийн засгийн бодлогын магистр зэрэгтэй.

1999-өөс 2002 онд Сангийн яамны Төсвийн бодлогын газарт мэргэжилтэн, 2003-аас 2004 онд Япон улсын Сангийн яаманд дадлагын ажилтан, 2005-аас 2012 онд Сангийн яамны Зээл, тусламжийн бодлогын газрын орлогч дарга, НҮБ-ын Түмэн бүс хөтөлбөр, Азийн хөгжлийн банк /АХБ/-ны Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн зохицуулагч, 2012-оос 2013 онд Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга, 2016-аас 2020 онд ХҮН намын Удирдах зөвлөлийн дарга, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. 2024 оноос Монгол Улсын Шадар сайдаар ажиллаж байна. Улсад 27 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдад Нямтайширын Номтойбаярыг танилцуулж байна. Нямтайширын Номтойбаяр 1978 онд Улаанбаатар хотод төрсөн, 48 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1996 онд Улаанбаатар хотын 10 жилийн сургууль, 1997 онд АНУ-ын Индиана мужийн Интерлинг хэлний төв, 2001 онд АНУ-ын Индиана мужийн Валпарайсо их сургууль, 2002 онд Тагнуулын ерөнхий газар /ТЕГ/-ын дээд сургууль, 2010 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/-ын Берлин хотын Техник, эдийн засгийн дээд сургууль, 2022 онд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант улсын Кембриджийн Их сургуулийн удирдлага, манлайллын хөтөлбөр, 2023 онд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант улсын Оксфордын их сургуулийн удирдлага, манлайллын хөтөлбөрийг тус тус дүүргэсэн. Улс төр, бизнесийн удирдлагын мэргэжилтэй, инженерийн магистрын зэрэгтэй.

2001-ээс 2005 онд ТЕГ-ын гүйцэтгэх ажилтан, 2005-аас 2008 онд Монгол алт компанийн төслийн менежер, 2008-аас 2009 онд ТЕГ-ын гүйцэтгэх ажилтан, 2010-аас 12 онд Монголын алт компанийн бодлогын зөвлөлийн гишүүн, дэд ерөнхийлөгч, 2012 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд, 2012-оос 2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016-аас 2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016-аас 17 онд Хөдөлмөр нийгэм, хамгааллын сайд, 2024 онд Үндэсний эвслийн тэргүүн, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Улсад 25 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын албан тушаалд Баттөмөрийн Энхбаярыг томилохоор танилцуулж байна. Баттөмөрийн Энхбаяр 1977 онд Дорнод аймгийн Чойбалсан хотод төрсөн, 49 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1994 онд Дорнод аймгийн Чойбалсан хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 1998 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрхзүйч мэргэжлээр төгссөн. 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд магистрын зэрэг хамгаалсан. 1998-аас 2004 онд Улаанбаатар эрдэм дээд сургуульд багш, 2000-2001 онд Улсын Их Хурлын гишүүний туслах, 2001-ээс 2002 онд Монгол УИХ дахь МАН-ын бүлгийн ажлын албанд референт, хуулийн зөвлөх, 2003-аас 2006 онд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Тамгын газрын дарга, 2006-аас 2007 онд ХЗДХЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, 2009-өөс 2011 онд Нийгмийн даатгалын ерөнхий газар /НДЕГ/-ын Тамгын газрын дарга, 2011-ээс 2013 онд МАН-ын даргын зөвлөх, 2014-өөс 2016 онд Монгол УИХ дахь МАН-ын бүлгийн зөвлөх, 2016-аас 2018 онд ХЗДХ-ийн дэд сайд, 2020-оос 2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2023 онд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /ХЗБХ/-ны дарга, 2023-аас 2024 онд ХЗДХ-ийн сайд, 2025-аас 2026 онд ХЗДХ-ийн сайдаар ажилласан. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж ажиллаж байна. Улсад 28 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гадаад харилцааны сайдад Батмөнхийн Батцэцэгийг томилуулахаар та бүхэнд танилцуулж байна. Батмөнхийн Батцэцэг 1973 онд Баянхонгор аймагт төрсөн, 53 настай, нөхөр, 3 хүүхдийн хамт амьдардаг. 1992 онд Дархан хотын 13 дугаар дунд сургууль, 1996 онд МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургууль, 2000 онд СЭЗДС, 2005 онд Нидерланд улсын Маастрихийн менежментийн их сургуулийг тус тус төгссөн. Олон улсын харилцааны ажилтан, багш, орчуулагч мэргэжилтэй, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

1996-аас 2005 онд Мөнхийн үсэг компанийн ерөнхий захирал, 2005 онд Аз хур компанийг үүсгэн байгуулагч, ерөнхий захирал, 2005-аас 2007 онд Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагт Гадаад сурталчилгаа хамтын ажиллагааны хэлтсийн дарга, 2007-гоос 2015 онд Мөнхийн үсэг компанийн ТУЗ-ийн дарга, 2010-аас 2011 онд МАН-ын ЕНБД-ын зөвлөх, 2011-ээс 2012 онд МАН-ын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, 2015-аас 2016 онд Сангийн сайдын гадаад бодлогын зөвлөх, 2016-аас 2020 онд Гадаад харилцааны дэд сайд, 2021-ээс 2024 онд Гадаад харилцааны сайд, 2024-өөс 2026 онд Гадаад харилцааны сайдаар ажилласан. 2024 оноос Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Улсад 30 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Сангийн сайдын албан тушаалд Загджавын Мэндсайханыг томилохоор танилцуулж байна. Загджавын Мэндсайхан 1979 онд Ховд аймгийн Мянгад сумд төрсөн, 47 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1996 онд Ховд аймгийн Мянгад сумын 10 жилийн дунд сургууль, 2001 онд СЭЗДС, 2008 онд Удирдлагын академийг тус тус төгссөн. Эдийн засагч мэргэжилтэй, бизнесийн ухааны магистр зэрэгтэй. 2001-ээс 2003 онд Монхангай компанийн хэлтсийн менежер, 2003-аас 2004 онд Дөрвөн уул компанийн гүйцэтгэх захирал, 2004-өөс 2013 онд Мээг компанийн гүйцэтгэх захирал, 2013-аас 2015 онд МТМ ХХК-ийн ерөнхий захирал, 2015-аас 2016 онд Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, 2016-аас 2019 онд ЭХЯ-ны ТНБД, 2019-өөс 2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /ТӨБЗГ/-ын дарга, 2020-оос 2022 онд ХХААХҮ-ийн сайд, 2022-оос 2023 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2024 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлого хариуцсан зөвлөх, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Улсад 25 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайдын албан тушаалд Сайнбуянгийн Амарсайханыг томилохоор танилцуулж байна. 1973 онд Улаанбаатар хотод төрсөн, 53 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1991 онд Налайх дүүргийн ЕБС, 1996 онд АНУ-ын Калифорния мужийн Фресно институт, 2000 онд АНУ-ын Саут Уест их сургуулийг тус тус төгссөн. Эрх зүйч мэргэжилтэй, хууль зүйн ухааны магистр зэрэгтэй.

1992-оос 1994 онд Шинжлэх ухаан, мэдээлэл технологийн төвд ажилтан, 2000-2004 онд Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-нд консулын ажилтан, атташе, 2004-өөс 2007 онд Американ трейд энд девелопмент компанид хөрөнгө оруулалт, гадаад худалдааны менежер, 2007-гоос 2017 онд Оюуны Ундраа компанийн гүйцэтгэх захирал, ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга, 2012-оос 2020 онд НИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч, 2016-аас 2017 онд НИТХ-ын Төсөв, санхүү, эдийн засгийн хорооны дарга, 2017-оос 2019 онд НИТХ-ын дарга, 2019-өөс 2020 онд НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга, 2021-ээс 2025 онд Монгол Улсын ЗГ-ын гишүүн,

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын даргаар ажилласан. Улсад 30 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад Гонгорын Дамдиннямыг томилохоор та бүхэнд танилцуулж байна. Гонгорын Дамдинням 1982 онд Дархан-Уул аймагт төрсөн, 44 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1999 онд Дархан-Уул аймгийн 7 дугаар дунд сургууль, 2004, 2007 онд МУБИС, 2007 онд МУБИС-ийг улс төр судлалын магистр, 2016 онд Канад улсын Бритиш колумбын их сургуулийг тус тус төгссөн. Нийгэм судлал, эрх зүйн багш мэргэжилтэй, улс төр судлал, уул уурхайн засаглал, бодлогын судлалын магистр зэрэгтэй.

2005-аас 2008 онд МАН-ын дэргэдэх Монголын Ардчилсан социалист оюутны холбооны дэд ерөнхийлөгч, 2007-гоос 2008 онд МАН-ын дэргэдэх Монголын Ардчилсан социалист залуучуудын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, 2008-аас 2009 онд Байгаль орчны сайдын зөвлөх, 2009-өөс 2010 онд Боловсрол, шинжлэх ухааны сайдын зөвлөх, 2010-аас 2013 онд ШУТИС-ийн Нийгмийн хөгжил, эдийн засгийн проектор, 2015 онд Канад улсын Бритиш колумбын их сургуулийн Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнд судлаач, 2017 онд Прокон Майнинг Монголиа компанийн гүйцэтгэх захирал, 2020-оос 2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2021-ээс 2022 онд Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, 2024-өөс 2025 онд Монгол УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга, 2025-аас 2026 онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ажилласан. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Улсад 18 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайдад Дамбын Батлутыг томилохоор та бүхэнд танилцуулж байна. Дамбын Батлут 1974 онд Архангай аймгийн Хашаат сумд төрсөн, 51 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1982 онд Архангай аймгийн ерөнхий боловсролын дунд сургууль, 1992 онд Орхон аймгийн ерөнхий боловсролын 5 дугаар дунд сургууль, 2004 онд ШУТИС-ийн харьяа Технологийн сургуулийг цахилгааны инженер мэргэжлээр, 2007 онд Удирдлагын академийг төрийн захиргаа, удирдлагын мэргэжлээр тус тус төгссөн.

1991-ээс 1993 онд Дорноговь аймгийн Зүүнбаян дахь 149 дүгээр цэргийн ангид алба хаасан. 1994-өөс 2000 онд Эрдэнэт хивс компанид туслах ажилтан, 2003-аас 2006 онд Дэлхийн зөн ОУБ-д гүйцэтгэх захирал, 2006-аас 2013 онд Орхон аймгийн Монголын Ардчилсан социалист залуучуудын холбооны тэргүүн, 2006-аас 2007 онд Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын мэргэжилтэн, 2008-аас 2012 онд Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын орлогч, 2006-аас 2013 онд Нийгмийн Ардчилал МЗХ-ны Орхон аймгийн тэргүүн, 2010-аас 2012 онд Баян-Өндөр сумын Намын анхан шатын байгууллагын дарга, 2013 оноос Орхон аймгийн МАН-ын дарга, 2008-аас 2020 онд Орхон аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгч, иргэдийн Хурлын бүлгийн дарга, 2016-аас 2020 онд Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагч, 2020-оос 2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2025-аас 2026 онд Батлан хамгаалахын сайдаар ажиллаж байна. Улсад 22 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад Цэндийн Сандаг-Очирыг томилохоор та бүхэнд танилцуулж байна. Цэндийн Сандаг-Очир 1977 онд Төв аймгийн Баяндэлгэр сумд төрсөн, 49 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1995 онд нийслэлийн Багануур дүүргийн 66 дугаар дунд сургууль, 2000 онд Тэнгэр дээд сургуулийг философич, нийгмийн ухааны багш

мэргэжлээр, 2001 онд Удирдлагын академийг төрийн захиргааны удирдлагын мэргэжлээр, 2008 онд Удирдлагын академийг төрийн удирдлагын магистрын зэрэгтэйгээр тус тус төгссөн

2000-аас 2004 онд Нийслэлийн БНД-ийн ЗДТГ-ын 4 дүгээр хорооны нийгмийн ажилтан, олон нийттэй харилцах мэргэжилтэн, 2008-аас 2012, 2016-аас 2020 онд Нийслэлийн БНД-ийн Засаг дарга, 2020 оноос 2 удаа Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. 2005 оноос 2012 онд нийслэлийн БНД-ийн МАН-ын хорооны дэд дарга, 2012 оноос одоог хүртэл нийслэлийн БНД-ийн МАН-ын хорооны дарга, 2012-оос 2020 онд 2 удаа НИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон. 2025 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, ТББХ-ны даргаар ажиллаж байна. Улсад 26 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Боловсролын сайдад Лувсанцэрэнгийн Энх-Амгаланг томилохоор та бүхэнд танилцуулж байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан 1970 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод төрсөн, 56 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1987 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотын 10 жилийн 2 дугаар дунд сургууль, 1992 онд ОХУ-ын Санкт Петербургийн их сургууль, 1996 онд АНУ-ын Дакотогийн их сургууль, 2002 онд БНСУ-ын Хангдоны их сургуулийг тус тус төгссөн. Сэтгүүлч, эдийн засагч мэргэжилтэй.

2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын Хөдөөгийн бодлого, дэд бүтэц хариуцсан зөвлөх, 2012-оос 2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2012-оос 2020 онд МАН-ын удирдах зөвлөлийн гишүүн, 2016-аас 2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016-аас 2017 онд Монгол Улсын Их Хурлын НББСШУБХ-ны дарга, 2017-гоос 2020 онд Монгол Улсын Их Хурлын дэд дарга, 2020-оос 2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, ТББХ-ны дарга, 2021-ээс 2022 онд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг гүйцэтгэгч, 2021-ээс 2023 онд Түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга, 2021-ээс 2024 онд Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайдаар, 2024-өөс 2025 онд Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдаар тус тус ажилласан. Улсад 34 жил, төрийн албанд 14 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад Тилеуханы Аубакирыг томилохоор та бүхэнд танилцуулж байна. Тилеуханы Аубакир 1976 онд Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумд төрсөн, 49 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1992 онд Сэлэнгэ аймгийн Цагаан нуур сумын 10 жилийн дунд сургууль, 2000 онд Отгонтэнгэр дээд сургуулийг тус тус төгссөн. Олон улсын эрх зүйч мэргэжилтэй. 2000-2005 онд Сэлэнгэ тариа компанийн дэд захирал, 2006-аас 2015 онд Тариа Цацал компанийн захирал, 2008-аас 2015 онд Баян-Өлгий аймгийн Нийгмийн ардчилал МЗХ-ны дарга, 2015-аас 2016 онд ГЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газрын дарга, 2017-гоос 2019 онд ГЕГ-ын харьяа Буянт-Ухаа дахь Гаалийн газрын орлогч дарга, 2020-оос 2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2025-аас 2026 онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажилласан. Улсад 25 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Зам, тээврийн сайдын албан тушаалд Борхүүгийн Дэлгэрсайханыг томилохоор та бүхэнд танилцуулж байна. Борхүүгийн Дэлгэрсайхан 1964 онд Дорноговь аймгийн Сайншанд сумд төрсөн, 61 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1982 онд Дорноговь аймгийн Сайншанд сумын 1 дүгээр дунд сургууль, 1987 онд Нийгмийн аюулаас хамгаалах яамны дэргэдэх Цэргийн дээд сургууль буюу одоогийн ХСИС-ийг төгссөн. Хуульч мэргэжилтэй.

1982-оос 83 онд Хилийн цэргийн 0129 дүгээр анги, Улаан-Уул дахь отрядын Рашаантын 6 дугаар заставд цэргийн алба хаасан. 1987-гоос 89 онд Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах хэлтсийн мөрдөн байцаагч, 1989-өөс 1992 онд Дорнод аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн дарга, 2016-аас 2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2023-аас 2024 онд Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга, 2024-өөс 2026 онд Зам, тээврийн сайдаар ажилласан, улсад 38 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын албан тушаалд Жуковын Алдаржавхланг томилуулахаар та бүхэнд танилцуулж байна. Жуковын Алдаржавхлан 1977 онд Улаанбаатар хотод төрсөн, 49 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1995 онд Улаанбаатар хотын 10 жилийн 50 дугаар дунд сургууль, 1998 онд Австрали улсын Сидней хотын Англи хэлний институт, 2000 онд Монгол бизнес дээд сургууль, 2005 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг тус тус төгссөн. Санхүүч, эдийн засагч мэргэжилтэй.

2001-ээс 2006 онд Улсын Их Хурлын Тамгын газарт туслах, зохион байгуулагч, референт, 2006-аас 2008 онд Сангийн яаманд зөвлөх, 2007-гоос 2012 онд Орон сууцжуулалтын сан корпорацийн гүйцэтгэх захирал, 2016-аас 2024 онд Хан-Уул дүүргийн Засаг дарга, 2016-аас 2024 онд НИТХ-ын төлөөлөгч, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дэд даргаар ажиллаж байна. Улсад 25 жил, төрийн албанд 22 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын албан тушаалд томилохоор Энхтайваны Бат-Амгаланг танилцуулж байна. Энхтайваны Бат-Амгалан 1977 онд Улаанбаатар хотод төрсөн, 49 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1994 онд нийслэлийн 1 дүгээр дунд сургууль, 1998 онд МУИС-ийн ОУХДС, 2004 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг тус тус төгссөн. Олон улсын дипломатч, эрх зүйч мэргэжилтэй, магистр зэрэгтэй.

2002-оос 2008 онд Баян Хадат тур компанийн гүйцэтгэх захирал, 2008-аас 2010 онд нийслэлийн БЗД-ийн ЗДТГ-ын Үйлдвэр, үйлчилгээний хэлтсийн дарга, 2008-аас 2012 онд нийслэлийн БЗД-ийн ИТХ-ын төлөөлөгч, 2010-аас 2012 онд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын орлогч дарга, 2015-аас 2020 онд ИНЕГ-ын харьяа Чингис Хаан ОУНБ-ын Гадаад харилцааны хэлтсийн дарга, 2016-аас 2020 онд НИТХ-ын төлөөлөгч, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Улсад 23 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, ХХААХҮ-ийн сайдын албан тушаалд томилохоор Цагаанхүүгийн Идэрбатыг танилцуулж байна. Цагаанхүүгийн Идэрбат 1981 онд Хэнтий аймагт төрсөн, 45 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1998 онд Хэнтий аймгийн Өндөрхаан хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 2003 онд Гадаад хэлний дээд сургууль, 2007 онд Удирдлагын академийг тус тус төгссөн. Англи хэлний багш, төрийн удирдлагын менежер мэргэжилтэй.

2003-аас 2008 онд Хэнтий аймгийн МАН-ын хороонд улс төрийн ажилтан, 2008-аас 2012 онд Хэрлэн сумын Засаг даргын орлогч, 2012-оос 2016 онд Хэнтий аймгийн МАН-ын хорооны орон тооны дэд дарга, 2016-аас 2020 онд Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч, 2020-оос 2021 онд Хэнтий аймгийн Засаг дарга 2021-ээс 2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2024 оноос Монгол

Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Улсад 23 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын албан тушаалд томилохоор Чинбатын Номинг танилцуулж байна. Чинбатын Номин 1983 онд Улаанбаатар хотод төрсөн, 43 настай, нөхөр хүүхдүүдийн хамт амьдардаг. 2000 онд ерөнхий боловсролын 45 дугаар дунд сургууль, 2001 онд ИБУИНВУ-ын Аббэй коллеж, 2006 онд ИБУИНВУ-ын Зүүн Английн Норвичийн их сургууль, 2015-аас 2018 онд АНУ-ын Харвардын Бизнесийн сургуулийг тус тус төгссөн. Эдийн засагч, нягтлан бодогч, бизнесийн удирдлагын менежер мэргэжилтэй.

2001-ээс 2010 онд хувийн хэвшилд ажиллаж байсан, 2008-аас 2021 онд Тэрэлж зочид буудлын ерөнхий захирал, 2011-ээс 2021 онд Монгол HD телевизийн ерөнхий захирал, 2015-аас 2021 онд Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийн Удирдах зөвлөлийн дарга, 2016-аас 2021 онд Монголын телевизүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, 2017-гоос 2021 онд Монголын оюуны өмчийг хамгаалах холбооны ТУЗ-ийн гишүүн, 2021-ээс 2022 онд Монгол Улсын ЗГ АНУ-ын ЗГ хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн дарга, 2021-ээс 2024 онд Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Соёлын сайд, 2023 онд Азийн улс төрийн намуудын ОУБ-ын эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүн, 2023-аас 2025 онд Монгол Улсын олон улс дахь Сурталчилгаа, мэдээллийн үндэсний хорооны дарга, 2023-аас 2025 онд Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дэд тэргүүн, 2023-аас 2025 онд Социал демократ Монголын эмэгтэйчүүдийн холбооны дэд ерөнхийлөгч, 2024-өөс 2025 онд Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдаар ажиллаж байсан. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Улсад 25 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрчим хүчний сайдын албан тушаалд томилохоор Бадрахын Найдалааг танилцуулж байна. Бадрахын Найдалаа 1975 онд Улаанбаатар хотод төрсөн, 51 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1993 онд нийслэлийн 10 жилийн 23 дугаар дунд сургууль, 1997 онд СЭЗДС, 2004 онд Япон улсын Кобе их сургуулийг тус тус төгссөн. Хөгжлийн эдийн засагч мэргэжилтэй, эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй.

1997-гоос 2002 онд СЭЗДС-д Эдийн засгийн онолын багш, 2004-өөс 2007 онд Анод банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал, эдийн засагч, 2007-гоос 2008 онд Хаан банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал, 2011-ээс 2012 онд Монголын эдийн засгийн форумын гүйцэтгэх захирал, 2012-оос 2015 онд Монголын банкны холбооны гүйцэтгэх захирал бөгөөд ЕНБД, 2018-аас 2020 онд Тогтвортой ногоон санхүүжилтийн хөгжил холбооны гүйцэтгэх захирал, 2016-аас 2024 онд ХҮН намын дарга, Удирдах зөвлөлийн гишүүн, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар ажиллаж байна. Улсад 29 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрүүл мэндийн сайдын албан тушаалд томилохоор Энхбаярын Батшугарыг танилцуулж байна. 1987 онд Улаанбаатар хотод төрсөн, 39 настай, эхнэр, хүүхдийн хамт амьдардаг. 2000 онд нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр дунд сургууль, 2004 онд АНУ-д бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 2008 онд АНУ-ын Бентлигийн их сургуулийг тус тус төгссөн. Эдийн засагч, банк, санхүүгийн мэргэжилтэй.

2008-аас 2011 онд Их Британи Умард Ирландын Нэгдсэн хаант улсын Лондон хот дахь J.P.Morgan хөрөнгө оруулалтын банканд банкир, 2011-ээс 2012 онд МАХН-ын Гадаад харилцаа хариуцсан нарийн бичгийн дарга, 2012-оос 2016 онд Монголбанкны Дэд ерөнхийлөгч, 2016-аас 2021 онд Медиа Холдинг компанийн ТУЗ-ийн гишүүн, 2021-ээс 2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2021-ээс 2024 онд МАН-ын дэргэдэх Нийгмийн ардчилал МЗХ-ны дэд ерөнхийлөгч, 2022-оос 2024 онд Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, 2025-аас 2026 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаар ажилласан. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Улсад 15 жил ажилласан туршлагатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 103.1, ЗГ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад тус тус заасны дагуу Монгол Улсын ЗГ-ын гишүүнийг УИХ-д танилцууллаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Монгол Улсын Ерөнхий сайдад баярлалаа. Саяын хийсэн танилцуулгатай холбогдуулж Ерөнхий сайд болон ЗГ-ын гишүүнээр томилогдох этгээдүүдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү? Хурлын ирцэд орсон дарааллаар эрэмбэлэгдэнэ, эрэмбэлэгдчих шиг боллоо. Хуралдаанд 126 гишүүнээс 117 гишүүн оролцож байна. Хэнээр таслах вэ, хамгийн сүүлийн гишүүн? Нарантуяа-Нара гишүүнээр тасаллаа. Дарааллын дагуу асуулт асууж, үг хэлнэ. Нэр нь ороогүй гишүүд байна уу? Баасанжаргал гишүүн, өөр, алга байна. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж асуулт асууж, үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Энэ миний өнгөрсөн жилүүдэд МАН-ын хулгайтай хийсэн тэмцлийн түүх байгаа юм. Зөвхөн хулгайтай холбоотой. Тэгээд ЖДҮ-ээр эхэлсэн, Хөгжлийн банк, нүүрсний хулгай, оффтейк, тендерийн хулгай, төмөр замын хулгай, Боловсролын зээлийн сангийн хулгай, ногоон автобусны зэрэг маш их олон хулгайнуудыг хийсэн. Тэгээд сая МАН-ынхан хоорондоо хэрэлдэхдээ миний өнгөрсөн жилүүдэд хэлсэн үгнүүдийг хоорондоо тавьж байгаад заргалдаж байна лээ. Тэгээд миний хэлсэн зүйл үнэн гэдгийг баталсан гэсэн үг.

Тэгээд энэ ковидын хулгай, 20 их наядын хохиролтой нүүрсний хулгай дөнгөж эхэлж байхад 7 их наядын хохиролтой гээд ярьж байж, эхэлж байхад л ярьж байсан. 3,2 тэрбум төгрөгийн усан сан машинаар зөөж усалдаг ийм усан сан энэ тэр гээд ярьж байсан байна. Тэгээд хулгайдаа цадсан та нар өнгөрсөн сая ингээд харж байхад бүүр Бодийн 120 саяыг ингэж тэнгэж хуваасан. Оюутолгойн 20 сая доллар ингэж, ингэж шамшигдуулсан энэ тэр гээд бүр хоорондоо бүр улаан цагаан. Энэ ард түмнийг зүгээр цагаан цаас гэж харж байгаад л зүгээр л маргалдчих юм. Тэгээд Ардын намын хөөрхий жирийн гишүүдийн нүүрийг нь түлээд нэг хэдхэн нөхдүүд та нар энэ урдуур тэд нарын нүүрийг түлж байгаа шүү дээ. Ерөөсөө хоорондоо барьцаалагдчихсан, чи миний оффтейкийн гэрээг ярьж байна, тэгвэл чиний энэ ковидын хулгай байгаа шүү гээд тэгэнгүүт ерөөсөө хоёулаа больё. Тэгээд хулгайгаа нуудаг.

Өнөөдөр яаж байна, тамираа тасартал хэрэлдэж байсан нөхдүүд өнөөдөр бүгдээрээ нийлчихсэн сайхан инээлдчихсэн байна. Ямар жаргалтай байна та нар. Тэгээд бүгдээрээ яадаг вэ та нар авлигачдаа 40 сая төгрөгөөр торгодог, 2, 3-хан жилээр ялладаг, 2 жилээр яллагдсан тэр нөхөр байна шүү дээ тийм ээ 24 тэрбум төгрөгийн маркийн цуглуулгатай шүү дээ, тэр хааччихсан бэ? Ард түмэн та нарт

ерөөсөө энэ хариуцлага тооцож чадахгүй юм байна, та нарт 2028 онд ард түмэн дүнгээ тавина. АН олуулаа болно, олуулаа болчхоод нэг зүйлийг хийнэ хариуцлага тооцно, та нарыг бүгдэнг чинь 461 дүгээр ангийн нэг камерт аваачиж хорино, тэгээд заавал ял өгнө. Ял өгчхөөд ногоон автобусаар чинь Мааньтын чанга дэглэмтэй хорих ангид аваачиж үлдсэн насыг чинь өнгөрөөнө. Нэг юм мартчихаж бас ногоон автобусанд 3 суудал авна, Ардын намаас АН-д тавьсан 3 бэтийг хамт ачна.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, үг хэлэхдээ бүдүүлэг үг хэрэглэхгүй, жоохон ёс зүйтэй байхыг анхаарна уу. Хариулт байхгүй, үг хэллээ. Эрдэнэболд гишүүн асуултаа асууж, үг хэлье.

С.Эрдэнэболд: Өнөөдөр 2026 оны 4 сарын 3-ны одоогийн 20 цаг 23 минут болж байна. Жил гаруйн дотор 21 сарын дотор танайх МАН-ын тэргүүлсэн ЗГ ингээд 63 дахь сайдаа оруулж ирж байна, дэд сайдтайгаа 80 сайд. Тэгээд 24 оноос хойш одоогийн гарч байгаа 19 сайдаас 12 нь ямар нэгэн байдлаар сайдын албан тушаал хашиж байсан хүн байна. Учрал даргаас асуулт асууя. Та сая 19 цаг 47 минутад үг хэлэхдээ тухайн ажил үүргийг гүйцэтгүүлэхэд хуримтлуулсан туршлага, мэдлэгийг тухайн салбарт албан тушаалд томилуулах үндэслэл гэж хэллээ. Бидэнд тараасан цаасан дээр 4 үндэслэл байна. ЗГ-аас дэвшүүлсэн зорилгыг, зорилтыг хэрэгжүүлэх чадвар, танхимаар ажиллах чадвар, удирдан зохион байгуулах чадвар, ажил хэрэгч чанар гээд. Яагаад энэ дээр жишээлбэл ёс зүйн шаардлага шалгуур тавихгүй байгаа юм бэ? Яагаад гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, Авлигатай тэмцэх газар /АТГ/ янз бүрийн хууль шүүхээр асуудал нь явж байгаа гэсэн шалгуур тавихгүй байгаа юм бэ? Яагаад хувийн ашиг сонирхлын зөрчилд орж байсан эсэх, нэр цэвэр байдлын шалгуур тавихгүй байгаа юм бэ? Яагаад энэ ард түмний хүсэж байгаа шударга ёсыг сахиулахад ус агаар мэт хэрэгтэй байгаа тэр шалгууруудыг Ерөнхий сайд тавихгүй байгаа юм бэ? Энэ асуултыг 1 дүгээрт хариулмаар байна.

2 дугаар асуулт. Та энэ 19 сайддаа нэр дэвшүүлж орж ирж байгаа, бидэнд танилцуулж байгаа сайд нартаа хэчнээн хувийн итгэл үнэмшилтэй, сэтгэл хангалуун байгаа юм бэ? 19-лэнд нь 100 хувийн сэтгэл хангалуун байгаа юм уу, эсвэл танд ямар нэгэн улс төрийн шахаанд орсон, дарамтад орсон хүнд нөхцөл байгаа юм уу? Түүх нэг л удаа явдаг шүү дээ. Танд асар их хүмүүс итгэж, найдаж, Учрал сүүлчийн найдвар боллоо гэж иргэд, олон нийт хэлж байна, энэ Их Хурлын танхимд зөндөө хүмүүс хэлсэн шүү дээ. 72-хон цагийн өмнө 3 сарын 30-ны өдөр таныг томилогдоход манай АН-аас гэхэд олон хүмүүс Бейсен гуайгаас өгсүүлээд олон хүмүүс та сүүлчийн найдвар шүү, эрх баригч намаас нэг шинэчлэлийг хийчих, энэ хулгай луйвраа зогсоочих, хариуцлага тооцчих, сүүлчийн найдвар байгаа шүү гээд бид таныг дэмжсэн.

Оруулж ирж байгаа ЗГ чинь ямар учиртай ЗГ юм бэ? Тухайн салбартаа мэргэшсэн байх гэдэг шалгуур байгаа. Тэр салбарт ажиллах нь байтугай хараад цочихоор хүмүүс орж ирж байна шүү дээ. Тэр салбарынх нь хүмүүсийг доромжилж байгаа юм уу? Сайн менежер байж болно л доо. Гэхдээ энэ улс төрийн наймаа, тохироо чинь ийм ил цагаан гаарч иргэд, олон нийтийн хүсэл бодлыг уландаа гишгэж, салбарынхны, мэргэжлийнхний тэр олон жилийн хичээл зүтгэл гаргаж ирсэн хүмүүсийн урмыг хугалах түвшинд явж болж байгаа юм уу? Та манай наяд оноос гарсан 2 дахь Ерөнхий сайд. Залуучууд айдасгүйгээр Засгаа байгуулаад, эрчтэй шийдвэр гаргаад явна гэсэн итгэл үнэмшил ард түмэнд байгаа шүү дээ. Эдгээр асуултуудыг Учралаас, Учрал Ерөнхий сайдаас асууя.

Нөгөө талаар энэ сайд болох гээд нэрээ дэвшүүлээд орж ирж байгаа зарим нэгэн хүмүүс ичих хэрэгтэй шүү дээ. Эхлээд тодорхой асуудлуудаа шалгуулдаг газарт нь шалгаад, нэр усаа цэвэрлээд, гэм буруугаа шүүхээр тогтоолгочхоод орж ирэх хэрэгтэй зарим хүмүүс. Нөгөө олон хулгай луйвар чинь тэгээд жүжиг байсан юм уу, ард түмнийг талцуулах хэрүүлийн алим байсан юм уу, юу байсан юм бэ тэгээд энэ чинь?

2 дугаарт тухайн салбарын мэдлэг, мэргэжилгүй хүмүүс нь шууд нэрээ тат л даа. Сайдын заяанд төрчихсөн юм шиг, сайн эцэг ,эхийн буянаар, бид ямар улсаар тоглож өв залгамжлагчаар энэ парламентыг доромжлуулах гэж байгаа юм уу, тийм юм байхгүй шүү. Ерөнхий сайдаас хариулт авъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд Ням-Осорын Учрал хариулна.

Н.Учрал: Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Монгол Улсын Ерөнхий сайдад Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрх бол кабинетаа өөрөө бүрдүүлэх. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тухайн үед би батлалцаж байсан Их Хурлын гишүүдийн нэг. Тэгэхээр энэ удаа кабинетыг бүрдүүлэхдээ мэдээж 1 дүгээрт ёс зүйн асуудлыг тавьсан, АТГ луу урьдчилан мэдүүлэг авдаг. Цаашдаа ч гэсэн би ёс зүй, сахилга хариуцлага шаардаж ажиллана. Ерөнхий сайдад Үндсэн хуулиар олгогдсон нэг бүрэн эрх бол сайд нараа хэний ч хамааралгүйгээр, цаг хугацаа алдахгүйгээр шууд чөлөөлөх бололцоо хуулиараа олгогдсон. Тийм учраас цаашид хэрвээ ажилдаа хариуцлагагүй хандсан, ёс зүйн зөрчил гаргасан, кабинетын зарчим алдсан, хурдтай шуурхай ажиллаж чадаагүй сайд нарыг тухай бүрд нь чөлөөлөөд, арга хэмжээнүүдийг аваад явна гэдгийг Эрдэнэболд гишүүндээ хэлье.

Нэг зүйл бий. Улсын Их Хурлын гишүүд хэлж байгаа, ярьж байгаа үгийг сайд нар сайн сонсох ёстой. Дөнгөж томилогдож байгаа учраас шууд дүгнээд ч гэдэг юм уу, юм хүлээх эрхгүй болно, эсвэл энэ Засгаас ямар үр дүн гарах вэ гээд ингээд урьдчилж яриад байх зохимжгүй. Тэгэхээр бид илүү үр дүнгээр харуулах нь зөв гэж үзэж байгаа. Тэгэхээр ажлын үр дүнгээрээ дүгнэ, хяналтаа тавь, тэр эрх УИХ-д байгаа. Тэгээд би их олон лоозон ярьж, хүмүүсийг залхаахыг хүсэхгүй байна. Ажлаараа харуулна, миний бодлого тодорхой, энэ ЗГ эрх чөлөөний төлөөх ЗГ байна. Бидний хүсдэг нийгэм, бидний үеийнхний хүсдэг нийгэм, хүнд суртал, дүрэм журам, гох дэгээ, саад тотгор учруулаад байгаа асуудлуудыг чөлөөлөх энэ эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлт гэсэн бодлогоо хэрэгжүүлнэ.

Тийм учраас би салбарын сайд нарыг сонгохдоо төрийн ажлыг хашиж байсан байдал, дээрээс нь хурдтай шуурхай байдал, дээрээс нь ажилдаа очоод шинээр суралцаад байх биш аймаг, орон нутгийг удирдаж байсан, дүүрэг удирдаж байсан, анхан шатанд ажиллаж байсан, олон нийтийн байгууллагыг удирдаж байсан гээд олон шаардлагыг тавьсан. Салбарын сайд өөрөө менежер байх ёстой, салбарын сайд бусдаар ажлыг хариуцлагатай хийлгэж чаддаг ийм менежер байх ёстой. Тийм учраас салбарын менежерүүд ажилдаа хурдтай шуурхай, цаг алдахгүй ороод, үр дүнгээрээ та бүхэндээ би хяналтаа тавиулна. Тэгэхээр мэдээж өнөөдөр шууд дүгнэх их хэцүү байна. Тэгэхээр анхан шатад ард түмний амьдралыг ойлгодог, ажиллаж байсан туршлагатай кабинет бүрдүүлэхийг хичээлээ.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Та чөлөөлөх гээд яриад байгаа, 4 чөлөөлөлт, эрх чөлөөний 4 зам гээд. Гэхдээ яг энэ танхимыг чинь бүрдэж байгаа орж ирж байгаа хүмүүс чинь

чөдөрлөхөөр хүмүүс орж ирсэн байна. Чөлөөлөлт биш чөдөрлөлт болж байна, богчоо, ногт, өрөөл. Нэг ингээд залчихсан бурхан шиг хэдэн нөхдүүд ингээд яаж ийж байгаад ороод ирдэг. Уг нь МАН-д эрх баригч намд зөндөө олон боловсролтой, чадалтай, итгэл үнэмшилтэй залуучууд байна, харж байхад ингээд сууж байна. Тэд нарын урдуур нь нэг ингээд боломж бүхнийг дээрэмддэг, бяралхаад дээрэлхээд сурчихсан хэдэн гарууд орж ирж байна. Тийм учраас Ерөнхий сайд цаашдаа энэ сайд нартаа өндөр шаардлага тавьдаг байх ёстой. Бид тодорхой төсөв, олон асуудал гарч ирэхээр сайд нар нь ирдэггүй. Хотоос ч ирдэггүй, Засгаас ч орж ирдэггүй. Гуйлгаж байж нэг юм орж ирдэг. Ажлын хэсгийн хурал, өчнөөн юмнууд хойшлоод байдаг. Эхнээсээ сахилга хариуцлагаа, одоо бид санал хураахгүй учраас хэлж байна л даа. Тийм учраас тэр ил тод, ёс зүй, хуулийн хариуцлагатай холбоотой шаардлагуудаа эхнээсээ тавьж яваарай. Та нар чадна гээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Шижир гишүүн асуултаа асууя, үгээ хэлье.

Ө.Шижир: Хонь хурга нийлчихсэн юм шиг холион бантан болсон ийм ЗГ-ын бүрэлдэхүүн орж ирж байна. Ер нь жоохон урам хугарч байна Учрал сайдад. Одоо энд байгаа сонгогдсон 68 гишүүнээс 41 нь ямар нэгэн байдлаар сайд болон дэд сайд хийж үзсэн хүмүүс байна шүү дээ, жагсаалтын хэдээс нь бусад нь бараг. Тэгээд хэдхэн хоногийн өмнө бие биеийнхээ хулгай дээрэм тонуул, хүн амь, байж болох бүх гэмт хэргийг ярьсан хүмүүс одоо нэг засагт мөр зэрэгцээд инээд алдаад суух гэж байна шүү дээ та хэд. Нөгөө өнгөрсөн 7 хоногт, өнгөрсөн саруудад ярьсан цүнх цүнхээр мөнгө зөөсөн нөгөө гэмт хэргүүд чинь хаачсан бэ? Ингээд эвлэрээд байх юм уу? Би энийг Хууль зүйн сайд болох хүнээс асуумаар байна. Яагаад гэвэл та нар ёстой яруу тодоор бие биеэ ярьж өгсөн шүү дээ. Би гэрчилнэ, би гэрчилнэ л гээд байсан. Одоо эвлэрээд нэг танхимд очоод суучихлаа.

Монгол Улсын төрийн түүхэнд анх удаагаа яам нь сайдгүй, дэд сайдгүй, үүрэг гүйцэтгэгчгүй 5 хонолоо. Та нар энэ хугацаанд төрөөр ингэж тоглолоо гэсэн үг. Энэ 5 хоногийн хугацаанд та нар хоорондоо эвлэрээд сууж байхдаа, хоорондоо юм яриад сууж байхдаа махны үнэ 31 мянгыг давсан тухай, бензиний үнэ өсөх тухай, иргэдийн худалдан авах чадвар буурч байгаа тухай, амьдрал хэцүүдэж байгаа тухай та нар нэг ч үг яриагүй шүү. Би тэрийг баттай хэлье. Харин төрд байгаа энэ хэдэн албан тушаалуудыг, яам, тамгын газруудыг, мөнгөтэй газруудыг хэн нь хэний бүлэглэл нь яаж хувааж явах вэ гэдэг л 5 хоносон. Энэ бодитой үнэн. Та нар ийм л 5 хоног хийсэн. Энэ 5 хоногийн хугацаанд та нар махны үнэд хэн ч санаа зовоогүй, 5 хоног төрийн ажлыг гацаалаа, 5 хоног ЗГ-ын ажлыг бүтэн гацаалаа.

Та хэдийг хараад энэ бизнес эрхлэгчид чинь бүлгийтлээ хараад сууж байгаа шүү дээ. Төрийн ажил юу болох бол, хэзээ жигдрэх бол, хэн ирж энэ ажил урагшлах бол гээд. Энэ итгэл найдвар бүгдээрээ нуран уналаа жинхэнээсээ. Тэгээд Улсын Их Хурлын шинэ дарга өнөөдөр хэлсэн үгэндээ хариуцлага нэхдэг, хүлээлгэдэг дэг журам байхгүй болсон байна гэж байна лээ. Үгүй ээ та нар засаг бариад 10 жил болж байгаа шүү дээ. Сонгууль болох болохоороо л иргэдээ санадаг, бусад үед нь таг мартдаг ийм л ЗГ, ийм л нам болчихсон байна шүү дээ. Хэнээс юу асуугаад, хэнд юу хэлээд байгаа юм бэ? 10 жил та нар энэ ЗГ-ыг барьж байгаа шүү дээ.

Энэ шинэ ЗГ нь хэмнэлтээс эхлэх ёстой байх гэж би бодож байна. Тэгэхгүй бол бензиний үнэ өслөө, өргөн хэрэглээний бараа, материал өслөө, ЗГ хэмнэх ёстой. Тэгээд 1 уриалга гаргах гэж байгаа юм. Нэг байгууллага нэг машин гэдэг уриалга гаргаач. 2,2 их наядын машинтай, зөвхөн сүүлийн 2020 оноос хойш 225 тэрбум 631 сая төгрөгийг зөвхөн бензин шатахуун төрийн байгууллагад зарцуулсан

байна шүү дээ. Нөгөө мөнгөгүй гээд байсан, мөнгө чинь хаана байгаа юм бэ? Яамнууд энэ сайд нар алхаж ирээч, хамгийн хол яам Дарханд байгаа гэж тооцвол Батлан хамгаалахын яам шүү дээ. Нэгхэн километрийн радиус дээр бүгдээрээ том, том жийп унаад яваад байх юм.

2 дугаарт хулгай том, жижиг гэж байхгүй яг ний нуугүй хэлэхэд. Өнгөрсөн жилийн сүүлийн 10 жилийн бүх хулгай та нартай холбогдоно. МАН-ын дарга байсан, Монгол Улсын Ерөнхий сайд байсан хүмүүс хуу хамчхаад, буухдаа хүртэл унаж байсан машинуудаа бараг хулгайлаад буучхаж байгаа шүү дээ. Жижиг, том хулгай гэж байхгүй. 0007 УНУ гэдэг төрийн тусгай хамгаалалтын дугаар Санжийн Баяр дээр чинь байгаа, 0008 УНУ гэдэг дугаар танай намын дарга байсан Батболд дээр чинь байгаа, 0012 УНУ гэсэн дугаар та танай намын дарга байсан Миеэгомбын Энхболд дээр байгаа. Үгүй ээ ядаж машины дугаарыг нь хулгайлахаа үлдээхээ болиоч. Үгүй ээ ямар ичдэггүй юм бэ энэ чинь. Хэдэн зуун сая доллароор нь хуу хамснаа л та нар хоорондоо яриад байгаа шүү дээ. Хэн, хэн яаж хулгайлснаа гэрчлээд байгаа шүү дээ. Үгүй ээ тэгээд ядаж машины дугаарыг нь энд нь төрийн тэр тусгай хамгаалалтын байгууллагад нь үлдээгээч. Үгүй ээ энэ чинь ямар ичиж зовдоггүй юм бэ?

Өнгөрсөн саруудад бүгдээрээ гэмт хэрэгтэй олон ангит кино үзлээ. Би дахиад хэлье, одоо эвлэрээд, мөрөө алгадаад нэг танхимд хамт суух юм байна л даа. Тэгээд энэ асуултуудад нь хариулт аваадахъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя. Дараа нь ХЗДХ-ийн сайдад нэр дэвшигч Амарсайхан бэлдэж байгаарай.

Н.Учрал: 5 хоног сайдгүй байхад ажил гацлаа гэж Шижир гишүүн хариуцлагатай үгийг хэлж байна. Тийм учраас энэ гацааг үргэлжлүүлэхгүйн тулд Засгаа бүрдүүлж байна. Тийм учраас сандал суудал ярьдаг биш, санал шийдэл ярьдаг, улс төр биш ажил хийх, гацаадаг биш гарц гаргадаг ЗГ байхыг л хичээнэ. Элдэв янзын энтертайнмент попрол байхгүй. Миний хувьд би ажил авсан бол тухайн ажлаа хариуцлагатай хандаж, үр дүн гаргахыг хичээж ирсэн. Тэр зарчмаа л барина. Энэ хурдыг, энэ бүтээмжийг манай сайд нар кабинетын зарчмаар дагаж хамтарч ажиллана гэдэгт би итгэдэг. Хариуцлага ёс зүй 1 дүгээр асуудал. Тийм учраас хариуцлага алдсан, салбараа удирдаж чадаагүй, манлайлал үзүүлж чадаагүй бол толгойг нь илээд байх юм байхгүй, шат шатанд нь хариуцлага тооцоод явна гэдгийг би танд хариуцлагатайгаар хэлье.

Тэгээд улс төрд удаан явсан, олон жил Их Хурлын гишүүнээр сонгогдсон, анхан шатад ажиллаж байсан ер нь улс төрч бүхэн л нийгмийн нүдэн дээр байгаа учраас нөгөө нийгэм өөрөө шүүдэг, иргэд эрүүлээр шүүмжилдэг. Тэгэхээр улс төрд удаан явсан хүн бол цав цагаан нэртэй байх боломж төдийлөн байдаггүй юм шиг байгаа юм. Ялангуяа энэ мэдээллийн эрин зуунд шүүмжлэх нь нээлттэй болсон. Энэ ч утгаараа Улсын Их Хурлын гишүүд дотроосоо тойргоос сонгогдож байсан, анхан шатанд ажиллаж байсан, ард түмний ахуй амьдралыг мэддэг, ер нь гүйцэтгэх засаглалын ажил гэдэг зүгээр ярьдаг биш, хийдэг, барьж аваад гүйцэтгэдэг ажил, үр дүнгээрээ дандаа ажлаа үнэлүүлдэг, гоё сайхан ярихдаа биш. Тэгэхээр одоо манай ЗГ зөвхөн ажлын үр дүнгээрээ үнэлүүлнэ.

Тэгээд Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг эрүүлээр шүүмжилж, болохгүй зүйлийг нь болохгүйгээр хэлж, зөвийг нь зөв гэж хэлж хамтарч ажиллахыг би хүсэж байна. Манай сайдууд ч гэсэн, манай кабинет ч гэсэн үнэн байхыг эрхэмлэнэ.

Чадахгүй зүйлийг чадахгүйгээр нь хэлж, чадах зүйлээ чадна гэж урагшлуулах ёстой. Тэгээд олон жил улс төржлөө. Би ЗГ-ынхаа тогтвортой байдлыг хангахыг нэгд эрхэмлэсэн. Одоо бид сандал суудал яриад сууж байх эрх алга. Тэр юу вэ гэвэл энэ түрж орж ирж байгаа дэлхий нийтэд үүсээд байгаа асуудал энэ түлш шатахууны нэмэгдэл бол ард түмний амьдралд тулгараад байгаа үнийн өсөлтийг бий болгоно. Үүнээс бид сандал суудал биш, санал шийдлээ ярьж урагшлах ёстой. Тэгээд кабинет доллар шиг хүн бүрд таалагдах албагүй. Манай кабинет зөвхөн үнэнийг ярина, ажил хэрэгч байна, энтертайнмент попорлоос холдоно, ажлаа хийнэ, бага ярина, ажлаа үр дүнгээрээ үнэлүүлнэ л гэдгийг хэлье.

С.Бямбацогт: ХЗДХ-ийн сайдад нэр дэвшигч Амарсайхан хариулъя.

С.Амарсайхан: Төрт ёс, хууль журам, ёс суртахуун гэдэг зүйлийг 1 дүгээрт тавьж ажиллана. 2 дугаарт шүүхээр нотлогдоогүй, эцэслэгдээгүй аливаа гэмт хэрэг, хэн нэгний хардлага сэрдлэг, гүтгэлэг эсвэл гэмт хэрэгтэй холбоотой асуудлуудыг урьдчилан хэн нэг нь ялладаг, эсвэл шүүх, хуулийн байгууллага юм шиг загнадаг ийм хандлагыг нийгэмд өөрчлөх ёстой гэж үзэж байгаа. 3 дугаарт мэдээж шүүмжилж болно, гүтгэж болохгүй, хардаж болно, доромжилж болохгүй. Тийм учраас энэ нийгэмд үнэхээр хууль журам нь байхгүй болчихсон юм уу, эсвэл бүгд хулгайч, дээрэмчдээр дүүрчихсэн юм уу, эсвэл гүтгэлэг доромжлолоор дүүрчихсэн юм уу гэдгийг хууль хяналтын байгууллагууд шалгаж тогтоох ёстой.

С.Бямбацогт: Тодруулчих уу? Гүйцээгээд хариулчих уу? Гүйцээгээд хариулчихъя. Амарсайхан нэр дэвшигч.

С.Амарсайхан: Шижир гишүүний ярьж байгаа асуудлыг би одоо ямар ч мэдээлэл алга байна. Энэ асуудлуудаар дараа нь тодорхой тайлбар өгч болох байх гэж бодож байна. Тийм.

С.Бямбацогт: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Би яриагүй, таны нэг Засагт хамт суух гэж байгаа наад хүмүүс чинь хоорондоо илчилсэн юм бие биеэ. Хэвлэл мэдээллийн байгууллага дээр илчилсэн юм, телевизүүдээр илчилсэн юм, олон нийтийн социал медиагаар илчилсэн юм. Хэн нэгэн зохиож яриагүй, тантай хамт нэг засагт суух гэж байгаа хүмүүс энэ бүгдийг хоорондоо бие биедээ илчилсэн. Тийм учраас та надаас асуулт асуух хэрэггүй.

Дэлхий нийтээрээ энэ геополитикийн нөхцөл байдал хүндэрч байна. Түлш шатахуун үнэд орох гэж байна. Тэгтэл нэг яс булаацалдсан ноход шиг л хэд хоног та нар хоорондоо зодолдлоо шүү дээ. Тэгээд цаашдаа яах юм бэ, үнийн өсөлт дээр яах юм бэ? Монгол Улс алт, зэс, нүүрс гээд гуравхан юм зардаг. Энэ дээр Аж үйлдвэрийн яам нь ямар бодлоготой байгаа юм бэ? Нөгөө хэдэн цаасаа эргүүлж тойруулж хараад суугаад байх юм уу, эрс шийдэмгий бодлого хийх юм уу? Ийм юмнуудаас нэг тодорхой хариултууд авмаар байна. Тэгэхгүй бол одоо ингээд нэг талаас өрөвдөлтэй юм даа, нээрээ энд тэгээд л нэг хэдэн хүмүүс хэдэн биеийнхээ хулгайг яриад л, юу ч болоогүй юм шиг нэг засагт одоо тэврэлдээд суух гэж байгааг нь харахаар.../минут дуусав/

С.Бямбацогт: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад нэр дэвшигч Дамдинням хариулъя.

Г.Дамдинням: Шижир гишүүний асуултад хариулъя. Манай улс байгалийн баялгийн олборлох салбараас хамааралтай эдийн засагтай ингээд явж байгаа. Харамсалтай нь бидний буруу, зөв олон популизмаас шалтгаалж энэ салбараа өөрийг нь хөгжиж дэвших ямар ч боломжгүй болгочихсон 1 дүгээрт. Тийм учраас өмнөх ЗГ-ын үед боловсруулаад бэлэн болгоод яамдаас бүх саналаа авчихсан байгаа. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг яаралтайгаар УИХ-д өргөн барьж хайгуул, хөрөнгө оруулалтыг татах, шинэ мөнгө оруулж ирэх тэр дундаа АМНАТ-ийг оновчтой болгох, зэсийн салбарын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /амнат/-ыг бодитой болгох, бусад шинэ төслүүдийг хөдөлгөх энэ боломжийг нээсэн ийм өөрчлөлтүүдийг хийсэн Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт орж ирнэ. Үүний араас.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Дамдинням нэр дэвшигч нэг минут.

Г.Дамдинням: Үүний араас бид зөвхөн ухаад, шууд экспортолдог ийм орон байгаад байгаа. Тэгэхээр бидний хувьд олборлосон түүхий эдээ ядаж хагас боловсруулдаг, улсын хэмжээнд энэ Биржийн тухай хуулийн нөхцөл байдлаас шалтгаалаад 47 боловсруулах үйлдвэр хаалттай байна. Энийг нээнэ, дотоодын борлуулалтыг зөвшөөрнө, Амнатыг шударга, зөв болгоно, энэнд чиглэсэн өөрчлөлтүүд орно. Мөн араас нь Хүнд үйлдвэрийн тухай хууль орж ирнэ. Хүнд үйлдвэрийн тухай хууль Монгол оронд үгүйлэгдэж байгаа боловсруулах, үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэх бодлоготой, хөрөнгө оруулалтыг татах чиглэлтэй ийм хуулиуд байгаа. Гангийн төсөл явна, ган хайлуулах үйлдвэрийн төсөл явна, зэс хайлуулах үйлдвэрийн төсөл явна, алт боловсруулах үйлдвэрийн төсөл явна, хөнгөн цагааны хайлш бэлтгэх үйлдвэрийн төслүүд явна. Зарим нь тендер нь зарлагдчихсан яваа, зарим нь тун удахгүй зарлагдахад бэлэн болчихсон ингээд явж байгаа.

С.Бямбацогт: Цэнгүүн гишүүн асуултаа асууя. Үг хэлж болно.

С.Цэнгүүн: 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа хэрэгжих болоогүй юм байна гэдгийг өнөөдрийн томилгооноос ер нь харж байна. Тэгээд энэ асар харамсалтай л байна л даа. Учрал Ерөнхий сайдыг өөрийнхөө баг бүрэлдэхүүнийг бүрдүүлээд, залуу хүний хувьд эрс шинэчлэл хийгээд ажиллах болов уу гэдэг хүлээлттэйгээр таныг Ерөнхий сайд болохыг дэмжсэн. Гэхдээ энэ баг бүрэлдэхүүнийг хараад бол танай ЗГ-ыг дэмжиж ажиллаж чадахгүй юм байна гэдэг дүгнэлтэд хүрч байна.

Тэгээд яагаад вэ гээд тэгэхээр гайхаад л байна ер нь. Б.Энхбаяр сайдаас асуумаар байна л даа. Таны эхлүүлсэн байсан тэр олон хулгайн ажлуудыг чинь одоо энэ Амарсайхан сайд болох гээд сууж байна. Энэ хүн үргэлжлүүлж явах болов уу? Та энэ дээр юу гэж бодож байна вэ? 5 жил тасралтгүй ажилласан Жавхлан сайд маань ажлаа өгч байгаа юм байна. Тэгээд үргэлжлүүлээд ажиллах хүн нь ядахдаа нэг санхүү баланс уншаад чаддаг мэргэжлийн, туршлагатай хүмүүс энэ МАН дотор байдаггүй юм уу гэдгийг би гайхаж байна. Чойжилсүрэн сайд маань ажлаа өгсөнд бол баяртай байна, одоо ингээд аргална даа, болно доо гээд станц дээр авчраад ламаар ном уншуулаад суугаад байдаг байдлаасаа нэг гарах болов уу гэдэг хүлээлт үүсэж байна. Тэр утгаараа Найдалаа гишүүн маань хэрвээ томилогдвол энэ эрчим хүчний салбар дээр эрс өөрчлөлтүүдийг зоригтой хийгээсэй гэж хүсэж байна. Яагаад гэхээр энэ ТӨК-уд дээр нь үүрлэсэн энэ ажлын байрны давхардал, хийдэл, ажил хийдэггүй хэр нь цалин аваад явдаг хүмүүсийг цомхотгооч гэж Чойжилсүрэн сайдад хэлж байхад үгүй ээ би сайд байхдаа энэ олон хүнийг цомхотгож чадахгүй

гэж хэлдэг ийм тайлбар хэлдэг байсан. Тэгвэл та очоод энэ ТӨК-удын ашигт ажиллагаа, дээрээс нь бүтцийн оновчлол дээр нь шууд алхмууд хийгээд явах бэлэн судалгаа, бүүр тайлангууд юмнууд нь байгаа. Тэгээд тэрийг хэрэгжүүлээд яваасай гэж хүсэж байна.

Яагаад гэхээр өнөөдөр манай Монгол Улсад тулгамдсан нэг номерын асуудал эрчим хүчний асуудал байна. Дулаан цахилгаангүй өвөлждөг болчихлоо. Тэгээд байж байтал бид Туулын хурдны замд 2,3 их наяд төгрөг зарцуулна гээд суугаад байна. Учрал Ерөнхий сайд энэ дээр ямар бодолтой байгаа юм бэ? Энийгээ хэлбэл сайн байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Гадаад орчин, геополитикийн нөхцөл байдал ийм байгаа үед гадаад хямралыг бид дотоод сахилга бат, эв нэгдлээр л давж туулах ёстой. Тийм учраас ЗГ-ын тогтвортой байдал надад юу юунаас илүү эрхэм байна. Бидний энэ дотоод зөрчил, зохион байгуулалтгүй, сахилга батгүй байгаа байдлыг гадаад орчин ойлгохгүй. Тэгэхээр дотооддоо илүү сахилга баттай, хариуцлагатай байхыг бид эрхэмлэх ёстой. Гишүүд маань эрт дүгнээд яах вэ. Би тодорхой хугацаанд кабинетаа тэргүүлээд ажиллая, тэгээд та бүхэн хяналтаа тавь, дүгнэ. Эргэлзэх, шүүмжлэх нь эрх чөлөөт нийгэмд хэвийн үзэгдэл. Тийм болохоор би эрүүлээр хүлээж авна. Ажлаа юутай ч эхэлье. Цаг хугацаанд нь та бүхэнд тайлангаа тавья. 2025-аас 2030 оны улсын хөгжлийн үндсэн чиглэлийг Их Хурал баталсан, 5 жилийн чиглэлийг би өөрөө бичсэн. Тийм учраас би индикаторуудтай, түүгээрээ ажлаа үнэлүүлнэ.

Тэгээд энд байгаа кабинетын гишүүдийг та бүхэн харж байгаа. Сайн, муу хэлүүлээд улс төрд хал үзэж халуун чулуу долоосон л улс төрчид. Тийм учраас нэг их сошиалын сенсацаар амьдраад байхгүй, урдах ажлаа хийгээсэй л гэж би бодож байгаа. Тэгээд амьдрал мэддэг хүмүүс. Манай кабинет ид шид, их гайхамшиг амлаж чадахгүй. Энэ хүмүүс эерэг зөөлөн цаг үед огт сайдаар томилогдоогүй, хамтдаа салхи шуурга сөрж ажиллахаас, илүү гал атгах л хүмүүс. Тэгэхээр улс төрд олон жил чанагдсан, ард түмнээсээ сонгогдсон, түмэн олондоо ажил үйлсээ үнэлүүлээд дүгнүүлээд ирсэн ийм л улс төрчид. Тэгэхээр нэг сошиалаар нэг сенсацад хөөгдөөд, эсвэл нэг хэдэн өдрийн ачаалал даахгүй, гал ус руу орж чадахгүй тийм хүмүүс байхгүй гэж би бодож байгаа. Тийм учраас хариуцлагатай үед суралцаад байх цаг байхгүй. Тэгээд анхан шатаас нь авхуулаад бүх түвшинд төр улсдаа олон жил ажилласан улс төрчид учраас ачаа үүрнэ л гэж би сонгосон. Тийм учраас бүгдээрээ л тойргоос сонгогдсон гишүүд, бүгдээрээ л төрдөө багадаа 20-оос доошгүй жил ажилласан ийм л кабинет бүрдүүлээ.

Тэгээд би 4 чөлөөлөлтийн бодлого, тэгээд тантай би санал нэг байгаа. Эрчим хүчний салбарыг би тэргүүлэх чиглэл болгоно. Тийм учраас энэ ногоон хөгжлийн чөлөөлөлт гэдэг бодлогоо дэвшүүлсэн, Их Хурал тогтоол гаргасан. Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг дэмжих, энэ эрчим хүчний алдагдлаа бууруулах чиглэлээр дэвшилтэт үзэл санааг эрхэмлэнэ. Тэгээд өнгөрсөн хугацаанд хийж байсан ажлуудаа үргэлжлүүлнэ. Авлигын эсрэг чөлөөлөлт, эрх зүйн чөлөөлөлт, эдийн засгийн чөлөөлөлт гэсэн 4 чиглэлээр хурдтай шуурхай ажиллана. Тэгээд та бүхэн маань бид эерэг зөөлөн цаг үе биш, энэ салхи шуургыг даваад ард түмэнтэйгээ хамт гарна, тэгээд та бүхэн шүүн тунгаагаарай л гэж хүсье.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Би их үнэ цэнээр олон үнэнийг илчилсээр ирсэн. Сая бас илчилж байгаа ийм улс төрч. Өнгөрсөн хугацаанд далд байсан маш олон зүйлийг өнгөрсөн парламентын үед ил болгосон, олон ч дайсантай болсон. Өнгөрсөн хугацаанд нийгмийн оюун санааг энэ Оюун-Эрдэнэ ба түүний ах 15 давхрын дээрэмчид яаж бузарлаж, гүтгэлгийн хар ийм зохиолуудаар нийгмийн оюун санааг бузарлаж байсан бэ гэдгийг нотолсон өдрүүд болж өнгөрсөн. Энд би өөрөө Улсын Ерөнхий сайд байсан, манай намын дарга байсан ийм амьд тролл өөрөө байсан.../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулах уу, болчихсон уу? Гүйцээгээд хариулчихъя.

Б.Энхбаяр: Намайг миний огт уулзаж үзээгүй Баясгалан, Нямжав, Амундра, Сумъяабазар нараас нийлбэр дүнгээрээ хэдэн тэрбум, их наядын хулгай авлига авсан гэж гүтгэж, бичлэг нь байна, би өгч байна, яг өгч байна. Тэр хүн юу ч өгөөгүй, зохиолуудаа үргэлжлүүлсээр байгаа. Тэр хүн хуулийн байгууллагад ямар ч нотлох баримт өгөөгүй. Энийгээ яах гэж хийсэн бэ гэдэг нь өнөөдөр харагдаж байгаа. Хууль зүйн сайдаас Энхбаярыг л буулгачихвал амь гарах гэж байгаа юм шиг үүрд санагдаж байгаа. Сүнс нь зайлчихсан. Энд нь манай АН-ынхан битгий тусалчхаасай гэж би бодож байгаа юм. ЗГ-ыг, УИХ-ыг ард түмэнтэй нь.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэр дэвшигч Мэндсайхан хариулъя.

З.Мэндсайхан: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр эдийн засгийн нөхцөл байдал, олон улсад үүсээд байгаа энэ Ойрх Дорнодод үүссэн зэвсэгт мөргөлдөөнөөс дэлхий нийтээрээ эдийн засгийн хүндрэл хүлээж байна. Ялангуяа ойрд шатах тослох материалын үнэ өсөх бодит хүндрэлүүд биднийг хүлээж байгаа. Сангийн сайдаар ажиллаж байсан Жавхлан сайд маань сайн ажилласан, ковидын хүнд үеийг давж гарсан. Энэ хүний бодлогыг хэрэгжүүлээд, цааш нь ЗГ-ын бодлогоо хэрэгжүүлээд явна. Мэдээж татвар төлөгчдийн орлогоор бүрдэж байгаа энэ төсвийн зарцуулалт нээлттэй, ил тод хариуцлагатай байх ёстой, энэ зарчмыг барьж ажиллана. Та бас Ерөнхий сайдын танилцуулгаас анзаараагүй юм шиг байна. Миний хувьд СЭЗДС төгссөн, эдийн засагч мэргэжилтэй. Өмнө нь Сангийн яамандаа Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргаар ажиллаж байсан. Мөн Төрийн нарийн бичиг.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

З.Мэндсайхан: Салбарын сайд болон салбарын ТНБД-аар ажиллаж байсан, төсвийн шууд болон шууд захирагчийг ажлыг өндөр хариуцлагатай ажлуудыг хашиж байсан. Сангийн сайдын ажлыг Ерөнхий сайддаа ачааны хүндийг нь үүрээд, энэ ажлыг хариуцлагатай хийгээд явах болно. Тэгээд танд шаардлагатай бол дараа илүү нарийн мэдээллүүдийг эдийн засгийн үзүүлэлт дээрээ гаргаж өгье.

С.Бямбацогт: Амарсайхан нэр дэвшигч хариулъя.

С.Амарсайхан: Би нэг зүйлийг маш тодорхой хэлье. Хуулийн сайд, Хууль зүйн яам, тэр дундаа Хуулийн сайд ялангуяа гэмт хэрэг, хэрэг зарга ярихгүй, бодлого ярина. Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй, нөлөөлөхгүй ийм шаардлага тавина. Хэрэг илрүүлэлт, мөрдөн байцаах үйл ажиллагаа, прокурорын хяналт, шүүхийн шийдвэр, Шүүхийн шийдвэрийн ерөнхий газрын үйл ажиллагаа хэнээс ч хараат бусаар ил тод, нээлттэй явах, тэр дундаа шилэн байх, тэгээд Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг хангах, дээрээс

нь хууль хэрэгжүүлэх ийм шаардлагыг тавьж ажиллана. Цаашдаа хэн нэгэн улс төрч УИХ, Төрийн ордонд яллагч шиг, хуулийн байгууллага шиг, мөрдөгч шиг.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

С.Амарсайхан: Битгий ярьдаг байгаасай гэж би бодож байгаа. Энийг бид таслан зогсоох ёстой гэж бодож байна. Хуулийн байгууллагуудыг бие даасан үйл ажиллагаагаа явуулах орчин нөхцөлөөр нь би хангаж ажиллана гэж бодож байгаа. Хоорондоо уялдаа холбоотой ажиллана гэж үзэж байгаа. Төрийн ордонд улс төрчид, түшээд төрт ёсныхоо, эрх зүйт төрийнхөө бодлого шийдвэрийг гаргадаг. Хариуцсан салбарын Хууль зүйн яам бодлогоо тодорхойлдог, бусад харьяа агентлаг, шүүх эрх мэдлийн байгууллагууд нь хуулиар олгогдсон эрхээ бүрэн хэрэгжүүлдэг байх энэ зарчмыг хатуу барьж ажиллана. Хууль барьсан хүний өмнө хутга барьсан хүн хүчгүй гэдэг байсан бол одоо утас барьсан хүн хуулийн өмнө хүчгүй болж байна. Иргэний эрх зөрчигдөж байгаа, улс төрчид өөрсдөө микрофоны ард, Улсын Их Хурлын танхимд хулгай дээрэм ярьдаг, батлагдаагүй асуудлуудаар бие биеийгээ гүтгэдэг. Хэрвээ гүтгэсэн бол тэр нь тогтоогддог байх ёстой. Шүүх хуулийн байгууллагаар эцэслэн шийдэгдээгүй бол хэн ч хэнийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Болсон уу? Батбаатар гишүүн асуултаа асууж, үг хэлье.

Б.Батбаатар: 1998 оны 10 сарын 2-ны өдөр ардчилсан хувьсгалын удирдагч Санжаасүрэнгийн Зориг бусдын гарт хэрцгийгээр алагдсанаар түүний журмын нөхөд, фракцынхан гэж ярьдаг үзэл санааг нь тээгч нар Иргэний Зориг, ногоон намыг үүсгэн байгуулж бүтээсэн юм. Ингэж Иргэний Зориг, ногоон нам шударга ёсны тэмцлээс төрж гарсан, өөрөөрөө төрж гарсан нам. Өнөөдөр надаас Иргэний Зориг, ногоон намын даргын хувьд намын гишүүд, журмын нөхдүүд, иргэд сонгогчид, итгэж дэмжиж, саналаа өгч энэ намыг Их Хуралд 4 суудалтай болгосон хүмүүс асууна. Иргэний Зориг, ногоон нам яагаад засагт хамтарсан юм, яагаад засгаас гарсан юм гэж. Үүн дээр би Ерөнхий сайдыг хариулт өгөөсэй гэж бодож байгаа. Тан дээр очсон бичгийн дагуу Иргэний Зориг, ногоон намын бланкийг эрхгүй этгээд ашиглаж, бичиг өгснөөр Иргэний Зориг, ногоон нам засагт хамтрах саналаасаа ухарсан гэж тайлбарласан. Ийм утга агуулгатай зүйлийг хэлсэн. Тийм болохоор Иргэний зоригийг дэмжигчид энэ хүн хэн бэ гэдгийг мэдэх ёстой.

Ер нь тэгээд Учрал даргын ЗГ урвалт шарвалт дундаас босож ирж байна даа. Урвагч хажууд, ард явахад урагш алхах зам байдаггүй юм шүү. Хамгийн эхний хазгай илтгээн дээр халтиргаад түлхчихдэг. Энэ Засгийн газруудын түүхүүд ийм шүү дээ. 2004-өөс 8 онд би 3 Их Хурлын дарга, 3 Ерөнхий сайдын нүүрийг харж байлаа энэ танхим дотор. Ард нь 7 сарын 1 болсон. Урвалт хаанаас үүсдэг вэ гэхээр зорилго, хүсэл мөрөөдөл, тэмцлийн дүнд үүсдэггүй, урвалт хувийн ашиг сонирхол, хулгайн замаар явсан тэр газраас урвагч нар төрдөг. Түрүүн АН дотор бэт байна гэж байна, магадгүй манай дотор аль аль нь бэтээ тавьсан юм байна. Тэгэхдээ 28 жилийн тэртээ хэргээс болж үүсэж гарч ирсэн энэ төрсөн нам үзэл санаа, итгэл үнэмшил, зарчим, үнэт зүйлээсээ ухрахгүй. Тэрийг тээсээр явна, цаашдаа ч тээх болно. Энэ улс төрийн шалтгааныг хариулаад, тодорхой хариулаад өгчхөөсэй гэж Ерөнхий сайдаас хүсэж байна.

Дараагийн асуудал нь ЗГ дээр одоо арай ажил хэрэгч зүйлүүд, ЗГ дээр янз бүрийн үндэсний хороод байдаг% 50 гаруй үндэсний% 40 гаруй үндэсний хороо байж байгаад сүүлд 28, 9 болж багассан. Энэ үндэсний хороодыг болж өгвөл

бүгдийг нь татан буулгах хэрэгтэй. Нэг давхардсан чиг үүрэгтэй, олон яамдыг хамарсан ийм зүйлүүд болоод байгаа. Үндэсний хороо чинь өөрөө ЗГ байхгүй юу. Үндэсний хорооны зохицуулагч нь ЗГХЭГ, тэгээд бие биеийнхээ салбарынхаа сайдууд бие биедээ чөдөр тавьчихсан, ажил явахад төвөгтэй, олон төрлийн үндэсний хороодоо татан буулгаж, буулгах талаар хэрвээ бодчихсон хариулж өгөөрэй, бодоогүй бодож үзээрэй гэж хэлж байна.

СОР 17 дээр дэвшүүлж байгаа Монголын санаачилгуудыг ажил болгоорой. Ялангуяа устай холбоотой хэсэг туйлын чухал асуудал шүү. СОР 17-г зохион байгуулахаар ажиллаж байх явцад одоо манай улсаас дансны дугаараа явуул гээд бичгүүд нь ирчихсэн бичгүүд ч байгаа. Саудын Арабаас 2 сая доллар, Хятадын С... байгууллагаас 3 сая доллар, Ассоциациас 1 сая доллартой тэнцэх Монгол төгрөг, мөн дөнгөж саяхан Люксембургээс 2, 3-хан хоногийн өмнө 2 нэмэх нь 5 сая евро 7 сая хүртэл евро, мөн СОР-н үеэр 200 орчим сая еврогийн хөрөнгө оруулалт хийнэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Иргэний Зориг, ногоон нам Занданшатар Ерөнхий сайдын ЗГ-т Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарыг удирдаж ажилласан. Тэгээд Сор-н бэлтгэл гээд Батбаатар сайд хариуцлагатай ажилласан. Намын даргын нэр дээр танай Иргэний Зориг, ногоон нам гэсэн албан бланктай бичиг ирсэн. Тэгээд дотооддоо бид асуудлаа шийдэх ёстой байх л гэж би үзэж байгаа. Яагаад вэ гэхээр энэ дэлхийн цаг төрийн байдал биднээс үл шалтгаалан өөрчлөгдөж байна. Энэ тодорхойгүй байдал маш тодорхой болчихлоо. Тийм учраас бид дотооддоо энэ зөрчил үүсгээд байх биш, хамтарч энэ гадаадад үүсээд байгаа хямралыг давж туулах ёстой. Ингэж байж иргэдээ энэ үнийн өсөлтөөс хамгаална. Тийм учраас энэ 5 нам, эвсэл ч тэр чигээрээ, манай сөрөг хүчин ч тэр чигээрээ энэ ард түмнийхээ ахуй амьдралыг дээшлүүлэх, энэ бензин шатахууны үнийн хөөргөдлөөс энэ дэлхий дахинд үүсээд байгаа асуудлаас болж энэ ард түмний амьдралд энэ үнийн өсөлт маш хүндээр тусна. Тэгээд үүнээс бид хоорондоо өрсөлдөх биш, асуудалтай өрсөлдөх ийм цаг байгаа юм.

Тэгэхээр танай нам дотооддоо ийм зөрчилтэй байхад бид цаашдаа нөгөө дотоод асуудлаа энэ гадаад хямралыг давахад энд бэрхшээлтэй. Тийм учраас нэг бодлогоор асуудлаа дотооддоо шийдээд, ингээд хамтраад явах нь зөв болов уу гэж би үзсэн. Тэгээд намын даргын хувьд ч тэр, Ерөнхий сайдын хувьд ч тэр энэ удаа шууд маргаашаас ажил эхэлж байгаа учраас хэд хоног би ч ганцаараа үзэж тарлаа шүү дээ. Өнгөрсөн хугацаанд нэлээдгүй л цаасан дээр суулаа, ажлаа төлөвлөлөө. Тэгэхээр нөгөө цаг биднийг хүлээхгүй байна. Цаг биднийг хүлээхгүй, тэгээд дотооддоо нэг ийм зөрчил үүсгээд байх тийм цаг байхгүй байна. Тэгээд намын дотроо эв нэгдлээ цогцлоогоод ажиллаасай гэж би хүсэж байна. Би ч гэсэн намын даргын хувиар дотоодод үүсээд байгаа энэ зөрчил, үл ойлголцлыг шийдвэрлэх бол миний нэгдүгээр зорилт.

Яагаад гэхээр гадагшаа хамт асуудал руу нүүр тулж ороход чинь энэ дотоод зөрчил маш төвөгтэй байна. Тэгээд үүнийг ард түмэн хараад үгүй ээ та нар асуудалтай нүүр тул л даа, энэ нэг зөрчилд нэг маргаанаа зогсоо л доо гэсэн юм ийм л зүйл хэлж байгаа юм. Тэгээд үүсгэн байгуулагч Санжаасүрэнгийн Зориг бол улс орны эрх ашгийг эн тэргүүнд тавья гэж хэлсэн үг нь бий. Тийм учраас нэгд улс орныхоо эрх ашгийг тэргүүн ээлжид эрэмбэлнэ. 2-т намын эрх ашиг, 3-д тэр хувийн

эрх ашиг шүү. Тийм учраас улс орныхоо эрх ашгийг нэгд тавьж хамтарч ажиллая гэж намууддаа уриалж байна.

С.Бямбацогт: Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Хариултыг хэлж өгсөнд баярлалаа. Энийг Ерөнхий сайдад, МАН-ын даргад манай намын бланкийг ашиглах эрхгүй этгээд хэрэглэж болохгүй шүү дээ, танай намын бланкийг би ашиглаад, үгүй бол хэн нэгэн хүн ашиглаад надад ирэхэд би хариулаад байж болохгүй шүү дээ. Ашигласан юм гэдгийг нь энд сууж байгаа Р.Батболд гэж этгээд, урвагч, хувийн ашиг сонирхол хөөцөлдөгч, тендерийн наймаачин энэ хүний хийсэн ажил гэдгийг ойлгож байгаа. Энийг Иргэний Зориг, ногоон намынхан, итгэж дэмжсэн сонгогчид мэдэж авах хэрэгтэй. Тийм болохоор хариулт өгсөнд баярлалаа. Ингээд СОР 17-г зохион байгуулахад 16 СОР-оос 15 СОР-ыг нь Байгаль орчны сайд удирдсан байдаг юм шүү хурал даргалагч, Ерөнхийлөгч. Энийг ингэж Гадаад хэргийн сайд руу өгөх нь буруу шүү. Та Сандаг-Очир сайдад өгч.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Батбаатар сайд өнгөрсөн хугацаанд СОР 17-гийн бэлтгэл ажлын хүрээнд олон улсаас хөрөнгө оруулалт татах, санхүүгийн дэмжлэг авах чиглэлээр санаачилгатай ажилласан. Олон талууд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэнд би баяртай байгаа. Энэ бол Батбаатар сайдын үр дүн. Тийм учраас үүнд төрийн ажлын залгамж чанарыг хадгалж Сандаг-Очир гишүүн онцгойлон анхаарч ажиллах хэрэгтэй. Тэгээд Сандаг-Очир гишүүн хариуцлагатай салбарыг удирдана. Тэгэхээр Батбаатар сайдын эхлүүлсэн байгаа энэ ажлуудыг үр дүнд хүргэж, энэ СОР 17-г зохион байгуулах, энэ цөлжилттэй тэмцэх энэ бага хурлыг 10 мянга гаруй зочид, төлөөлөгчид ирэх гэж байгаа томоохон хурал Монголд болох гэж байна. Тэгээд Сандаг-Очир дарга нийслэлийн Төлөөлөгч байсан, дүүргийн дарга байсан аж ахуйч хүн. Тэгэхээр маргаашаас ажилдаа ханцуй шамлан орох байх гэж итгэж байна. Тэгээд Батбаатар гишүүнээс сайн зөвлөгөө авах хэрэгтэй гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа Цогтбаатар, Да.Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе. Юуны өмнө Улсын Их Хурлын шинэ даргаар томилогдсон Бямбацогт даргад баяр хүргэж, ажлын амжилт хүсье. 2, 3 үг хэлье. Та хуралдаан даргалагч болсон, эрх мэдэлд очоогүй. Одоо та наанаа очингуутаа л гишүүдээ чангална донгодно гэсэн юм яриад эхэлж байна лээ. Эхнээсээ зөв явахгүй бол та буруу явах гэж байна. Буруу явбал та наанаа 2 жилийн дотор суух гэж байгаа 3 дахь дарга.

Миний бодлоор таны ажил энэ төрд дэг журмыг тогтоох. Энэ сүүлдээ ийшээ чинь хүмүүс орж ирэхээрээ бие засах газар орох гэж байгаа юм шиг орж ирдэг болж байна шүү дээ. Хааччихсан гэхээр бие засах газар орчихсон. Төрийн ордонд биш, энэ чинь энэ төрийн төлөөний өмнөөс Төрийнхөө ордонд орж ирж байгаа хүмүүс зүгээр нэг эмэгтэй гишүүн төр төлөөлөөд сууж байхад маасайтал инээгээд сууж байдаг болчихсон. Энэ мэт энэ нэг дэг журамгүй юмнуудыг та дэглэж, журамлах ёстой болохоос биш энэ ард түмнээсээ мандат аваад ороод ирчихсэн гишүүдийг дэглэх, журамлах, хариуцлага тооцох, донгодох албан тушаалтан та биш шүү гэдгийг танд хариуцлагатайгаар хэлье. Тэгээд ажилд нь амжилт хүсье.

ЗГ яах вэ өвчин хэлж ирэхгүй, хийсэж ирдэг тэр ойлгомжтой гэсэн чинь сайд нь харин яг өвчин шиг гарч ирэх юм даа гэнэтхэн. Энэ Ерөнхий сайдын үгэнд нэлээн хэд гарлаа салбартаа хуримтлуулсан туршлагыг гээд. Энэ Эрүүл мэндийн сайдад халууны эмд явсан туршлага ч бараг байхгүй байх даа. Атаархаад байгаа юм биш, би зүгээр гомдоод байна. Санхүүгийн салбарт та мэдлэг боловсрол сайн байх, тэгэхдээ эрүүл мэнд тусдаа асуудал. Жишээлэхэд та яах юм бэ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ эсвэл Монгол Улсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа донор байгууллагуудын удирдлагатай ярихаараа яах юм бэ ЭМД-ын тогтолцоогоо ярих юм уу, ажилчдынхаа цалинг ярих юм уу? Өвчлөл, ханиад юу байдаг юм бэ энэ халдварт өвчин, дархлаажуулалт гээд ийм мэргэжлийн юмаа яримаар байна шүү дээ.

УИХ ч гэсэн энэ ЗГ-тай мэргэжлийн сайдтай мэргэжлийн юм яримаар байна. Салбарын юм яримаар байна. Тэгж байхад чинь юу вэ энэ Мөнхсайхан гээд нэг эмч сайд гишүүн байна, Ганмаа гишүүн байна, Саранчулуун гишүүн байна, энэ Чинбүрэн гишүүн байна. Ичдэггүй юм уу та нар. Ийм хүнээр Эрүүл мэндийн сайд тавих гээд сууж байхаасаа. Улсын нэг эмнэлгээр орж үзээгүй, улсдаа бараг хувийн эмнэлгээр орж үзээгүй хүн улсын салбарын эрүүл мэндийн асуудлыг хариуцах гээд сууж байна шүү дээ. Нүүр улайгаад байна яг тоглоомыг үнэнээ хэлэхэд. Хүний урдаас ичнэ гэдэг нээрээ хэцүү гэсэн, үнэхээр хэцүү юм байна. Монгол Улс дэд сайдтай байсан, одоо бол бүүр нууц сайдтай болох гэж байна шүү дээ. Энэ цагаан байрныхан арай дураараа хэтэрч байгаа юм биш үү.

Тэгээд энэ нөгөө ЗГ-т орж ирж байгаа сайд нар дотор чинь энэ гэр хорооллын амьдрал мэдэхгүй, Монгол Улс ХАА-н орон, эд нартайгаа тэмцээд бид ХАА руугаа юу хийх юм бэ гэдэг рүүгээ тэмүүлж байгаа ёстой нөгөө нэг гэрийнхээ тулганы галыг ч бадрааж үзээгүй шахуу нэг баян айлын памперстай хүн нэг биш, хэд, хэд ороод ирлээ. Яаж улс орныхоо амьдралыг сайжруулах юм бэ Ерөнхий сайдаа? Энэ Батшугар гэж Эрүүл мэндийн сайд тавина гээд байгаа юм. Энийг та нар энэ 2024 оны сонгуульд орохдоо ийм Эрүүл мэндийн сайд тавина гэсэн бол та нарыг л лав Монгол Улсын иргэд сонгохгүй. Би бол баталгаатай мэдэж байна.

Батшугар энэ сайдад нэр дэвшигчээс би ганцхан асуулт асуучихъя. Ерөнхий сайд яах вэ зүгээр танд тоглоод ч юм уу, нэг ийм санамсаргүй байдлаар санал тавьж үзсэн байх. Эр зориг гаргаад больчих байх гээд. Та нэг эр зориг гаргаад, би энэ салбарыг үнэхээр мэдэхгүй, Монгол Улсаа шившиг болгохоос би болимоор байна, эр зориг гаргаад больж болох уу гээд шууд хэлж чадах уу?

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн эхний асуудал хэлэлцэж асуудалтай холбоогүй асуудал ярьсан. Гэхдээ надтай холбоотой учраас би тодорхой байр сууриа илэрхийлэх нь зөв байх. Энэ индэр дээр, энэ хүндтэй суудалд би суучаад суусныхаа дараа гишүүдийг дэглэнэ, журамлана, сахилга хариуцлага, ёс зүй ярина гэж хэлээгүй. Би нэр дэвшээд явж байхдаа танай намын бүлгийн хурал дээр, ХҮН намын зөвлөлийн хурал дээр, Иргэний Зориг, ногоон намын гишүүдэд, гадна гараад хэвлэл мэдээлэлд энийгээ хэрвээ би дарга болбол Их Хурлын дарга энэ Их Хурал дээрээсээ сахилга хариуцлага, ёс зүй байх ёстой, өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлнэ гэж асуудал ярьсан. Та бүхэн ч гэсэн улс төржихгүй байх ёстой, нам бус байх ёстой, Ерөнхийлөгчид нэр дэвшихгүй байх ёстой, Их Хурлыг Их Хурал шиг болго, төрд итгэх ард түмний итгэл унаж байна, төрийг төр шиг болго, тэгж байж энэ парламентын нэр хүнд, унаад байгаа гишүүдийн нэр хүнд сэргэнэ гэдэг асуудал

ярьсан. Үүний дагуу би энэ индэрт суухаасаа өмнө нэр дэвшиж байхдаа ярьсан шүү. Та андуураад байх шиг байна.

2 дугаарт нь бид өөрсдөө хариуцлагатай, өөрсдөө ёс зүйтэй, өөрсдөө сахилга баттай байж бусдыг шаардана. Өөрсдөө сахилга батгүй, хариуцлагагүй, ёс зүйгүй байхчаад төрийн албан хаагчдыг ёс зүйтэй бай, Их Хурлын гишүүдийн өмнөөс өөдөөс маасайгаад жорлонд сууж байгаа юм шиг сууж бай гэж хэлэх эрх байхгүй. Гэхдээ мэдээж энэ төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудад УИХ-д хүндэтгэлтэй хандах ёстой төрийн албан хаагч нар, хүндэтгэлтэй хандаж чадахгүй бол хариуцлага тооцох зохицуулалт байгаа. Түүний дагуу та хэзээ, хаана, ямар төрийн албан хаагч асуудал үүсгэсэн бэ, ёс зүйгүй хандав энийгээ Улсын Их Хурлын удирдлага болон Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороонд хандаад гаргавал тэр албан хаагч нарт хариуцлага тооцно. Төр төмбөгөр ёс ёмбогор байх ёстой шүү. Жоохон хэлэх үгээ бодож хэлж ярих хэрэгтэй шүү. Ерөнхий сайд.

Н.Учрал: Бид, би үнэнээ хэлье. Тэгээд сайдын 32 шинж төгс бүрдсэн супер хүмүүс томилоогүй нь үнэн. Гэхдээ юу тулгараад байгаа вэ гэдгээ л тодорхой болгох хэрэгтэй. Эрүүл мэндийн салбарт бид эмч нар томилж үзсэн, сүүлийн 3 удаа л эмч томиллоо. Тэгээд өнөөдөр ЭМД-ын санхүүжилт хийхэд байна шүү дээ өнгөрсөн хугацаанд бараг 2,5 дахин нэмэгдчихээд байна шүү дээ. ADB-ийн эмнэлгүүд барих ажил хүлээгдээд байна. Эмч нарын цалин, эмч нарын цалин чинь орон нутагт очихоор цалингийн тогтолцоо нь өөрчлөгдөөгүй, тэгээд одоо хүртэл шүүмж дагуулсаар л байдаг. Мэдээж Чинбүрэн сайд хариуцлагатай сайн ажилласан. Гэхдээ ЗГ болгон өөр өөрийн баримталж байгаа чиглэл бодлоготой. Би Ерөнхий сайдаар томилогдохдоо хэлсэн манай ЗГ салбар болгонд байгаа хүнд суртлуудыг, дүрэм журам, саад тээгүүдийг арилгана, илүү хувийн хэвшлээ дэмжсэн. Тийм учраас би түрүүн жишээ нь Амарсайхан сайд хувийн эрх зүйн шинэчлэл хийнэ. Энэ чинь манай ЗГ-ын онцлог шүү дээ.

Тэгэхээр эрүүл мэнд бол бидний нэн тулгамдсан асуудал. Тэгэхдээ юу тулгараад байгаа юм, эмч нарын чадвар дутагдаагүй шүү дээ, манай эмч нар дэлхийн хаана ч очсон чадвартай. Би өөрөө энэ Монгол эмч нарын буянаар өдий зэрэгтэй ингээд эрүүл саруул ажлаа хийгээд явж байгаа хүн байхгүй юу. Монголд эмийн чанар, эрүүл мэндийн тогтолцоо, санхүүжилтийн механизм өөрөө тулгарчихсан. Эрүүл мэндийн салбарын цахимжилтыг би Батшугарыг Байнгын хорооны дарга байхад бид 2 наад И Монгол дээр бүх цахимжилтыг нь хийж байсан. Би олон юм шаардахгүй. Батшугарыг би хагалгаа хийгээгүй, Батшугарыг би сайн менежер бай гэж, банканд ажилласан, санхүүч байсан, J.P.Morgan-д ажиллаж байсан хүн. Тийм учраас тулгараад байгаа асуудлыг шийдэх нь өнөөдрийн асуудал байхгүй юу. Тэрнээс биш энэ чинь Батшугараа чи хагалгаа хийгээрэй, мэс засал хийгээрэй гэж хэлээгүй шүү дээ. Мэргэжлийн хүмүүс ажлаа хийнэ. Тэгэхдээ Батшугарын мэргэжил яг өнөөдөр би энэ салбарт би өөрчлөлт авчирна гэдэг эргэлзэхгүй байгаа юм. Яагаад гэвэл нэгд энэ цахимжилтын асуудал, 2-т энэ ЭМД-ын тогтолцоо. ЭМД-ын тогтолцоо.

Тэгээд өнгөрсөн хугацаанд мэргэжлийн бус зөндөө сайдаар томилогдож байсан. Тэгэхдээ манай эрүүл мэндийн салбарынхан Ламбаа сайдыг мундаг сайд байсан гэж ярьдаг юм. Нөгөө Сарангэрэл сайдыг ковидын үед сайн давсан шүү гэж ярьдаг. Яагаад гэвэл сайн менежерүүд байхгүй юу. Тийм учраас миний бодож харж байгаа буюу манай ЗГ-ын дэвшүүлж байгаа бодлого чиглэл өөрөө тулгараад байгаа

асуудлыг шийдэх л зорилготой. Тэрнээс Батшугарыг насаар нь Эрүүл мэндийн сайдаар томилчихсон юм байхгүй шүү дээ. Өнөөдөр шийдэх асуудлаа шийдье, банк, санхүү эдийн засгийн мэргэжилтэн хүн хэрэгтэй байна.

С.Бямбацогт: Батшугар сайд хариулах уу? Нэмэлт хариулт.

Э.Батшугар: Цогтбаатар гишүүний асуултад хариульъя. Тийм ээ би эрүүл мэндийн мэргэжилтэй биш, эмч биш. Гэхдээ салбараа эрүүл мэндийн салбараа цогцоор нь харна. Дан эмчийн нүдээр биш, санхүүжилтийг нь харна, гадаад харилцааг нь харна, яаж олон улсын даатгалын системийг Монголд авчрахгүй гэж харна. ЭМД өөрөө хүнд нөхцөлд байгаа, энийг яаж илүү хүртээмжтэй болгох вэ гэж харна. Эмнэлэгт дугаарлаад, ор олдохгүй байгаа коридорт хэвтдэг биш, харин Монгол Улс 10 мянган хүнд оногддог ороорой эхний 10-д ордог. Яаж энийг нь зөв менеж хийх вэ, яаж хүртээмжтэй болгох вэ гэдгийг нь харна. Эрүүл мэндийн салбарт зарцуулагдаж нэг төгрөг болгон Монгол хүний эрүүл мэндийн төлөө зарцуулагдахын төлөө ажиллана гэж хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Сөрөг хүчнээ хараад сайхан байна шүү дээ. Сөрөг хүчин маань сөрөг хүчин шиг, сөрөг хүчнийхээ ажлыг хийгээд ойрд уулзсангүй, та нар маань ямар их удав. Сүүлдээ нөгөө сөрөг хүчин нь хэн бэ гэдэг нь мэдэгдэхгүй их хүнд байлаа шүү дээ нэг хэсэг. Ерөнхий сайд 19 сайд томилсон, 8 сайд нь хуучин яам дээрээ хэвээрээ үргэлжилж байна, 2 сайд нь сэлгэн өөр яаман дээр очиж байна, 5 сайд өмнө нь өөр яамны сайдаар ажиллаж байсан туршлагатай байна, 4 сайд цоо шинээр орж ирж байгаа. Гэхдээ улс төрийн туршлагатай ийм сайд нар байна. Жендэрийн хуулийг би өмнө нь хэлсэн. Жендэрийн хуулийнхаа 15 хувийн босгыг биелүүлсэнгүй. Жендэрийн хуулийн зөрчилтэй кабинет бүрдүүлээ. Тэгэхээр энийгээ Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх юм даа. Гэхдээ Жендэрийн үндэсний хорооны даргын хувьд энэ асуудалд анхаарч цаашид тэгээд анхаарна биз дээ. Кабинетаа бүрдүүлэхэд их хүнд байсан байлгүй. Дэд сайд нар 4 дэд сайд үлдсэн юм байна, 2 нь эмэгтэй юм байна сайн байна.

Би энэ 2 сэлгэнээр орж, яамаа сэлгэж байгаа 2 сайд дээр Батшугар дээр нэлээд шүүмжлэлтэй хандаж байна. Тэгээд би Батшугарыг зоригтой байгаарай. Сая Учрал сайд хэллээ шүү дээ. Өмнө нь дандаа эрүүл мэндийн салбарын эрүүл мэндийн мэргэжилтэй хүмүүсийг томилж байсан гэж. Тэгээд одоо менежерийн, нэн ялангуяа банк, санхүүгийн салбарын хүн ирэхлээр тодорхой энэ цахимжуулалт, энэ хуурамч нэхэмжлэл, эргээд яг энэ ЭМД-ын сангийн нөхцөл байдал нь юунаас болж зөрчил гэдэг юм уу, энэ алдагдалд ороод байна вэ гэдгийг яг санхүүгийн хүний нүдээр харахлаар яг алдаа дутагдал нь харагдана. Бид улсын төсөвт урсгал зардал, цалин хөлсийг нь тавьж өгөөгүй мөртөөсөө эмч нарын цалинг нь нэмэгдүүлнэ гээд маш их өндөр амлалт өгчихсэн. Яг энэ юу гэдэг юм нэг нэхэмжлэл, үйлчилгээ гэдэг маань яг эрүүл мэндийн салбарын хамгийн гол хүнд нөхцөл байдал. ЭМД-ын шимтгэл төлж байгаа хүмүүс эмч, эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын цалин хөлсийг төлж, харин өөрсдөө эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй нөхцөл байдалд хүрсэн байгаа нь бодлогын санхүүгийн алдаа. Тэгэхээр энэ дээрээ анхаарч өгөх хэрэгтэй.

Нэн яаралтайгаар төсвийн тодотголоо хийхийг хүсэж байна. Яагаад гэвэл улаан, ногоон лазер удирдаж маш буруу төсвийг баталсан шүү дээ. Тухайн үедээ сөрөг хүчний хувьд бараг би, бидний хэдэн нөхөд та нар буруу алдаа хийж байна

гэдгийг хэлсэн. Улаан, ногоон лазераар хүч түрээд баталсан. Багш нарынхаа цалингийн төсвийг нь дутуу баталчхаад, тэгээд хэрэгжүүлээд ингээд одоо маш хүнд нөхцөл байдалтай байгаа. Тэгэхээр үүнийгээ анхаарч энэ төсвийн тодотголоо хийгээрэй.

Ерөнхий сайд ЗГ-ын кабинетаас юу хүсэх вэ гэхлээр шинэ сайд нар, шинэ яаман дээр очиж байгаа сайд нар багахан шиг төрийн албан хаагчдаа халж солиорой. Төрийн албан хаагчдаа ээлтэй ЗГ байгаарай. Төрийн албан хаагчдынхаа тэтгэвэрт гарахад 36 сарын тэтгэмжийг 2 хувааж өгнө, төсвийг нь 50 хувийг нь л баталж өгсөн шүү дээ. Тэгээд үүн дээрээ эхлээд гарч байгаа хүмүүст нь тэр дор нь өгнө, дараагийн хүмүүсийг нь шилжүүлнэ гэсэн худлаа. Тэгээд гарч байгаа тэтгэвэртээ гарч байгаа хүмүүсийн 50 хувийг нь л өгөөд байгаа юм байна лээ. Энэ дээрээ анхаараарай гэж хүсмээр байна.

Улсын Их Хурлын даргад Улсын Их Хурлын тухай хуулийн 41.2-ыг би 1 минутаа аваад нэмчхэж болох болов уу?

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн 1 минут.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын тухай хуулийн 41.2 гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд нэгдсэн болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлж хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль тогтоомжийн төсөл, УИХ-аар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй гэж байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд бусдыг гэмт хэрэгт доромжилж болохгүй, гүтгэж болохгүй, шүүхийн өмнө хариуцлага хүлээнэ. Энэ бол таны бүрэн эрхийн асуудал биш. Тэгээд иргэний шүүхээр дуудагдахлаар гэрийн хаяг нь олдохгүй бас зарим нэгэн хүмүүс байгаад байна шүү дээ бусдыг байнга л гэмт хэрэгт гүтгээд байдаг, больчооч. Таны эмзэг цэг чинь яг энэ асуудал чинь байх вий дээ Ерөнхий сайдаа. Би олон юм ярихгүй, гэхдээ та анхаараарай. Зарим хүмүүс чинь хэцүү л байна шүү.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Би Ардын намын дарга олонхыг бүрдүүлж байгаа намын дарга. Тэгэхээр бид ЗГ-ыг бүрдүүлэхдээ нэгд энэ олон талын олон ургалч үзэл бодол уралдуулж, санал шийдэлд хүрдэг кабинетын зарчмаар ажилладаг байх шаардлагыг л тавина. Тэгэхээр манай сайд нар цаашид мэдээж бие даасан үзэл бодол илэрхийлж ажиллахгүй байхыг би хүсэж байна. Тэгэхээр ЗГ-ын гишүүд кабинетын зарчмаар ажиллана гэдгийг хатуу санах хэрэгтэй. Өнөөдөр би энд томилохоор танилцуулж байгаа сайд нар миний дэвшүүлж байгаа, Ерөнхий сайдын дэвшүүлж байгаа бодлого, зорилтыг яаж дэмжлэг үзүүлж, ачаа үүрэх үү гэдэг сонголтыг л хийсэн. Тийм учраас ЗГ-ын гэмт хэрэгтэй тэмцэх, дээрээс нь энэ авлигын төсөөллийн индекс 10 байр хойшилчихсон байгаа явдал, гэмт хэрэг болоод дууссаныг нь дараа ярьдаг биш, урьдчилан сэргийлэх ажлыг илүү хэрэгжүүлэхэд би сайд нарыг сонгосон.

Жишээ нь Хууль зүйн сайдаар ажиллаж байсан Энхбаяр сайдыг би өнгөрсөн хугацаанд ТӨК-ийн хууль, Нийтийн өмчийн хуулийг боловсруулж өргөн мэдүүлж

байсан сайн хуульч. Тийм учраас энэ ТӨК-уд дээр олборлох салбарын ил тод байдал дээр, энэ авлигын индекс дээр, дээрээс нь энэ ЗГ-ын хууль шийдвэрүүд хууль зөрчихгүй байх дээр илүү анхаарч ажиллаасай. Бодитоор авлигын индексийг бууруулаасай. Дахиад энэ авлигатай холбоотой асуудал дахиж битгий гараасай. Тийм учраас би баруун гартаа, дэргэдээ авчирч томиллоо л доо.

ХЗДХ-ийн сайд Амарсайхан Америкт өөрөө энэ бизнесийн эрх зүйгээр төгссөн. Тэгэхээр миний хүсэж байгаа зүйл хувийн эрх зүйн шинэчлэл. Энэ Арилжааны хууль, Дампуурлын хууль, Иргэний хуулийн шинэчлэл, энэ эдийн засгийн эрх чөлөө, энэ татварын шинэчлэл, энэ эрх зүйн чөлөөлөлт хийхэд илүү манлайллаасаа. Тэгэхээр би ЗГ-ынхаа гишүүд нэг зүйлийг л шахна, үр дүнгээрээ хэмжүүл, болоогүй юмыг битгий гарч олон юм яриад бай, болоогүй зүйлийг телевиз болгоноор гарч рекламдаад байх шаардлага байхгүй, үр дүнгээрээ хэмжүүл. Тийм учраас одоо ийм байдалтайгаар Их Хурлын гишүүд биднийг нээлттэй шүүмжилж байна шүү дээ. Сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж байна зарим нь. Тэгэхээр энд хариултад та нар яаж хариулт өгөх вэ, үр дүнгээрээ л үнэлгээ өгнө. Тэгэхээр үр дүнгээрээ, гүйцэтгэлээрээ, илүү үнэлсэн тийм ажил хэрэгч, хариуцлагатай ийм ЗГ-ыг л бүрдүүлж ажиллахыг би эрхэмлэнэ гэдгээ хэлье. Миний мэдээж зарчим энэ байна л гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Үнэхээр харамсалтай байж мэдэх, хүлээлтээс доогуур ийм бодлого танилцуулагдаж байна. Зөвхөн энэ бүрэлдэхүүн сайд нар яах вэ тэгээд олон нийт дүнгээ тавьж байх шиг байна. Уг нь зүй нь зөв бодлого амжилттай явахын тулд эхлээд тэр үзэл санаагаа, бодлогоо тавиад, тэрэндээ таарсан бүтцээ зураад, тэр бүтцэдээ таарсан бүрэлдэхүүнээ оруулж ирэх л ёстой. Гэтэл өмнөх Ерөнхий сайдын үеийн бүтцийг тэр чигээр нь ямар бодлогод ямар ач холбогдол өгөөд, яагаад шинээр бүтцийг өмнөх засаг болохгүй байна гээд л огцроо биз дээ? Шинээр ийм өөрчлөлтийг би үзэл санаа болгож тавьж байна. Энийгээ ийм бүтэц би бүтцийн өөрчлөлт хийнэ, энэ бүтцийг дагаад хэрэгжүүлж чадах ийм хүмүүс бүрэлдэхүүн сайд нарыг оруулж ирж байна гэвэл жинхэнээсээ энэ өөрчлөлтийн бодлого энэний цаана харагдах ёстой байсан байх. Уг нь Учрал сайд нэг үзэл санаа танилцуулаад чөлөөлнө, эдийн засгийн эрх чөлөө гээд олон зүйлүүдийг ярьж байсан. Эдгээр нь зүгээр нэг ийм уриа лоозон, тунхаг байсан юм байна харамсалтай. Зүгээр л олон нийтэд тааруулж уриалж, тунхаглаж л байж. Нөгөө ам, ажлын зөрөө гэдэг яг амьдрал дээр ингэж л гарч байна.

Сөрөг хүчний үүднээс харвал их тийм ашигтай ч байж болох ЗГ. Харин энэ ард түмний үүднээс, аж амьдралын үүднээс, эдийн засгийн үүднээс харвал үнэхээр харамсалтай байж болох ийм л бодлого, ЗГ бүтэц, зохион байгуулалт танилцуулагдаж байна. Тэгээд аль юмыг шүүмжилж барах вэ? Тэгээд Монгол Улсад ашигтай байгаасай, энэ ЗГ үр дүнтэй ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд танай ЗГ энэ бүтэц, бүрэлдэхүүнд тэгээд амжилт хүсье. Асуулт алга.

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууж, үгээ хэлье.

Л.Мөнхбаясгалан: Танхимд амжилт хүсье. Учрал Ерөнхий сайдаас асуух зүйл байна. Та хүний амьдралд их л олон юм тууллаа. Ялангуяа сүүлийн хэдэн жилд Цахим хөгжлийн сайд, Хэрэг эрхлэх газрын дарга, Эдийн засгийн хөгжлийн шадар сайд, намын дарга, Улсын Их Хурлын дарга, одоо Ерөнхий сайд. Зарим улс төрчийн

30, 40 жилийн карьерыг хоёрхон жилийн дотор тууллаа. Би тэгэхээр танаас ийм юм асуух гээд байгаа юм. Та хүнд өвчнөөс босож ирсэн хүн, та bully гэж юу байдгийг мэддэг хүн. Цахим bully гэж юу байдгийг. Энийг өнөөдөр дэлхий нийтээрээ ярьж байна.

Би энд хотын дарга Нямбаатарын нэг үгийг сонсгоё гэж бодож байна. /“Өглөө болгон би Туулын голоо санаж сэргэж сэрдэг, Туулын голынхоо усыг ууж би амьдардаг гэж ярьж байна. Ийм байж болох уу, ийм хүн Туул голоо аврах уу? Тэр Шүүдэрцэцэг гээд ямар зохиол бичсэн юм. Хэдүүлээ бүүр bully-дмээр байна.” дүрс бичлэгээс сонсгов/ Ингэж эмэгтэй хүнийг, эх хүнийг, зохиолч хүнийг Туул голоо аваръя гэж хэлснийх нь төлөө бүүр bully-мээр байна гэж байгаа байхгүй юу. Айлын гадаа очоод Улаанбаатар хотынхоо иргэний гадаа очоод элдвээр доромжилж байгаа юм. Өөрийг нь шүүмжилсэн Улсын Их Хурлын гишүүдийг бас доромжилдог. Ийм нэг хүн өнөөдөр таны доор энэ Улаанбаатар хотын захирагчаар ажиллаж байна. Цахим bully-ээс сэргийлэхийн тулд дэлхий нийт ажиллаж байгаа байхгүй юу, манай улс ч гэсэн. Тэгэхээр ийм хүнтэй та ажиллах юм уу, энэ хүн ингээд л хүн доромжлоод л байх уу, энэ хүн хүнийг bully-дье гээд ярьсаар байх уу? 14 настай охинтой бэлгийн харьцаанд орж болно гэдэг хуулийг дэмжээд явж байсан энэ хүн өнөөдөр жинхэнэ Монгол төрийн толгой дээр гарч байна, иргэдийнхээ толгой дээр гарч байна. Энэ хүнтэй та ажилласаар байх уу. Би таныг цахим bully-д их автаж байсан хүний хувьд, дээрээс нь танай гэр бүлд ч гэсэн bully-д автаж байсан. Энэ зөв үү Ерөнхий сайд аа? Ийм нэг асуулт байна.

Би Энх-Амгалан сайдад өчигдрийн УИХ-аар хэлэлцүүлсэн тэр Сургууль орчмын аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль энэ Мөнхсайхан сайд, Мандхай гишүүн, та 3 өргөн барьсан байна лээ. Энэ маш зөв хууль шүү. Энэ дээр та цэцэрлэгийг оруулж өгөөч. Өнөөдөр сургуульд хорт хавдар үүсгэдэг бодисоор будаж байна. Хүүхдийн цусанд хүнд металл, хар тугалга ордог бодисоор будаж байна. Манай улсад стандарт нь байгаа мөртөө тэрийг шинжилж чадах лаборатори нь алга. Тэгэхээр та зөвхөн сургууль биш, цэцэрлэгийн орчныг оруулж өгөөч. Энэ дээр чинь маш сайн дэмжиж ажиллана.

Тэгээд говийн бүсийн гишүүний хувьд хамгийн их ажиллах сайд бол Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд. Энэ яам уг нь тэргүүлэх чиглэлийн яам баймаар байгаа юм даа. Тэгээд амжилт хүсье. Ерөнхий сайдаас хариултаа авъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь сахилга хариуцлагагүй, ёс зүйн ийм зөрчил гаргаж байгаа улс төрийн ч бай, төрийн ч бай албан тушаалтнууд их олширлоо. Тэгээд би үүнд их эмзэг ханддаг. Би өөрөө эмэгтэй дүүтэй, 3 охинтой хүн. Ер нь эх хүн рүү, эмэгтэй хүн рүү ийм хариуцлагагүй үг хэллэг хэлж байна гэдэг төрийн хариуцлагатай албан тушаалтны биш, зүгээр эр хүний амнаас гарч болохгүй үг л гэж би бодож байгаа. Тийм учраас энэ эрх барьж байгаа намын даргын хувьд ч тэр, Ерөнхий сайдын хувьд ч тэр ийм зүйлүүдтэй эвлэрэхгүй, тэр бол ойлгомжтой. Тэгээд би кабинетаа бүрдүүлж байна, шат шатанд нь Ажлын хэсэг байгуулж, үүсээд байгаа нөхцөл байдлууд дээр дүгнэлтүүд хийнэ гэдгээ танд би хариуцлагатайгаар хэлъе. Мэдээж тэр өөрийнхөө хийж байгаа ажил дээр ямар үр дүн гаргаад явж байгаа юм тэр нарийн мэдээллүүдийг нь би очиж авна, сануулна, тодорхой асуудлуудыг ярина. Мэдээж ер нь тэгээд хаана хаанаа л бүгдээрээ сахилга баттай л баймаар байна, хаана хаанаа л.

Манай ЗГ-ын гишүүдэд ч би хэлье. Та бүхэн ёс зүйтэй байх ёстой, хариуцлагатай байх ёстой, Их Хурлын гишүүн, дээрээс нь төрийн сайд гэдэг зүгээр энгийн хүн биш шүү. Үндсэн хуулиар олгогдсон олон эрх чөлөөгөө хасуулдаг юм шүү дээ ЗГ-ын гишүүн бол. Бусад шиг би эрх чөлөөгөө эдэлж байна гээд явж болохгүй. Өөрсдөө хариуцлагатай, ёс, зүйтэй, манлайлалтай байх ёстой. Тэгж байж төрийн сайдыг хүндэтгэнэ. Тэрнээс биш өнөөдөр төрийн сайдын ч нэр, Их Хурлын гишүүдийн ч нэр хүнд унаад байгаа чинь зарим хүмүүсээс л болоод байгаа шүү дээ. Тэгэхээр одоо энэ төрийнхөө нэр хүндийг сэргээе. Төрийнхөө нэр хүндийг сэргээнэ. Ганцхан зүйлээр л сэргээнэ төр ард түмнийхээ төлөө ажиллаж л сэргээнэ. Төр бол ард түмнээс олж авсан эрх мэдэл, тэгээд ард түмэнд нь зориулах ёстой. Тэгээд байгаа цагтаа байсан шиг байгаад, ажлаа хариуцлагатай хийх ёстой.

Ер нь тэгээд ЗГ-ын гишүүн гэдэг нөгөө гал усан дундуур орж чаддаг, түмний төлөө гэсэн сэтгэлтэй хүн байх ёстой. Тэгээд ажилсаг хүн гэдэг их өөр л дөө. Тэгээд яах вэ хүмүүс сошиалаар зарим хүмүүсийг ингээд шүүмжлээд л байдаг. Яг үнэндээ эргээд харахад манай Чойжилсүрэн сайд шиг, Дэлгэрсайхан сайд шиг, Жавхлан сайд шиг ажил нугалдаг хүн яг цаг дээрээ байдаггүй л дээ. Тэгээд энэ ЗГ-ын ажил чинь их зовлонтой. Зүгээр ингээд нэг сошиалаар нэр хүндтэйдээ биш юм байна лээ. Энэ ЗГ гүйцэтгэх засаглалын ажил. Тэгэхээр би кабинет учраас кабинет дүнгээ л тавиулна. Тэгэхээр гол нь би сайд нараасаа яг таны хэлж байгаа энэ ёс зүй, сахилга хариуцлага, энэ үг, үйлдэлдээ эзэн байхыг шаардаж ажиллах болно.

С.Бямбацогт: Байгаль орчны сайдад нэр дэвшигч хариульъя. Сандаг-Очир гишүүн. Энх-Амгалан сайд хариульъя.

Л.Энх-Амгалан: Ганц минутад хариулахад их тийм хүндрэлтэй хариулт, хариулт ч яах вэ үүрэг даалгавар өглөө гэж ойлгож байгаа шүү дээ Мөнхбаясгалан гишүүнээ. Тэгээд энэ мэдээж энэ хуулийг хамтарч өргөн барьсан гишүүний хувьд 1 дүгээрт, 2 дугаарт би энэ салбарт ажиллаж байсан салбарын сайдын хувьд энэ сургууль, цэцэрлэгийн аюулгүй байдлын асуудлыг бид үндэсний тогтолцоо болгох ёстой гэж би бодож байгаа. Тэгээд үндсэндээ Боловсролын сайдаар ажиллаж байхдаа энэ асуудлыг анх хөндөж, шүгэл үлээж энэ үе тэнгийн дээрэлхэлт гэдэг байдаг юм байна. Нийт хүүхдүүдийн 70 хувь нь үе тэнгийн дээрэлхэлт ямар нэгэн байдлаар өртсөн байна. Энэний бараг үндсэндээ 60 хувь нь гэр бүлийн орчинд, 30 хувь нь сургуулийн орчинд үйлдэгддэг гэдэг нэг ийм сэтгэл эмзэглүүлэм статистик байдаг. Тэгээд энийг шийдэхийн тулд сургуулийн сэтгэл зүйчдийг шийдэж ажиллаж байсан энийгээ цааш нь ажил хэрэг болгож ажиллана гэж.../минут дуусав/

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн гүйцээгээд хариулчихъя, 1 минут нэмэлт.

Л.Энх-Амгалан: Өчигдөр тэр хуулийн хэлэлцүүлэг явж байх үед тэр Нарансүх профессор тийм сэтгэл эмзэглүүлэм зүйлийг ярьж байна лээ. Сургууль, цэцэрлэгийн тасалгааг нь энэ хорт хавдар үүсгэгч будаг, барилгын материалд хэрэглэдэг болсон байна. Энэ дээр бүүр онцгойлон анхаарах байх ёстой. Бид энэ хяналтын байгууллагын боловсролын, бид мэргэжлийн хяналтыг удахгүй би сэргээх ёстой л гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгээд энэ хяналтын байгууллагууд сайн ажиллаж, энэ хүүхэд цэцэрлэг, сургуулиуд дээрээ хорт хавдар үүсдэг энэ орчинд би сурч, хүмүүжиж болохгүй л гэж ойлгож байгаа. Тэгээд энийг ингээд нэг ийм нэг удаагийн гал унтраасан арга хэмжээ авах би тийм сонирхолгүй. Миний ажилладаг стиль тийм биш, тодорхой тогтолцооных нь хувьд хардаг, системийнх нь хувьд харж байж энэ шийдлүүдийг хийх ийм зөв шийдлүүд байх болов уу гэж бодож байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байх үед энэ Хүүхэд

хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлж 600 орчим нийгмийн ажилтантай болсон.../минут дуусав/

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн асуултаа асууя, үгээ хэлье.

О.Батнайрамдал: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Ерөнхий сайд кабинетаа оруулж ирж танилцуулж байна, тэгээд амжилт хүсье. Надад 3 багц асуулт байгаа юм. Энэ нь эргээд буцаад Учрал Ерөнхий сайдын кабинет миний хувьд буцаад хэрхэн амжилттай ажилласан бэ гэдгийг дүгнэх 3 хэмжигдэхүүн болох болов уу гэж бодож байна. 1 дүгээрт, зөндөө ярьсан Оюу толгой /ОТ/-н хэлэлцээрийг та бүрэн эрхийнхээ хугацаанд эцэслэх үү? Болж өгвөл амлалтаа өгчихмөөр байна. Энэ нь эргээд ард түмний маш том хүлээлт байгаа.

2 дугаарт, Үндэсний баялгийн сан байгуулснаас хойш яг одоогийн байдлаар Ирээдүй өв сан дээр 6 их наяд, Хуримтлалын сан дээр 1,1 их наяд нийлээд 7,1 их наяд төгрөг буюу 2 тэрбум орчим доллар хуримтлагдаж чадсан байна. Тэгэхээр энэ Үндэсний баялгийн сан дээр төвлөрсөн 2,1 их наяд төгрөгийг хэрхэн цаашаага илүү арвижуулж чадсан бэ гэдэг бас нэг хэмжигдэхүүн гарч ирэх болов уу гэж хүлээж байгаа. Тэгэхээр Үндэсний баялгийн санг цаашаага арвижуулах бодлого авч явах уу, эсвэл янз бүрийн шалтаг хэлж байгаад зарцуулах хэлбэр лүү орох уу? Тэгэхээр энэ дээр маш тодорхой хариулт авмаар байна. Буцаад Үндэсний баялгийн сангийн энэ 2,1 их, 2,2 тэрбум буюу 7,1 их наяд төгрөгийн хуримтлал цаашаа хэр ахисан бэ гэдэг дүгнэлт хийгдэх байх гэж бодож байна.

3 дугаарт, Боловсролын сайдад нэр дэвшигчээс ойлгомжтой нэг асуулт асуумаар байна. Яг 3 жилийн өмнө юм байна, яг 3 жил одоо ой нь болж байна. Би гишүүн байгаагүй л дээ тэр үед. Боловсролын зээлийн сангийн асуудлыг гаргаж ирж байсан. Тэр дунд нэг ноцтой асуудал нь үе үеийн 16 сайдын тушаалаар би энэ АТГ-ын өгсөн баримтыг уншиж байна л даа 25 сая ам.доллар буюу 90 тэрбум төгрөгийг Улсын Их Хурлын бүрэн эрхээс даваад, сайд нар хууль бусаар хүчингүй болгосон гэсэн ийм тушаалууд байгаа. Надад яг АТГ-ын дарга, тэргүүн комиссар Дашдаваагийн гарын үсэгтэй Монгол Улсын Ерөнхий сайд руу хандсан хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулах ийм албан тоот миний гарт байна. Одоо ингээд 3 дахь Ерөнхий сайдынхаа нүүр үзэж байна. АТГ-ын дарга Дашдаваа энэ хууль бус шийдвэрүүдийг хүчингүй болгож, энэ 90 тэрбумыг эргэн төлүүл гэдэг албан тоотыг тухайн үеийн Ерөнхий сайдад өгч байсан. Одоо хүртэл хийгдээгүй.

Одоо энэнээс хойш би ингээд Улсын Их Хурлын гишүүн болж орж ирээд 2 жил ярьж байна. Татвар төлөгчдийн мөнгө 90 тэрбум төгрөг шүү. Тэгээд энэ хууль бус тушаал дотор бас таны тушаал байгаа. Тэгэхээр та ёс зүй зааж энэ хууль бус тушаалуудыг хүчингүй болгох уу, АТГ-ын энэ өгсөн албан тоотыг та биелүүлэх үү? Тэгэхээр энийг таныг нэр дэвшиж, нэр дэвшигчээр ороод ирсэн үед нь яг асуучихмаар байна, та тийм, үгүй гэж байгаад хариулчихвал их сайн байна? Яагаад гэвэл та бүх ардах түүхийг нь сайн мэдэж байгаа. Энэ 3 асуултдаа хариулт аваад, тодруулъя. Баярлалаа.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: ОТ-н яриа хэлэлцээг урагшлуулна мэдээж. Батнайрамдал гишүүний ахалсан Түр хорооны тогтоол байгаа. Тэгэхээр тэр тогтоол бол ЗГ-т чиглэл өгсөн тогтоол. Тэр тогтоол дээр Монголын талын өгөөжийг 53 хувьд хүргэх ийм үүрэг хүлээсэн. Тэгэхээр ОТ-н талуудын яриа хэлэлцээг хож, хож гэсэн зарчим

дээр л үр дүнд хүрэх ёстой. Тэгэхээр мэдээж бид өнгөрсөн хугацаанд би Орано Майнингийн хэлэлцээрийг ахалсан. Тухайн үед яг нөгөө due diligence хийлгээд, тэгээд санхүүгийн модель дээр суурилсан хэлэлцээрийг хийж байсан. ОТ-н яриан дээр ч гэсэн яг энэ зарчмаа бариад 53 хувьд хүргэх хэлэлцээрийг үргэлжлүүлж үр дүнд хүргэнэ гэхээр бүрэн өөрөөс шалтгаалах бүхнийг хийж ажиллана. Мөн энэ баялгийн сантай холбоотой Үндсэн хуульд заасан өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн зарчмыг хангуулах чиглэлээр энэ зөвлөлдөх санал асуулга ирэх долоо хоногт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад эхэлж байгаа юм байна лээ.

Занданшатар даргын ЗГ-ын үед энэ Хуримтлалын сангийн орлогыг нэмэгдүүлэх бодлогыг эхлүүлсэн. 175 мянган төгрөг байгааг 10 сая хүртэлх нэмэгдүүлэх бололцоотой ийм үе шаттай ажлуудыг эхлүүлсэн. Энэ төрийн ажлын залгамж чанарыг хадгалж, энэ Баялгийн сангийн зөвлөлдөх санал асуулга энэ асуудлыг хэлэлцэж, шаардлагатай бол Үндэсний баялгийн сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. Баялгийн сангийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх, арвижуулах, хуваарилах асуудлуудыг тодорхой болгоно. Тэгээд иргэдийнхээ эхлээд саналыг сонсох байгаа. Ирээдүй өв санд хуримтлуулаад байгаа хувь, өгөөжийг өнөөдөр үед нь илүү хуримтлуулах нь зөв үү, үгүй юу гэдэг дээр зөвлөлдөх энэ санал асуулгын хуулийн дагуу үр дүнг нь харъя гэсэн ийм хүлээлттэй байна.

Дээрээс нь стратегийн ордуудтай хэлэлцээр хийх ажлуудыг Занданшатар Ерөнхий сайдын үед хийсэн байсан. Гэхдээ бид хоосон гэрээ хийгээд зогсож болохгүй. Тэр орд болгон дээр бид санхүүгийн модель гаргаж, яг өгөөжөө тооцох ёстой. Яг энэ corporate гэрээ яг хийгээд бид чинь сурчихсан шүү дээ нэг үеэ бодвол. Тэгэхээр яг энэ зарчмаар ажиллана. Тэрнээс зүгээр нэг гэрээ хийгээд тэдэн хувийг нь авъя гэдэг ийм зарчим байж болохгүй. Тийм учраас эхлээд яг өгөөж гэж юу юуг тооцох вэ, ямар төлбөр, татвар нийлээд өгөөж болох юм, хэдэн хувьд хүрэх юм бэ гэдгийг хуульчлах хэрэгтэй. Тэгэхээр энийг Батнайрамдал гишүүн таныг хуульд тодорхой болгоод, өгөөж тооцох ийм эрх зүйн орчныг бүрдүүлж өгөөсэй. Тэгээд бид хэлэлцээрүүдийг үргэлжлүүлээд төрийн эзэмшлийн 34 хувь нь яг тэр Баялгийн сан руу ордог энэ зөв механизм руу оруулна гэдгийг танд хэлье.

С.Бямбацогт: Энх-Амгалан нэр дэвшигч хариульъя.

Л.Энх-Амгалан: Их Хурлын даргаа бүтэн минут хариулт өгөх нэг бүтэн минут олгож өгөөч гэж. Батнайрамдал гишүүнд талархаж байгаа. Улсын Их Хурлын гишүүн болохоосоо өмнө энэ Боловсролын зээлийн сангаар шүгэл үлээсэн. Тэгэхдээ ганцхан Батнайрамдал үлээчхээгүй шүү гэдгийг би өөрт чинь хэлж байсан. Энэ мэдээлэл өөрийн чинь гар дээр очиход 2 жил яамны хамт олон өдөр, шөнөгүй зүтгэж, нийт сүүлийн 30 жилийн хугацаанд давхардсан тоогоор 1,2 сая хүүхдийн хувь заяаг шийдсэн сангийн эх өгөгдөл датаг бэлэн болгосныг та хууль бус аргаар таны гарт очсон. Энийг би хэн өгсөн, хэзээ яаж авсан гэдгийг би бүгдийг нь мэдэж байгаа. Би нэг зүйлд харамсаж байгаа Харвардын их сургууль төгссөн хүн бусдын хийсэн ажил, оюуны ажилд ингэж хандсанд би номоороо бичсэн. Та энийг ойлгосон болов уу гэж бодож байна. Одоо цөмөөрөө тэгээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, 1 минут.

Л.Энх-Амгалан: Тэгээд 1,3 их наядын энэ зээлээр өнгөрсөн 33 жилийн хугацаанд Монгол Улсын бүх л салбарт бид боловсон хүчнээ бэлдсэн. Энийг бүгдийг нь харлуулж болохгүй. Ер нь хариуцлага алдсан, ар өврийн хаалга орсон хүүхдүүд нь 160 гаруй л байдаг юм шүү дээ. Та энийг бүгдийг нь мэдэхийн дээдээр

мэдэж байгаа. Би энэ ажлуудыг эхлүүлсэн хүний хувьд очиж энэ ажлуудыг гүйцээж, тэгээд ингээд нэг ийм хэрүүлд цөмөөрөө нэг цэг тавья. Тэгэхгүй бол ганц, хоёрхон хүний улс төрийн хонжоо, улс төрийн шантааж, улс төрд нэрд гарах гэсэн, тодрох гэсэн ийм асуудал би байж болохгүй л гэж харж байгаа юм Сийлэгмаагаас авхуулаад. Сүүлдээ хүмүүсийг нэр төрөөр нь шантаажилдаг ийм болчихсон юм шүү дээ. Олон улс төрчдийн нэр төр энэнд сэвтсэн, хууль бусаар сэвт сэвтсэн. Тийм учраас цаашдаа бид энэ Боловсролын зээлийн санг нэг Боловсролын хөгжлийн сан болгох шинэ концепцын асуудлыг оруулж.../минут дуусав/

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн тодруулъя, 1 минут.

О.Батнайрамдал: Энх-Амгалан нэр нэр дэвшигчээ хоёулаа Харвард гээд л сургууль руу ороод яах вэ. Тухайн үедээ та нар нялх Сэнгүм юм гээд л элдэв янзын юм ярьж л байсан. Одоо зүгээр шийдлээ л яримаар байна. Би танаас маш ойлгомжтой асуулт асууж байгаа шүү дээ. Энэ хууль бус шийдвэрийг хүчингүй болго гээд АТГ-ын Дашдаваа даргын гарын үсэгтэй энэ албан тоот Ерөнхий сайд руу очиж байсан шүү дээ. Энэ нь өөрөө ингээд биелэхгүйгээр 3 ЗГ-ын нүүр үзэж байна шүү дээ. Тэгэхээр та энийг эхлүүлсэн бол тэгвэл одоо ингээд эцэслэх л дээ гэж байгаа шүү дээ. Таны тушаал ч байгаа. Гэхдээ та ёс зүй заагаад энийг үнэхээр хууль бус юм бол хүчингүй болгочих л хэрэгтэй. Хүчингүй болгож байгаад тэн дотор үнэхээр зөв залуучууд зөндөө байгаа би мэдэж байгаа, тэгээд наанатай цаанатай бүгдийг нь ингээд шийдэж эцэслэх хэрэгтэй байгаа юм. Тэр нь хууль бус зүйл бол хууль бус л зүйл. Тэгэхээр энийгээ эндээсээ л эхэлчихье л гэж байгаа юм.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн хариулъя.

Л.Энх-Амгалан: Батнайрамдал гишүүнээ энийг цөмөөрөө хамтарч хийнэ. Энэ эрх зүйн шинэчлэл хэрэгтэй юм байна лээ. Энэ 126 гишүүн цөмөөрөө хамтарч хийнэ. Тийм учраас ингээд энэ Боловсролын зээлийн санг цаашдаа энэ Боловсролын хөгжлийн сан болгож, улс орны хөгжил дэвшилд шаардлагатай энэ хүний нөөцөө бэлддэг энэ тогтолцоог ил тод болгох, иргэн бүрд хүртээмжтэй болгох энэ тогтолцоог л бид хийнэ энэ тогтолцооны шинэчлэл.

Тэр АТГ-аас ирсэн тийм бичгүүд байгаа бол би очиж ажил аваад танилцъя. Тэгээд үнэхээр шударга бус, тийм хууль бус зүйлүүд хийгдсэн бол би хамгийн түрүүнийхээ тушаалаар энэ тушаалуудыг хүчингүй болгоё гэдгийг би хариуцлагатайгаар хэлье гэж бодож байна.

С.Бямбацогт: Бейсен гишүүн асуултаа асууж, үг хэлье.

Б.Бейсен: Шинээр сонгогдсон Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, түүний кабинетын бүх сайдуудад баяр хүргэж, ажлын амжилт хүсээд, хамтарч ажиллана гэдгээ хэлье. Би нэг юманд санаа зовж байна. Ер нь эрүүл мэндийн салбарт ер нь санаа зовохгүй байна даа. Монгол Улсын иргэд маань эрүүл байж бүх салбарт хөдөлмөр хөдөлмөрлөх ёстой. Энэ 6 жил сууж байна энэ УИХ-д, 7 дахь сайд нь солигдож байна. Арай л байна даа. Тэгээд энэ сайдууд яагаад солигдож байна төсөв нь хүрэхгүй, орон тооны хэтрэлттэй, эмнэлгүүд нь клиникийн эмнэлгүүд, дүүргүүдийн эмнэлгүүд, аймгуудын эмнэлгүүдийн өр зээлийг нуудаг, ЭМД нь алдаа дутагдалтай ажилладаг. Өвчнөө нуусан хүн үхдэг шүү дээ.

Батшугарыг би эсэргүүцэж байгаа юм биш, түрүүн Ерөнхий сайд хэллээ л дээ эдийн засгийн талаар сайн авч явчих байх гээд тэгж байна. Тэгэхдээ Батшугар минь

ёстой эдийн засаг нь элгээрээ хэвтсэн нэг гал дотор орж байна даа. Тийм учраас миний дүү чи энэ эмнэлгүүдийн өр зээл, авлага, өглөгийг нь тодорхой болго, ил зарла. Тэгэхгүй бол сүүлдээ чи ажлаа өг гээд ингээд өр зээл чиний юун дээр тохогдоно шүү.

Нөгөө талаар хотод 33 том хувийн эмнэлэг байгаа. Яг энэ хотын клиник улсын эмнэлгүүдтэй адилхан санхүүжилт авчхаад, төлбөртэй үйлчилдэг. Хотын клиникийн 1, 2, 3, 4, Хавдар судлал, Халдварт ч юм уу том клиникийн эмнэлгүүд, дүүргүүдийн нэгдсэн эмнэлгүүд, аймгуудын нэгдсэн эмнэлгийн өр зээлийг дарж, энийг хувийн эмнэлгийн санхүүжилт зогсоож байж энийг босгохгүй бол босохгүй. Эрүүл мэндийн салбарт үнэхээр санаа зовж байна. Эмч, ажилчдын цалин нь бага, эм, эмнэлгийн хэрэгсэл нь байхгүй, квот тогтоочихсон үнэхээр хүнд байдалтай. Тэгэхээр энэ дээр та Анагаахын шинжлэх ухааны их сургууль /АШУИС/-ийн мэргэжлийн багш нарыг, тэнхимийн багш, доктор, профессоруудтай хамтарч ажиллаад, туршлагатай багш нар авч ажиллуулахгүй бол, зөвлөгөө авч ажиллуулахгүй бол энэ явахгүй. Энийг зөвлөө. Энэ талаар та хамтарч ажиллах уу энэ дээр.

Сая ТУЗ гээд 1 дүгээр эмнэлгийн даргыг 3 удаа солилоо шүү дээ 1 сарын дотор. Энэ алдаа завхралыг та засаж чадах уу? Эдийн засгийн тал дээр ДНБ 6 хувьтай тэнцэх хэмжээний төсөвтэй байх ёстой. Энд Сангийн сайд, Шадар сайдууд энэ туслах хэрэгт байна Ерөнхий сайдад маань. Сангийн сайдыг сая мэргэжлийн бус хүн гэж ярьж байна. Мэргэжлийн хүн байна. Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга, ХААЯ-ны сайд буюу ЗГ-ын гишүүн энүүгээр ажилласан туршлагатай хүн гэж бодож байна. Тийм учраас энэ эрүүл мэндийн салбарт дэмжиж хамтарч ажиллах уу гээд энэ сайдуудаас асуумаар байх юм.

Дараагийн нэг асуудал энэ эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ маш өндөр байна. Энийг буулгах талаар нэлээн анхаарал хандуулж ажиллахгүй бол үнэхээр заримдаа эм байхгүй, хэвтсэн өвчтөнүүд гаднаас эм авчирч байна. Эмнэлэгт хэвтэж байгаа улсууд гаднаас эм авчирч байна шүү дээ ерөөсөө. Даатгал гэдэг байхгүй болсон. Энэ дээр ямар бодлого барьж ажиллах вэ, энэ талаар тодруулъя? Дараа нь тодруулна.

С.Бямбацогт: Батшугар нэр дэвшигч хариулъя.

Э.Батшугар: Бейсен гишүүний асуултад хариулъя, сүүлээс нь хариулчихъя. Үнэхээр Монгол Улсад тодорхой эм байхгүй, чанар нь муу байна. Дээрээс нь энд Монгол Улсын иргэд жилдээ өнгөрсөн 25 онд гэхэд л 120 сая доллар гадагшаа гаргаж эмчлүүлж байна. Энэ нь төлбөрийн тэнцэл, ханш дээр цаашдаа маш сөрөг нөлөө авчирч байгаа юм. Тэгэхээр үүн дээр дэлхийн чанартай эмнэлгийг авчрах зорилго тавьж ажиллана. Ингэхийн тулд дан урьж авчрах биш, харин манай даатгалын тогтолцоогоо сайжруулж, ЭМД-ын тогтолцоог, хувийн даатгалыг яаж нийлүүлэх вэ, яаж олон улсын ЭМД-ыг Монголын даатгалын компанитай нийлүүлж, Монголдоо нутагшуулах вэ гэдэг дээр анхаарч ажиллана.

Янз, янз, ЭМД дампуурсан, мөн хувийн эмнэлгүүд болон бусад эмнэлгүүд мөнгө аваад байдаг мөртөө үйлчилгээ нь муу, чанар муутай, мөн өвчтөнддээ хангалттай үйлчилгээ авч, үзүүлж чадахгүй байна гэдэг тийм зүйл хэллээ та. Үүн дээр жишээ нь би бол яг системээ анализ хийнэ, яг хаана нь болохгүй байна гэдгийг бүгдийг нь харж байгаад засахын төлөө ажиллана. Мөн цаашлаад яривал энэ бүх ЭМД-ын сан дээр би өөрөө бүх санхүүгийн мэдээллийг нь авч байгаад, тэгээд аудит

хийнэ. Аудит хийхдээ мэргэжлийн улсуудыг ч цуг ажиллана, мөн өөрөө ч гэсэн яг сууж байж хийнэ. Яг юуны түрүүн санхүүч хүн билээ.

Салбарын хувьд би мэдээж хамгийн салбарын туршлагатай, мундаг эмч нар, багш нар, доктор, профессоруудтай цуг хамтарч ажиллана. Мөн туршлагатай эмч Их Хурлын гишүүдтэйгээ цуг бодлого тодорхойлохдоо цуг хамтарч ажиллана гэж хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Бейсен гишүүн нэмэлт 1 минут асууя.

Б.Бейсен: Байгаль орчны сайд Сандаг-Очир сайдаас нэг юм асуумаар байх юм. Энэ төрийн тусгай хамгаалалттай газар байна шүү дээ. Бид түрүүн туршлага судлаад ирсэн. Гэтэл тэнд хувийн хэвшилтэй хамтарч ажилладаг юм байна. Тэгэхгүй бол отоглох газар байхгүй, ариун цэврийн байгууламж байхгүй. Энэ тал дээр та хувийн хэвшилтэй хамтарч ажиллах тал дээр ямар бодлого барьж ажиллах вэ гэдгээ хэлье, асууя.

Эрүүл мэндийн сайдтай холбоотой сая нөгөө өр зээлээ ил гаргахгүй бол ерөөсөө болохгүй өглөг, авлагын бүх эмнэлгүүдийн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад түрүүн өргөн хэрэглээний бараа, мах, сүү, талх, бензин бүх шатахуун нэмэгдлээ, мах 30 мянга хүрлээ. Тийм учраас түрүүчийн 80 мянга чинь юу ч үгүй болчихлоо. Одоо цалинг нь тэтгэвэр, тэтгэмжийг дахиж нэмэхгүй бол болохгүй нь гэдгийг хэлье. Байгаль орчны сайд.../минут дуусав/

С.Бямбацогт: Сандаг-Очир нэр дэвшигч хариулъя.

Ц.Сандаг-Очир: Бейсен гишүүний асуултад хариулъя. Манай салбар онцлог. Тэгээд Төрийн тусгай хамгаалалттай газрын асуудлыг ярьж байна. Хувийн хэвшлийнхэнтэй яаж, хэрхэн хамтарч ажиллах вэ гэж. Манай салбарын онцлог төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоо, тэдний дуу хоолойг сонсож, хамтарч ажиллах асуудал хамгийн чухал асуудал. Тийм учраас мэдээж энэ салбарт төрийн бус байгууллагууд, олон нийтийн оролцоотой иргэдийн дуу хоолойг сонсож, хамтарч ажиллахаас өөр гарцаагүй. Тийм учраас энэ салбарт аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр, байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудлын чиглэлээр, тэгээд уур амьсгал, орчны бохирдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллана гэж ингэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Батчимэг гишүүн асуултаа асууя. Энэ УИХ маань өнөөдөр 3 дахь ЗГ-ынхаа нүүрийг үзэх гээд, сайдад нэр дэвшигчдээсээ асуулт асууж байна. ЗГ огцрох бүрд төрийн захиргааны төв байгууллага хөдөлгөөнд орж, бүтцэд өөрчлөлт орж, бөөн зардлууд гардаг ийм явдал байдаг. Өнөөдөр энэ сайдад нэр дэвшиж байгаа гишүүдийн дунд Соёлын сайдад нэр дэвшиж байгаа манай Номин гишүүний хувьд би хэлэх гээд байна л даа. Манай нэр дэвшигч маань байна уу зааланд, чуулганы танхимд? Номин сайдын хувьд Хууль зүйн сайд Энхбаярын удаа дараагийн мэдэгдлээр Соёлын сайд байхдаа зориулалтын бусаар ОТ-гоос авсан 20 сая ам.долларын тодорхой дүнг хоёрхон гишүүнтэй гадаад компани руу мөнгө шилжүүлж байсан гэсэн энэ шуугиан өнөөдрийг хүртэл тасрахгүй л байгаа.

Өөрийнхөө wikipedia хаягийг хөгжүүлсэн, гадаад явахдаа хэлэх үгээ бэлтгүүлсэн, бүүр хоолны мөнгө зардал ч гэсэн ийм мэдээлэл явдаг. Тэгэхээр энэ

зориулалтын бус зарцуулалт энэ сайд байхдаа ийм зохисгүй үйлдэл хийж байсан ийм нэр дэвшигч өнөөдөр шинэ ЗГ-ын сайдад нэр, бүтцэд орж нэр дэвшээд орж ирж байгаад гайхаж байна. Энэ асуудал юу болсон бол Учрал сайд? Дахиад ингээд Номин гишүүн та ийм зарчимгүй асуудалд нэр холбогдохгүй байж чадах уу гэж Номин гишүүнээс асуух байна?

Ер нь тэгээд Учрал Ерөнхий сайд танд нэр цэвэр, асуудалд холбогдоогүй ийм гишүүн сайд байгаагүй юм уу? Ийм байдлаар ингээд явахад таны энэ иргэдийн итгэл сэргэж, шударга ёс хангагдаж байгаа байж чадаж байгаа юм уу, хангагдаж байна гэж үзэж байна уу? Ер нь энэ ЗГ-ын шинээр байгуулагдах ЗГ-ын уриа лоозон ер нь юу юм бэ? Нөгөө л урд талын Занданшатар Ерөнхий сайдын ЗГ хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, том мега төсөл л гэсэн. Тэгвэл энэ ЗГ-т ямар чиглэлээр яг үйл ажиллагаагаа явуулах юм бэ? Энд ер нь эрээн мяраан олон л өнгө харагдаж байгаа юм. Хүнд сурталтай ч хүмүүс нь харагдаж л байна, хөнгөн жингийнх нь ч харагдаж л байна. Гүйдэг, суудаг улсууд, гишүүд ч явж л байгаа. Мэдээж сайн, сайн ажилласан, мэдлэг туршлагатай зарим сайдууд нь ажлаа өгсөнд маш их харамсаж байна. Зарим нь өвлүүлээд өмчлүүлээд өгчихсөн юм шиг сууж байгаа тийм суумал сайдууд нь ч байна. Магадгүй сайн ажиллахыг үгүйсгэхгүй.

Тэгэхдээ энэ сайдын суудал бол менежер бэлтгэдэг талбар биш. Мэргэшсэн хүний ажилд очиж ажилладаг, мэргэжлийн туршлагатай хүний л очиж ажиллах энэ талбар байгаа шүү дээ. Жишээ нь Дархан руу ХХААЯ-ыг нүүлгээд богино хугацаанд хөдөлгөөн хийсэн Ж.Энхбаяр сайдын гавьяа юу, гай юу одоо бид дүгнэхэд үнэхээр чадахгүй байна л даа. Дараагийн сайд нь ажиллаад бас л хэдхэн сар болоод уначихсан. Хаврын тариалалт, өчнөөн олон аж ахуй, хөдөө аж ахуйн орон.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд асуучих уу? Батчимэг гишүүн гүйцээгээд асуучихъя.

П.Батчимэг: Хаврын ид ажил тариалалт, үр тарианы, энэ цаг ноос ноолуур бүх юм ингээд хөдөлчихсөн аж ахуйн ажлын цаг дээр завсрын бүс дээр ингээд л ЗГ огцроод л, сайдууд нь ингээд л бүүр эрэлд гараад энэ бүгд ингээд хөдөлгөөнд орчихсон ороо босгоо ордны амьдрал, гадаа амьдрал маш хүнд. Дааж давшгүй ачаа үүрсэн энэ татвар төлөгчдийг өнөөдөр хайрлах, энэрэх хүмүүс энэ танхимд ер нь хэд байдаг юм бол? Авлигал, хээл хахууль энэ аймаар сүлжээ, хулгайчид, нүүрсний хулгайчид баахан сошиалаар ард түмний тархийг оюуныг бүр гэмтээгээд бэртээгээд, өттүүлээд, өмхийрүүлээд тавьчихсан. Гэтэл өнөөдөр аль нь үнэн, аль нь худлаа гэдэг нь ерөөсөө мэдэгдэхгүй байгаа. Энэ тал дээр өнөөдөр Хууль зүйн сайд яаж ажиллах юм бэ? Энхбаяр сайдад үнэхээр би талархалтай ханддаг. Тэгэхээр энэ ЗГ үнэхээр яг ямар чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж тогтвортой байх юм уу, үгүй юу?

С.Бямбацогт: Энхбаяр, Ерөнхий сайд хариулъя, араас нь Номин сайд бэлдэж байгаарай.

Н.Учрал: Бүгдэд таалагдах бүрэлдэхүүн хэзээ ч байгаагүй, хэзээ ч байхгүй нь үнэн байх. Энэ бол эрх чөлөөт нийгмийн зүй тогтол. Сөрөг хүчин эрх барьж байгаа намын байгуулж байгаа ЗГ-ыг шүүмжлэх нь энэ бол ардчилсан орны нээлттэй үзэгдэл. Би сөрөг хүчнээ үргэлж хүндэтгэнэ. Та бүхэн шүүмжлэх эрхтэй, хяналт тавих эрхтэй. Гэхдээ ЗГ-ын ажил Их Хурлын гишүүн эсвэл Их Хурлын дарга бусад албан тушаалаас их өөр. Би 3 удаа ЗГ-т ажиллалаа. Яг ачаа үүрдэг л ажил,

гал усан дундуур орж, түмэн олныхоо дунд шүүлгэдэг, элдэв янзаар хэлүүлдэг, түүнийг дааж гардаг хэдий ч улс орны амьдралд цаг минутаар хэмжигддэг учраас цаг минутаар тэр ачааг дааж гардаг ажил. Тийм учраас шинэ Үндсэн хуулиар энэ Ерөнхий сайд өөрөө кабинетаа бүрдүүлэх гэхээр нь Ерөнхий сайдад өөрт нь хариуцлага тооцох гээд байгаа хэлбэр. Тэгэхээр тэр хүн хоолоо хэнээр хийлгэх юм, цайгаа хэнээр чануулах юм, ачаагаа хэнээр өргүүлэх юм бэ гэдгээ өөрөө сонгоод, би энэ багаар энэ үр дүнд хүрэх юм байна гэж сонгодог учраас энэ эрхийг өгсөн.

Тийм учраас би энэ удаа Цахим хөгжлийн сайдаар Номин сайдыг томилохоор танилцуулж байгаа. Бид хамтдаа засагт ажиллаж байсан. Надад үр дүн чухал. Номин өнгөрсөн хугацаанд энэ зөөлөн хүчний индексийг урагшлуулахад, энэ цахим засаглалын индексийг урагшлуулахад онцгой гавьяа байгуулсан. Надад бол жоохон ажил хийдэг хүн л хэрэгтэй байгаа юм яг үнэндээ. Тэрнээс биш би нөгөө нэг ард түмэнд их гоё сайхнаар дандаа дуудуулдаг гээд би нэг бүх оддын чуулган гэдэг шиг сайд нар оруулж ирнэ. Тэгээд би тэд нарт ажил заах гэж өөрөө төөрсөөр байгаад тэгээд амжилтгүй болно. Тийм учраас өмнө нь сайд байсан, аймаг, орон нутаг удирдаж байсан, үр дүн гаргаж байсан ийм хүмүүсийг аваад одоо ингээд л маргааш анхныхаа хурлыг хийе. Дараа долоо хоногоос ажилдаа ханцуй шамлаад оръё, тэгээд гал усан дундуур явна, элдэв үгээр шүүмжлүүлнэ, тэгээд тэр шүүмжийг үл тоо, үр дүнд гаргахын төлөө л явах ёстой гэж би шаардаж байгаа юм.

Тийм учраас яг нөгөө ачаа даах чадвар болоод манай энэ цахим засаглалын индекс өнгөрсөн хугацаанд 28 байр урагшилсан. Цаашдаа бид надад энэ хүнд суртлын чөлөөлөлт гээд энэ бодлогоо хэрэгжүүлэхэд буюу танд хэлээд байгаа энэ эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлт, Авлигын эсрэг чөлөөлөлт, Ногоон хөгжлийн чөлөөлөлт, Эрх зүйн чөлөөлөлт, Эдийн засгийн чөлөөлөлт гэсэн 4 чөлөөлөлтийг хийхэд буюу энэ авлигын эсрэг чөлөөлөлтийг амилуулахад нээлттэй Засаг их чухал. Тийм учраас И бизнесээр дамжуулаад зөвхөн зөвшөөрлийг цахимаар олгох, И бизнесийг олон нийтэд танилцуулна. Тэгээд ер нь И Монголыг ахисан түвшинд гаргана. Үүн дээр би Номин сайдыг хариуцлага хүлээгээд, ачаа үүрээд ирсэн хүн, цаашид чадна гэдэгт эргэлзэхгүй байгаа. Тэгээд үр дүнгээрээ харуулах байх гэж бодож байна.

С.Бямбацогт: Нэр дэвшигч Номин хариулъя.

Ч.Номин: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Юун түрүүнд энэхүү 20 сая доллартой холбоотой асуудлыг төрийн захиргааны байгууллагын хувьд ямар ч Соёлын яамтай буюу миний өмнө нь тэргүүлж байсан яамтай хамааралгүй. Миний хувьд яг тухайн үед Монгол Улсыг олон улсад сурталчлах үндэсний хороог ахалж ажиллаж байсан. Энэ ажлынхаа хүрээнд би 2 жилийн хугацаатай Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах стратеги төлөвлөгөөгөө боловсруулаад, энэ стратеги төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн ажлуудын 200 гаруй хуудастай тайлангаас зөвхөн нэг хуудсыг тусгайлан гаргаж тавьсан ийм ташаа мэдээлэл дээр суурилсан, шууд гүтгэлэг гэж үзэж байгаа. Миний хувьд ямар нэгэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл нэг ч хийгээгүй. Төрд ажиллаж байх хугацаандаа зөвхөн Монгол Улсынхаа нэр хүндийг дэлхийд өргөхийн төлөө ажилласан.

Энэний үр дүнд ч гэсэн өнөөдөр бид бүхэн аялал жуулчлалын салбарт эдийн засгийн эргэлтийг 1,6 тэрбум төгрөг доллар шүү, 1,6 тэрбум доллар болгож.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

Ч.Номин: Нэмэгдүүлсэн байна. Мөн намайг ажил авч байх үед буюу pre covid өмнөх үед 500 мянга орчим жуулчин ирж байсан бол өнөөдөр 800 мянга орчим жуулчин ирсэн байна. Тэгэхдээ та бүхэн юуг ойлгох ёстой вэ гэхээр бид өөрийн улсаа зөвөөр сурталчилж байж эргээд орлого олно. Нөгөө талдаа бид бүхэн улсынхаа мэдээ мэдээллийг дэлхийд зөвөөр ойлгуулж байж нөгөө түрүүний яриад байгаа эдийн засгийн индексүүд нэмэгдэнэ, зөөлөн хүчний индексүүд нэмэгдэнэ. Энэ ажлыг л би бүрэн хэмжээнд хийсэн. Ямар нэгэн авлигал, ашиг сонирхлын зөрчилтэй асуудалд оролцоогүй гэдгээ албан ёсоор хэлье.

С.Бямбацогт: Батчимэг гишүүн 1 минут.

П.Батчимэг: Учрал сайд та миний юунд гүйцэд хариулсангүй л дээ. Зүгээр өөрийнхөө хуучин ажиллаж байсан Цахим, инновац энэ яамныхаа талаар ярьж байх шиг байна. Wish гэдэг юм нэг өөр байдаг, хүлээлт гэдэг юм чинь тас өөр юм л даа. Тэгэхдээ Номин гишүүний хувьд дахиад энэ сайдад нэр дэвшиж байгаа, энэ сайдын үүрэгт ажлыг хийх явцдаа ингэж дахиж нэр юу ийм үйлдэл гаргахгүй байх тийм баталгаа юу байгаа юм бэ л гэж асуусан.

Тэгээд би бас энэ Хууль зүйн сайдад нэр дэвшигчээс асууж Амарсайхан гишүүнээс асуулаа. Ж.Энхбаяр сайдтай холбоотой асуулаа. Тэгээд энд хариултыг бүрэн авъя.

С.Бямбацогт: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Батчимэг гишүүний асуултад хариулъя. ХХААХҮЯ Дархан хотод шилжсэн тухай. ЗГ-ын мөрийн хөтөлбөрийг та бид баталсан. Энэ мөрийн хөтөлбөрөөр УИХ тогтоол гаргаж, ХХААХҮЯ-ыг төвлөрлийг сааруулах, хөдөөгийн хөгжлийг дэмжих, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үүднээс нүү гэдэг тогтоол Их Хурал баталж, надад ЗГ-т үүрэг өгсөн. Энэ дагуу яам салбартаа шилжин очсон, үр дүн өндөр гарсан, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл өссөн. 2 хүний нэг нь ажиллаж байгаа энэ салбарт нийт 38 мянган ажлын байр шинээр бий болж, ХАА-н салбар 33 хувийн өсөлтийг үзүүлж, Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн 60 гаруй хувийг дангаараа хангаж ирлээ. Энэтэй холбоотойгоор хүнс, хөнгөн үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалан гээд цогц бодлогыг хэрэгжүүлсэн, бодлогын үр дүн их эерэг гарсан. Энийг цаашдаа үргэлжлүүлэх ёстой гэж.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхбат гишүүн асуултаа асууя, Мөнхбат гишүүн алга. Наранбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Н.Наранбаатар: Оройн мэнд хүргэе. Шинээр томилогдож байгаа гишүүддээ бүгдээрэнд нь амжилт хүсье, дэмжиж байгаа. Зөвхөн говь нутгийн асуудал биш, Монгол орны хэмжээнд цөлжилтийн асуудал нэн тулгамдсан ийм асуудал байгаа юм. Тэгэхээр зэрэг манай улсад энэ зун зохион байгуулагдах энэ цөлжилтийн эсрэг энэ талуудын оролцоотой бага хурлыг би нэлээн ач холбогдол өгч хүлээж байгаа. Тэн дээр олон зүйлүүдийг шийдэх байх гэж бодож байгаа.

Ялангуяа энэ говийн бүс нутаг руу ус аваачих, усжуулах 2 томоохон төсөл ЗГ-ын мөрийн хөтөлбөрт суугаад ингээд явж байгаа. Тэгэхээр зэрэг шинээр томилогдож байгаа Сандаг-Очир сайд маань энэ чиглэлд нэлээн анхаарч ажиллах байх. Түрүүчийн сайд ярьж байсан нэлээдгүй ажлуудыг хийж байгаа, энэ чиглэлд

нэлээн хөрөнгө оруулалт ирж байгаа гэсэн зүйлүүдийг ярьж байсан. Тэгэхээр үүнийг үргэлжлүүлж энэ Орхон говь, Хэрлэн Тоонот гэсэн 2 төслийг урагшлуулах эрчимжүүлэхэд онцгой анхаарч ажиллаасай гэж ингэж хүсэж байна.

Дараагийн дугаарт манай малчдын гол эх үүсвэр энэ ноолуур байгаа. Жилийн 4 улиралд хавар цагт нь ганц олдог. Нийт ер нь орлогынхоо 50 гаруй хувийг нь энэ ноолуураас олдог. Зүүн бүсэд сая ноолуурын дуудлага худалдаа явсан. Үнийн хувьд гайгүй боломжийн байсан гэж ойлгож байгаа. Ноолуурын үнийг бууруулахгүй байх дээр тодорхой бодлого барих хэрэгтэй. Малчдын маань хүсэн хүлээгээд байгаа тэр малын гаралтай түүхий эдийг боловсруулах, дотооддоо нэмүү өртөг бий болгох, өндөр үнэтэй экспортод гаргах энэ чиглэл дээр онцгой анхаарч ажиллаарай гэж хүсэх байна.

Дараагийн ээлжид Дамдинням сайд маань Ашигт малтмалын тухай хуулийг боловсруулаад нэмэлт, өөрчлөлтийн төслийг тун өргөн барихад ойрхон оччихсон байгаа. Ойрын үед өргөн барих байх гэж бодож байгаа. Энэ орон нутгийн өгөөжийг нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарах хэрэгтэй байна гэж. Ялангуяа энэ уул уурхайн бүс нутгийн иргэдийн амьдрал, бэлчээр, усны асуудал гээд хүнд асуудлууд тулгарч байгаа. Өнөөдөр бидний ганц орлого олж байгаа л салбар энэ уул уурхайн салбар байгаа. Тийм учраас тэнд ажиллаж байгаа энэ иргэд, тэнд ажиллаж байгаа засаг захиргаа, байгаль орчин, малчид руу чиглэсэн хөрөнгө оруулалтыг хийхэд энэ Амнат-ын төлбөрийн хуваарилалт их чухал байгаа. Тийм учраас энэ хуулиа түргэн өргөн барьж, түргэн нэг өдрийн өмнө ч гэсэн батлах нь зүйтэй гэж хэлэх гэсэн юм.

Дараа нь Эдийн засгийн хөгжлийн сайд энэ бүсчилсэн хөгжлийн асуудлыг хариуцдаг. Тэгэхээр энэ бүсчилсэн хөгжил гээд 2002 оноос л бид ярьсан. Тэгээд дорвитой сайн ажил хийгдэхгүй нэг цаасан дээр яваад байгаа. Тэгэхээр энэ дээр нэлээн анхаарч хууль, эрх зүйн орчныг өөрчлөх, энэ бүсийн удирдлага, зохицуулалт, бүсийн хөрөнгө оруулалт, төсөв санхүү, энэ бүсийн хоорондын уялдаа, бүсийн хэмжээний томоохон бүтээн байгуулалт гээд энэ бүсчилсэн хөгжил дээр анхаарах хууль, эрх зүйн орчныг нь өөрчлөх ийм чиглэлийн ажлуудыг нэлээн хийх нь зүйтэй болов уу гэж ингэж бодож байгаа.

Боловсролын салбарын хувьд Өмнөговь аймагт байгаа ШУТИС-ийн харьяа сургуулийн барилга баригдахаар шав тавигдсан. Тэгээд өнөөдрийг хүртэл ажил эхлээгүй явж байгаа. Уг нь.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Хэнээс, гүйцээгээд асуучихъя Наранбаатар гишүүн асуултаа нэмж асууя.

Н.Наранбаатар: Тэгэхээр одоо уг нь ОТ компанитай хамтын ажиллагааны гэрээнд бас энэ асуудал ингээд тусгагдчихсан байдаг юм. Тэгэхээр энийг цааш нь ажил хэрэг болгох, тэр түрээсийн байранд байгаа энэ сургуулийг нь өөрийн гэсэн байртай болгох, оюутны хотхоныг иж бүрэн цогцоор нь барьж байгуулах, өмнө нь эхлүүлсэн энэ ажлаа цааш нь үргэлжлүүлж, яаравчлуулах ийм шаардлагатай байгаа гэдгийг хэлье. Тэгээд бүгдэд нь амжилт хүсье. Асуулт алга.

С.Бямбацогт: Ганзориг гишүүн асуултаа асууя. Асуулт асуусангүй. Байхгүй байна. Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Монгол Улсын Ерөнхий сайдаас эхнийхээ асуултыг асууя. Монгол Улсын Ерөнхий сайд үнэн байя гэдэг үгийг сүүлийн

3 хоног тасралтгүй хэлсэн. Өнөөдрийн энэ томилгоо яг таны өөрийн итгэл үнэмшлээр үнэн байж чадаж байна уу? Энийг яг ард иргэдийнхээ өмнө нэг хэлээд өгчхөөрэй. Ялангуяа Монголчууд, залуучууд, эмэгтэйчүүд, Монголын ард түмэн танд өнөөдөр итгэж байгаа. Тэгэхэд энэ томилгоо үнэн байж чадсан уу? Энд нэг хариулаад өгчхөөрэй.

Дараа нь Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Жадамбын Энхбаяраас асууя. Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ийг яг хэзээ, хэрхэн яаж 10 мянган долларт хүргэх вэ? Хариулаад өгөөрэй.

Дараагийнх нь Монгол Улсын ЗГ-ын Шадар сайд Тогмидын Доржхандаас асууя. Эрчим хүчний үндэсний хороо гэж ажилласан. Гаднаас эрчим хүчний хөрөнгө оруулалтыг татаж оруулж ирсэн гэсэн. 2 жилийн дотор би эрчим хүчний салбарыг тусгаар тогтнолыг нь Монголдоо дотооддоо 100 хувь үйлдвэрлэж, тусгаар тогтнолоо зарлана гэсэн, экспортод гаргана гэсэн, яг хэзээ, хэрхэн яаж бид дотоодынхоо эрчим хүчийг 100 хувь өөрсдөө хангаж, хэзээ экспортод гаргах вэ?

Дараагийн асуултыг Монгол Улсын ЗГХЭГ-ын дарга Баттөмөрийн Энхбаяраас асууя. Энхбаяр сайд танд төрийн өмчийн олон компаниуд очно. Энэ алдагдалтай, ашиггүй ажиллаж байгаа төрийн өмчийн компаниудад хэзээ хариуцлага тооцож, дампуурахыг нь дампууруулж, татан буулгахыг нь татан буулгаж, хувьчлахыг нь хэзээ хувьчлах вэ?

Монгол Улсын Сангийн сайд Загджавын Мэндсайханаас асууя. Төсөв батлах болгонд Их Хурлын гишүүн тойрог дээрээ мөнгө татаж, Сангийн сайдыг зовоодог. Та Сангийн сайдын хувьд энэ байдлыг 2027 оны төсөв батлахад таслан зогсоож чадах уу?

Дараагийнх нь Монгол Улсын ХЗДХ-ийн сайд Сайнбуянгийн Амарсайханаас асууя. МАН-ынхан 2 тал болоод бие биеийгээ хулгайч гээд Монгол орон даяар сүүлийн хэдэн сар зарлалаа. Тэр 110 сая долларыг Энхбаяр сайдыг авсан гэдэг. Энхбаяр сайд нь Бортээгтэй холбоотой асуудлыг ярьдаг, бараг л хүн шатаагаад алсан гэдэг. Тэгэхээр та хууль зүйн бодлого эд нараа боловсруулж, энэ ард иргэдийн дунд үүссэн байгаа Жижиг, дунд үйлдвэрлэл /ЖДҮ/-лэлийн сантай холбоотой, Боловсролын сантай холбоотой энэ бие биеийнхээ хулгай луйвартай асуудлыг хэзээ, хэрхэн яаж хийж, тодруулж, иргэддээ тайлагнаж хэлэх вэ?

Дараагийнх нь Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдиннямаас асууя. Аж үйлдвэрийн паркийн тухай хууль нэлээн сайн боловсруулаад явж байгаа. Нэгд та түрүүн хэллээ. Монгол Улс гангийн үйлдвэртэй болох ёстой гэсэн. Хэзээ Монгол Улс гангийн үйлдвэртэй яг болох вэ, нефтийн үйлдвэр яг хэзээ орох вэ, хэзээ зэс баяжуулах үйлдвэрээ бид хийж дуусгах вэ?

Дараагийнх нь Монгол Улсын Боловсролын сайдаас асууя. Боловсролын тогтолцоо үнэхээр муудсан. Боловсролын тухай хуулийг шинэчлэх шаардлагатай юу, шаардлагагүй юу? АН-ын бүлгийн гишүүн Мөнхтуяа гишүүнээс Боловсролын энэ тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр ажиллаж байгаа юм байна лээ. Та тэрэнтэй танилцсан уу, энийг юу гэж бодож байна вэ?

Дараагийнх нь Зам тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайханаас асууя. Хэзээ Монгол Улс зүүн болон баруун босоо энэ төмөр зам орох вэ? Энэ төмөр зам чинь Монгол Улсын хөгжлийн гол тулах цэг болж байгаа юм.

Дараагийнх нь Монгол Улсын Аялал жуулчлал, залуучуудын сайд Алдаржавхлангаас асууя. Хэзээ Монгол Улсад хэрхэн, яаж энэ гаднын жуулчид орж ирж, ДНБ-д нэмэр болох вэ? Энэ жил хэд орж ирэх үү, дараа жил хэд орж ирэх үү? Бид гаднын аялал жуулчлалыг татахын тулд ямар бодлого боловсруулж ажиллах вэ?

Дараагийнх нь Хот байгуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалангаас асууя. Гадаа иргэд босож байна. Та энэ бослогыг хэрхэн, яаж дарах гэж байна вэ? Хэзээ Монгол Улсын иргэд бүгд орон сууцад орж, аз жаргалтай амьдрах вэ? Энэ дээр ямар, 1 минутаа авчихъя.

Дараагийнх нь ХХААХҮ-ийн сайд.../минут дуусав/

С.Бямбацогт: Очирбат гишүүнд 1 минут нэмээд.

Г.Очирбат: Цагаанхүүгийн Идэрбатаас асууя. Монгол Улс хэзээ дотооддоо өөрсдийнхөө хэрэгцээний хүнсний ногоог 100 хувь үйлдвэрлэж чаддаг болох вэ? Хэзээ бид энэ арьс ширээ өнөөдөр Монголын арьс шир гадагшаа экспортод гарч чадахгүй гацаад зогсож байна гаалийн ганц хоёрхон бичгээс болоод. Хэзээ бид энэ арьс ширээ экспортод гаргадаг болох вэ?

Дараагийнх нь Монгол Улсын Эрчим хүчний сайд Бадрахын Найдалаагаас асууя. ЗГ-ын чиглэл өгөх тухай 119 дүгээр тогтоол гарсан ногоон эрчим хүч гээд. Энийг яг өнөөдөр ингээд Их Хурлын тогтоол гаргаад өгчихсөн байгаа боловч энэ цахилгаан дамжуулах түгээхэд чинь иргэд 20квт-ын эрчим хүчээ өөрөө үйлдвэрлээд мөнгөө авъя гэхээр өгөхгүй байна, журам нь гараад өгчхөөч, энийг хэзээ та шийдэх вэ?

Хамгийн сүүлийнх нь Эрүүл мэндийн сайдаас асууя Батшугар сайдаас. Монгол Улсын иргэд эмнэлэг дээр дугаарлаад зогсож байна. ЭМД-ын сан чинь гацчихсан, энэ гацаанаас хэзээ гарах вэ гэсэн асуултуудад хариулт авъя.

С.Бямбацогт: Сайд нар 1, 1 минутад багтаагаад хариулчхаарай. Энхбаяр сайдаас эхэлье ЗГХЭГ-ын даргад нэр дэвшигч.

Ж.Энхбаяр: Өнөөдөр 25 оны гүйцэтгэлээр ДНБ-ий 1 хүнд ноогдох орлого 7320 ам.доллар хүрээд байна. Монгол Улсын эдийн засаг 25,2 тэрбум доллар болжээ. 2001 онд Монгол Улсын эдийн засаг 1 тэрбум доллар байсан юм. Өнгөрсөн 25 жилийн хугацаанд бид эдийн засгаа 25 дахин тэлсэн байна. 2030 он хүртэлх Монголын нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх үндсэн зорилтын хүрээнд 2030 он гэхэд нэг хүнд ноогдох орлого 10700 болно гэсэн ийм зорилт тавьж, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байна. Ингээд энэ их гол үзүүлэлт байдаг, ДНБ 1 хүнд ноогдох орлого 10 мянган доллар хүрснээр үндсэндээ амьдралын чанарт эрс өөрчлөлт гардаг. Боловсрол, эрүүл мэндийн болон орлогын чанарт их өндөр үзүүлэлт үзүүлж эхэлдэг. Зээлийн хүү буурдаг, улс орны эдийн засгийн чадавч сайжирдаг, цалингийн өсөлт 60-аас доошгүй хувиар өнөөгийн байгаагаас нэмэгдэх ийм бололцоо.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүний одоо хэрэгжиж байгаа хуулийн дагуу л сайд нараа оруулж ирсэн, та бүхэнд танилцуулж байна. Тэгээд энэ манай кабинет. Би энэ багаар үр дүнд хүрч чадна л гэж тооцсон. Гадаад хямрал болж байгаа үед дотоод зөрчил байж болохгүй. Тийм учраас энэ цаг үеийг давахад дотоод сахилга бат, хариуцлага хамгийн их чухал. Тэгэхээр энэ кабинет бие биеийнхээ дутууг нөхөөд ажиллаж чадах бололцоотой. Дээрээс нь суралцаад байх шаардлага байхгүй ийм л туршлагатай баг гэж үзэж байна. Тэгээд миний итгэл үнэмшил, миний Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх энэ багаар үр дүнд хүрнэ гэж тооцож л өөрийнхөө кабинетыг оруулж ирсэн. Тэгээд би ажил эхлэхээс өмнө их гайхамшиг бүтээнэ, ид шид бүтээнэ гэж гоё, гоё сайхан юм яриад яах вэ. Үр дүнгээрээ хэмжүүлье, ажилдаа хурдан шуурхай оръё. Тэгээд бид үнэнтэй нүүр тулж байгаа, үнэнээс зугтаж их олон жил явсан. Үнэнтэй их тулах хэрэгтэй.

Тийм учраас бид дэлхийн цаг төрийн байдал ийм байхад үнэнтэй нүүр тулна. Тэр үнэнийг би хэзээ ч нуухгүй, тэр үнэнийг ямар нэгэн худал зүйлээр дарах гэж янз бүрийн оролдлого хийхгүй. Ард түмнийгээ энтертайнментаар угаахгүй, болж байгаа юмыг болж байгаагаар нь, болохгүй юмыг болохгүй байгаагаар нь үнэнээ хэлээд, хамтдаа энэ салхи шуургыг сөрж давна. Үүн дээр хоосон улс төрчид хийхгүй, худлаа попрол хэрэглэхгүй. Сөрөг хүчнийхээ дуу хоолой болоод парламентын гишүүд, ард түмнийхээ дуу хоолойг сонсож, ард түмнийхээ дунд орж ажиллана.

Тэр ТӨК-удын зардлыг бууруулах болоод төрийн алба бусад түвшинд тэр хэмнэлт юу хийх дээр өнгөрсөн хугацаанд Хэрэг эрхлэхийн дарга байхдаа хийсэн ажлууд бий. Тийм учраас нэг зүйлийг нэмээд хэлэхэд ТӨК-уд дээр зөвхөн хөрөнгө оруулалтыг нь эрэмбэлэх чиглэлээр хэмнэлт хийх бололцоог судалгааг нь гаргасан. ТӨК-удыг share office хэлбэрт шилжүүлж, жил бүр 5,3 тэрбумыг хэмнэнэ. KPI-р үнэлдэг болно, цалин хөлсний шинэ тогтолцоог нэвтрүүлнэ. Тэгээд олон тэр хэмнэлтүүдийг би илтгэлдээ дурдсан. Олон хөгжлийн төвүүд шаардлагагүй зүйлсийг мэргэжлийн холбоодод нь шилжүүлнэ. Ер нь авлигатай ч бай, бусад хууль бус үйлдэлтэй болоод өнгөрснийх нь дараа шаналж суух биш, болохоос нь өмнө урьдчилан сэргийлэхийн тулд бид хариу арга хэмжээнүүдийг шат дараатай авна. Олон жил дуусдаггүй олон ярианууд бий. Дуусгахын төлөө ажиллана. Аливаа хүндрэлд сайн тал бас байдаг. Тэгээд ийм үед үнэн.../минут дуусав/

С.Бямбацогт: Хэрэг эрхлэхийн даргад нэр дэвшигч, Шадар сайд Доржханд нэр дэвшигч.

Т.Доржханд: Яг 6 жилийн өмнө яг 2020 оны ЗГ орж байхад би 2 минутад багтааж 15 асуулт асууж байсан юм. Манай Очирбат гишүүн болохлоор бараг 2 минутад 20 асуулт асууж байна. Маш сайн асуулт байна. Товчхон хариулъя. 2, 3 жилийн дотор та энэ эрчим хүчний эрх чөлөөг бий болгоно гэж мэдэгдэж байсан гээд үнэн. Тэр бол 2025 оны 01 дүгээр сард тэгж зарлаж байсан. Эрчим хүчний үндэсний хороо байгуулагдаж байсан, тэгээд харамсалтай нь яг 6 сар ажиллаад ЗГ солигдсон. Тэгээд Үндэсний хороог татан буулгасан. Энэ ингээд бодит байдал. Тэгээд ЗГ солигдсоны дараа тогтворгүй байдал үүссэн байна гээд том хөрөнгө оруулагч нар, харьцаж байсан байгууллагууд зогссон. Тэгэхдээ 10 сард Aqua power гээд Саудын Арабын компани 10 гегаваттын хөрөнгө оруулалт хийхээ өөрсдөө ирээд зарлаад, ажлаа хийгээд, одоо ингээд судалгааны ажлаа дуусгачихсан ингээд явж байгаа. Дахиад ЗГ солигдож байгаа, тэгээд тэнд дайн болж байгаа. Тэгэхдээ бид харилцаатай байна.

С.Бямбацогт: Шадар сайд 1 минут тодруулчихъя.

Т.Доржханд: Тэгээд энэ хугацаанд зүгээр юу хийсэн бэ гэхээр яг энэ нэг жилийн хугацаанд 2 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийх Европын хөрөнгө оруулалтын банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк бол ингээд шийдвэрээ гаргасан, шууд хувийн секторт мөнгө өгөх. Тэгэхлээр өнөөдөр эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийх хувийн сектор бол мөнгө нь тэнд бэлэн байгаа. Харин одоо юу дутаад байна гээд гэхээр нөгөө АQT буюу өөрийнхөө хөрөнгө нь 20-оос 30 хувийг гаргаад, тэгээд санхүүжилтээ 70-аас 80 хувийг авдаг. Энэ дээр гацчихаад байгаа, энэ ажлыг үргэлжлүүлээд явах гэж байна. Тэгээд 2028 он гэхэд хэрвээ энэ ЗГ тогтвортой байгаад явбал бид хөрөнгө оруулалтаа татаад, тэгээд бие даасан байдлыг хангах бүрэн боломжтой гэдэг.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр нэр дэвшигч ЗГХЭГ-ын даргад нэр дэвшигч.

Б.Энхбаяр: 2016 онд ХЗДХ-ийн дэд сайдаар ажиллаж байх үедээ төрийн өмчийн компанийн, нийтийн өмчийн хуулийн төслийн ажлын хэсгийг анх ахлуулж эхлүүлж байсан. Энэ төсөл маш олон ЗГ дамжиж, Ерөнхий сайд Учрал Хэрэг эрхлэхийн сайд байхдаа ажлын хэсгийг ахалж УИХ-д өргөн барьсан. Бид хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн байгаа. УИХ дээр Үүрийнтуяа, Сайнзориг, Номинчимэг гишүүн нар улс төрийн манлайлал хийж, энийг авч явж байгаа. Хамгийн түрүүнд хууль өөрөө шинэчлэгдэх ёстой юм байна лээ. Бид нийтийн өмч гэдэгт Үндсэн хуульд заасан яг ард түмний мэдэлд ямар өмчийг тооцох вэ гэдгийг, тэр өмчийг хэн, ямар хүрээнд, хүрээ хязгаартайгаар шийдвэр гаргах вэ гэдгийг тодорхой болгохгүй бол энэ өмчийн хулгай, баялгийн хулгай тасрахгүй юм байна лээ. Тийм учраас эхлээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням гишүүн, Дамдинням нэр дэвшигч.

Г.Дамдинням: Асуултад хариулъя. Үйлдвэр, технологийн паркийн тухай хууль манайд хэрэгжээд, мөрдөгдөөд явж байгаа. Энэ хууль зөвхөн хашаан доторх асуудлыг шийдээд байгаа. Тэгээд Хүнд үйлдвэрийн тухай хууль бэлтгэгдэж байна. Минут бага байгаа учраас би танд тодорхой хариултууд өгье. Зэсийн зэс боловсруулах үйлдвэрийн төсөл 2027 онд дуусна гэсэн ийм төлөвлөлттэй байна. Гангийн үйлдвэр 2026 ондоо бид гэрээ байгуулж амжвал ЗГ-ын хуралдаанаар ороод, олон улсын нээлттэй тендер зарлах юм. Ингээд хэлцэлд ороод, ороод ирвэл бид 1,5 жилд багтаад дуусгана. Нефтийн үйлдвэр 2028 оны 1 дүгээр улиралд дуусах хуваарьтай ажиллаж байна. Одоо суурь байгууламжууд ер нь бүтэн дууссан, бүтээн байгуулалтын ажил 60 хувь руу дөхөж явна. Үндсэн тоног төхөөрөмжүүд захиалагдаад явж байгаа.

С.Бямбацогт: Өөр хэнээс асуулаа? Амарсайхан.

С.Амарсайхан: 1 дүгээрт, Ерөнхий сайдын үүрэг болгосны дагуу иргэн, ААН-ийн эрхийг хамгаална, хууль бус асуудлыг таслан зогсооно. ААН, иргэдээ элдэв дарамт шахалт, хууль бус шаардлагаар шахан хэвтдэгийг зогсооно. 2 дугаарт, хууль шүүхийн байгууллага хууль хэрэгжүүлэх эрхийг хамгаална. 3 дугаарт, улс төрчид ямар нэгэн байдлаар хууль шүүхийн байгууллагын байгууллага, ажилтан, албан хаагчдыг улс төрийн зодооны зэв зэвсэг болгохыг хатуу шаардаж, таслан зогсооно. 4 дүгээрт, хууль хяналтын байгууллага улс төрийн төрийн бүх шатны байгууллага хуулийн байгууллагууд энэ хууль шүүхийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хэн нэгнийг буруутгах, шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй байхад яллаж ээмлэдэг.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Амарсайхан нэр дэвшигч.

С.Амарсайхан: Хууль шүүхийн байгууллагаар гэм буруутай нь тогтоогдоогүй байхад хэн ч хэнийг ялладаг, гүтгэдэг ийм байдлыг таслан зогсооно. Хамгийн сүүлд бид нэг зүйлийг тодорхой болгох хэрэгтэй. Энэ улс үнэхээр гэмт хэрэгтнүүдээр дүүрчихсэн юм уу, эсвэл гүтгэгч нараар дүүрчхээд байгаа юм уу, нэг бол хуулийн байгууллага нь ажил хийхгүй байгаа юм уу гэдгийг хариуцлагатайгаар ялгаж салгана. Энэний төлөө бүгдээрээ хууль тогтоогчид хамтарч ажиллах ёстой. Тэгээд хууль хяналтын байгууллагын бие даасан үйл ажиллагааг хангахад анхаарч ажиллана. Яагаад гэвэл төрийн хууль цаазын мөн чанар гэм бурууг үнэн бодитоор тогтооход оршдог учраас энэ бүхний уялдааг хангахын тулд хуулийн бүх байгууллагууд уялдаа холбоотой, харилцан эргэх холбоотой, тогтолцооны стандартыг нэвтрүүлж ажиллах ийм зарчмын хангана, шаардана, бие..../минут дуусав/

С.Бямбацогт: Энэ маш чухал асуудал шүү. Үнэхээр гэмт хэрэгтнүүдээр дүүрчхээд байгаа юм уу, гүтгэгчдээр дүүрчхээд байгаа юм уу энэ улс орон, энэ төр засаг. Энэ дээр онцгой анхаарч, хэний ч гэм буруу нь тогтоогдоогүй байхад, гэм буруу бол шүүх л тогтооно. Тогтоогдоогүй байхад гүтгээд, гэмт хэрэгт холбоод байгаа энэ асуудал дээр онцгой анхаарч ажиллах ёстой ХЗДХ-ийн сайдад нэр дэвшигч анхааралдаа авах ёстой гэж хэлж байна, зөв. Замира. Алдаржавхлан нэр дэвшигч хариульъя, Барилга, хот байгуулалт /БХБ/-ын сайдад, дараад нь Сангийн сайд.

Ж.Алдаржавхлан: Соёл, спорт, аялал жуулчлалын яам.

С.Бямбацогт: Соёл, спорт, аялал жуулчлал.

Ж.Алдаржавхлан: Баярлалаа. Манай Бат-Амгалан сайд уучлаарай. Аялал жуулчлалын салбар Монгол Улсын тэргүүлэх салбар болох ёстой. Монгол Улс бол жилд 25 орчим тэрбум доллар эргэлддэг эдийн засагт. 2024 онд 800 мянган жуулчин ирж байсан юм байна лээ. 2025 онд 847 мянган жуулчин ирсэн байна. Үүнээс 1,6 тэрбум доллар Монгол Улсын эдийн засагт оржээ. Энэ 2026 онд 1 саяд хүргэхээр зорьж байгаа. Тэгэхлээр манай эдийн засагт хамгийн том эргэлтийг аялал жуулчлалын салбар ирээдүйд оруулна гэж үзэж байгаа. Тэгээд аялал жуулчлалын салбар бид жуулчдыг ирэхэд маш их таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллах ёстой гэж зорьж байгаа. Тэгээд яаман дээр очоод мэргэжлийн улсуудтай уулзаад энэ бодлого дээрээ анхаарч ажиллана. Ер нь манайх чинь уул уурхайн эдийн засгаас аялал жуулчлалын эдийн засаг руу шилжиж, аялал жуулчлалаас маш их хэмжээний орлого олдог улс болох ёстой гэж.../минут дуусав/

С.Бямбацогт: Сангийн сайдад нэр дэвшигч Мэндсайхан хариульъя. Дараад нь Зам тээвэр.

З.Мэндсайхан: Очирбат гишүүний асуултад хариульъя. Тэгэхээр төсвийн хөрөнгө оруулалтыг ерөнхийдөө 2 хэрэгцээ дээр л үндэслэж байгаа бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд. Нөгөө талдаа иргэд, орон нутгаас ирсэн салбараас ирж байгаа хэрэгцээ дээр үндэслэж төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж байгаа холбогдох хууль тогтоомжийн дагуу. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол ард түмнээсээ сонгогдсон, тэдний нийгэм, эдийн засгийн хэрэгцээнд шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтыг УИХ-д уламжлах, мөн үүнийг

улсын төсөв дээр суулгах үүрэгтэй. Тийм учраас тойргийн гишүүдийн хөрөнгө оруулалт гэж харахаасаа илүүтэй бид нийгэм, эдийн засгийн хувьд тухайн бүс нутаг Монгол Улсад эдийн засгийнх нь ач холбогдлоор нь эрэмбэлж хөрөнгө оруулалтыг тусгах нь зөв. Түүнээс биш тойргийн гишүүдийн хөрөнгө оруулалт гэж ойлгож болохгүй. Энэ тэртээ тэргүй төсвийн хөрөнгө оруулалтыг тухайн шахаа гэхээсээ илүүтэй.../минут дуусав/

С.Бямбацогт: Зам, тээврийн сайдад нэр дэвшигч Дэлгэрсайхан, дараад нь Бат-Амгалан. Бүгдээс нь асуучихсан юм уу?

Б.Дэлгэрсайхан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Энэ бид баруун, зүүн босоо тэнхлэгийн төмөр замыг явуулна. Энэ баруун, зүүн босоо тэнхлэгийг явуулахын тулд төр, хувийн хэвшлийн түншлэлээр буюу концессоор явуулна. Төр энийг хийх ямар ч боломж байхгүй. Тэгэхлээр энийг бид гаднын хөрөнгө оруулагчдыг татахын тулд хамгийн ашигтай саналыг тавих ёстой. Жишээлбэл би ганц жишээ хэлье. Саяхан ОХУ Владивостокоос нарийн царигаар төмөр зам гаргаж, ОХУ-д нарийн царигаар төмөр зам явуулахыг зөвшөөрсөн. Энэ ажил эхэлж байна. Тэгэхлээр бид баруун бүс, зүүн босоогоо явуулахын тулд янз бүрийн цариг ярилгүй энийгээ Их Хурал дээрээ шийдчихвэл сонирхогч орж ирэхэд бэлэн байгаа. Тэгэхгүйгээс болоод царигаас болоод ингээд хамаг бидний холболт гагцхидаг юм. Тийм учраас энийг хэдүүлээ хамтдаа Их Хурал дээрээ нийлээд шийдэж чадах байх гэж би итгэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: БХБ-ын сайдад нэр дэвшигч Бат-Амгалан хариулъя.

Э.Бат-Амгалан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Манай салбартай хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын салбартай холбоотой асуудлыг би хариулж болж байна. Энэ гадаа байгаа жагсаалыг яаж дарах вэ гэнэ. Энэ бол надтай хууль эрх зүйн хүрээнд нь, компанийн засаглалын хувьд би ямар нэгэн байдлаар энэ компанитай холбоотой эрх, үүрэг, хариуцлага үүрэх ийм хүн биш. Энэ бас сая ХЗДХ-ийн сайдад нэр дэвшиж байгаа Амарсайхан сайд маань хэлж байна. Энэ гүтгэгчид дүүрсэн, энэний учрыг олох ёстой гэж. Тэгэхээр би итгэж байна. Хууль зүйн сайдад нэр дэвшиж байгаа хүн хамтарч энэ хаврын синдром эхэлсэн, халуун хавар нь эхэлж байгаа энэ үед энэ асуудлыг шийдэх ёстой. Онлайнгаар сошиалаар хүнийг bully-ддэг, маш олон Улсын Их Хурлын гишүүд ярьж байна шүү дээ. Энэ асуудлыг нэг талд нь гаргаж шийдэх ёстой гэж ингэж бодож байна.

С.Бямбацогт: Эрүүл мэндийн сайдад нэр дэвшигч Батшугар, дараад нь Боловсролын сайдад нэр дэвшигч Энх-Амгалан.

Э.Батшугар: Гишүүний асуултад хариулъя. Хэзээ иргэд коридортоо ор олдохгүй хэвтэхээ болих вэ гэж та асуусан. Тэгэхээр 1 статистик хэлье. 10 мянган хүнд оногддог ороороо Монгол Улс 86 ор оногддог. OECD улс орнуудын дундаж нь 43, дэлхийн дундаж 27, Азидаа Япон, Солонгосын эс хасвал Монголд номер 1-т байдаг ороорой. Тэгсэн мөртөө хүмүүс ээж, аав нар хүүхдээ бариад л коридорт хэвтээд байна. Тэгэхээр энэ юу харуулж байна вэ гэхээр энэ үр дүнгүй орууд ашиглаад байна. Орны менежментийн дутагдал байгаад байна. Тэгэхээр таны асуултад яг одоо би хариулж чадахгүй байна. Яагаад вэ гэвэл би өөрөө газар дээр нь ажиллаад, өөрөө яг symptoms-ыг нь тодорхойлоод, хаана алдаа гараад байна, юу болохгүй байна вэ гэж тодорхойлоод хариулъя. Тэгэхдээ би энийг засаж чадна гэдэгт итгэлтэй байна. Статистик манай талд байгаа.

С.Бямбацогт: Боловсролын сайдад нэр дэвшигч Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Очирбат гишүүн маань Мөнхтуяа гишүүний өргөн барьсан хуулийг дэмжих үү, Боловсролын хуульд одоогоор өөрчлөлт оруулах шаардлага байна уу гэж байна. Яг одоогоор Очирбат гишүүнээ Боловсролын хуульд өөрчлөлт оруулах огт шаардлага байхгүй. Яагаад гэвэл Боловсролын багц хууль батлагдсан. Боловсролын багц хуулиар боловсролын 6 том шинэчлэлийг бид зарласан. Одоо энэ боловсролынхоо баталсан энэ хуулийг бид хэрэгжүүлэх ийм л үүрэгтэй. Тийм учраас Мөнхтуяа гишүүний санаачилж байгаа хуулийн зорилго нь зөв. Яагаад гэвэл боловсролын салбарын санхүүжилтийг нэмэх ийм зорилготой. Гэхдээ яг өнөөдрийн байдлаар энэ хуулийг батлагдаж, хэрэгжүүлэхэд санхүүгийн маш их том эх үүсвэрүүд шаардлагатай болох юм байна лээ. Би энэ хуулиудтай танилцсан. Эхний ээлжид ямар ч байсан энэ цалин дээр үүссэн маргаанаа цөмөөрөө нэг шийдье, нэг талдаа гаргая. Яг одоогийн байдлаар нийгмийн даатгалын санд бараг 70 гаруй, 70 тэрбум орчим төгрөгийн өр үүссэн. Багш нар маань шинэ цалин, хуучин цалин гэдэг ийм ойлгомжгүй зүйл рүү орсон. Энэнээс болоод багш нар маань өнөөдөр декрит.../минут дуусав/

С.Бямбацогт: 3 минутад энэ чинь 12 асуулт асуучихсан байх. Тэгэхээр ганц минутад нэг сайд хариулчхаж болно биз дээ. ХАА-н сайдад нэр дэвшигч Идэрбат.

Ц.Идэрбат: Очирбат гишүүний асуултад хариулъя. Монгол Улс хүнсний ногоогоо өөрсдөө хангадаг. Гэхдээ улирлын нөхцөл байдлаас болдог, усалгааны цар хүрээ, бороо орох орохгүй, байгаль, цаг уурын онцлог нэлээн нөлөөлдөг. Атрын 3 дугаар аянаас эхлээд хүнсний ногоогоо 100 хувь хангадаг болсон. Дээрээс нь энэ хүнсний хувьсгалын хүрээнд хүнсний ногоогоо боловсруулах, хадгалах гээд ахиц дэвшил гараад ингээд явж байгаа гэж хэлье. Гэхдээ 2025 онд Монгол Улс энэ байгалийн бороо бага орсноос шалтгаалж таван зуугаад мянган тонн ургацаа алдсан. 2026 оны энэ хаврын тариалалт хэзээ мөдгүй эхлэх гэж байна. Миний хувь бид хэрвээ сайдаар ингээд батламжлагдаад, ирэх бүтэн сайн өдрөөс энэ газар тариалангийн бүс нутаг Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн бүсэд ажиллана гэсэн ийм бодолтой байгаа.

С.Бямбацогт: Одоо болсон. Идэрбат нэр дэвшигч хариулчихъя гүйцээгээд.

Ц.Идэрбат: 2 дахь асуулт юутай холбоотой байна энэ малын арьс ширтэй холбоотой асуултууд асууж байна. Үнэхээр малчидтай уулзаад явахад малын түүхий эдийг үнэтэй болгоод өгчихвөл төрөөс бид юу ч гуйхгүй болоод явчихдаг ийм хүмүүс шүү дээ гээд. Малын түүхий эд үнэтэй байх үед яг л ийм байсан. Гэтэл өнөөдөр яг өнөөдрийн байдлаар зах зээл дээр адууны арьс 10 мянга, үхрийн арьс 3 мянга, хонь үнэгүй, ямаа нэг ... бол 80 мянга, ноолуургүй бол тэгээд л үнэгүй ийм байдалтай байгаад байгаа. Тэгэхээр та бол нэг тодорхой юм ярилаа шүү дээ. Малын арьс, шир гаргах гээд байхад гаалийн бүүр тодорхой хэлсэн тийм ээ, гаалийн бичиг дутуугаас болоод гаргаж чадахгүй байна гэсэн. Тэгээд үнэхээр би бол үнэхээр энэ малын арьс, шир гаргахад ийм төрийн зохицуулалт нь дутуу байгаагаас юм уу, төрийн албан хаагчаас болоод ийм тохиолдол үүсэж байгаа бол хурдан засна гэсэн ийм л бодолтой байна. Арьс, ширний талаар яривал нэлээн урт.../минут дуусав/

С.Бямбацогт: Замира гишүүн асуултаа асууя, үгээ хэлье.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе. Манай 126 парламентын гишүүн сонгогдоод жил хагасын хугацаанд 3 удаа Их Хурлын дарга нь

3 удаа, Засаг, яамнуудын сайд нар нь солигдлоо. Тийм учраас цаашдаа энд шинээр сонгогдсон Их Хурлын дарга, ЗГ-ын Ерөнхий сайд, сайдуудыгаа тогтвортой ажиллаасай гэж хүсэж байна. Амжилт хүсэж байна.

Дараа нь Ерөнхий сайдаас асуумаар байна. ОТ-н тухай. ОТ ер нь хөрөнгө оруулалт юм уу луйврын замаар манай баялгийг тонож дээрэмдэж байна уу гэдэг дээр би танаас нэг асуулт асуумаар байна? Хөрөнгө оруулалт гэдэг нь улс орнууд хоорондоо харилцан ашигтай ажиллахыг, тэр улсдаа ашиг өгөхийг, хөгжүүлэхийг хэлдэг юм. Хэрвээ яг одоогийн ОТ-н байдлаар хүү төлүүлээд, улс орноо алдагдалд оруулаад байгаа юм бол энэ хөрөнгө оруулалт биш, энэ луйвар. Одоо ОТ бол ... явуулж байгаа газрыг нь харахад тухайн үеийн Эрдэнэттэй ингээд харьцуулахад Эрдэнэт ямар хөгжсөн бэ жишээ нь энэ жил дотор. ОТ-н байгаа газарт нь хэдэн нэг сэндвичин барилга л харагдах юм. Тэгсэн чинь хэчнээн жил газар доорх баялгаа зөөгөөд байна, газрыг үйлдвэр байгуулсан газрыг тэр зүгээр ашиглаж байгаа юм шиг байна. Төлбөр төлөх ёстой тэр газарт. Тэр хөрөнгө оруулагч үйлдвэр явуулахын төлөө тэр газар төлбөр төлөх ёстой. Газрын баялгийг Монголын ард түмэндээ, Монгол Улстай ашиг хуваалцах ёстой. Дээрээс нь ус ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр гэж төлөх ёстой. Тийм учраас энэ ОТ-н гэрээг гуйж гувших биш, нэг бол Монгол Улсдаа аваад, урьд өмнө нь гадаад руу гаргасан хэчнээн баялгийн тооцоог нь хийгээд, ашиг өгөх гэрээг шинэчлэн хийх тал дээр та шаардах ёстой гэж бодож байна. Та энэ тал дээр ямар бодолтой байгаа юм бэ? Энэ дээр хариу авъя.

2 дугаарт, тэтгэврийн зээлийг, тэтгэврийг нэмж чадахгүй ч гэсэн ядахдаа зээлийг нь бууруулах ямар арга байна вэ? Энэ тал дээр та нэг бодсон нь зөв байх гээд би бодож байна.

Тэгээд 2 дугаарт Дамдинням сайдаас асуумаар байна. Алт хөтөлбөр нэг гэдэг нь маш амжилттай Жасрай сайдын үед сайн ашигтай ажилласан. Дараа нь тэгээд янз бүрийн хууль бус, янз бүрийн буруу хууль баталснаас болоод бүх дотоодын компаниуд дампуурч, гадаадын хөрөнгө оруулагч /ГХО/ нар гараад явсан байгаа. Тэгээд алт 3 гээд зарлаад манай засаг төр тэгээд удаж байна. Энэ дээр ямар төлөвлөгөө боловсруулсан бэ, цаашдаа яаж амжилтад хүрэх гээд байна вэ?

3 дугаарт, Дэлгэрсайхан сайдаас асуумаар байна. Баян-Өлгий аймгийг аялал жуулчлалын бүс гэж зарласан, удаж байна. Тэгээд Азийн оронд холбох Баян-Өлгий аймгийг Казахстаны онгоцыг нисгэх тал дээр ер нь та эцэслэн шийдвэр гаргасан уу 1 дүгээрт? 2 дугаарт, энэ дотоодын рейсийг нэмэх боломж байгаа юм уу дотооддоо? Энэ асуултыг танаас асуумаар байна.

3 дугаарт, Доржханд Шадар сайдаас асуумаар байна. Доржханд ч Шадар сайд одоо 3 дахь ЗГ-т хамтран ажиллах гэж байгаа. Урьд өмнөх 1, 2 ЗГ-тай хамтран ажилласан. Ер нь Монгол орон хөгжих үү, та ер нь засаг төртэй хамтарсан бол юу гэж бодоод хамтраад байгаа юм бэ? Энийг танаас асуумаар байна. Ийм асуултад.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Бид их олон жил попорлоо, хийрхлээ. Тэгээд тэр хийрхлийнхээ дунд гаднын олон хөрөнгө оруулагчдыг үргээсэн. Тэгээд хөрөнгө оруулах эрх зүйн орчноо сайжруулах хэрэгтэй. Урьж авчирсан бол ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Тэгээд урьж авчраад хөөгөөд явуулдаг, залж авчирчхаад заамдаад

явуулдаг энэ тогтолцоонд бол гаднын хөрөнгө оруулалт сайжрахгүй. Сүүлийн жилд гадаадын хөрөнгө оруулалт 50 хувь буурчихлаа. Тэгэхээр бид хөрөнгө оруулалтынхаа орчныг сайжруулах ажил асар их чухал. Тийм учраас манай ЗГ энэ бизнесийнхээ орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтыг татах чиглэл рүү ажиллана. Тийм учраас Хууль зүйн шинэ сайд бол сая хэлж байна. Ер нь энэ хувийн эрх зүйн орчноо сайжруулъя, бизнесийнхэндээ ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлж өгье. Тэгж байж цаашаа хөдөлж байгаа, хөдөлмөрлөж байгаа хэн бүр сайхан амьдарна. Тийм учраас хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад анхаарна.

ОТ шиг олон төсөл явуулмаар байна ОТ шиг. Мэдээж хэлэлцээрүүдийгээ бид үргэлжлүүлнэ, Монголын ард түмэнд ашигтай байх байдлаар гэрээ хэлцлүүдийг хийнэ. Би Хэрэг эрхлэхийн дарга байхад ч гэсэн олон л төслүүд дээр ажлын хэсгээ ахалж байсан, манай залуучууд чадамжтай болчихсон. Хэнтэй ч нэг ширээний ард суугаад, хэлэлцээр хийх потенциалтай түвшинд оччихсон. Тэгэхээр бид илүү бизнесийг нь хамгаалдаг ийм эрх зүйн орчныг бүрдүүлж байж хөрөнгө оруулалтаа татах бодлого манай ЗГ-ын гол бодлого байна гэдгийг хэлье. Бид хөрөнгө, ОТ шиг ийм төслүүд дээр харилцан ашигтай байх зарчмыг л баримтлах ёстой. Win win тэгээд хож хож гэсэн зарчмыг барина. Би энэ бүх стратегийн ордууд дээр цаашдаа тэр due diligence хийлгэнэ. Тэгж байж хэлэлцээр хийнэ. Тэрнээс биш нэг тийм хоцрогдчихсон арга барилаар ажиллахгүй. Хоцрогдсон арга барилаар ажиллахгүй.

Монголын төр нэг компаниа, нэг компанийн үйл ажиллагаанаас дор байж болохгүй шүү дээ. Тийм учраас дэвшилтэт үзэл санааг барина гэж бодож байгаа. Тэр ОТ дээр өнгөрсөн ЗГ-ын үеийн хэрэгжиж байсан хэлэлцээрийг үргэлжлүүлнэ. Түр хорооноос гарсан тэр 53 хувийн өгөөж дээр би хатуу байна. Дээрээс нь энэ өгөөжид юу тооцох вэ гэдгийг хуульчлан хамгаална. Таны хэлж байгаа ус бохирдуулсны төлбөр, бусад бүх төлбөр, татвар юу нийлээд тэр 53 хувийг бүрдүүлэх вэ гэдгийг тодорхой болгоно. Олборлох салбарын ил тод байдлын хуулийг Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулна. Ингээд хариуцлагатай уул уурхай, хөрөнгө оруулалтыг дэмждэг, эрүүл саруул юм ярьдаг улс л болмоор байна.

С.Бямбацогт: Доржханд сайд, дараад нь Дэлгэрсайхан сайд, тэгээд Дамдинням сайд.

Т.Доржханд: Замира гишүүнд маш их баярлалаа. Тэгээд энэ чуулган дээр хэлсэн үгийг маань таслаад гуйвуулаад ингээд иргэдэд буруу мэдээлэл өгөөд байгаа. Би маш тодорхой хэлье. Хэрэвзээ ЗГ тогтворгүй байвал гадна, дотнын хөрөнгө оруулалт байхгүй. Тэгвэл хөгжих боломжгүй гэж хэлсэн 1.

2 дугаарт, Монгол Улс том газар нутагтай, цөөхөн хүн амтай. Тэгээд тэр том газар нутагтай дэд бүтцээ санхүүжүүлээд явна гэвэл энэ боломжгүй гэж хэлж байгаа. Тэгээд хөгжих боломжтой юу гэвэл тогтвортой ЗГ үүсгэснээрээ бид гадна, дотнынхоо хөрөнгө оруулалтыг татаад, бизнесийг дэмжвэл хөгжих бүрэн боломжтой. 2 дугаарт, нийт том газар нутгаараа дэд бүтцээ угсрах биш, харин төвлөрүүлээд угсарвал хөгжих бүрэн боломжтой гэдэг ийм агуулгаар би мэдэгдлээ хийсэн. Энэ байр суурь дээр хатуу байна. Бодит мэдээлэл энэ. Тэгээд цаашаагаа бид зах зээл рүүгээ гарахын тулд урагшаагаа бид.../минут дуусав/

С.Бямбацогт: Дэлгэрсайхан сайд хариулъя, дараад нь, 1, 1 минутад багтаагаад л хариулчихъя, цагаа жоохон шахъя.

Б.Дэлгэрсайхан: Замира гишүүний асуултад хариулъя. Баян-Өлгийн онгоцны буудлыг бид олон улсын онгоцны 4С болгоно, зураг төсөл, ТЭЗҮ бэлэн болсон. Тендер зарласан, тендер маргаантай болоод ингээд хойшилчихсон. Дотоодын нислэгийн хувьд долоо хоногт 2 удаа нисэж байгаа, удахгүй ингээд 3 удаа нисдэг болгож байгаа гэдгийг танд албан ёсоор хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Дамдинням сайд.

Г.Дамдинням: Алт 3 хөтөлбөрийн тухайд Улсын Их Хурлын Алт 3 аяныг дэмжих тухай тогтоолыг дагаж гарч байгаа ЗГ-ын тогтоол. ЗГ-ын тогтоолоор шийдвэрлэж байгаа асуудал 1 дүгээрт гол мөрний урсац ойн сан бүхий газрын хил хязгаарын заагуудад дэглэм бууруулах, урсгал өөрчлөх боломжит нөхцөлүүд дээр Байгаль орчны яам, сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хамтарсан ажлын хэсэг гарч, үнэлгээ дүгнэлт өгч, боломжит олборлох хэсгүүд дээр олборлох олборлолт явуулъя. Ингэхдээ байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөрийг 100 хувь урьдчилж аваад ингээд олборлолтын үйл ажиллагааг дэмжээд явъя гэдэг ийм чиглэлтэй ажил хийгдэнэ.

2 дугаарт, Монголбанктай алт олборлогч ААН-үүдээ уулзуулж, санхүүжилтийн зохион байгуулалтад оруулах ажлыг хийгээд ингээд ажил эрчимтэй явагдаж байна. Уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ зэргийг шуурхай горимоор хийгээд гаргаад ингээд явуулж байгаа.

С.Бямбацогт: Болсон тийм ээ? Тодруулъя Замира гишүүн.

С.Замира: Ерөнхий сайдаас нөгөө тэтгэврийн зээлийн хүүг бууруулах боломж байна уу гээд асуусан.

С.Бямбацогт: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдад нэр дэвшигч хэн байгаа билээ? Аубакир сайд.

Т.Аубакир: Тэтгэврийн зээлийн хүү яг шууд ЗГ-аас буюу салбар яамнаас зохицуулах боломж байхгүй. Энэ бол цэвэр арилжааны банкны арилжааны чанараар зохицуулагддаг харилцаа. Зарим улсад тэтгэврийн зээлийг барьцаалж зээл олгохыг хуулиар хориглодог. Энэ маань нөгөө ахмадууд тэтгэвэр авагчдын маань нийгмийн баталгаа алдагддаг гэж үздэг. Бидний манай яамны хувьд тэтгэврийн зээлийн хүүг бууруулах тал дээр төсвийн ямар зохицуулалт дэмжлэг байж болох вэ гэдэг талаар судалгаа хийж байгаа, шууд зохицуулах бол арилжааны банкнуудын асуудал байгаад байгаа.

С.Бямбацогт: Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ оройн амрыг эрье. Хэдийгээр олон нийт, ард түмэн маань татварын ачаалал, өрийн дарамтад дарагдаж, өдөр хоногоо өнгөрөөж, өрөнд баригдсан ч гэсэн үүнээсээ илүү юунд ач холбогдол өгч санаа зовж байна вэ гэвэл шударгаар, Сант Маралын судалгаагаар гарсан байгаа. 2015 онд шударга бус байдал илүү байна гээд 68,8 хувь нь үзсэн бол 2023 онд 93,1 хувь нь шударга бус байдал илүү байна. Энэ хамгийн том зовлон гэж үзсэн байгаа юм. Тэр өрөнд баригдаж өтөнд идэгдэж байгаа нь татварын ачааллын хажууд шударга бус нь муухай байна гэж үзэж байна шүү дээ ард түмэн.

Ардын нам сүүлийн 10 жил засаглахдаа ам ангайх болгондоо шударга ёсыг дээдэлнэ, авлигатайгаа тэмцэнэ, хүний эрхийг дээдэлнэ гээд. Тэгээд өнгөц сонсоход бараг нүднээс нулимс гартал ингэж уяраатал ярьдаг. Гэтэл ачир дээрээ юу болж байна вэ. Ардын нам 2 хуваагдсан. Өөрснөө хуваагдаад зогсохгүй ард иргэдийг 2 хэсэгт хувааж талцуулсан. Өчигдөрхөн 2 бүлэглэлийн нэг хэсэг нь бидэнд 4-өөс 5 сайд өгнө гэж байгаа. Гэвч бид авахгүй, бид шударга ёсны төлөө тэмцэнэ гэж байх шиг байсан. Тэгээд өнөөдөр харсан чинь яг тэр 5 хүн сайд болоод ороод ирж байх шиг байна тэр 30-ийн бүлэглэлээс нь нэгд.

Энэ хэвлэл мэдээллээр бас юм явж байна л даа. Энэ хэдийг минь нь л нэг хэргээс мултлаадхаач. Тэгвэл зүгээр бид юу гэх вэ, дахиж ярих юм байхгүй, эвлэрээд алья гээд уйлж унжсан сураг байна хэвлэлээр. Тэгэхээр би Учрал сайдаас асуумаар байна. Та ер нь юун дээр эвлэрчхэв, танай эвлэрэл яг юун дээр явагдчихав? Гэмт хэрэг наймаалцчихсан юм биш биз дээ гэдэг маш ийм санаа зовсон асуулт байна. Яагаад гэвэл ам болгондоо хээл хахууль, авлигатай тэмцэнэ гэж байгаа. Хэдийгээр ачир дээрээ 10 байраар нэгхэн жилийн дотор ухарчихсан явж байгаа шүү дээ.

Дахиад та менежер чухал байна, ажлын ачаалал даах хүн хэрэгтэй гээд байх юм. Гэтэл тэр ажлыг чинь ТНБД хийдэг юм шүү дээ, төрийн захиргааны төв байгууллагын гол менежер. Сайдууд ер нь бодлогын хүн байх ёстой. Тухайн салбараа том зургаар нь ерөнхийд нь бодлогын хэмжээнд харах ёстой. Тэгж байж тэр кабинетэд чинь бодлого чинь зөв явж, шийдвэр чинь зөв гарна. Гэтэл шулуухан хэлье танай энэ 2 хуваагдсан нэг бүлэглэл чинь цахимаар bully-ийг аймаар хийдэг юм шүү дээ, bully-дэлтийн бүүр дэлхийн аварга шалгаруулдаг бол танай нөгөө бүлэглэл чинь 15 давхрын тэр хэсэг чинь хийдэг байхгүй юу. Гэтэл тэр бүлэглэлийн гишүүн байж болохуйц ийм хүнийг та Цахим сайдаар тавих юм. Тэгэхээр энэ цахим bully чинь бүүр аймаар хөгжих юм биш үү? Би бүр айж байна ний нуугүй хэлэхэд. Тэрийг ингээч гээд хашхирдаг юм гэсэн ажилтнууд нь ярьж байна лээ. Тэрийг ингэж цахимаар bully-л гэж шаардлага тавьдаг гишүүнийг та Цахимын сайдаар тавихаар энэ цахим bully чинь 15 давхрынхаа зохиолоор улам амилах юм биш үү. Танай 105 жилийн түүхтэй энэ намд өөр Цахим сайд хийчих хүн алга уу?

Дараагийн асуулт. Харбины гэрээ. Танай бас нэг асуудалд орооцолдоод ялаа үүрээд гарч ирсэн нэг гишүүн саяхан ярьсан л даа. 64 доллароор оффтейк гэрээг хийсэн байна 26 оны байдлаар. Гэтэл амны дүн, цаана нөгөө Гашуунсухайт-Ганцмод дээр 131 доллароор зарж байна. Зөрөө 67 доллар нь хаачсан бэ? 80 сая тонны нөөц гэсэн байх шүү, нөөц юу байх вэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Баярмаа гишүүн тодруулчихъя, гүйцээчихье.

Ж.Баярмаа: 26 оны зөвхөн 80 сая тонныг зөрөөг нь 67 доллароор тооцохоор хэд юм бэ гээд танай намын Аюурсайхан гишүүн ярьсан шүү. Тэгэхээр эндээс үүдээд юу асуух гэж байна гэвэл Харбины гэрээг явуулах юм уу, Хянан шалгах хороог ажиллуулах юм уу? ОТ-н гэрээ 17 жилийн өмнө байгуулагдсан хэдий ч алдаа, оноогоо ярилцаж, хэлэлцээд, засахыг оролдож байна. Энийг би сайшааж байна. Яг тэрэнтэй агаар нэг одоо хэрэгжээд удаагүй байгаа энэ Харбины гэрээ асуудалтай болсон эсэхийг хянаж шалгахгүй юм уу? Ямааны мах халуун дээрээ гэдэг шиг энийгээ алдаатай бол засаж зааварлахгүй юм уу? Энэ чинь ард нь ард түмэнд орох орлого нэмэгдэх л тухай асуудал яриад байгаа юм л даа. Тэгэхээр та энэ дээр шууд хариулах хэрэгтэй байна.

Дараагийн асуулт, асуулт юу байх вэ? Эвтэй байхдаа хүчтэй гэж танай намын уриа л даа. Гэтэл шударга байхдаа хүчтэй гэдэг нь илүү зөв л дөө. Чингис хаан хэрвээ эвтэй байхдаа хүчтэй гээд л эвлэлдэж нэгдээд л, буруу зөрүү зүйлийг зөвшөөрөөд л явж байсан бол дэлхийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: ЗГ авлигатай тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлнэ. Тэгэхдээ зүгээр үг яриагаараа биш, Авлигын төсөөллийн индекс 10 байр хойшилсон байна. Транспэрэнси интернэшнл бидэнд зөвлөмж өгсөн. Наад эрх зүйн орчноо янзал гэж. Тэр Шүгэл үлээгчийн хууль, Олборлох салбарын ил тод байдлын хууль тэр ял завшаад байгаа асуудал, нийтийн албан тушаалтны тэр хөрөнгө мөнгийг хураах эрх зүйн орчин гээд энэ ажлууд дээр дэвшил гаргана. Дээрээс нь гэмт хэрэг, авлига гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг хийхийн тулд энэ төрийн албан тушаалтнуудын олгоод байгаа зөвшөөрөл, эрх олголтуудаас энэ хүний оролцоог салгана. Тийм учраас И Монголиа, И Бизнесийн 2 дугаар платформыг нээж, зөвшөөрлийг зөвхөн цахимаар олгоно. Хиймэл оюун дээр суурилсан эрсдэлийн үнэлгээ хийгээд, зөвшөөрлүүдийг автоматаар сунгана гээд ийм ажлуудыг хийе гээд төлөвлөж байгаа.

Таны яг асууж байгаа асуултад би хариулъя. Төр тасралтгүй, тогтвортой ажиллах шаардлага байна. Цагийн сорилтууд бидэнд улс төр биш, ажил хийх хэрэгцээ шаардлагыг улам бий болгож байна. Би худлаа бол биш, манай намын бүлэг дотор тодорхой үл ойлголцлууд үүссэн. Гэхдээ би намын даргын хувьд 68 гишүүнээ харж байгаад бүхлээр нь аль ажлыг хэнд хариуцуулбал анхан шатад ажилласан туршлагатай, ачаа үүрч чадах вэ гэдэг байдлаар сонголтоо хийсэн. Тэрнээс биш янз бүрийн тэр нэг албан тушаал, тэдэн яам, эдэн яам, ийм тийм албан тушаал наймаалцах юм огт байхгүй. Харин энэ үл ойлголцоод байсан хүмүүс магадгүй энэ ЗГ-ыг бүрдүүлэхэд энэ чинь 68-уулаа оролцох л ёстой. Нэг л нам гэдэг утгаар. Тэрнээс биш юу гэдэг юм хууль дүрэм зөрчсөн, зөрчил гаргасан, гэмт хэрэгт холбогдсон ийм зүйл дээр эвлэрнэ энэ тэр гэдэг ойлголт огт байхгүй. Би бол авлигатай тэмцэх ажлыг манлайлж хийнэ.

Тийм учраас цаашдаа хариуцлагын механизмаа илүү сайжруулна, эрх зүйн орчноо ч сайжруулна, ТӨК-уд дээр ч тэр, төрийн албан дээр ч тэр ёс зүйн хариуцлага нэхэж, шаардаж ажиллана гэдгийг хэлье. Цахим, хөгжлийн яамны гол зорилго өөрөө энэ нэг тийм хэвлэл мэдээлэл гэхээсээ илүү энэ Цахим хөгжлийн яам илүү дижитал хөгжлийн асуудал, ил тод байдлын асуудал, төрийн үйлчилгээг илүү цахимжуулахтай холбоотой ажил учраас би өнгөрсөн хугацаанд хийж байсан ажил цаашаа үр дүн гаргах гээд олон талыг нь харж томилсон гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Хариулчхаад яах уу? Дэлгэрсайхан сайд хариулсны дараа тодруулъя.

Б.Дэлгэрсайхан: Би Баярмаа гишүүний асуултад хариулъя. Энэ Харбины гэрээ одоо Хяналт шалгалтын түр хороо байгуулах асуудал гишүүний бүрэн эрх. Гэхдээ Харбины гэрээнд би урд хөрш ямар ч буруу байхгүй. Тэр хямд нүүрс авч байгаа энэ тэр гэдэг худлаа шүү. Өнгөрсөн онд Харбины гэрээтэй холбоотой ердөө 4,5 сая тонн нүүрс гарсан Чайна энержид. Таны хэлдгээр 64 доллар аман дээрээсээ дээр нь нэмэх нь 20 доллар тээврийн зардал МТЗ-д орж байгаа. Энэ үед үнэ ийм л байсан. Тэрнээс биш тэр сая гараад ирсэн хүн гэнэтхэн тэр өнгөрсөн жил 130 хэдтэй байсан нүүрсийг тал үнийг нь алга болгочихлоо гэж ийм ярьж, хөрш орноо ингэж

гутаан доромжилж болохгүй. Энэ хэрвээ юм асууж ярих гэж байгаа бол бид жоохон.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Хэрвээ шаардлагатай гэвэл би танд ингээд тайлбар хийхэд бэлэн байна гэдгийг хэлье. Өнгөрсөн жил таны хэлдэг 90 сая тонн нүүрс дандаа биржээр гарсан. Үүнээс зөвхөн 4,5 сая нь л Чайна Энержи буюу Харбины гэрээтэй холбоотой нүүрс гарсан юм. Тэгэхлээр бид өөрсдөө гуйж төмөр замаа холбоё, энийгээ явуулахын тулд ингээд 16 жилийн хугацаатай гэрээ хийе гэж өөрсдөө гуйж оччихоод, тэгээд өрөөл бусдыг гутаан доромжлох ийм асуудал хийж болохгүй шүү. Бид эдийн засаг ямар байгаа билээ, урд хөршийг дэлхий гуйж байхад бид бөөрөнд нь наалдчихаад ингээд муулаад суугаад юмаа зарна гэвэл ёстой худлаа болно шүү. Тийм учраас жоохон улс төржиж болно, эдийн засгаа бодолцоорой гэдгийг би зориуд хэлье.

С.Бямбацогт: Баярмаа гишүүн нэмэлт асуулт.

Ж.Баярмаа: Энэ ерөөсөө улс төржүүлж байгаа асуудал биш л дээ. Энэ чинь өчигдөрхөн та хэд чинь бие биеийнхээ хулгай зэлгийг ерөөсөө гайхаад шагшаад, бүүр ерөөсөө бөөн юм болцгоож байсан юм биш үү. Энэ чинь би зохиогоод байгаа юм биш л дээ. Та хэд чинь 30, 38 болчихоод л өдөр болгон замын нөгөө голын 2 эрэг дээр гарчхаад л хэн нь хэдэн төгрөгийн хулгай хийснээрээ бие биеийгээ дуудалцаад байсан юм биш үү? Үгүй ээ тэгэхээр чинь бид чинь болгоомжлох нь зүй ёсны асуудал шүү дээ. Энэ дунд чинь цавчаа байдаг, өмнөх оффтейк гэрээнүүдээс хэчнээн их наядын цавчаа гарсан тухай яриаг та нар өөрснөө л гаргадаг шүү дээ. Бид ердөө зохиогоогүй шүү дээ. Тийм. Тэгэхээр бид олон нийтийн өмнөөс энэ асуултыг асуух ёстой, олон нийтийн өмнөөс хянан шалгах ёстой.

Дахиад нэг зүйлийг хэлэхэд Учрал сайд залуу хүн өөрөө энэ төрийн хэмнэлтийг хийх хэрэгтэй. Энэ сайдууд 300 саяын төгрөгийн 300 унадаг байх ланд. Би үнийг нь мэдэхгүй сая unegui.mn-ээс асуулаа л даа. 20 сая, 20 сайд нийлээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Санал хэлчихлээ. Алтаншагай гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Н.Алтаншагай: Оройн мэнд хүргэе. ЗГ тогтвортой ажиллах нь ер нь Монгол орны эрх ашигт 1 дүгээрт байх ёстой гэсэн зарчимтай нийлэх байх. Юуны түрүүнд 4, 5 ЗГ дамжаад олон яам солиод ажиллаж байгаа хошой тэргүүний сайд нартаа амжилт хүсье. Сайн ажиллах байх гээд итгэж байна. Томилогдож байгаа сайд нар маань энэ салбар салбартаа яг оногдсон, оногдсон ажил дээрээ амжилт гаргаасай, энэ үр өгөөжийг нь иргэд, ААН-үүд нь, салбарууд нь хүртээсэй. Нийгмийн салбарууд нь боловсрол, эрүүл мэнд, дэд бүтцийн салбарууд нь хүртээсэй гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм.

Хэдэн тодруулах зүйлүүд байгаа юм. Боловсролын сайдаас, Эрүүл мэндийн сайдаас асууя. Энэ ажилчин албан хаагчдын цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудлууд өнгөрсөн төсөв дээр бөөн дуулиан болоод ингээд ерөнхийдөө өнөөдрийг хүрээд царцанги байдалтай болчихсон байна гэсэн ийм ойлголттой байна энэ эрүүл мэнд, боловсролын салбарынхан байна.

Дээр нь энэ ахмадууд маань энэ тэтгэврийн нэмэгдэлтэй холбоотой асуудлуудыг хөндөж байна. Сая чуулган эхлэхэд ахмадууд гадаа жагсаад л зогсож байсан. Тэгэхээр энийг яаж шийдэх юм бэ?

Нэмэлтээр Ерөнхий сайдаас асууя. Энэ төсвийн тодотгол хийж таарах уу? Тэгэхгүй бол энэ боловсрол, эрүүл мэндийн энэ үүссэн асуудлыг, санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд ер нь маш хүнд болчихсон юм байна гэсэн ийм ойлголттой байгаад байгаа юм.

Эрчим хүчний сайдаас өнгөрсөн өвөл ер нь дэнтэй дунтай л өвөлжлөө шүү бид бүхэн Улаанбаатарчууд. Монгол орон даяараа тог хязгаарлалттай, байрнууд нь хөлдчих гээд. Тэгэхээр нөгөө яриад байгаа реформ маань яг ямар түвшинд яваа юм бэ? Иргэддээ нэг сайн мэдээлэл өгөөч. Энэ өвлийн яг бэлтгэл ажил хэдэн хувьтай хангагдах юм бэ, одоо бэлтгэл ажил руугаа орсон юм уу? Яг энэ байгаагаараа энэ өвлийнх шиг өвөлжвөл тун хүнд байдалд орох юм байна лээ шүү дээ. Маш сүртэй яригдсан асуудлууд, үнэ тариф нь нэмэгдсэн. Тэгээд Бөөрөлжүүтийн тэр цахилгаан станц нэг орж байгаа нэртэй ингээд нэг хагас дутуу дэм болж өнгөрсөн. 5 дугаар цахилгаан станц гээд эхэлчихсэн байгаа гэж байгаа юм.

Дээр нь энэ Туулын хурдны замыг яг ЗГ-ын зүгээс бодит дэмжлэг үзүүлэх үү? Иргэдийг яг 2-т талцуулж байна. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлууд хэрэгтэй байна. Бид бүхэн олдсон боломжоо ашигламаар байна. Нийслэлийн маань иргэд энэ хүнд асуудлуудаасаа гармаар байна, утаанаасаа, түгжрэлээсээ, энэ буруу төлөвлөлтөөсөө. Энэ Туул хурдны зам ашиглалтад орвол томоохон асуудлуудыг шийдэхээр л харагдаж байгаа шүү дээ. 20, 30 жил ингээд яваад л ирсэн. Шинэ ЗГ бүрдэх болгонд том хүлээлт үүсэж байгаа иргэдэд маань. Тэрийг Учрал сайдын Ерөнхий сайдын ЗГ маань хэр хүлээж авч асуудлуудыг уян хатан байдлаар шийдэх юм бэ? Мэдээж энэ 30, 40 жил хуримтлагдсан асуудлыг жилийн дотор шийдэхэд хэцүү, маш сайн, зөв эрэмбэлээсэй. Дараа жилийн энэ 2027 оны төсөв дээр одоогоос суугаасай, саналуудаа маш сайн ажлуудаа эрэмбэлээд гаргаж ирээсэй гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм.

Тэгээд энэ гишүүдтэйгээ нэг бүрчлэн уулзаж, саналыг нь аваач. Шууд боож оруулж ирээд шидчихдэг, тэгээд цаг туллаа, болохоо байлаа гээд л ингээд шийддэг. Энэ чинь ямар ч үр өгөөж байхгүй байгаа шүү дээ. Ноднингийн ярьж байсан юмнууд ер нь бараг шийдэгдээгүй дээ, яг бахь байдгаараа л байгаа. Бодит ажлыг, бодит өөрчлөлтийг энэ богино хугацаанд хүсэж байна. Өөр гарц байхгүй.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулна.

Н.Учрал: Бид өнөөдөр бодит нөхцөл байдалтайгаа эвлэрэх ёстой. Би тодорхой зүйлийг хэлье. Бидний баталсан төсөв 31,9 их наядын орлого, зарлага нь 32,9, 1 их наяд орчмын алдагдалтайгаар баталсан. Тэгэхээр одоогийн нөхцөл байдал ямар байна вэ гэхээр төсвийн гүйцэтгэл 2 сарын байдлаар бараг 720 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа юм. Нэг ёсондоо орлого дутагдана яг үнэнийг хэлэхэд. Тэгэхээр багш, эмч нарын цалин дээр 1,2 их наяд төгрөг бараг нэмэлтээр шаардлагатай ийм л цагтай бид тулаад байна. Тэгэхээр төсвийн тодотголыг мэдээж хийж давах ажил руу орно. Урсгалыг танахаас өөр гарцгүй.

Дээрээс нь хөрөнгө оруулалтуудыгаа эрэмбэлнэ. Ялангуяа тэр төслүүдийг. Тэгэхээр шаардлагагүй төслүүдийг хойшоо тавихаас өөр замгүй болж байгаа. Дээрээс нь ингээд бензин шатахууны үнэ өсөөд ирэхээр энэ бол иргэдэд их хүндээр

тусна. Тэгэхээр бид тодотгол хийж, үүнийг давахаас өөр замгүй. Тийм учраас ЗГ-ын эхний авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол түрүүн Баярмаа гишүүн ч хэлээд байсан. Энэ шаардлагагүй их урсгал зардлуудыг багасгахаас өөр цаашаа хүнд болно. Дээрээс нь хэмнэлт хийхээс гадна, орлого нэмэгдүүлэх, орлого бүрдүүлэх нэмэлт арга хэмжээнүүдийг авах ёстой. Тийм учраас Татварын хуулийг татаж аваад, буцаагаад өргөн барина. Энэ юу юм бэ гэхээр нөгөө төлдөг нь хохирдог, төлдөггүй нь хождог энэ татварын тогтолцоог өөрчилж, татварынхаа бааз суурийг өргөжүүлэхээс өөр гарц байхгүй.

Дээрээс нь энэ гаалийн журмын хэрэгжилтийг сайжруулах, импортынхоо шат дамжлагыг цөөрүүлэх, нөгөө цахимжуулах ажлуудыг хийх хэрэгтэй. Дээрээс нь энэ стратегийн бүтээгдэхүүнүүдийг буюу нөгөө хүнс, эм, нефть, эмнэлгийн хэрэгсэл гээд эдгээрийг тусгай горимоор шуурхай нэвтрүүлэх арга хэмжээнүүдийг авна. Дээрээс нь энэ гаалийн системд орлогын албан татварын тогтолцоонд хиймэл оюун нэвтрүүлэх, хүнд суртлуудыг нь багасгах, ер нь экспорт нэмэгдүүлэх ямар арга хэмжээ байна шат дараалалтай хийхээс өөр гарц байхгүй. Тэгэхээр ер нь төсвийн тодотголыг оруулж ирнэ гэж ойлгох хэрэгтэй. Дээрээс нь үүнийг хийхийн тулд мэдээж энэ гадаадын хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлэхэд ямар, ямар ажлууд хийх вэ гэдэг дээр бид эрэмбэлээд ажилдаа орно. Улс орон даяар шаардлагагүй байгаа төслүүдийг хамгийн эхлээд би эрэмбэлье гэж бодож байгаа. Нийслэл дээр ч гэсэн зарим төслүүдээ эрэмбэлэхээс өөр зам байхгүй.

С.Бямбацогт: Боловсролын сайдад нэр дэвшигч Энх-Амгалан хариулъя.

Л.Энх-Амгалан: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Ямар ч байсан энэ сая нөгөө 26 оны төсвийг батлахад бид хаанаа үл ойлголцол болсон юм, салбар тодорхой тооцооллын алдааг Их Хурал дээр танилцуулсан нэг ийм алдаа гарсан юм байна л гэж харж байгаа. Бид төсөв батлагдахад байр сууриа илэрхийлж байсан олон гишүүд байгаа. Танилцуулсан тооцоо бол зөвхөн багш нарын цалингаа 50 хувь нэмэх тооцоо танилцуулж орж ирээд, тэгээд гараад хэлэхдээ багш, ажилчдынхаа цалинг 50 хувиар нэмнэ гээд ингээд батлагдаагүй төсвөөр том ачаалал аваад, хүлээлт үүсгэчихсэн ийм бодитой нөхцөл үүссэн байна. Энийг үнэнийг хэлэх ёстой бид, үнэнийг хэлэх ёстой 1 дүгээрт.

2 дугаарт, энэ салбарын энэ шинэ, хуучин цалингийн ялгаатай цалингийн ойлголт гарч ирээд, нэмэгдлүүдээ дандаа хуучин цалингаас нь олгосон учраас багш нар маань сэтгэл дундуур үлдсэн. Тэр тусмаа олон жил ажилладаг нэмэгдэл авсан багш нар маань сэтгэл дундуур үлдсэн ийм.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Энх-Амгалан нэр дэвшигч.

Л.Энх-Амгалан: Ийм нөхцөл байдал үүссэн байна. Тэгээд өнөөдөр нийгмийн даатгалын сан дээр 70-аад тэрбум төгрөгийн өр үүссэн. Үүнээс шалтгаалаад багш нар маань декретээ авч чадахгүй, листийн мөнгөө авч чадахгүй, энэ жил тэтгэвэр тогтоолгох гэж байгаа багш нар маань аль цалингаасаа тэтгэврээ тогтоолгох вэ гэдэг ийм нөхцөл байдал үүссэн учраас энийг ойрын хугацаанд ЗГ УИХ-д үүссэн нөхцөл байдлыг бодитойгоор танилцуулж, тодорхой шийдлүүдийг бид гаргана гэж бодож байна. Ганцхан боловсролын салбарын асуудал биш, цаашдаа Ерөнхий сайдын хэлж байгаа нийт Монголын төрийн албаны тодорхой шинэчлэл, бүтцийн шинэчлэлүүдийг хийгдэж, тухайн нэг салбарыг нэмэх биш, нийтээр нь Монголын төрийн албыг бүтээмжтэй, үр дүнд суурилсан цалингийн тогтолцоонд шинэчлэх энэ ажил боловсролын салбараас хамгийн түрүүнд эхлэх ёстой гэж би ойлгож байгаа.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн, Эрүүл мэндийн сайдад нэр дэвшигч Батшугар хариулъя.

Э.Батшугар: Эрүүл мэндийн салбарын цалингийн төсөв нь энэ жилдээ 1,2 их наяд төгрөг байгаа. Гэхдээ түрүүн Ерөнхий сайд маш тодорхой хэлсэн. Бид бодит үнэнтэйгээ нүүр тулах ёстой, батлагдсан төсөв нь энэ 1,2 их наяд. Тэгэхээр энэнд нь ямар байдлаар, хаана нь бид амласан хүлээлтэд хүрч чадаагүй вэ гэдэг дүн шинжилгээ хийнэ. Гэхдээ би тэдэн өдрийн дотор ингэж хэдэн сард хийнэ гэж одоо амлахгүй. Эхлээд нэг бодит байдалтайгаа танилцана, тэгээд шийдэл нь болно. Тэгснийхээ дараа гишүүндээ танилцуулна.

С.Бямбацогт: Эрчим хүчний сайдад нэр дэвшигч Найдалаа хариулъя.

Б.Найдалаа: Алтаншагай гишүүний хэлж байгаа тэр эрсдэл энэ жил байгаа. Ноднингийн үүссэн эрчим хүчний чадлын дутагдал энэ жил мөн байсаар байгаа, эрсдэл нь байгаа. Бид бодит үнэнтэйгээ нүүрээ тулах ёстой. Мэргэжилтнүүдийн тооцож байгаагаар энэ жилийн хамгийн оргил ачаалал нь 1957мвт болохоор юм байна лээ. 150 орчим мегаваттын өсөлт гарч байгаа, тэгээд 70мвт-ын Сэлэнгийн ДЦС ашиглалтад орно. Энэ бүгдийг тооцоод, тооцоод, импортоор ч тооцоод 90мвт сох дутна. Тэгээд энийг яаж нөхөх вэ гэж байгаа нь маш богино хугацаанд шийдэх ёстой байгаа. Тэгэхээр нөхцөл байдал онцгой юм чинь онцгой байдлаар ажиллахаас өөр аргагүй. Энэ дээр яах вэ мэдээж хэрэг одоо очиж тооцож үзэх ёстой, мэргэжилтнүүдтэй ярилцах хэрэгтэй. Гэхдээ урьдчилсан төсөөллөөр магадгүй батарей хураагуурыг маш богино хугацаанд бид барих хэрэгтэй байгаа юм. Тэгвэл энэ богино хугацааны асуудлыг шийдэх боломжтой. Тэгээд цаашдаа ч гэсэндээ.../минут дуусав/

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Нэг ЗГ гараанаасаа гаргаж байгаа учраас амны бэлгээр бүгдэд нь ажлын амжилт хүсье. Ерөнхий сайдаа бага зовоогоорой л гэж хүсэж байна. Яах вэ элдэв ажил санаачлаад зовоох гэхээс илүү ажил хийхгүй байдлаар зовох вий гэдэг дээр санаа зовж байна. Ажлуудыг тээг саад болох вий гэдэг дээр санаа зовж байна. Тэгэхээр энэ дээрээ анхаараарай гэж хүсэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд нэр дэвшиж байгаа хүн дээр талархалтай байна. Хувийн эрх зүйн шинэчлэлийг хийнэ гэж дуугарч байна. Ер нь зүгээр өмнөх сайдууд дээр явахад дандаа цагдаа эрүүгийн чиглэлийн л юм яриад байдаг байсан. Энэ удаад Ерөнхий сайд ч гэсэн өөрөө чөлөөлье аяныг санаачлаад, энэ үзэл санаан дээрээ нэр дэвшигч маань хэлж байгаад талархалтай байна. Арилжааны шүүх байгуулах уу, эсвэл арилжааны буюу бизнесийн эрх зүйгээр буюу энэ чиглэлд мэргэшсэн шүүгч нараар яг энэ маргааныг шийдэхгүй бол энэ бизнес эрхлэгчдийн хооронд маргаан шүүх дээр ерөөсөө шийдэгдэж чадахгүй байна. Энэ бизнесийг анхнаас нь нөгөө мөнгөний үнэ цэнийг мэдэх, мөнгө яаж эргэлддэгийг мэддэг хүмүүс шүүхгүй бол болохгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлдээ таныг нэг анхаарч, энэ арилжааны шүүхийг байгуулах болон энэ хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаараасай гэж хүсэж байна.

2 дугаарт, Учрал Ерөнхий сайдын яамнаас нэг зүйл таалагдлаа. Кабинетын зарчмаар ажиллах. Одоо яг кабинетын зарчмаар ажиллаж үзээрэй. Энэ хэвлэл мэдээллийн индрийг ашиглаад элдэв янзын юм ярьдгаа сайд маань болиорой,

хувьчилсан тоглолт хийдгээ болиорой, твиттер жиргээ дээр янз бүрийн юм жиргэдгээ болиорой. Энэнээс чинь л болж байгаа шүү. Тохой нийлж суучаад бие биедээ үгээ хэлж чадахгүй, твиттер жиргээгээр хэлээд л ингээд энэ нөхцөл байдал болдог. Тэгээд энэ дээр Учрал сайд нэг залуу хүн манлайллын хувьд ийм байвал нэг кабинетын зарчим алдаж байгаа хүн дээр нэг хариуцлагыг нь тооцож, бас нэг Монголд жишиг тогтоож өгөөч энэ төрийн. Ярьдаг боловч бүгд байхгүй. Тэгээд 2 сайд нь орж ирээд энд хэрэлдээд байгаа байхгүй юу Ерөнхий сайдаа тэр урьдын жишгүүд. Тэгэхээр ийм баймааргүй байна. Тэгээд энийг нэг анхаараарай.

2 дугаарт энэ ОТ гэдэг нэг сэдэв байна, энэ хэлэлцээр явахгүй, манайхан энд fail-дчихсэн байгаа, би энийг мэдэж байна. Аргалаад урагшлуулна гэдэг зүйл байж байгаа ОТ-гоосоо бол Засаг унаж байгаа гээд улс төрийн сэдэв болгож байна. Ингэж хөрөнгө оруулагчдаа нэр хүндэд нь халдаж болохгүй байх. Тэгэхээр 1 хувилбаруудыг сайн бодооч л гэж би хүсэх гэж байгаа юм. Одоо яг ОТ-н хэлэлцээр дээр ингэж сүүлийн хэдэн жил ажилласан сайд нараас үлдсэнгүй л дээ. Хамгийн сүүлд Бямбацогт сайд байсан ингээд Хурлын дарга болчихлоо. Тэгэхээр энэ нөхцөл байдлууд чинь хүнд болно. Одоо ингээд ОТ-н энэ арбитрын хэлэлцээр ингээд орох гэж байна. Сая бүх тактикуудаа ер нь задлаад шийдчихлээ. Маш хүнд байгаа.

Тэгэхээр энэ 34 хувиа ер нь тодорхой хориг тавих эрхтэйгээр, өмчлөлийг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд хориг тавьдаг ийм эрхээ аваад, ерөнхийдөө энэ Амнат-аар солих асуудлыг яривал яадаг юм бэ? Энэ улс орны эдийн засаг хүнд байгаа энэ үе дээр, зэс ингэж өсөж байгаа үе дээр бид хэд энэ бодит эдийн засгийн эрсдэл үүрэхгүйгээр орлогоо аваад, энэ өнөөдрийн асуудлуудаа шийдвэл яадаг юм бэ? Тэгээд алийн болгон ингэж ноогдол ашгийг 37, 40 он, 50 он гээд ингээд явах юм бэ? Энэ дээр яг аль сайд нь хариуцах юм бол, ЗГ-ын гишүүд маань жоохон ухаан зарж ажиллаач гэж хүсэж байгаа юм. Тэгээд ер хайрцагнаас гарч сэтгээрэй. Тэгээд хайрцагнаас гарна гэхээр л шийдлийг олохгүй болохгүй энэ стандарт бус гээд бие биеэ зэмлээд байдаг юм шиг байгаа юм. Ер нь энэ стандарт ч гэдэг юм уу, уламжлалт тэр байдлаар явна гэж байхгүй. Ер нь аль болохоор л нэлээн сэтгэж, хурдтай маневр хийж байж л явна. Тэгээд энэ асуудал дээр хандлагын өөрчлөлт байна.

Би Батшугар найздаа жоохон санаа зовоод байгаа юм. Ковид шиг үе болбол онцгой байдлын сайд гэхээсээ юу гэдэг юм Эрүүл мэндийн сайд арга хэмжээ авна. Ганц ЭМД-ын сангийн асуудлыг зөв болгох гээд явдаг энэ нөхцөл байдлууд дээр асуудал хүндэрнэ шүү.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд асуучихъя.

П.Сайнзориг: Өөрийнхөө улс төрийн капиталыг л тавьчихлаа даа, уг нь залуу хүн дараа дараагийн юм байсан л байх. Ингэн, ингэн сайд болж өөрийгөө ийм хүнд салбар дээр уг нь манай яам ч гэсэн эмч боловсон хүчнүүд нь тоймгүй л нэлээн л байх шиг байна уг нь тэр төлөөлсөн бол.

Энхбаяр сайддаа хэлье дээ, миний удирдлага байсан юм. Энэ ингээд таныг чинь янз бүрийн байдлаар ингээд асуугаад л, гэрийн хаяг нь олдохгүй байна гэх юм. Одоо бас ийм үл ойлголтуудыг та битгий гаргаач. 2 дугаарт, ярьж байсан энэ газрын реформоо танд яг чиг үүрэг чинь хүрээд ирлээ. Та хийж чадах уу? Газрын реформ буюу газрын багц хуулиудыг та явуулж чадах уу? Таны ярьж байсан нөгөө бид хэдийн хамт ярьдаг байсан төрийн албаны реформоо та явуулж чадах уу, энэ дээр ер нь ямар бодолтой байгаа вэ?

Тэгээд ЗГ-ын 100 хоног гэж хэрэггүй байх. Эдийн засгийн энэ хүнд нөхцөл байдлын эсрэг хариу арга хэмжээний л төлөвлөгөөнүүдээ сайн гаргаж ажилла. 100 хоног гээд л нэг эрчимжчихээд л, 100 хоногийн дараа ажил хийхгүй байгаа юм шиг. Тэгээд муу Дамдиннямдаа ганц үг хэлье.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Сайнзориг гишүүний хэлж байгаа санаануудыг сайд нар анхааралдаа авах хэрэгтэй. ОТ дээр хэлэлцээр үргэлжилж байгаа, би тэгэхдээ бүтэн мэдээлэл байхгүй байна. Хэлэлцээр ямар түвшинд явж байгааг Дамдинням сайд хариулах байх. Миний ойлгож байгаагаар би Оранотой хийсэн гэрээн дээр төрийн эзэмшлийн хувь хэмжээг Амнат-аар орлуулах асуудлыг шийдвэрлэсэн. Тухайн үед бэлтгэл хангаад Баялгийн сан, Цөмийн энергийн хуулиудад өөрчлөлт оруулсан. Ингээд төрийн эзэмшлийг орлуулж байгаа хувь нь Баялгийн сан руу ордог. 2-т хамгийн том асуудал төрийн эзэмшлийн 34 хувь дээр ОТ дээр ТУЗ-д 3 хүн Монголын талыг төлөөлж сууж байгаа мөртөө нөгөө ... эрх байхгүй. Хориг тавьж чаддаггүй. Тийм эрхтэй 3 хүнээс илүү Орано дээр хийсний дагуу нэг хориг тавих эрхтэй ТУЗ-ийн гишүүн илүү үнэтэй байхгүй юу. Тийм учраас ОТ-н хэлэлцээр дээр нэлээд сайтар бэлтгэл хангах хэрэгтэй байна.

Тэр Улсын Их Хурлын 120 дугаар тогтоолоор тодорхой чиглэл өгсөн тэр өгөөжийг 53 хувьд хүргэхийн тулд хуулийг нь гаргаж өгмөөр байна. Тэгээд төрийн эзэмшлийн хувь хэмжээг хэрвээ Амнат-аар орлуулбал заавал тэр нь өөрөө тэр Баялгийн сан руу ордог байхыг нь тодорхой болгож өгмөөр байна. Тэгэхгүй цаашид энэ нөгөө ОТ-той хэлэлцээр хийхэд нөгөө өгөөж нь орохгүй байвал их төвөгтэй байдалд шилжинэ. Тийм учраас хэлэлцээр дээр үүнийг онцгойлон анхаарч ажиллана.

2-т тэр кабинетынхаа зарчмыг манай сайд нар баримталж ажиллах хэрэгтэй. Тэгээд орж ирээд Байнгын хороон дээр, чуулган дээр тэс өөр 2 санаа ярьдаг, сошиалаар бие биедээ үгээ хэлдэг ийм зарчим байж болохгүй. Тийм учраас кабинетын зарчим гэдэг бол нэг дуу хоолойтой, нэг байр суурьтай байхыг хэлнэ. Тэгэхээр Их Хурлын гишүүд үүнийг л шаарддаг. Бид нэг кабинет, бидний зорилт адилхан, үр дүн адилхан. Тэгэхээр 100 хоногийн хугацаанд энэ эдийн засгийн нөхцөл байдлыг хэрхэн даван туулах вэ гэдэг арга хэмжээгээ тодорхой болгож байж л цаашаа гарна. Ер нь тухайн цаг үе сорилттойгоо уялдуулж салбарын сайд нарыг сонгох гэж хичээсэн. Тийм учраас Батшугар сайдын эхний ажил энэ ЭМД, санхүүжилт, цалингийн тогтолцоо. Энийг бүхлээр нь эргэж харах хэрэгтэй. Тийм учраас тулгамдсан асуудлаа шийдье, тэгээд даваад гаръя гэдэг ийм л зүйлийг хэлмээр байна.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя. Газартай холбоотой асуудал, төрийн алба төрийн алба. ЗГХЭГ.

Б.Энхбаяр: Сайнзориг гишүүн бид хоёр 2016-аас 18 онд 3 жил би Хууль зүйн бодлогын асуудлыг хариуцсан дэд сайдаар ажиллаж байсан, Сайнзориг гишүүн Хууль зүйн бодлогын газрын даргаар ажиллаж байсан. Бид хамтдаа их олон эрх зүйн шинэтгэлийн ард гарсан. Энэ дотор Газрын багц хуулийг боловсруулж, өнгөрсөн парламентын үед 5 багц хуулийг оруулж ирж байсан. Бид концепц нэг байдаг. Би бол тийм гал уснаас айдаг хүн биш. Өмчийн хууль эхлээд батлагдаад, дараа нь газрын багц хууль батлагдах хэрэгтэй байгаа юм. Ингэж байж бид жинхэнэ

утгаараа өмчийг зах зээлийн эдийн засагт шилжүүлэх, хувийн өмчит эрхэд хамгаалагдсан чөлөөт эдийн засагтай улс гэж хэлэгдэх боломж бүрдэнэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

Б.Энхбаяр: Нийтийн өмчийн хууль батлагдахыг би давхар ач холбогдолтойд тооцож байгаа юм. Ер нь болж өгвөл бидэнд хугацаа богино байгаа учраас бид хамтдаа энэ парламентын бүх намууд энэ дээр нэг нийтийн өмч, нийт төрийн өмчийн компанийн хуулийг баталчихвал энэний ардаас юу явуулах гээд байгаа вэ гэхээр Нийтийн албаны тухай хуулийг явуулах гээд байгаа юм. Бид төр данхайлаа, цалин тэтгэмж, энэ халамжийн зардлууд их байна, томроод байна гэдгийн бас нэг суурь шалтгаан нь бид яг нийтийн алба гэдэгтээ юуг ойлгох вэ, энэ хүмүүс маань ямар цалин хангамж, баталгаатай байх вэ гэдгийг их тодорхой болгох ёстой. Тэгэхгүй бол төсвөө дагаад бид байнга төрийн албаа тэлээд яваад байгаа. Нийтийн өмчийн хууль дээр бид зүгээр ямар бодлого барих вэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Баялгийн сантай холбоотой асуудал дээр би ЗГХЭГ-ын дарга байхдаа ажлын хэсэг ахалж байсан. Байгалийн баялгийн өгөөжийн дийлэнх нь Монголын ард түмэнд ноогдох ёстой гэж 2019 онд хууль баталсан. Байгалийн баялгийн өгөөжийг хуваарилахдаа өнөөдөр амьдарч байгаа иргэд болон ирээдүйд амьдрах иргэддээ тэгш хүртээмжтэй хуваах зарчмыг барина гэж Үндсэн хуульд зааж өгсөн. Энийг амилуулах тал дээр 2007 онд баталсан Стратегийн ордуудын улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн стратегийн ордуудын 34-өөс 50 хувийг төр үнэ төлбөргүй эзэмших ёстой гэж хууль баталсан. 20 жил, сүүлийн 20 жил хэрүүл хийсэн. Нэг ч хувийг авч чадаагүй, нэг ч асуудал шийдэгдээгүй байсан. Энийг Занданшатар Ерөнхий сайдын ЗГ-ын үед бид бүхэн нэлээн ахиулсан байгаа шүү. Энхбаяр сайд ЗГХЭГ-ын дарга хариуцах ёстой. Энэ дээр бид байгалийн баялгийн өгөөжийг энэ стратегийн ордууд дээр 34-өөс 50 хувийг авах биш, үүний тийм үү, үүнтэй тэнцэх буюу үүнээс илүү 60 хувийн өгөөжийг Монголын төр авах, Монголын ард түмэнд ноогдуулах энэ хэлцлүүдийг хийсэн байгаа. Үүнийг нэн яаралтай хэлэлцээр болгож, Монгол УИХ-д өргөн барьж Их Хурлаар батлуулах ёстой. Ингэж баялагтаа эзэн Монгол хөтөлбөр хэрэгжинэ. Ингэж Үндсэн хуулийн, амилна Үндсэн хууль.

Тийм болохоор энэ маш том асуудал байгаа. Монголын ард түмэн байгалийнхаа баялгийн өгөөжөөс хүртэх гэж олон жил хүсэж байгаа, хүртэж чадахгүй байгаа учраас, бага хүртэж байгаа учраас маш их бухимдаж байгаа. Ийм болохоор байгалийн баялгаа ашиглуулахаас харамладаг, бухимддаг, энэ асуудлыг өгөөжөөсөө өнөөдөр амьдарч байгаа иргэд хүртээд эхэлчихвэл, ирээдүй хойч үедээ хадгалуулаад ирчихвэл энэ Монголын ард түмэнд, Монгол Улсын хөгжил дэвшилд хэрэгтэй. Энэ асуудлыг сая Сайнзориг гишүүн хөндөж ярьсан. Энийг Энхбаяр сайд анхааралдаа аваарай гэдгийг хэлье. Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Тэгээд яах вэ нэг зүйлийг хэлье гэсэн юм. Миний энэ сайд нараас болж байгаа энэ Дамдиннямыг л өрөвдөж байна л даа. Тэгээд гадаад нөхцөл байдал ийм. Ер нь зүгээр энэ бензин шатахууны үнэ бол өөрөөс нь үл хамаарч байна. Бусад нь шалтаг байхгүй шүү гэдэг үгийг л би түрүүн гүйцээх гэж байсан юм. Тэгээд ажлаа сайн хийгээрэй л гэж сайд нараасаа хүсэж байгаа юм. Тэгээд гол асуудал сая Энхбаяр сайд хэллээ. Газрын реформтойгоо, нийтийн албаны реформтойгоо та зууралдаарай. Элдэв хов жив хэрэггүй байх. Ер нь энийгээ оруулаад ирвэл энэ томоохон шинэтгэлүүд болох юм. Эдийн засгийн сайд маань,

Аялал жуулчлалын сайд тусгай хамгаалалтай газар нутаг /ТХГН/-ийн асуудал хариуцаж байгаа болон Зам, тээврийн сайд нийлж байгаад энэ аялал жуулчлал буюу хамгийн их олон ажлын байр хадгалдаг энэ салбар дээр нэг тодорхой дэд бүтцийг бий болгох чиглэлээр нэг бонд босгоод, ер нь дараагийн дунд хугацааны тогтвортой аялал жуулчлалын асуудал дээрээ бүүр анхаараад үзвэл яадаг юм бэ? Энэ дээр Энхбаяр сайд ер нь ямар бодолтой байна вэ? Ж.Энхбаяр сайд шүү. Ямар бодолтой байна вэ? Дамдинням сайд нөхцөл байдал ер яаж.../минут дуусав/

С.Бямбацогт: Эдийн засгийн хөгжлийн сайдад нэр дэвшигч Энхбаяр хариулья.

Ж.Энхбаяр: Энэ Ойрх Дорнодын бүс нутагт үүссэн нөхцөл байдлаас шалтгаалаад эдийн засагт учирч болзошгүй хямралыг хохирол багатай даван туулах, онцгой нөхцөл байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан. Энэ ЗГ анхны хурлаараа энэ нэг асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам танилцуулна. Төсөв, санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн чиглэлээр, хүнс, хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх, нөөц бүрдүүлэх чиглэлээр, эм, эмнэлгийн нөөц бүрдүүлэх, эрүүл мэндийн бүтээгдэхүүний тасалдлыг үүсгэхгүй байх чиглэлээр, түлш, эрчим хүчний чиглэлээр, тээвэр, логистикийн чиглэлээр, мөн гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээрээ ингээд бодлогын 6 энэ салбар хүрээнд бодлогуудыг бэлдсэн.

Таны хэлж байгаатай санал нэг. Хамгийн олон ажлын байр бий болгож байгаа үйлчилгээ, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт бид энэ үед ажлын байрыг хадгалах, орлогыг бууруулахгүй байх, инфляцаас зөөллүүлэх, инфляцыг зөөлөн буулгах нэг ийм бодлогыг яг энэ салбарт авч хэрэгжүүлэх учиртай. Яагаад гэвэл 2 хүний 1 нь эдгээр салбарт ажиллаж байгаа юм.

С.Бямбацогт: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад нэр дэвшигч Дамдинням хариулья.

Г.Дамдинням: Өмнөх ЗГ-тай ОТ-н хэлэлцээртэй холбоотой 67, 68 дугаар захирамжаар 2 ажлын хэсэг байгуулагдсан. Миний Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын ахалж байгаа ажлын хэсэг бол менежментийн төлбөрийг бууруулах чиглэлээр үүрэг даалгавартай ажиллаж байгаа. Энэ ажлын хэсэг бол ЗГ-аас өгсөн үүрэг, даалгаврыг ер нь биелүүлэхэд тун ойрхон болчихсон байгаа. Хэлцэл ер нь эцэслэх шатдаа орж байгаа.

Дараачийн нэг Ажлын хэсэг Онтрэ-гийн хэлэлцээр байгаа. Онтрэ-гийн хэлэлцээрийг яг Сайнзориг гишүүний хэлж байгаа, мөн Ерөнхий сайдын хэлж байгаа нөгөө энэ хувь эзэмшихээсээ илүүтэй роялти суурьтай буюу Ораногийн хэлцэлтэй ижилхэн хэлбэрээр хийе гэдэг ийм чиглэлтэйгээр хэлэлцээрийг эхлүүлээд явж байгаа. Харьцангуй тал талаасаа ойлголцолтой ингээд ярилцаад явж байна.

Шатахуунтай холбоотой асуудал дээр ойлгож хүлээж авч байгаад их баярлалаа. Гадаад нөхцөл байдал туйлын хүнд байна. Тэгээд би дараа нь дэлгэрэнгүй мэдээлэл өгье.

С.Бямбацогт: Пунсалмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Пунсалмаа: Баярлалаа. Засаг ер нь ойрхон, ойрхон солигдоод, энэ хөгжлийн бодлого, төлөвлөлт ер нь ярих завгүй байгаад байна л даа. Тэгэхлээр энэ

удаа шинээр томилогдож байгаа ЗГ тогтвортой ажиллаарай, сайн ажиллаарай гэж хүсье. Тэгээд 1 зүйлийг хэлмээр байна.

Өнөөдөр Монгол Улсын эдийн засаг асар өсөлттэй байгаа шүү. Сүүлийн 10 жилийн байдлаар гэхэд Монголын эдийн засаг 5 дахин өсчихсөн, 23 их наядын эдийн засаг чинь одоо бараг 100 их наядын эдийн засаг болчихсон байхгүй юу. Гэхдээ энэ өсөлт чинь өрх рүү орж ирэхгүй байна. Иргэний цалин болж нэмэгдэж очихгүй байна. Тэгэхлээр бид жил болгон төсвийн хүрээнийхээ мэдэгдэл дээр ДНБ-ээ тооцож байгаа юм. Тийм учраас эдийн засаг өсдөг юм шиг байна. Тэгэхлээр одоо энэ дээр бид well-being index гээд чанарын тухай ярих ёстой байхгүй юу. Чанарын индексээ тооцох хэрэгтэй байна. Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд чанарынхаа индексийг тооцож байна л даа. Жишээлбэл Англи, Их Британи, Солонгос. Тэгээд эдгээр улс орнуудын эдийн засаг нь өсөөд байна. Гэтэл Африкийн зарим орнууд энэ чанарынхаа индексийг тооцохгүй байна. Тэгэхлээр Африкийн улс орнууд ядуугаараа байгаад байна.

Ерөөсөө амьдралын чанарын индекс гэхлээр юу юм цалин хөлс, өрхийн орлого, боловсрол, эрүүл мэнд, агаарын чанар, орчны чанарын тухай л яриад байгаа шүү дээ. Тэгэхлээр бид өнөөдөр Африк шиг байх юм уу, эсвэл өндөр хөгжилтэй улс орон байх юм уу, бид аль хэсэг дээр нь байх юм бэ? Бид сүүлийн 10 жил халамж өглөө, халамж хөгжлийн шийдэл биш юм байна гэдэг нь харагдаж байна. Тэгэхлээр татвар бууруулах, бизнесийн орчныг таатай болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх л тухай яриад байгаа шүү дээ.

Сангийн сайдаас надад асуулт байгаад байгаа юм л даа. Энэ амьдралын чанарыг сайжруулах талаар, энэ индексийг тооцох талаар та ер нь авч хэрэгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх үү? Жишээлбэл тэрнийгээ хэмждэг, төлөвлөдөг, түүндээ хүрдэг ийм чанарын тогтолцоог бид хэрэгжүүлэх хэрэгтэй байна well-being index.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас асуумаар байна. Танайх жишээлбэл амьдралын чанарыг дээшлүүлэх ямар индикатор одоо ашиглаж байгаа юм бэ? Жишээлбэл сүүлийн үед бид ахмадуудынхаа тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлсэн, багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлсэн. Гэхдээ энэ эдийн засгийн өсөлттэйгөө харьцуулахад хангалттай өсөлт мөн үү? Цаашдаа бид энэ эдийн засгийн энэ индикаторыг ашиглаад, энэ амьдралын чанарыг нэмэгдүүлэх ийм бодлого танай яам хэрэгжүүлж ажиллах уу гэдэг ийм асуултыг 2 сайдаас асууя.

С.Бямбацогт: Аубакир сайд хариулъя. Мэндсайхан сайд эхлээд хариулъя.

З.Мэндсайхан: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ДНБ-ий өсөлт яах вэ энэ жил 6,8 хувьтай гарсан. Эдийн засгийн өсөлт, ДНБ-ий өсөлт, эдийн засгийн тэлэлт байгаа хэдий ч иргэдийн орлого нэмэгдэхгүй байна гэдэгтэй санал нэг байна. Ер нь таны хэлж байгаа саналыг ойлголоо. Зүгээр амьдралын чанарыг сайжруулах индекс гэдэг нь хүмүүсийн амьдрал хэр тав тухтай байгаа юм, аюулгүй, сэтгэл ханамжтай байдал нь хэр байгаа юм гэхээр энэ нийлмэл үзүүлэлтүүдийг ашигладаг. Тэгэхдээ энэ зөвхөн орлого биш, олон талын хүчин зүйлсийг тооцож үздэг байгаа. Тэгээд би таны хэлсэн аргачлалыг одоо яг манайхан ашиглаж байгаа, үгүй дээр дээр би одоо бол мэдээлэлгүй байна. Танд энэ талаар би эргээд нарийвчилсан мэдээлэл өгье.

С.Бямбацогт: Аубакир нэр дэвшигч хариулъя.

Т.Аубакир: Манай яам бол Хөдөлмөрийн яам. Бид халамж гэхээсээ илүү хөдөлмөр эрхлэлтийг илүүтэй дэмжих. Хэрвээ та хөдөлмөрийн чадвартай бол хөдөлмөр эрхэл гэдэг асуудлыг 1 дүгээрт тавьж байгаа. Зайлшгүй халамж шаардлагатай иргэддээ төр үзүүлэх халамжаа үзүүлсээр байх болно цаашдаа. Яг одоо манай улсын хувьд яг халамжид нийтдээ 600 орчим тэрбум төгрөг зарцуулагддаг. Яг л зорилтот бүлэгтээ гэсэн үг. Тийм учраас 1 дүгээрт бид хөдөлмөр эрхлэлтийг тавина. Цалин хөлсний бодлого бол манай улсын хувьд нийтдээ 33 хуулиар, салбарын 33 хуулиар цалин хөлсний асуудал зохицуулагддаг. Энэ маань юу гэж байна вэ гэхээр цалин хөлсний нэгдсэн бодлого алдагдсан гэсэн үг. Бид хууль, эрх зүйн орчноо шинэчлэх хэрэгтэй, илүүтэй бүтээмж дээр гүйцэтгэлд суурилсан цалинг бид цалин хөлсний нэгдсэн бодлоготой болгох шаардлагатай. Тийм учраас хэн нь ямар яам, салбар нь лобби ихтэй байна тэр нь цалингаа хэт нэмээд байдаг. Нөгөө талдаа мэдээжийн хэрэг өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Батсуурь гишүүн алга байна. Баатархүү гишүүн алга байна. Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Оройн мэнд хүргэе. Ерөнхий сайдаас асуух гэсэн юм, харин Ерөнхий сайд алга байна. Тэгээд өнөөдөр Ерөнхий сайд Учралын царай их дүнсгэр байна л даа. Шинэ ЗГ-т амжилт хүсье. Шахааны барьцад орж, энэ бүлэглэлүүдийн шахаанд өртөж энэ сайдуудаа тавьсан байна гэж харагдаж байна. МАН-д мэдлэгтэй, мэдлэг боловсролтой олон залуус байгаа гэж итгэж байна. Тэр хүмүүсээ бол тавьж чадаагүй бололтой. Хонь хурга нийлсэн ЗГ-ыг зөндөө харж байсан. Хонь чоно нийлсэн кабинетыг анх удаа л харж байна. Тэгээд Учралын ЗГ-ын сайдуудыг сонгосон тэр сонголтыг би их гайхаад байх юм. Өмнөх салбартаа, ажиллаж байсан салбартаа амжилт гаргаж байсан сайдуудыг үргэлжлүүлэн ажиллуулахгүй, өөр салбарт гулсуулсан байх юм. Өмнөх салбартаа амжилт байтугай гай болж байсан сайдуудыг цоо шинэ салбар луу гулсуулсан байх юм. Сайд дээрээ тохирохгүй болохоор танай бүлэг азын сугалаа хийчихсэн юм байна гэж харж байгаа шүү дээ. Тэгээд сугалаагаар бараг энэ сайдуудаа тодруулсан юм байна гэж хардлага төрж байна.

Тэгээд Монголд төрийн ажил явж байна. Ингээд сугалаагаар тодруулсан сайдууд салбартаа эзэн болж ажиллах ёстой гэж бодож байна. Би ингээд сайдуудаас асуумааргүй байна. Та бүхэн бол одоо ажилтайгаа танилцаагүй байгаа учраас ерөнхий бөөрөнхий хариулт өгнө. Тэгээд ЗГ-ын Хэрэг эрхлэхийн сайдаас асууя гэж бодож байна. Ерөнхий сайд нь байхгүй байгаа учраас. Энхбаяр сайдаас. Энхбаяр сайд ч гэсэн өнөөдөр ямар дүнсгэр байх юм. Инээд алдаад суудаг байсан, салбар нь өөр юм руу гулсчих шиг боллоо л доо. Үгүй ээ, саяхан хэвлэлээр Энхбаяр сайдаа та хэд чинь ээлжлээд АТГ-ын гадаа, дотор, ордонд хэвлэлийн хурал хийгээд байсан. Би хувьдаа энэ хууль шүүхийн байгууллагууд их удаан байна даа гэж бодож байсан. Тэгээд л 100 сая доллар авлигад авсан, аваагүй бичлэг байгаа, байхгүй тухай л юм яриад байсан хүмүүс. Нэг кабинет байтугай, нэг улсад багтаж амьдарч чадахгүй гэмээр байсан хүмүүс өнөөдөр ингээд нэг кабинетад сууж байна л даа. Тэгээд Монгол Улсын ЗГ гэмт хэрэг, хулгайтай тэмцэх энэ үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж чадах юм уу 1 дүгээр асуулт?

2 дугаар асуулт энэ хууль хяналтын байгууллагууд чинь улс төрийн нөлөөллөөс хамааралгүй ажиллах ер нь боломж байна уу? Хуулийн сайдаар ажиллаж байсан хүний хувьд, ЗГ-ын Хэрэг эрхлэхийн сайд болж байгаа хүний хувьд та энд нэг хариулт өгөөч? Манаачийг хэн манах вэ гэдэг нэг тийм үг байдаг. Гэтэл

өнөөдөр хууль хяналтын байгууллагыг бид шүүмжлээд байдаг. Гэтэл энэ улс төрийн нөлөөллөөс ангид, ажлаа хийгээд үр дүн гаргах боломж хэр байгаа юм бэ гэдгийг 1 дүгээрт тодруулж өгмөөр байгаа юм.

БХБ-ын сайд байна уу? Үгүй ээ, энэ Барилгын сайд уг нь Улаанбаатар хотоос сонгогдсон хүн. Нэг зүйлийг би тодорхой асуумаар байна. 2,3 их наяд төгрөгийн өртөгтэй, 1км нь 76 тэрбум төгрөгөөр Туул голын голдиролд нөлөөлнө гэж үзээд байгаа энэ хурдны замыг зайлшгүй явуулах хэрэг байгаа юм уу? Энийг зогсоож болдоггүй юм уу? Зам, тээврийн сайд нэмж хариулаарай. Энэ Улаанбаатар хотод дэлхий дээр байгаа хамгийн өндөр өртөгтэй Туулын хурдны зам, метро.../минут дуусав/

С.Бямбацогт: Баатархүү гишүүн асуултаа асууя, сунгая.

Ц.Баатархүү: Хамгийн өндөр өртөгтэй хурдны зам, метро, трамвай, дүүжин тээвэр энэ бүх төслүүдийг хэрэгжүүлэх гэж лоббидож байна шүү дээ. Эрэмбэ дараалал гэж байна уу? Бүтээн байгуулалтын ажлыг бид шүүмжлээгүй. Энэ түгжрэлийг бууруулах нэрийн ард асар их лобби яваад байгаа хардлага төрж байна. Энийг эрэмбэлээд Туулын хурдны замыг шууд зогсоох шийдвэр гаргаж чадах уу гэдгийг Ерөнхий сайд орж ирсэн байна асуучихмаар байна.

Байгаль орчны сайд Цэндийн Сандаг-Очироос асууя. Богд уулын амыг чинь отог нэрээр өмнөх сайдууд чинь газрыг нь олгочихсон. Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд нь барилга барих зөвшөөрөл өгсөн. Богд уулын аманд иргэд алхах орон зайгүй, ам амаар нь хүмүүс авсан, ЗГ-ын гишүүд чинь авчихсан.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя, дараад нь Байгаль орчны сайд.

Н.Учрал: Баатархүү гишүүн маань ЗГ-т ажиллаж байсан хүн. Тэгэхээр ЗГ-ын гүйцэтгэх засаглалын зовлон бэрхшээлийг их сайн мэднэ. Тэгээд өдөр өдрөөр л ажил хөвөрч байдаг, цаг минутгүй ажилладаг ийм л ажил. Тэгээд яриад үр дүн бага гардаг, тэгээд хийсэн ажлаараа л үнэлүүлдэг. Үр дүнг нь ард түмэн ойлгож мэдэрч байвал тэр ЗГ-ын ажил үйлс сайн байдаг. Тэгэхээр Ерөнхий сайд өөрөө кабинетаа бүрдүүлээд, эцсийн гарах үр дүнг өөрөө хариуцдаг. Тэгэхээр Ерөнхий сайд болгоны дэвшүүлж байгаа бодлого, зорилтууд өөр.

Миний дэвшүүлж байгаа энэ Эрх чөлөөний зам 4 чөлөөлөлт гэсэн бодлогыг хэрэгжүүлэхэд манай салбарын яамнууд тэргүүлэх ажлууд нь юу байх вэ, тэр ажлуудыг хэн хийж чадах вэ л гэдгийг хүн боддог болохоос биш, өөгүй сайхан нэр хүндтэй, улс төрд олон жил явж байгаа хүмүүс бол энэ ардчилсан нийгэмд их хэцүү л дээ. Тийм учраас энэ ЗГ өөрөө илүү улс төрийн тэр капиталын цөм юм л гэж би сонголтоо хийсэн юм гэдгийг та бүхэн ойлгоорой. Тийм учраас нөгөө үр дүн гаргах тал руу нь илүү харж байгаа юм.

Авлигатай тэмцэж байсан бодлого бол үргэлжилнэ. Миний энэ дэвшүүлж байгаа Эрх чөлөөний зам 4 чөлөөлөлтийн нэг чөлөөлөлт бол энэ авлигын эсрэг чөлөөлөлт. Би түрүүн хэлсэн холбогдох эрх зүйн орчнуудыг өөрчилнө, төсөөллийн индекс дээр үр дүн авчирна. Тэрнээс биш Хууль зүйн яам өөрөө мөрдөх алба бол огт биш. Мөрдөх алба. Хууль зүйн яам хэн нэгнийг мөрдөн байцаагаад, шалгаж шүүгээд, эцэслэхидэг газар ч биш. Хууль зүйн яам илүү эрх зүйн орчин талдаа ажилладаг ийм л салбарын яам. Тийм учраас энэ удаагийн Хууль зүйн яамны дэвшил бол илүү энэ хувийн эрх зүйн шинэчлэл рүү анхаарах ёстой гэдэг утгаараа

би энэ Америкт ч төгссөн, дээрээс нь энэ төрийн олон хариуцлагатай албыг хашиж байсан. Яг таны хэлээд байгаа энэ хотын асуудлууд дээр хотын дарга байсан хүний хувьд бас нэг ийм эрх зүйн орчин талд нь дэвшил гаргах болов уу. Энэ хуульд байхгүй дүрэм журмуудыг нь цуцалж, нийслэлд үнэхээр бодитой хүнд суртлын чөлөөлөлтийг, эрх зүйн чөлөөлөлтийг хийх болов уу гэдэг утгаар би энэ Амарсайхан сайдыг та бүхэнд танилцуулж байгаа юм.

Баттөмөрийн Энхбаяр сайдын хувьд өнгөрсөн хугацаанд Хууль зүйн сайдаар ажиллаж байсан. Гэхдээ энэ тал нь илүү их ард түмэнд харагдаад байсан болохоос биш Энхбаяр сайд бол яг энэ өмчийн эрх зүй, газрын эрх зүй, энэ төрийн албаны шинэчлэлийг хийх үйл хэрэгт надад хань болно, нөмөр нөөлөг болно гэдэг утгаар би сонголтоо хийсэн. Энэ ярьж байгаа 4 чөлөөлөлтийг үр дүнд хүргэхэд энэ баг өөр өөрийнхөө урдах ажлыг хариуцлагатай хийнэ. Тэгээд та бүхэн шүүнэ.

С.Бямбацогт: Ерөнхий сайд гүйцээгээд хариулъя.

Н.Учрал: Тэргүүн Шадар сайдаар ажиллаж байхад ЗГ-ын мега төслүүдийг би 4 бүлэг, 16 зүйл, аргачлалаар үнэлж байсан. Тэр үнэлгээг тухайн үед танилцуулж, ЗГ-ын зүгээс 5 жилийн үндсэн чиглэлийг баталсан. Тэр мега төслүүдийг үнэлж, эрэмбэлсэн байдлаа цаашид хатуу барина. Нийслэл дээр байгаа 20 төслүүдийг яг энэ аргачлалын дагуу тухайн үед үнэлж байсан. Гэхдээ батлуулж чадаагүй. Одоо энэ үнэлгээнийх нь аргачлалыг шинээр оруулаад, ЗГ-аас батлаад эрэмбэлнэ. Шаардлагатай хөрөнгө оруулалтыг царцаана. Төсвийн орлого тасарч байгаа энэ үед зарим газруудыг, зарим газруудад төслийг царцаах, хойшлуулах арга хэмжээнүүдийг авна. 5 дугаар сарын 31-нд л гэхэд бараг 1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил зарлагдаж чадахгүйгээр царцах ийм төлөвтэй байгаа. Одоо бид чинь бодит утгаараа багш, эмч дээр бараг 1,2 их наядын нэмэлт санхүүжилт хэрэгтэй болчихоод байна шүү дээ. Тэгэхээр зайлшгүй л ийм ажлууд хийгдэнэ.

С.Бямбацогт: Байгаль орчны сайдад нэр дэвшигч Сандаг-Очир.

Ц.Сандаг-Очир: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Богд уулын аманд олгогдсон отог нэртэй энэ газруудыг цуцалж чадах уу гэж асууж байна. Өнөөдрийн байдлаар газар олголт маш олон хэлбэрээр явагдаж байна. Дүүргүүд нэг газар олгож байна, нийслэл нэг газар олгож байна, Байгаль орчны яам өөрөө нэг олгож байна өнгөрсөн хугацаанд. Тэгээд энэ газар олголтын ийм олон хэлбэрээр олгогдож байгаа учраас өнгөрсөн хугацаанд энэ Богд ууланд гарсан, Богд уул ч гэлтгүй ер нь газар олголтын бодлогод алдаа зөрчил зөндөө гарсан. Гэхдээ миний бие эргэж харахаасаа илүүтэйгээр урагшаа харж ажиллана. Цаашдаа энэ газар олголтын хуулийг эрх зүйн хувьд шинэчлэх тал дээрээ онцгой анхаарч ажиллаж, ахиж энэ гарсан энэ алдаа завхралыг гаргахгүй байх тал дээр онцгой анхаарч ажиллана гэж ингэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баатархүү гишүүн тодруулъя.

Ц.Баатархүү: Сайдууд гоё, ганган нэртэй төсөл, хөтөлбөрөө битгий хийгээрэй гэж хэлмээр байна. Монгол хэлэнд байгаа хамгийн сайхан үгтэй уриа лоозонтой бүх төслийг өнгөрсөн 10 жил хийчихсэн шүү. Ширээн дээр байгаа бодлогоо уншаарай. Шинэ юм хийх гэж байна гээд дандаа ийм гацалтын эргүүлэгт ордог, ажил чинь уялддаггүй, цаг их богино байгаа, хүлээлт өндөр байна. Иргэд бол ЗГ-т, энэ УИХ-д, улс төрд, төрд итгэх нь битгий хэл цөхөрсөн байдалтай байна. Тийм

учраас зөв юм оруулж ирж байвал УИХ дандаа шүүмжлэхгүй, дэмжинэ. Хоосон уриа лоозонгоор гоёж гангалж, шинэ шийдэл, реформ нэртэй төсвийн мөнгө үрсэн ажлыг бол дэмжихгүй.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Орой болсон байна, тэгээд бараг хоног дамжиж хэлэлцэж байна. Тэгээд засаг төрөө эмхлээд, хурдан яаралтай ажилдаа орох хүлээлт их өндөр байгаа, тулгамдсан асуудлууд их байгаа. Хамгийн түрүүний асуудал энэ бензин шатахууны хүндрэлтэй холбоотой асуудал дээр ЗГ цогц төлөвлөгөө оруулж ирэх хэрэгтэй. Би бол бэлдсэн байгаа гэж ойлгож байгаа. Ялангуяа бид чинь тавьхан мянган төгрөг өгөөд, хүүхдээ хараад сууж байгаа эмэгтэйчүүд амьдарч байгаа хүмүүс байгаа, хүүхдийнхээ 100 мянган төгрөгөөр амьдарч байгаа хүмүүс байгаа. 300 мянган төгрөгийн асрамжийн тэтгэмж аваад амьдарч байгаа хүмүүс байгаа, 600 мянган төгрөгөөр амьдарч байгаа ахмадууд байгаа. Тэгээд энэ олон хүмүүсийг энэ үнэ тарифын өсөлт, болзошгүй эдийн засгийн эрсдэлээс хамгаалах тал дээр түрүүн Ерөнхий сайд хэллээ. Энэ тал дээр бид давхар төлөвлөгөө хийхээс өөр арга байхгүй. Энэ тал дээрээ олон талыг бодолцож, энэ төлөвлөгөө дээрээ Засаг маань магадгүй ирэх долоо хоногт энэ асуудлыг бараг ярилцаж, оруулж ирэх болов уу гэж би хүлээлттэй байна.

2 дугаарт ЗГ залгамж халаатай байх ёстой. Энэ байгалийн баялгийн үр өгөөж гэдэг энэ асуудлууд дээр би өмнөх Ерөнхий сайд тэр Зөвлөлдөх зөвлөл гэдэг дээр байгалийн баялгийнхаа асуудлыг хоорондоо бид маргана гэхээсээ илүү, зарим энэ маргаантай асуудлуудыг бүгдээрээ ухаантан болж ярьж байсныхаа оронд ард түмнээсээ асуучих нь зүйтэй байдаг. Тийм учраас энэ ажил дээр нэлээн хүлээлт үүссэн байгаа юм байна гэж би бодож байгаа.

Боловсролын салбарт Боловсролын жил учраас онцгойлж хэлье дээ. Цалин хөлстэй холбоотой асуудал байна. Энэ тал дээр гарц гаргалгааг нь нэлээн ярилцсан. Энэ тал дээр нэгэнт энэ салбарыг онцгойлж байгаа учраас энэ асуудлыг нь байгаа бодит нөхцөл байдалтайгаа бараг Энх-Амгалан сайд бүрэн мэдэж байгаа учраас энийг нэг тийш нь шийдэх ёстой. Зарим бусад салбарууд гэдэг юм уу, хүмүүс бүгд барьцаад байх хэрэггүй болов уу гэж би бодож байна. Тийм учраас энэ шинэ цалин, хуучин цалин гэдэг асуудлууд дээр нэн яаралтай шийдлээ Энх-Амгалан сайд их зоригтой мэдэгдэл хийсэн байна. 1 сарын дотор шийднэ гэж. Тэгэхдээ энэ хүн ганцаараа шийдэж чадахгүй нь ойлгомжтой. Бусад Сангийн яам болон улс төрийн бас дэмжлэг үзүүлэх ийм шаардлага байгаа.

Эрүүл мэндийн салбар мөн ялгаа байхгүй. Сар болгон тодорхой цалингийн нэмэгдлүүд нь хүлээж байгаа. Цахим шилжилтийн асуудал чухал бас байгаа. Бид чинь 2, 3 программ ингээд тавьчихсан. Дунд нь эмч, эмнэлгийн ажилчид нь учраа олохоо байчихсан ийм асуудал байж байгаа. Захын өвчтөн бол хаана үзүүлэх вэ, ямар эм уух вэ, яах вэ, ийх вэ гэдэг зүйл нь маш ойлгомжтой тодорхой нэг И Монголиа гэдэг дээрээ зангилагддаг ийм зүйл байх ёстой гэдгийг хэлмээр байна.

Салбарынхаа ажилчидтай нэг сайн уулзаарай гэдгийг хэлмээр байна. Ялангуяа шинэ сайд нарт хэлэхэд. Магадгүй болж бүтэхгүй байгаа зүйлүүдийг нь тэр салбарт олон жил ажилласан хүмүүс хэлээд өгөх байх. Томилгоо янз бүрийн зүйл хийхдээ тэр салбартаа мэргэшсэн хүмүүсээ битгий ад шоо үзээд, магадгүй зарим нь шударга хэлчихдэг, тэр хүмүүсээ янз бүр болгоорой. Тэр хүмүүсийгээ харин багтаа авч ажиллуулаарай гэдгийг хэлмээр байна.

ЭМД-ын юун дээр би ЭМДҮЗ-д өнөөдөр өглөөхөн хэлж байсан. Тэр нэг зарим хурлаа ЭМДҮЗ-лөлийнхөө хурлыг нээлттэй хийж байгаарай. Би 3 ч сайдыг дамжиж хэллээ. Байнгын хороо нээлттэй хурлаа хийгээд, Их Хурал нээлттэй гээд байхад зарим зөвлөл, хороод хурлаа нээлттэй хийж байя, нуугаад байх юм байхгүй. Бодит дүнтэйгээ асуудлыг нь ярих хэрэгтэй гэж бодож байна.

Аубакир сайддаа захиж хэлсэн байгаа. Тэтгэврийнхээ зөрөөний асуудлыг яаралтай шийдээрэй, бэлдчихсэн байгаа, тодорхой төсөв орж ирэх байх гэж байгаа. 170 мянган хүний асуудал хүлээгдэж байна гээд маш олон ахмадууд өдөр, шөнөгүй энэ асуудлыг амрахгүй байна гэдгээ хэлмээр байна.

Аюулгүй байдал гээд Номтойбаяр сайд хариуцсан гэж ойлгож байгаа. Энэ байгалийн болзошгүй, нийслэлийн болзошгүй, хүн амын болзошгүй энэ аюулгүй байдал дээр онцгой анхаарал хандуулах шаардлага байна. Нэмэлт 1 минут авчихъя.

С.Бямбацогт: Асуултаа гүйцээж асууя, нэмэлт минут.

С.Эрдэнэбат: Би Улаанбаатар хотоор нэг бензин, газ тээвэрлэж явж байгаад дэлбэрсэн бөөн асуудал болсон. Дахиад иймэрхүү асуудал болбол иргэд ер нь тэр газ алдагдаж байгаа гэдэг зүйлийг юугаар мэдэх вэ гэдгээс авхуулаад маш нарийн тийм менежментийн асуудал байгаа. Салбар хоорондын асуудал юм байна лээ. Би нэлээн олон салбаруудын дунд гүйж үзээд, одоо яг дунд нь хаягдчихсан бас нэг асуудлууд байгаа юм байна лээ. Энийг олж харж хэлээрэй. Иргэний аюулгүй байдлын асуудлуудыг бусад яамтайгаа, салбартайгаа хамтарч аюул, эрсдэл тохиолдсон үед нь иргэд нь өөрөө бэлэн байдаг, бүгдийг төр чадахгүй, хувийн хэвшил, иргэдийг оролцуулсан ийм цогц менежментийн эрсдэлээс хамгаалсан ийм төлөвлөгөө боловсруулж ажиллахгүй бол болохгүй юм байна лээ шүү гэдгийг хэлмээр байна.

Хөдөө орон нутгаар явахаар олон юм нэхэх юм. Болдог бол нэг томхон жийпээ зараад, нэг аймгийг эрүүл мэндийн бүх сумыг мотоциклтой болгох юм байна лээ. Тэгээд иймэрхүү ажлыг хүртэл.../минут дуусав/

С.Бямбацогт: Монгол Улсын Шадар сайдад нэр дэвшигч Номтойбаяр хариулна.

Н.Номтойбаяр: Хариултаас өмнө гишүүддээ нэг зүйлийг хэлье. Бүсчилсэн хөгжил миний эрхлэх асуудлын хүрээнд байгаа. Тэгээд тойргоос сонгогдсон гишүүд болон жагсаалт үл харгалзаад, намын харьяалал үл харгалзаад бүсчилсэн хөгжлийн бодлого тодорхойлох, түүний хэрэгжилтийг хангахад ЗГ хамтарч ажиллахад таатай болохыг бүгдэд нь хэлэх нь зүйтэй байх.

Бүсчилсэн хөгжил гэхээр төдийлөн нэг цогц бодлогыг гишүүд маань хараахан ойлголт хомсхон байгаа бололтой. Мэдээж энэ бол хүнд болон хөнгөн аж үйлдвэр, эрчим хүч, эдийн засаг, дэд бүтцийнхээ бодлого, хүний нийгмийн бодлоготойгоо уялдсан цогц бодлого. Тэгээд Монголд суурь нь тавигдаад, төдийлөн бодит ажил хэрэг болж чадалгүй явж байгаа чиглэл байгаа. Ингээд гишүүдтэйгээ энэ дээр хамтарч ажиллахыг хүсэж байна. Ялангуяа тойргоос сонгогдсон гишүүд тухайн орон нутгийнхаа онцлог байдал, хөгжиж болох давуу талуудыг бидэнд зааж зөвлөж ажилламаар байна.

Онцгой байдалтай холбоотой. Ер нь эрсдэлийн үнэлгээг урьдчилж тооцох нь хамгийн чухал. Тэгээд Эрдэнэбат гишүүн иргэдийн оролцоог ярьж байна. 2015 онд байх Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг УИХ-аас баталсан. Тэгээд энэ хуулийн зарим зүйл, заалт онцгой байдлын чиг үүрэгтэй холбогдохоор зүйл, заалтуудыг тухайн үед нь оруулж байсан байх. Гагцхүү энэ хууль маань амьдрал дээр ердөөсөө хэрэгжиж үзээгүй. Төдий л нөгөө онц байдал тогтоох хэм хэмжүүр нь хараахан хүрээгүй байх гэх мэтчилэн энэ нэр томъёололтой холбоотой аливаа асуудлыг урьдчилан сэргийлэх, аливаа байгалийн давагдашгүй хүчин зүйлд бэлэн байдалтай байх, цогц бодлогын арга хэмжээг шинэ түвшинд гаргана гэж үзэж байгаа.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн асуултаа асууя.

Д.Ганмаа: Оройн мэнд хүргэе. Би үе үеийн ЗГ-ыг дэмжиж байсан, тогтвортой байдлыг чухалчилдаг. Засаг төр тогтвортой байвал бодлого хэрэгжилт нь сайжирч, ард иргэдийн амьдралд хэрэгтэй болов уу гэсэн хатуу итгэл үнэмшилтэй. Тэр утгаараа одоо ч гэсэн бүрэлдэх гэж байгаа ЗГ-ыг дэмжих болно. Тэгээд амжилт хүсье бүгдэд нь.

Эрүүл мэндийн сайдаар шинээр томилогдож байгаа Батшугар танд хэлэх зүйл зөндөө байна. Тэгэхдээ товчлоод ярья. Миний олон жил ажиллаж, амьдарч байсан Бостон гээд хотын маань маш сайн сургуулийн нэг нь Бентли гэж их сургууль. Тэр Бентлигийн их сургуулийг төгссөн манай Батшугар мэдлэг, туршлага салбарын шинэчлэлд үр дүнтэй энэ мэдлэг, мэргэжлээ ашиглана гэдэгт би итгэж байна. Энэ чиглэлээр та Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаар ажиллаж байсан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ буюу би дөнгөж сая ЗГ-т, дөнгөж сая биш ээ, ЗГ-т хүргүүлээд нэлээн байж байгаа миний санаачилсан Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хууль байгаа. Тэр хуульд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцооных нь хэрээр харж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн төвтэй, нэгдмэл, тасралтгүй байдлаар хүргэх, үзүүлэх биш, эмнэлэг тусламжийг бүүр хүргэх гэсэн концеп... цоо шинэ тийм хуулийн шинэчилсэн найруулга орж ирсэн. Тэр шинэчилсэн найруулгад хэрвээ хэрэгжүүлээд явбал ажилд, таны ажилд нэлээн тус дэм болно. Бүүр анхаарч сайн хараарай.

Мэдээж тэр хуулийн нэг хэсэг буюу тасралтгүй, нэгдмэл гэсэн дотор 2 юм явж байгаа нь 1 дүгээрт цахимжилттай холбоотой. Цахимжилт, мэдээллийн сантай холбоотой. Цахимжилт, мэдээллийн сан нь сайн явж байж нөгөө эмнэлэг шатлалын хооронд, шатлал дунд иргэд, өвчтөн, үйлчлүүлэгч хаягдахгүй, санхүүжилт нь яг дагаж явах, эцсийн эцэст иргэнээ эцсийн бүрэлдэхүүнд эрүүл сайн байлгах энэ эрүүл мэндийн бодлогын хамгийн эцсийн зорилт бүхий энэ том зорилго явж байгаа. Тэрэн дээр мэдлэг, мэргэжлээ маш сайн ашиглаж тийшээгээ бас орно гэдэгт би баяртай байгаа.

2 дугаарт санхүүжилт. Эрүүл мэндийн түрүүн ярьсан 6 бүрэлдэхүүн хэсгийн нэг нь санхүүжилт. Санхүүжилт дотор ЭМД гэдэг чинь нэг жижиг хэсэг. Тэгэхлээр санхүүжилтийг санхүүч хүн аягүй сайн мэддэг учраас цоо шинэ нүдээр санхүүчийн нүдээр харж, үр ашигтай, үр бүтээлтэй cost effective энэ системийг бий болгох байх гэдэгт итгэж, энэ ер нь их аятайхан нүдээ олсон томилгоо болчхов уу, үгүй юү гэж би дотроо баярлаж хүлээж авч байна. Мэдээж мэргэжлийн хүмүүсийг өөрийнхөө зөвлөхөөрөө маш сайн хүмүүсийг аваарай. Туршлагатай, мэдлэгтэй, мэргэжилдээ хайртай, сэтгэлтэй, хамгийн гол нь ашиг сонирхлын зөрчилгүй, зөвхөн салбараа

гэсэн сэтгэлтэй энэ мэргэжлийн хүмүүсийг авч тэндээ ажиллуулаарай гэж хүсэж байна.

Мэдээж манай эмч, эмнэлгийн ажилчдад том хүлээлт байгаа. Зөвхөн цалин ч биш, нийгмийн асуудал, татвар дээр, барилга байшин, ипотек. Тэгэхдээ та бол ЭМЯ биш, Эрүүл мэндийн сайд болж байгаа учраас иргэдийн хүлээлт маш өндөр байгаа. Иргэдийн халааснаас гарах төлбөрийн асуудал байгаа. Архаг өвчлөлийн квот гээд тогтоочихсон учраас хүндрэл, нас баралтууд маш өндөр байгаад байгаа. Тэгэхлээр энэ дээр бүүр анхаарч, энэ бодлогыг бүүр сууриар нь зайлшгүй өөрчлөлт хийх шаардлагатай байгаа.

Энэ утгаараа бид энд өөрчлөлтүүдээ хийхийн тулд энэ чанарын асуудал, хариуцлагын асуудал, нийгмийн асуудлууд эдгээрийг бүгдийг нь хүртээмжтэй, хариуцлагатай хүргэх, ялангуяа хөдөө орон нутагт гэдгийг бүүр сайн бодоорой. Цаашид дэмжиж, хамтран ажиллах болно. Амжилт хүсье. Ганцхан юм, 1 минут авчихъя тэгэх үү?

С.Бямбацогт: Сунгачихъя. Ганмаа гишүүн 1 минут сунгая.

Д.Ганмаа: Эрүүл мэндийн асуудал гэхээр санхүүжилт рүү түлхүү анхаараад, яг үнэндээ 21 онд хийгдсэн эрүүл мэндийн санхүүжилт шинэчлэлийн асуудал дээр нэлээн сайн шинэчлэлүүд хийгдчихсэн. Тэрийг олон улсын шинжээчдийн баг ч гэсэн саяхан Хүний хөгжлийн байнгын хороон дээр ирээд хэлсэн. Одоо яг дагаж юу шинэчилж чадахгүй, юугаа бодлогоор хийж чадахгүй байгаа гэхээр тэрэнд тааруулсан эрүүл мэндийн энэ бодлогоо яг боловсруулаад тусламж, үйлчилгээг хүргэх модель загвар гэж байгаа, service specification гэж нэрлэдэг байхгүй юу. Тэрийгээ сайн бодож, боловсруулж чадахгүй, тэгээд тэрнээс болоод Сангийн яамаар удирдуулаад, санхүүжилтдээ тааруулж эмнэлгийн тусламжийг хүргээд, олон талаас хавчигдаад яваад байгаа учраас бодлогоо хамгаалж, Сангийн яамтай, Боловсролын яамтай, Гэр бүлийн яамтай хамтарч сайн ажиллаарай гэдгийг би зайлшгүй хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Бусад яамныхан ЭМЯ, салбараа дэмжээд өгөөсэй гэж үнэн сэтгэлээсээ хүсэж байна.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Ганбаатар гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Учрал сайдад нээрээ урам хугарч байна шүү. Та яг кабинетаа өөрөө ингээд үнэхээрийн бүрдүүлж чадсан юм уу? Их харамсалтай байна шүү эрх баригчдаа, 2 жил хүрэхгүй хугацаанд бид 3 Улсын Их Хурлын дарга, 3 ЗГ-ын нүүр үзэж байна. Ер нь өнөөдрийн энэ ЗГ-ыг бүрдэж байгаа байдлыг хараад манай улсад ер нь хариуцлага, ёс зүй гэдэг үг бол бараг үгийн сангаас хасагдаж байгаа юм байна даа гэж бодогдож сууна. Ер нь бид өөрсдөө улс төрчид энд суугаа улсууд л энэ улс оронд энэ хариуцлагагүй, ёс зүйгүй, хар муухай гүтгэлэг, ийм эмх замбараагүй байдлыг бид өөрсдөө бий болгож байна шүү. Тэгээд энэ бүгдийг хараад байж байхад нөгөө Чойномын шүлэгт гардаг шиг улаа шагайсан хэдэн хүүхэд улс болж тоглож байна гэдэг тэр бадаг нь л санаанд ороод байна. Ер нь тийм шантаажны, барьцааны юм шиг. Саяхан та нар шал өөр л юм ярьж явсан. Танай намын нэг сайд үндсэндээ Харбины гэрээ ярьсаар байж байгаад хүүхдээ Эрүүл мэндийн сайд болгож байна, чадаж байна шүү дээ. Худлаа биш биз дээ?

Нөгөө нэг их яриад байсан хулгай, луйвар чинь яасан бэ? Та хэд чинь бүүр бараг бараг жил шахуу, ноднин намраас хойш л яриад байсан биз дээ? Ингээд ард түмнийг талцуулчихаад, тэгээд эрх мэдэл, албан тушаалаараа, эсвэл нэг нэгнийгээ

гүтгэж шоуддаг юм уу, уйддаг юм уу та нар чинь. Уг нь шүүхээр тогтоолгох ёстой биз дээ энэ чинь. Тэгээд одоо ингээд бүгдээрээ барьцаанд ороод, Монголын төр нөгөө нэг их нүүрсчдийнхээ өмнө ингээд буугаад өгчхөж байгаа юм уу? Ний нуугүй хэлэхэд энэ ЗГ бол гэмт хэргээ нууж хаацайлах гэсэн ял наймаалцсан л ЗГ гэж би харж байна. Үнэндээ тэр их та нарын яриад байсан хулгайч чинь бидний боломжийг, дээрээс нь улс орны хөгжлийг, иргэдийн ирээдүйдээ итгэх итгэлийг, бидний үр хүүхдүүдийн ирээдүйг, амьдралын чанарыг хулгайлсан хулгай шүү дээ. Жоохон ичдэггүй юм уу?

2 асуулт байна. 1 дүгээрт нь, Дэлгэрсайхан сайдаас бидний нөгөө яриад байсан Замын-Үүдээс Олон овоо руу, Олон овоогоос Улаанбаатар луу эдийн засгийн гол коридор болсон нөгөө засмал зам баригдах асуудал юу болж байгаа вэ? Сүүлд Лүнгийн зам гээд яриад эхэлсэн, энэ чинь юмны эрэмбэ дараа гэж нэг юм байна биз дээ?

2 дахь асуудал нь говийн бүсээс сонгогдсон гишүүний хувьд говийн бүсийн тээвэрчид, ялангуяа уул уурхайн тээвэрчдээс маш их хүсэлт ирэх юм. Ачаа тээвэр олдохгүй байна. Дээрээс нь тэр нэг квот гээд яриад байх юм. Дээрээс нь ахиад ингээд энэ өдрөөс өдөрт түлшний үнэ, дизелийн хомсдол үүсэж байна. Энэ дээр ямар бодлого баримталж байна вэ? Тэр тээвэрчдэд ачаа тээвэр олж өгөх асуудал дээр нь, дээрээс нь энэ дизель түлшний энэ хомсдолд энэ үнэ өдөр болгон энэ чинь сая 300, одоо ингээд 500, энэ чинь удахгүй ер нь 5000 хүрэх нь байна шүү дээ. Энэ дээр ямар бодлого баримталж байна вэ гэж?

Хоёрдугаарх нь шинээр томилогдож байгаа ХАА-н сайдаас танай намын маш буруутай бодлогоос газар тариалангийн салбар уналтад орсон. Маш буруу бодлого явуулсан шүү. Одоо үүнийгээ яг яаж засаж сайжруулах гэж байгаа юм бэ? Бас нэг асуудал нь болохлоор энэ газар тариалангийн бүтээгдэхүүний экспорт, ялангуяа таримлын шинэ бүтээгдэхүүнийг экспортод гаргах чиглэлээр та яг ямар юм хийх гэж байгаа юм бэ? Өнөөдөр Монголын нөхцөлд улаан буудай, тэгээд нөгөө юнгар гэдэг рапс, тэжээлийн ургамал төдийхөн тариад, таримлын сэлгээ нь их багатай. Жаал юм тарина, түлш ховордож байна. Дээрээс нь экспорт байхгүй, үнэ хямд, газар тариалангийн салбар чинь.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ганбаатар гишүүн нөгөө Чойномын шүлэг хэллээ. Би нэг бас шүлэг хэлэхэд нөгөө явсан замаа харсан чинь ямар богинохон юм бэ, явах гэж байгаа замаа харсан чинь ямар урт юм бэ гэдэг шиг ийм л цаг үед ЗГ ажилдаа орж байна. Нэг ёсондоо энэ Ойрх Дорнодын бүс нутагт үүссэн нөхцөл байдлаас шалтгаалж, эдийн засагт учирч болзошгүй хямралыг хэрхэн даван туулах вэ гэдэг бид сорилтын өмнө ирлээ. Ер нь энэ эдийн засгийн хүндрэл, сорилтын үед л байгуулагдаж байгаа ЗГ. Тэгэхээр дотоод улс төр гэхээсээ илүүтэйгээр дотооддоо илүү эвлэж нягтарч, нөгөө асуудал сорилттойгоо тулах ийм шаардлага үүсэж байгаа.

Ялангуяа энэ нийлүүлэлтийн гаралтай инфляц үнэхээр санаа зовоож байгаа. Яг ард түмний нуруун дээр ирнэ. Энэ дизель түлш, бензиний үнэ нэмэгдэх ийм төлөвтэй болчихлоо. Ялангуяа энэ эм, эмнэлгийн хэрэгсэл, стратегийн энэ гол, гол бүтээгдэхүүнүүдийн үнэ нь нэмэгдээд эхлэхээр энэ бол их доргилт болно. Тийм учраас энэ цаг үе өөрөө илүү асуудалтайгаа нүүр тулах цаг гэж бодож байгаа. Мэдээж ЗГ гэмт хэрэгтэй тэмцэх, авлигатай тэмцэх ажлуудаа тасралтгүй явуулна. Гэхдээ үүнийг уг үндсээр нь устгах арга хэмжээ авахгүй бол нэг асуудал гаргаж

тавиад материал хуулийн байгууллагад өглөө гээд тэр асуудал эцэслэн шийдэгдэх хүртлээ асар их цаг хугацаа алддаг.

Жишээ нь Хууль зүйн яам ч тэр, ЗГ ч тэр Мөрдөх алба ерөөсөө биш байхгүй юу. Тэр чинь эцсийн шийдвэрээ гаргадаг тийм алба өөрөө ЗГ, Хууль зүйн яам биш. Харин ЗГ-ын гишүүдийн хувиар өнгөрсөн хугацаанд жишээ нь ЗГ тэмдэглэл гаргаад, тэр Төгрөг нуурын ордтой холбоотой асуудал дээр бид ЗГ дээр оруулаад, нийт материалыг нь АТГ хүлээлгэж өгч байсан. Тэрнээс хойш одоо тэр процесс ямар түвшинд явав гэхээр нөгөө хууль хяналтын байгууллагын тэр мөрдөн шалгах ажил руу хэн ч орох эрх байдаггүй. Ингээд л хүлээгээд байдаг. Тэрнээс иргэд болохоор ярьчихсан юм бол бараг ингээд аваачаад шоронд хийчхээч гээд. Тийм эрх ЗГ-т байхгүй. ЗГ гүйцэтгэх засаглал. Тухайн үед Төгрөг нуурын ордтой холбоотой материалыг хууль хяналтын байгууллагад аваачаад л өгсөн, энийг шалгаж өгөөч гээд ингээд л байж байдаг.

Тэгэхээр цаашдаа гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авахын тулд би яриад байгаа нь тэр зөвшөөрлийг 100 хувь цахимаар өгье. Тэр 820 мянган шилэн мэдээлэл байсныгаа илүү олон болгоё. Энэ эрх зүйн орчноо шинэчилье гээд. Энэ засгийн үед мэдээллийн ил тод байдал сайжрах нь дамжиггүй, хүний оролцоо багасах нь дамжиггүй, дэвшил гарах нь дамжиггүй. Тэгэхээр их ярих биш, үр дүнгээрээ та бүхэндээ дүнгээ.../минут дуусав/

С.Бямбацогт: Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Манай яамнаас зарласан сонгон шалгаруулалт Замын-Үүд Чойрын 490км тусгай зориулалтын хүнд даацын авто замыг яллагч нь тодорчихсон, бид 4 сарын дундуур нээх гэж байгаа ажлыг нь. Тийм учраас энэ ажил явна 1 дүгээрт.

2 дугаарт манай урд энэ Улаанбаатар хотоос Чойр, Сайншанд, Замын-Үүдийн энэ зам хамгийн их ачаалалтай зам учраас бид цаашдаа ер нь энэ Говьсүмбэр, тэгээд Хөшигийн хөндий орж ирэх зам, тэгээд бусад энэ замуудыг, ер нь энэ том замуудыг цаашдаа бид төсвийн мөнгөөр биш, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хувийн мөнгөөр, төлбөртэй зам барьдаг болно. Төсөв цаашдаа ийм том замуудыг барих тийм даац.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Цаашдаа бид олон улсын жишгээр төлбөртэй замуудыг бий болгосноор ийм замын шинэ зам барих ийм боломжуудыг нээж өгнө. Уул уурхайн энэ компаниуд ачаагүй байна гэж ярьж байна. Бид 25 оны 9 сарын 23-ны өдрийн 77 дугаар тогтоолоор ЗГ тодорхой төлбөртэйгөөр уул уурхайн ачааг тээвэрлэх ийм боломжийг нээж өгсөн байгаа. Тийм учраас урагшаа наашаа импортын ачаа ачаад явж байгаа машин болон урагшаа явж байгаа бүх машинууд 2 талдаа ачаатай явах ийм боломжийг нээж өгсөн гэдгийг энэ ташрамд хэлье. Тийм учраас цаашдаа аль болохоор бид энэ замыг аль болохоор төлбөртэйгөөр явуулах энэ боломжийг нээж өгнө. Төлбөртэй болгож байгаа нь бид эргээд замаа засах энэ хөрөнгө оруулалтыг бий болгож байгаа шүү. Сангийн яам замыг өөрөө мөнгөө олоод засаж бай гэдэг ийм үүрэг.../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулчихъя, нэмэлт 1 минут.

Г.Дамдинням: Газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой асуудал дээр Ганбаатар гишүүнээс нэг юм хүсье. Зүгээр бүх л нам, эвслийн бүлэг, тэгээд гишүүдээсээ нэг ийм зүйлийг хүсье. Хомсдолд орох нөхцөл байдал одоогоор байхгүй, сарын хэмжээнд байгаа. Хэдүүлээ бас нэг ард иргэдээ тайван амгалан байлгаж, хэрэглээгээ бодох тал дээр нь анхаарах ёстой. Энэ дээр улс төржмөөргүй байна. Яагаад вэ гэвэл бид дэлхийн 90 гаруй орны нэг болчихоод байна. Гадаад нөхцөл байдлаас шалтгаалсан хүндрэл учраас бүгдээрээ энэ дээр болгоомжтой хандацгаая. Одоогийн байдлаар нэг сар орчмын нөөц байна дизель түлш дээр.

2 дугаар асуудал би танд үнэн дээр нөхцөл байдлыг хэлье. Юу вэ гэхээр манай улс 100 хувь, бараг 97, 98 хувь ОХУ-аас шатахууны бүтээгдэхүүнээ авдаг. Манай гол ханган нийлүүлэгч Роснефть компани 4 дүгээр сарын хил үнэ гэж үнэ ирүүлсэн.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

Г.Дамдинням: Энэ хил үнээр би хэлж өгье танд. Түлш энгийн зуны дизель түлш 648 доллароор тонн тутамдаа нэмэгдээд, 1385 доллар болсон байна, 2 дахинаас илүүгээр үнэ өсчихсөн гэсэн үг үнэ нь. Евро 5 дизель түлш 712 байсан бол 483 доллароор нэмэгдэж 1410 доллар болсон 2 дахин. Евро 5, АИ-92 авто бензинд 765 байсан бол 441-ээр нэмэгдээд 1206 болсон, АИ-95 авто бензин 735-аас 441 доллароор нэмэгдэж 1176 болсон. Ингээд үндсэндээ төрөл тус бүр дээрээ 441-ээс 648 доллароор өсөөд, үүнтэй холбоотойгоор зах зээл дээр АИ-92 авто бензинээс бусад төрлийн шатахууны үнэ дээр энгийн дизель түлш 2200 төгрөгөөр нэмэгдэж 5200, евро 5 дизель түлш 1300 төгрөгөөр нэмэгдэнэ шүү дээ 5300 төгрөг, Евро 5.../минут дуусав/

С.Бямбацогт: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.

Ц.Идэрбат: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. ХХАА-н салбарын экспортын гол ачааг одоогоор ноолуур, махны экспорт орлож байна. Арьс, шир, ноосны экспорт маш бага дүнтэй байдаг. Газар тариалангийн салбар луугаа ороод ирэхээр энэ манай ХАА-н салбар, газар тариалангийн салбар зөвхөн дотооддоо хоолтой байх гэдэг тэр л зарчим руугаа яваад байдаг юм байна лээ. Улсын хэмжээнд 1,2 сая га газрыг бид газар тариаланд хэрэглэх боломжтой. Гэхдээ энэнийхээ талд нь шахуу л тарьдаг. Нөгөө талдаа нэг сөрөг юм байгаад байгаа нь байгаль, цаг уурын энэ онцлогоос ихээхэн зүйлүүд шалтгаалдаг. Зарим үед ургац сайн, зарим үед ургац алддаг. Шалтгаан нь зөвхөн бороо байгалийн эрхшээлд байдаг. Тэгэхээр газар тариалангийн салбарыг экспортын нэг том салбар болгохын тулд 1 дүгээрт олон улсын стандарт.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

Ц.Идэрбат: Нийцүүлж байхын тулд Ургамлын агентлаг хүртэл өнгөрсөн 24 онд, 2024 байгуулж өгсөн. Тэгээд одоо ажлаа авахаар миний гол анхаарах сэдвүүдийн нэг бол энэ гэж үзэж байгаа. Энэ бүтэн сайн өдөр Сэлэнгэ, Дархан, Төвийн бүсээр газар тариалангийн салбарын нөхцөл байдалтай танилцана. Тэгээд ер нь газар тариалангийн салбарыг зөвхөн арилжааны зориулалтаар тарьсан ургамал зүйлийг гаргахгүй зарахгүй эд нар гэдэг гэнэтийн, гэнэтийн энэ шийдвэрүүд бол бас энэ ургамлын экспортын, газар тариалангийн экспортод нэлээн сөрөг нөлөө үзүүлдэг юм байна гэж дүгнэж байсныг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын

хороон дээр. Тэгэхээр энэнтэй яг салбарын хариуцсан мэргэжилтнүүдтэйгээ, энэ салбарт ажиллаж байгаа хүмүүстэйгээ нэлээн сайн судалж, ахиц гаргахын төлөө байна гэж та ойлгож болно.

С.Бямбацогт: Шөнийн 12 цаг өнгөрсөн байна. Өнөөдөр хэлэлцэх асуудлаа явуулаад дуусгачихна биз дээ. Тэгэхгүй бол маргааш, нөгөөдөр чуулган хуралдах боломжгүй. Нэг дэх өдөр гэхээр чинь тэгээд ЗГ энэ эдийн засаг хүндрэлтэй цаг үед 1 цаг, 1 минут алдахгүй ажиллах шаардлагатай байгаа. Тийм болохоор Их Хурлын гишүүд маань арай хүндэтгээд ингээд суучих байх. Гадуур, Их Хурлын гишүүд ерөөндөө хүлээж байгаа байх. ЗГ-ын гишүүдийг тангараг өргөх үед танхимдаа сууж байхыг хүсье.

Тийм болохоор ерөөнөөсөө телевизээ харж байгаа гишүүд байвал ер нь 1 цаг 30 минутын үед тангараг өргөх болов уу гэсэн тийм баримжаатай байна. Тэгэхээр гишүүдийг танхимдаа байх, хүрэлцэн ирэхийг, тэр үед байж байхыг урья, хүсье. Золжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Золжаргал: Мэргэжлийн цомхон ЗГ Ерөнхий сайд байгуулна гэдэг бараг боломжгүй юм байна. Цаашдаа урт хугацаанд шинэ Үндсэн хуулийн дүрмээрээ ингээд их олон Засгийн газрууд ирэх жилүүдэд солигдоно. Тэгэхээр ер нь эрх зүйн орчноо яах вэ гэдгийг бодох хэрэгтэй юм байна гэж. Их л хэцүү улс төрийн нөхцөл байдал дундаас эвлүүлж дэвлүүлж байгаад энэ засаг маань арай гэж нэг эвлэж байх шиг байна. Тэгээд муу хэлээд яах вэ, яая гэх вэ, тэгээд л ийм дүрмээр л ажиллах юм чинь. Захиас, анхааруулга хэлье.

IT, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжинэ гээд хууль баталсан юм 2024 оны 6 сард, одоо 2 жил болчихсон хэрэгжээгүй. Ингээд нөгөө дэмжлэгүүд олгоно, гоё дэвшилтэт технологид грант олгоно, НДШ-ээс нөхөн олгоно энэ тэр гээд. Тэгээд хуульд байдаг, нөгөө кабинет дотроо 2 сайд зүтгээд чаддаггүй. Одоо та бол 3 дахь сайд нь болох нь байна. Бусад нөгөө сангууд нь буруу хараад зогсчихдог, кабинетын манлайлал хэрэгтэй. Занданшатар сайд Ерөнхий сайд байхад нь бичиг явуулсан, маргааш нь огцорсон. Учрал сайд өөрөө энэ салбар дээр ажиллаж байсан хүн энэ хуулийг, энэ ажлуудыг болгочихвол баатар болно, болохгүй бол тэгээд 3 дахь бас нэг бардаггүй сайд болох нь. Жишээ хэлэхэд, энэ Астана hub Казакстанд тэр IT-чид 2 их наяд төгрөгийн экспорт хийсэн байна. Тэнд Монгол залуучууд байгаа. Монголд тэр залуучууд байхгүй, нөхцөл нь байхгүй байна.

Бас нэг зүйл хэлье. Би Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад та улираад дахиад сонгогдох нь байна бодлогоо үргэлжлүүлэх байх. 10 сарын өмнө, 9 сарын өмнө нөгөө Ашигт малтмалын тухай хуулиа яаралтай оруулж ирнэ гэж ярьж байсан, өнөөдөр бас тэрийгээ ярьж байгаа. Энэ хуулийг хурдлахгүй бол домог болох нь хуулийн юу маань нэмэлт, өөрчлөлт. Хөрөнгө оруулалт популизмаас болоод гарч байна гэж ярьдаг. Гэхдээ тэр популизм чинь өөрөө эрх зүйн орчноос бий болж байгаа. Монголын УИХ дээр баталсан хуулийн алдаанаас болоод Монголоос хөрөнгө оруулалт дайжсан. Нөгөө Амнат-ыг нь орон нутагт нь үлдээдэггүй байдал, стратегийн хөрөнгө оруулагч орд гэж хязгаарлаад 1 хүн 34-өөс илүү байдаггүй энэ тэр гэдэг хязгаарлалтууд эд нар зориуд юм уу, зориуд бусаар юм уу хөрөнгө оруулалтыг үргээсэн үр дагавар. Энийгээ засахгүй бол популизм ард түмний эсэргүүцэл үр дагавар шүү, үндсэн шалтгаан биш гэдгийг хэлмээр байна.

Эрчим хүчний сайдад Найдалаа гишүүнд хандаж хэлэхэд ногоон хөгжил, эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч гээд энэ хүн бол ажиллаж байсан

туршлагатай хүн би мэднэ. Тэгэхээр тэр бодож байсан юмаа л нэг ажил болгох гэж оролдох ийм их боломж гарч байна гэж харж байгаа юм. Маш олон санаа, толгой эргэм янзын төслүүд байгаа бүгдээрээ л нэг юм эргэлдүүлчих гээд. Тэгээд 1, 2 ийм мөр үлдээх юм хийгээд аваасай. Ногоон хөгжил гэдэг сайхан зүйл. Тэгэхдээ ногоон хөгжил гэж шашин байдаг, хэтэрхий ийм энергитэй. Тийм юм бүтэхгүй, прагматик байх хэрэгтэй байна. Бидэнд нөгөө дулааны станцууд нь хэрэгтэй байна. Мөр үлдээхээр 1, 2 томхон юм барьж аваад хийгээсэй, тэгэхгүй бол төөрнө шүү гэж хэлмээр байгаа юм. Үргэлжлүүлээд 1 минут дуусахаар нь авна.

Би Хот байгуулалт, барилга, орон сууцны сайдыг бас үргэлжлүүлэх гэж байгаа юм байна. Гэр хороолол дээр зөндөө юм ярьдаг боловч дандаа хоцорчихдог юм. Орон сууцны тухай хууль, Орон сууцны санхүүжилтийн тухай хууль гээд явж байгаа. Тэрэн дээр хашаандаа сайхан амьдрах хүнийг дэмжих агуулгууд нь тун бага байна. Тэрэн дээр төсөв тавьдаггүй, дулаан байшинд нь ипотек олгож өгөх талаар. Тэгээд хэсгээрээ, гудмаараа нийлээд 5 давхар.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд авчихъя асуултаа.

Ж.Золжаргал: Гудмаараа нийлээд 5 давхар барих энэ тэр санаачилгуудыг дэмжсэн хувилбаруудыг нэмж өгөөч гэж хүсмээр байна.

Боловсролын сайд хотхоны бага сургууль, багийн бага сургуулийг анхаарч явуулаасай. Түгжрэлийн асуудал энэтэй холбоотой, малчин ахуйн хүндрэлтэй асуудлууд энэтэй холбоотой. Өмнөх сайд нь ч энэ дээр ажиллаж байсан. Тэгээд энэ асуудал яваасай гэж хүсэж байгаа юм.

Эрүүл мэндийн сайдад хандаж хэлэхэд эн түрүүн стратеги гээд Ерөнхий сайд хэлнэ лээ. Эм, хүнс, одоо цаг үе хэцүү байна гээд байдаг их онцгой анхаарах хэрэгтэй болчихоод байгаа юм. Эмийн үйлдвэрүүд чинь энэ жижиг, дунд хүнсний үйлдвэрүүдийн авдаг хөнгөлөлт юм нь байдаггүй юм байна лээ шүү дээ. Цэвэр арилжаагаар явдаг. Тэгээд чаддаггүй зүйл бол бас биш, чаддаг. Тэгээд ЭМД-ын сан, Нийгмийн даатгалын сангийн орлогоор төсвийн алдагдал нөхдөг маш буруу жишиг байгаа шүү. Энийг Сангийн сайд анхаараасай. Тэгээд олон их наядуудаа хэмнээрэй гэж хүсье.

С.Бямбацогт: Золжаргал гишүүн асуулт асуусангүй, санал хэллээ. Манай ЗГ-ын гишүүн сайдад нэр дэвшигчид цаашид онцгой анхаарч ажиллах чухал саналууд хэлж байна шүү. Булгантуяа гишүүн асуултаа асууя, алга байна. Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганбат: Энэ чинь өнөө шөнө чинь, шөнө ч болчихсон байх шиг байна. З дахь Засгийн газраа байгуулж байна л даа энэ бүрэн эрхийн хугацаанд. Яах вэ Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын ЗГ-ыг анх байгуулж байхад хэлж байсан юм би. Та яг яаж ирсэн тэрэн шигээ л буцах нь дээ гэж. Гадаа жагсаж байгаад ирсэн л дээ, тэгээд жагсаж байгаад л буцаах шиг боллоо. Мега төсөл гэж ярьсан тэр нь мега хулгай болж хувирсан гэх мэтчилний. Тэгээд Азийн хөлөг улс болгоно гэсэн Азийн гөлөг улс болчихсон өнөөдөр байж л байна.

Дараа нь Занданшатарын ЗГ авлига, хулгай, луйвартай зоригтой тэмцээрэй, зоригтой тэмцэж чадахгүй бол дуусна шүү л гэсэн. Тэгээд ч тэрүүгээр л явчихлаа.

Учрал Ерөнхий сайдыг болж байх үед нь та нэг барьцаалагдахгүй, барьцаагүй ЗГ-тай болчихоод ороод ирэхийг бодоорой л гэсэн. Одоо тэгээд энэ ямар ЗГ ч юм мэдэхгүй. Тэгээд ийм л байна л даа. Ли Куан Ю бид чинь Сингапурыг их жишээ болгож ярьдаг. Ли Куан Ю-д 2 сонголт байсан гэж байгаа юм. Эхнийх нь сонголт өөрийнхөө дотнын найз нөхдийн хулгай, луйвартай нь эвлэрээд явах байсан. Тэгээд өөрөө ч баяжаад, тэд нар ч баяжаад ингэж дуусах байсан. Хэд хэдэн Ази, Африкийн орнууд тэгж явсан. Өөр нэг сонголт нь тэр эргэн тойрны байгаа муу муухай зүйлтэй тэмцэж, тэд нарыг явдаг газар нь явуулж ингэх зам байсан. Энэ замыг сонгосон л доо. Тэгээд өнөөдөр Сингапур ямар байгааг та бүхэн мэдэж байгаа. Та энэ дээр яг 2 сонголтын алийг нь хийчих вэ?

Нөгөө талаар та нар чинь саяхан 30, 38 гээд бие биетэйгээ үзээд л байсан. Би ч хар, чи ч хар ийм, ийм муухай юм болчихлоо энэ тэр гээд зурагт телевизээр өдөр, шөнөгүй л яриад байсан шүү дээ. Та нарыг юу эвлүүлчхэв? Энэ сайдаар болсон нөхөд, сайд болж байгаа нөхдүүд сайд болчихсон л байх л даа. Энэ дээр та нарын хувийн бодол ямар байна вэ өөр өөрсдийнхөө бодлыг? Энэ намууд ч гэсэн хэлчхээрэй тийм. Та нарыг ингээд юу нэгтгэчхэв, ийм нэгтгэчхэв гэсэн ийм асуулт байна?

Харбины гэрээгээр сонсгол хийж байгаа юм. Мөн энэ төмөр зам, авлига, хулгай энэ 100 сая доллар тараагаад байгаа энэ тэрээр сонсгол хийе гэж байгаа юм. Би санаачлаад явж байгаа. Тэн дээр та бүхэн гарын үсэг зурах уу, энэ сайд нар хэлчхээрэй дэмжих үү, үгүй юү гэдэг юм? Харбины гэрээ үнэхээр сайн гэрээ байж болно. Тэгээд үнэхээр сайн сайхан гэрээ бол ард түмнээсээ юуг нь нуугаад байгаа юм бэ, яагаад ярьж болохгүй байгаа юм бэ? Тэгээд бид 2 хөрш, 2 хөрш маань тогтвортой, хөгжилтэй Монгол Улсыг хүсдэг. Гэтэл дунд нь муухай хулгай, луйвруудыг хийдэг. Тэгчхээд 2 хөрш рүүгээ нялзаадаг. Яах вэ тэр муу муухай Хятад ч юм уу, Орос хүн байж болно, тэрийг нь хаанаасаа ч олоод найзалчихдаг юм, яачихдаг юм, мэдэхгүй. Тэр Хятадын ард түмэн, Оросын ард түмэн энэ 2 орны удирдлага мэдээжийн хэрэг хөрш оронтойгоо хөгжилтэй, сайн сайхан байгаасай л гэж хүсэж байгаа. Тэр төмөр зам нь тавьчхаасай, зам нь нийлчхээсэй, хурдан энэ ажлыг хийчхээсэй гээд. Дундаас нь хулгай, луйвар хийдэг, авлига авдаг, өгдөг, тэр юмаа нууж хаацайлахын тулд үгүй юм шиг загнадаг, тэгээд тэрийгээ ярьдаг. Хятад улс.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихсэн үү? Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Түрүүн манай Золжаргал гишүүн хэлж байсан. Тэгээд миний яг шууд хэлж чадахгүй байгаа үгийг Золжаргал гишүүн хэлж байна лээ. Ер нь ЗГ-ын тогтвортой ажиллах энэ нөхцөл бүрдэхгүйгээсээ болоод хөрөнгө оруулалтын орчинд ч тэр, гадаадын энэ хөрөнгө оруулагчид ч тэр манай улсад орж ирээд хөрөнгө оруулалт хийхдээ тийм итгэл төгс биш байна. Гадаадын хөрөнгө оруулалт 50 хувь буурна гэдэг энэ бол төр засгийн үйл ажиллагааны тогтворгүй байдал мөн. ЗГ-ыг тогтвортой ажиллуулах ёстой. Түрүүн тэр Золжаргал гишүүний хэлээд байгаа чинь яг үнэн. Тогтвортой ажиллая гэвэл яг бидний хичээл дээр үздэг тэр цомхон төр, бүтээмжийн талаар яг амьдрал дээр хэрэгжүүлээд улс төрөө дийлдэггүй. Энэ зовлонг нэг их тийм би ч амсаад байгаа юм биш. Энэ үе үеийн ЗГ-ын зовлон. Төрийн ажлаа бодох уу, улс төрөө бодох уу гэдэг ийм 2 сонголтын өмнө ирчихээр Ерөнхий сайд өөрөө төрийн ажилд 100 хувь анхаарал хандуулах нь маш их хүндрэлтэй.

Тийм учраас улс төрийн дотоодын зөрчил, үл ойлголцлын асуудлыг шийдэж байж төрийн ажилд 100 хувь анхаарал хандуулна. Ерөнхий сайд хүн чинь ингээд 2

тал руу фокуслах ийм шаардлага үүсээд байдаг. Тэгэхээр энэ цаг үед нөгөө улс төржилт хийж, дотоод энэ асуудал, үл ойлголцлыг давахгүйгээр гадаадаас ирж байгаа хямралтай тулна гэж бараг л байхгүй. Тийм учраас бид одоо энэ ирж байгаа энэ шуургыг сөрж давах хэрэгтэй. Тийм учраас үүн дээр сөрөг хүчин ч бай, парламентад байгаа улс төрийн 5 нам, эвсэл нэгдэж л гарахгүй бол өнөөдөр энэ шатахууны үнийн хөөргөдөл яг иргэдийн амьжиргаа руу ороод ирэхэд үгүй мөн хүнд сарууд ирнэ гэдэг нь энэ статистикуудаас харагдаж байгаа юм л даа. Төсөв, санхүүгийн сахилга бат хэмнэлтийн чиглэлээр, хүнс, хөдөө аж ахуй, эмнэлэг, түлш, эрчим хүч, тээвэр, логистик, хөрөнгө оруулалт гээд арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлж эхэлнэ.

Тэгэхээр яг энэ цаг бол ид шид бүтээх, гоё, гоё сайхан юм ярих цаг биш, хүндрэл сорилтыг яаж давах вэ л гэдэг цагийн өмнө ирчихсэн учраас энэ хоосон улс төржилт, хийрхлээ боль гэдгийг би өөрийнхөө намын бүлэг дээр ярьсан. Ингээд 68-ыгаа бүхлээр нь хараад, хэн энэ ажлыг хариуцлагатай хийж чадах вэ гэдэг сонголтоо л хийсэн. Тэрнээс биш хулгай, дээрэмтэй эвлэрч байна энэ тэр гэдэг үгнүүд зохихгүй байх л гэж бодож байна. Манай энэ ЗГ хариуцах ажлаа нэр төртэй хийж чадах ийм кабинет бүрдсэн. Тэрнээс биш энд янз бүрийн тийм ойлголт байхгүй шүү. Хэрвээ эрх ашгийн зөрчил гаргавал, хариуцлага алдвал үе шат бүрд нь хариуцлага тооцоод л явна.

С.Бямбацогт: Баярлалаа. Хариулчихсан биш үү? Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Харбины гэрээ гээд нэг хардлага дагуулсан энэ гэрээ байгаа юм. Яах вэ зүгээр шаардлагатай гээд үзвэл мэдээж Хяналт шалгалтын түр хороо байгуулах нь гишүүний, гишүүдийн бүрэн эрх. Тэр бол таны бүрэн эрх, тэрийг үгүйсгэхгүй. Гэхдээ үнэн зөв мэдээлэл өгөхөд миний бие бэлэн байна. Ялангуяа АН-ын бүлэг, тэр дотроо би Баярмаа гишүүн, Ганбат гишүүнд үнэн зөв мэдээллийг өгөхөд бэлэн байгаа шүү нэг талаар.

Нөгөө талаар энэ гэрээг бид өөрсдөө хийе, замаа холбоё, нүүрсээ өгье гэж өөрсдөө гүйж очиж гэрээ хийчхээд, одоо болохлоор хөршөө янз бүрээр хэлээд байж болохгүй. Энэ геополитикийн энэ цаг үед ямар байгааг та мэдэж байгаа, эдийн засгийн нөхцөл байдал ямар байгааг та мэдэж байгаа. Ийм цаг үед бид улс төрждөг.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Та юмны наана, цаадхыг ойлгодог хүн гэж би бодож байгаа. Тийм учраас хэрвээ шаардлагатай бол энэ хэрүүлээ хэдүүлээ дотроо ярья, битгий хөрш орноо хамруулаад ингээд яриач. Дотроо яриад, шаардлагатай гэвэл хуулийн байгууллагад өгөөд шалгуулж болно гэдгийг би танд нэг бус удаа хэлж байсан. Энэ дээр улс орноо бодож энэ гэрээг бид өдөр, шөнөгүй 2 Ардчилсан нам, манай нам хамтарсан ЗГ байх үедээ илэн далангүй хамтдаа сууж байгаад л шийдэж хийсэн. Энэ дээр нууж хаасан тийм далд янз бүрийн юм байхгүй гэдгийг би танд илэн далангүй хэлье. Тэгээд шаардлагатай гэвэл би танд бүх материалыг энэ үнэ хямд байна гэж худал ярьж байгаа энэ цуу яриаг баримттайгаар бүх гэрээнүүдийг танд үзүүлэхэд бэлэн байгаа.

С.Бямбацогт: Хариулчихсан шүү дээ. Ерөнхий сайд тэр асуултад улс төрийн асуултад Ерөнхий сайд хариулъя. Салбарын сайд нар салбарынхаа асуултад хариулна.

Н.Учрал: Ерөнхий сайд Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Их Хурал дахь 68-ын бүлгээсээ кабинетаа бүрдүүлсэн. Тэрнээс биш эдгээр сайд нар тэгж юун дээр нэгдэх нийлэх гэдэг юм юу байх вэ. Би мэдээж намынхаа дотоодод үүссэн үл ойлголцол, хот, бүс, хэдэн удаа сонгогдсон, улс төрийн туршлага, капитал энэ болгоныг нь дэнсэлж байгаад Засгийн газраа бүрдүүлсэн. Нэг ёсондоо ЗГ-ын үйл ажиллагаа тогтвортой явах, энэ олон ургалч үзлээр хандах гэдэг зорилгоор л энэ 68-ын бүлгээсээ өөрөө сонголтоо хийсэн. Тэгэхээр харахаар зарим нь зүүн бүсийн, хангайн бүсийн, баруун бүсийн, хотын юу байдаг юм таны ярьж байгаа нөгөө хуваагдал юу байдаг юм, аль аль талаас харагдаад байгаа байх. Тэрнээс биш энэ бол нэг л бүлэг. Тэгэхээр би өөрөө л тэгж сонголтоо хийсэн гэдгээ хэлье.

С.Бямбацогт: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Үгүй ээ энэ юмны чинь хажуугаар дуугүй яваад байвал яг та нартай би адилхан болчихоод байгаа юм бид. Тэгээд энэ баялгийн чинь эзэн ард түмэн юм. Мэдэх эрхийнхээ дагуу асуухаар хариулахгүй юм, нуугаад байх юм, улам л муухай харагдана шүү дээ та нар.

Нөгөө талаар энэ авлига, хулгай энээ тэрээ юмаа одоо тэгээд ярихгүй өнгөрнө, тэгдэг, ингэдэг гээд зайлуулаад байна гэдэг чинь тэрийг хүлээн зөвшөөрөөд, тэрний нэг хэсэг болоод байгаа байхгүй юу. Ард түмэн та нарыг хараад бахархаад байх юм ерөөсөө байхгүй. Ингээд хулгай, авлига дээрээ суурилад, тэрүүгээрээ эв нэгдлээ хийгээд ингээд явах чинь энэ ард түмний итгэл найдварыг унагаж байгаа байхгүй юу. Үнэхээр дургүй нь хүрээд л хараад сууж байгаа өнөөдөр. Ийм ядарсан ард түмнээрээ хэдий болтол ядуу байлгаж та нар ингэж явах юм бэ? Уул нь та нарыг сонгоод явуулсан шүү дээ.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Сайд нар маань өнөөдөр дөнгөж томилогдож та бүхэнд танилцуулж байна. Тэгээд аваагүй ажлаар нь дүгнээд яах вэ. Ажлаа авсных нь дараа үр дүнгээр нь хэмжих хэрэгтэй. Дээрээс нь эрхэм гишүүд та бүхнээс хүсье хулгай дээр суурилсан л гэнэ, юун дээр яасан л гэнэ. Нэр устай нь тодорхой ярихгүй бол хэнийг хэлээд байгаа нь мэдэгдэхгүй ингээд нэг ийм юм яриад байхаар ойлгомжгүй байна. Тийм учраас асуудал тодорхой, баримттай, хэнийг хэлээд байгаа нь тодорхой, тэр хүн нь хариулаад ингээд явахгүй бол. Энэ ЗГ бүрэлдэхэд мэдээж энэ ЗГ-ын гишүүд чинь АТГ луу ашиг сонирхлын мэдүүлгээ өгөөд, энэ дунд ямар нэгэн хууль хяналтын байгууллагаар буруу зөрөөтэй нь тогтоогдсон хүн байхгүй. Ингээд л ингэж томилгоо явж байгаа шүү дээ. Тийм учраас одоо бүгдээрээ, миний яг үзэл баримтлал бол би тийм энтертайнментаар ч юм уу, янз бүрийн тийм юм ярьж асуудалд ханддаг хүн биш, хэдүүлээ прагматик ажиллана л гэж би бодож байна.

С.Бямбацогт: Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Асуулт асууж, үг хэлнэ.

Х.Баасанжаргал: Би ерөнхийдөө байр суурь үгээ хэлчихье гэж бодож байна. Яах вэ хамгийн сүүлд Хууль зүйн сайд болоод, Сангийн сайдад хандаж нэг асуулт байгаа. 1 дүгээрт яг энэ суудал, сайдын суудлын тухайд, ялангуяа энэ сайд болох нь яг улс төрийн ажлын туйлын зорилго мэт ингэж байгааг би анхнаасаа буруушааж,

энэ буруу үзэгдэл гэдэг ийм байр суурьтай байсан. Энэ байр суурь маань одоо ч гэсэн хэвээрээ байгаа.

Харин Ерөнхий сайдыг кабинетаа бүрдүүлэх, нөгөө талаар намын удирдах зөвлөлийн шийдвэрт хүндэтгэлтэй хандах ёстой. Нэгэнт олонхоороо шийдвэр гаргаж байгаа бол тэр шийдвэрийг бид хүндэтгэж дагах ёстой. Гэхдээ улс төрийг зөвхөн сайдын албан тушаалд төвлөрүүлж ойлгох нь өөрөө маш өрөөсгөл. Парламентыг өөрийг нь маш хүчгүй болгож байгаа, парламентын гишүүдийн үүргийг бид маш сул харагдуулж байгаа, сул дорой болгож байгаа гэсэн үг. Тэгэхээр сайд болж байж бодлого явдаг мэт яг энэ ойлголтыг бүгдээрээ өөрчилье гэсэн ийм нэг байр суурь илэрхийлье. Парламентын даргаа, эрхэм спикерээ үг хэлж байна л даа, уг нь бие биедээ хэдүүлээ хүндэтгэлтэй хандъя. Асуулт биш гэхээр, минутыг маань та болохгүй бол 1 минутыг маань нэмээд өгөөрэй.

2 дугаарт АН энэ удаа зүй ёсоор сөрөг хүчний байр суурин дээр 2 жилийн дараа очиж байгаад та бүхэнд баяр хүргэе. Хэдийгээр парламентын хайран 2 жилийн хугацаа өнгөрсөн ч гэсэн одоо л манай парламент яг ардчилсан парламентын нэг чухал элемент маань ингэж амилж байгаад би хувьдаа маш их баяртай байна. Өмнөх төсвийн үеэр би хэлж байсан ийм сөрөг хүчин гэж байдаг юм уу гэж хэлж байсан. Тэгэхээр нөгөө төсөв дээр ноён нуруу нь хугарсан шиг цаашид битгий ноён нуруу нь хугараад явчхаасай гэж бодож байна.

3 дугаарт ер нь манай хууль зүйн салбарыг яг нэг хоорондоо хэрэг наймаалцдаг улс төрчдийн яг нэг арга хэрэгсэл болдог гэдэг энэ яриагаа энэ улс төрчид боливол яасан юм бэ? Энэ чинь өөрөө нийгмийн үнэт зүйл. Энэ бүхний ард хэн хожиж байгаа юм, бүгд хожигдож байгаа биз дээ? Бүгд итгэх итгэл нь байхгүй болчихсон, улс төрчдөд итгэхгүй, шүүх эрх мэдэлд итгэхгүй, энэ хэнд хэрэгтэй юм бэ? Одоо энэ бүх зүйлээсээ сургамж аваад, энэ чинь цаашаагаа нийгэм чинь урагшлах ёстой биз дээ. Хуулийн салбарыг одоо бүүр ямар ч амьгүй болголоо. Энэ чинь хамгийн чухал элемент шүү дээ манай нийгмийн, хамгийн чухал үнэт зүйлийг хадгалж байгаа ийм салбар байгаад байдаг. Тэгэхээр энэ салбарт нэг жоохон, одоо нэг жоохон нэг өөриймсөг хандаасай гэж бодож байна. Тэгээд анхнаасаа хэрэг ярьдаг Хууль зүйн сайдыг томилж байгаад би анхнаасаа эрс эсэргүүцсэн гишүүний нэг. Тийм учраас өмнөх ЗГ-т маш шүүмжлэлтэй хандаж ирсэн. Тэгээд энэ удаагийн ЗГ-т эрх биш хэрэг ярихгүй гэдгээ Хууль зүйн сайд нь мэдэгдэж байгаад, мөн Ерөнхий сайд энэ талаар байр сууриа илэрхийлж байгаад би хувьдаа баяртай байна. Хууль зүйн салбарынхан ч гэсэн энийг бүгд харж байгаа. Бүгд энийг нэг дор бүрнээ дүгнэлт хийж байгаа байх гэж бодож байна.

Хамгийн сүүлийн асуулт нь юу вэ гэвэл шүүх эрх мэдлийн санхүүгийн бие даасан, хараат бус байдал гэдэг маш том хэрүүлийн сэдэв болдог. Хуулиараа Ганбат гишүүн маш сайн мэдэж байгаа, манай ХЗБХ шүүх эрх мэдлийн төсвийн төсөөллийг 5 сар, 6 сард батлаад явуулдаг. Гэхдээ Сангийн яам хэзээ ч энэ хэвээр нь төсвийг барьж орж ирдэггүй. Хууль зөрчөөд, сүүлийн 2 жил дандаа хууль зөрчигдөж ирсэн. Тэгэхээр Хууль зүйн сайд, Сангийн сайд 2 энэ асуудал дээр ямар байр суурьтай байна вэ? Өмнөх парламентын үед баталсан яг энэ хуулийн гол амин сүнс нь юу вэ гэвэл шүүх эрх мэдлийн төсвийг Сангийн сайд мэддэг биш, энийг Их Хурал өөрөө мэдээд шийддэг. Их Хурал шүүх эрх мэдлийн бие даасан, санхүүгийн бие даасан байдлыг хадгалах гэж, хангах гэж баталсан ийм хуулийн зохицуулалт байгаа. Тэгээд энэ ерөөсөө амилахгүй байгаа. Тэгээд энийг амилуулахын төлөө Хууль зүйн сайдыг манлайлал гаргаж ажиллаасай. Энэ хууль зүйн салбарын

хамгийн чухал асуудлын нэг шүү гэдэг ийм асуулттай байна. Тэгээд Сангийн сайд, Хууль зүйн сайд 2 энэ дээр хариулт хэлээч гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Хууль зүйн сайд эхлээд хариулчихъя, дараад нь Сангийн сайд хариулъя.

С.Амарсайхан: Шударга ёсыг шударгаар тогтооё гэвэл энэ шүүх эрх мэдлийн шинэчлэлийг тууштай хийх ёстой. Тэгэхдээ шинэчлэл гэдэг зөвхөн хууль шинэчилснээр болчихгүй. Тийм учраас энэ хууль, шүүх эрх мэдлийн бие даасан бодлогын шинэчлэлийн хөтөлбөр гэж хөгжлийн хөтөлбөр гэж батлагдсан. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой. Нөгөө талаараа энэ төсөв санхүүгээр нь хангаж байж, энэ хууль хүчний байгууллагууд, шүүх эрх мэдлийн байгууллагуудын алба хаагчдын нийгмийн асуудал, цалин хөлс, цаашилбал ажиллах орчин нөхцөлийг бүрэн хангаж байж, бид энэ хуулийг авлига, хээл хахуульгүй, улс төрөөс ангид хэрэгжүүлэх боломж нөхцөл бүрдэнэ 1 дүгээрт.

2 дугаарт энэнтэй холбоотой хувийн эрх зүйн чиглэл, цаашилбал арилжааны эрх зүй гээд маш олон хуулиудыг Их Хурал батлах гэж байгаа. Нэн шаардлагатай хуулиудыг нэн тэргүүнд батална, оруулж хэлэлцүүлнэ. Энэ Шүгэл үлээх тухай хуулиас эхлээд, тэгээд улсын бүртгэлийг цахимжуулах, төгөлдөршүүлэх. Заавал энэ ААН-үүд, аж ахуй эрхэлж байгаа иргэд аж ахуй нэгж байгуулж байж аж ахуй эрхэлдэг байх энэ буруу тогтолцоог халахаас эхлээд, Ерөнхий сайдын ярьж байгаа энэ эрх чөлөө, ААН-үүдийн үйл ажиллагааг чөлөөтэй явуулах, байж байгаад нэг ААН гэж дайсан гаргаж ирдэг, иргэдийнхээ эрх чөлөөг боомилдог, эцэст нь улс төр болоод дуусдаг, эдийн засаг унадаг, улс орон урагшилдаггүй ийм нөхцөл байдал байгаа. Өнөөдөр Монгол Улсад бүтэн нэртэй, бүлээн зүстэй хүн байхаа больсон. Ёс зүй, ёс суртахуун гэдэг зүйл ёроолдоо ортол доройтсон. Энэний хамгийн том хүчин зүтгэгчид нь өөрөө улс төрчид өөрсдөө. Тийм учраас би энэ улс төрийн хэрэгслийг хуулиар, хуулийн байгууллагаар хийдгийг больё гэж байгаа нь энэ юм.

Нөгөө талаараа энэ хуулийн шинэчлэлтэй холбоотой асуудал байгаа. Бидэнд хууль дутаагүй, хэрэгжилт хангалтгүй байна. Энэ хэрэгжилтийг хангах асуудлуудыг бид эдийн засаг, эрх зүйн үр дагавраар нь ангилаад, өнөөдрийн байдлаар хууль батлаад батлагдаагүй журам, хэрэгжиж чадахгүй хууль 1-ээс 7 жил болсон байгаа юм. Өмнө ч гэсэн бид ярьдаг байсан, хууль өөрөө хэрэгжихэд журам нь тодорхой байх ёстой. Журмаас илүү процессын хуультайгаа байх ёстой гэж. Тэгэхээр энэ эрх зүйн процессын асуудлууд, материаллаг хуулийн асуудлууд гээд бидэнд асар олон асуудлууд, ярилцах шийдвэрлэх зүйлүүд байгаа. Гэхдээ нөгөө талдаа энэ байгууллагуудын уялдаа холбоог хангахтай холбоотой асуудлууд сая ярьсан энэ эрх зүйн шинэчлэлийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Сангийн сайд хариулъя.

З.Мэндсайхан: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ шүүхийн төсөвтэй холбоотой асуудал жил болгоны төсөв дээр бас асуудал болдог. Тэгэхээр мэдээж миний хувьд шүүх засаглал хараат бус байх, бие даасан байх, мөн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах энд мэдээж хөрөнгө оруулалт энэ шүүхийн төсөв бол шууд хамааралтай гэж үздэг. Гэхдээ шүүхийн төсвийг 6 сард ХЗБХ-гоор хэлэлцээд, Сангийн яаманд ирүүлдэг. Төсвийн хязгаараа бид тухайн жилийнхээ төсвийн хязгаарыг 6 сарын хуулийнхаа хугацаагаар 6 сарын 26-нд хэлэлцээд, Сангийн яам бол 7 сарын 5 гэхэд салбар яамнууд руу явуулдаг байгаа. Тэгээд үүнийг хуулийн цаглавар болон төсвийн бидний өөрийн хязгаарын хүрээнд энэ

асуудал маань ингээд асуудал болоод явдгийг та хэд бүгд мэднэ. Тэгэхээр энэ дээр энэ хуулийн цаглаврын талд нь ч тэр, төсөвт тусгах талд нь ч гэсэн тантай би бас хэдүүлээ хамтраад ажиллая гэж хэлж байгаа юм.

С.Бямбацогт: Тодруулъя Баасанжаргал гишүүн 1 минут.

Х.Баасанжаргал: Би нэг зүйлийг хэлэхээ мартсан байна. Юу вэ гэвэл жендэрийн квотын асуудал ЗГ-ын түвшинд ч тэр, Улсын Их Хурлын түвшинд ч тэр яг санаа зовоосон, ямар ч ахиц дэвшил гарахгүй байгаа асуудал яг нэг асуудал яг үлдээд байгаа. Тэрийг цаашид анхаарах ёстой байх. Ялангуяа УИХ дээр ирэх 28 оны сонгууль дээр 40 хувийн квот байгаа. Дээрээс нь орон нутгийн сонгуульд бид орон нутагт нэр дэвшигчдийн жендэрийн квотын асуудлыг ярих ёстой байгаа. Тэгээд энэ дээр манай эрэгтэй улс төрчид манлайлалтай бөгөөд сэтгэл зүйн бэлтгэлтэй байгаасай гэж бодож байна.

С.Бямбацогт: Үг хэллээ. Гантөмөр гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Л.Гантөмөр: Тэгэхээр ер нь цомхон төрийн тухай ойлголт бол сайд нарын эрх ямбыг авч хаяж байж л яригдах юм байна. Учралын ярианаас яг тэгж ойлгож байна. Эрх ямба ихтэй байна, сайд болох дуртай хүн маш их байна. Намынхаа эв нэгдлийг бодоод бүгдийнхээ хүсэл сонирхлыг хангаад явахаар энэ чинь болдоггүй юм байна. Би намын дарга байсан хүний хувьд тэр жаргал, зовлонг ойлгож байна. Тэгэхээр Их Хурлын дарга Бямбацогтын хийх ажил их байна. Энэ сайд нарын эрх ямба гэдэг зүйлийг алга болгох ажлыг бид маш яаралтай хийж байж, дараагийн ЗГ цомхон, чадварлаг, мэргэжлийн гэдэг зүйл рүү явах юм байна. Энэ бол их тодорхой байна.

Тэгэхээр сайд нараас нэг асуулт байна. Та бүхний ажиллах цар хүрээ бол ерөөсөө ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр. Энэ хөтөлбөрөөсөө 3, 3 зүйлийг хэлчихмээр байна өөрт чинь оногдож байгаа. Дээр нь 26 оны үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа. Энэ төлөвлөгөөнөөс нэг анхаарал тавьж ажиллана даа гэсэн 3, 3 зүйлийг та бүхэн хэлмээр байна. Би танай намын амлалтыг энд асуухгүй өнөөдөр. Эртээр Ерөнхий сайдаас асуусан, Ерөнхий сайд ер нь багцаалдахгүй байна лээ. Нэг ийм зүйлд хариулт авмаар байна.

2 дугаарт, их гоё ярих биш, гол зүйлдээ анхаарах хэрэгтэй одоо бол. Яагаад гэвэл үндэсний аюулгүй байдлын түвшинд харанга дэлдэж байгаа хэд хэдэн асуудал байгаад байна. 1 дүгээрт, эрчим хүчний асуудал энэ дээр Ерөнхий сайд өөрийнхөө бодлыг их тодорхой болгож, энийгээ ажил хэрэг болгох хэрэгтэй. 2 дугаарт, тэр ОТ-н хэлэлцээр. Түрүүн Батнайрамдал хугацаа асуугаад байсан. Ерөнхий сайд одоо зээлийн хүүгийн хэлэлцээр хийх хугацааныхаа эцсийн хугацааг мэдэж байна уу, үгүй юү? Тэрийгээ нэг хэлчихмээр байна. Зээлийн хүүг заавал буулгах хэрэгтэй.

3 дугаарт, та нар Баялгийн санд одоо гар дүрэх гэж байна. Учрал сайд энийг болиулах хэрэгтэй. Энэ цэвэр популизм байсан. Жоохон мөнгө төгрөг гачигдаад ирэнгүүт нөгөө ирээдүйдээ зoorилж байсан жоохон цаасаа гаргаж тараагаад, үнэгүйдүүлээд ингээд явах гэж байгаа. Энэ маш хуучин арга барил шүү. Бид ирээдүйд хадгалж байгаа мөнгийг зарахыг улайлдан эсэргүүцэх болно, болохгүй. Өнөөдөр зарах мөнгөө л зарах хэрэгтэй.

Дараагийн асуудал энэ импортлогдох инфляц. Энэний төлөвлөгөөг их нарийн гаргаж өгөх хэрэгтэй. Зах зухаас нь Энхбаяр танилцуулмаар байна. Ерөнхийдөө маш их хариуцлага, сахилга батын доор энийг давж гарна. Түүнээс биш хүмүүст мөнгө өгснөөр энийг давж гарахгүй, бэлэн мөнгө нийлүүлэх тусмаа үнэ хөөрөгдөнө. Үнэ хөөрөгдчихөөрөө буцаад бууж ирэхгүй маш тодорхой шүү. Тэгэхээр өмнөх ЗГ чинь ер нь 10 сарын хугацаанд юу хийчхэв гэдгийг л та нар одоо очихоороо сайн харна даа. Жишээлбэл өнөөдөр 720 тэрбум төгрөг орлого дутаж байгаа, дээр нь багш нарын цалин энэ тэр гээд 1 их наяд төгрөгийн хэрэгцээ шаардлага байна. Галийн татвар шатахуун дээр тэглэхээр та хэд дээр 250 тэрбум төгрөгийн ачаалал дахиад ирнэ. Тэгэхээр бид байгаа хөтөлбөрөө ажил хэрэг болгож байж ард түмэн дээр очно. Их Хурлын гишүүд, та бүхэн бүгд Их Хурлын гишүүд. Эцэст нь хариуцлага, сахилга батын асуудал байгаа. Хариуцлага, сахилга батын асуудал байгаа.

С.Бямбацогт: Гантөмөр гишүүн 1 минут сунгая.

Л.Гантөмөр: Энэ хариуцлага, сахилга бат гэдэг зүйлийг яаж хийх вэ гэдгийг Эдийн засаг, хөгжлийн яаман дээр Энхбаяр сайдын мэдэлд тэр хяналтын байгууллага нь очоод, үнэлгээ өгдөг, ингэж хариуцлага тооц гэдэг зүйлийг гаргачихсан. Өвөл цахилгаан тасалсны хариуцлагыг Чойжилсүрэн хүлээгээд огцорсон. Түлш тасарсны хариуцлагыг хэн хүлээх вэ, бензин тасарсны хариуцлагыг хэн хүлээх вэ, эзэн байхгүй. Ерөнхий сайдын ЗГ-ын гишүүд бол кабинетын гишүүд гэдгээ л ухамсарлах хэрэгтэй. Тэгвэл та нар хариуцлага ирнэ, сахилга бат ирнэ. Та нар Их Хурлын гишүүний статусын хажуугаар одоо Ерөнхий сайдын бүрэн эрхт цэргүүд. Олон өнгөөр дуугарч болохгүй, ард түмнийг самууруулаад байдаг. Нэг өнгөөр дуугардаг, нэг юмны араас явдаг.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Би Гантөмөр даргад өмнө нь хариулсан. Би миний хувьд намын даргаар сонгогдоод, намынхаа 2024 оны сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг бүтэн үнэлж дуусгасан. Бүр хиймэл оюун ажиллуулж байгаа л даа. Намын гишүүд болгон дашборд дээр харахад бүрэн бололцоотой болсон, хувь хэмжээ маш тодорхой гардаг болсон. Бодитойгоор үнэлж байгаа, үнэлгээ хийсэн. Тэгээд би өмнө нь танд тоонуудыг нь ч хэлсэн шүү дээ. Тэгэхээр мөрийн хөтөлбөрүүдээ үнэлээд явна. Тэгээд тухайн үед 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг та бид хамтдаа боловсруулсан. Танай намын мөрийн хөтөлбөрийн зорилт бол энэ 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт байгаа. Энэ хөтөлбөр биелэхгүй бол танай намын мөрийн хөтөлбөр бас энэ дотор байгаа л гэж ойлгох ёстой учраас мэдээж энэ мөрийн хөтөлбөр биелээсэй гэдэг ийм хяналтыг сөрөг хүчний зүгээс тавих нь зайлшгүй гэдгийг хэлье.

Тэгээд ийм сайд нарын эрх ямба ч гэж дээ, та ямар эрх ямба эдэлж байсан юм бэ Тэргүүн шадар байхад. Тэгээд эрх ямба гээд байх юм байхгүй шүү дээ. Сайд нар нэг өрөөнд сууж байх шиг байна, мэдээж нэг яаман дээрээ сууж байх шиг байна. Тэр чинь нэг төсөв, татвар төлөгчдийн мөнгөөр бүрдэж байгаа учраас төсвөө захиран зарцуулах нь хуулийн хүрээнд шийдэгдээд л явдаг асуудал. Яах вэ сайд нар машин унадаг байх, тэгээд 1 туслахдаа л биз дээ. Нэг их эрх ямба энэ тэр гэж ярихаар их томдох болов уу гэж би бодож байна. Таныг нөгөө Тэргүүн Шадар байхад яг ямар эрх ямба эдэлж байсан юм гээд бодоод үзэхээр та мэднэ. Тэгэхээр ЗГ-ын гишүүн бүгдээрээ байж үзсэн хүмүүс, олон ч удаа засагт ажилласан. Энэ Их Хурлын гишүүнээс тэс өөр ажил. Энэ зовлонтой, үнэнтэй нүүр тулдаг ажил. Хамаагүй ярьж

ч болдоггүй ажил, хамаагүй амлаж ч болдоггүй ажил, үр дүнгээрээ дандаа үнэлүүлдэг учраас.

Тэгэхээр манай энд байгаа ЗГ-ын гишүүн болж байгаа Их Хурлын гишүүд энэ гишүүдийн хэлж байгаа үгийг сайн сонсох хэрэгтэй. Гантөмөр дарга ч хэлж байна. Та нар кабинетын зарчмаар ажиллана шүү. Одоо тэгж тэс өөр, өөр өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлдэг цаг чинь өнгөрсөн гэдгийг хэлье.

ОТ-н тэр хэлэлцээр дээр нөгөө 7 жил тутамд хэлэлцэх ёстой, хувь нийлүүлэгчдийн гэрээний жил чинь 25 онд дуусаад, одоо 26 онд ингээд нөгөө зээлийн хүүгийн хэм хэмжээ, хэмжээг эцэслэх ёстой. Тэгээд 26 ондоо дуусгах ёстой. Энэ мэдээж нөгөө Түр хорооны тогтоол дээр ч орсон байна лээ. Онтрэгийн хэлэлцээнээс шалтгаална. 26 ондоо дуусгана. Тэрнээс хугацаа шууд хэлэх боломжгүй.

С.Бямбацогт: Баялгийн сангийн асуудал дээр би хариуцаж байсан болохоор гар дүрэх гэж байгаа юм байхгүй шүү, буруу мэдээлэл өгч болохгүй. Одоо Ирээдүйн өв сан руугаа гар дүрэх гэж байна, хоослох гэж байна гэж ярьдаг чинь буруу шүү. Их Хурлын гишүүд бодитой мэдээлэл өгөх ёстой. Өнөөдөр Ирээдүйн өв санд 6 их наяд байгаа, Хуримтлалын санд 1 их наяд байгаа. Яаж 1 их наядаа илүү арвижуулж иргэн болгоны дансанд байгаа 175 мянгыг ахиу болгох вэ гэдэг асуудлыг бид ярьж байгаа ЗГ. Бусдаар тэр 6 их наядыг татаад аваад, зарцуулах асуудал ерөөсөө ярихгүй байгаа шүү. Энийг манай шинэ сайд нар цаашдаа бодлогодоо барьж, анхаарч ажиллах ёстой шүү гэдгийг энд онцолж хэлье. Эрдэнэбүрэн гишүүн. Тодруулъя.

Л.Гантөмөр: Яах вэ манай сайд нар ингээд дараа дараагийн хурал дээр ингээд цаас барьж явахдаа ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр яг өөрт чинь оногдож байгаа аравхан юм байгаа шүү дээ, тав, аравхан л юм байгаа. Тэгээд 26 оны хөгжлийн төлөвлөгөө гээд бас аравхан юм байгаа. Идэрбат сайдад 10, 15-хан л юм оногдоно, тэрийгээ л бариад явж баймаар байна. Тэр хүрээндээ ажлаа хийгээд байвал тэгээд энэ чинь сайд хүн гэдэг чинь хууль л биелүүлдэг хүн байхгүй юу. Тэгээд сайд нар хуулиа биелүүлж байвал болоо. Би хөтөлбөр нэхээд байгаа шалтгаан Учрал дарга яг тэр суудал дээрээс уг нь тэр Ipad-аа харж байгаад 10 ширхэг амлалт надад уншаад өгчихмөөр байгаа байхгүй юу, гүрийгээд байгаа юм. Би дүн шинжилгээ хийж байгаа. Үгүй ээ үгүй та наадах руугаа бичүүлж байгаад надад уншаад л өгчих л дөө. Бид яг ингэж, ингэж амласан юм. Би энэ дээр жоохон ач холбогдол өгч байгаа шүү гээд. Ингэж нэгэндээ сануулж явахгүй бол бид мөрийн хөтөлбөр.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ тийм үү? Үг хэллээ, бүх сайд нар анхаарлаа аваарай. Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя.

Р.Эрдэнэбүрэн: МАН-аас сонгогдсон эрхэм гишүүд, нэр дэвшиж байгаа ЗГ-т нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нарт энэ оройн мэндийг хүргэе. Маш харамсалтай байна. МАН 100 жилийн, 100 гаруй жилийн түүхтэй. Энэ улсыг авч явах тулхтай, тохитой нам гэж өөрснөө ярьдаг, ярьдаг байсан ийм нам өнөөдөр ингээд булан тохойгоос гарч ирээд, бие биеэсээ сайдын суудал нэхээд, би, чи гээд ингээд хэрүүл хараал хийгээд ингээд явж байгаад үнэхээр харамсаж байна. МАН-ын маш том, том хуульчид байсан Лүндээжанцан, Нямдорж, Нямаагийн Энхболд эд нар гээд хууль, гол бодлого бариад ингээд явж байдаг энэ парламентыг залж байдаг тийм хуульчидтай, том, том төсөл ярьдаг Баяр гээд даргатай, Хүрэлсүх гээд даргатай ийм

нам байсан энэ нам одоо хаачив? Үнэхээр харамсалтай байна. Хэчнээн сар гацааж байна. Энэ төрийн ажлыг ийм хүнд үед ямар ч сэтгэл байхгүй байна.

Гадаад, дотоод нөхцөл байдал чинь юу болж байгааг бүгдээрээ мэдсээр байж сайдын суудал яриад л, Их Хурлын даргын суудал ярьцгаагаад л энд тэнд хэвлэлээр гарч ирээд орилолдоод л байх юм. Яасан муухай сэтгэлгүй юм бэ? Тэгээд юм л бол АН руу дайрах юм гарч ирээд л. АН-аас болоод энэ гацаад байна энэ тэр гээд л, юу ярьцгаагаад байгаа юм бэ? Харин тэгж яривал АН чинь харин та нарыг бойкот хийж элдэв дээд болгож байж ингэж нэгтгэж, Засгаа байгуулах хэмжээнд аваачиж байгаа шүү. Та нар манай намын бүлэг, намын дарга, Бүлгийн даргын гаргасан шийдвэрт талархаж байх ёстой.

Цаашдаа энэ байдлаа болимоор байна, энэ улс чинь хэцүүдлээ шүү дээ. Одоо тэгээд ингээд нэгдэж барьсан бол маргааш энэ Чингисийн хөшөөн рүү урагшаа гараад 68-уулаа гараад энэ Монголын ард түмнээс уучлалт гуйх хэрэгтэй шүү. Парламентын нэр хүндийг танай 68 унагаж байгаа шүү, энэ төрийн нэр хүндийг. Ямар хаашаа юм. Одоо харин нэг жоохон ойлгож эхэлж байх шиг байна. Хэд хэдэн гишүү, сөрөг хүчиндээ баярлалаа, баярлалаа гэгцгээж байна. Та нар үнэхээр баярлаж байгаа бол нэг алга ташчих сөрөг хүчиндээ баярлалаа гээд.

2, 3 асуулт асуучихъя. Одоо ажил яриад ч нэг их бараг дэмий юм шиг байна тэгэхдээ. Энэ Ойрх Дорнодод болж байгаа дайнтай холбоотой тийшээ явдаг байсан ажиллах хүчин маш хямд болж байна ажилгүй болоод. Олон орноос авдаг байсан. Тэгээд яг ийм хямд үед нь оруулж ирээд, нэг ажил, одоо бид чинь сая нэг ийм хууль ярих гэж үзлээ. Зөвхөн цагаан сар, шинэ жилээрээ амардаг байя, бусад амралт баяруудаа больё гэсэн тэгээд явсангүй. Тэгээд одоо ингээд юу эхэллээ аялал жуулчлалын улирал эхэллээ, наадам, амралтын юу эхэллээ. Энэ ажиллах хүчээ гаднаас тэр нөгөө ажиллах хүчнийхээ тэр төлбөрөө болиод, ажиллах хүчин хямд байгаа дээр энэ гаднаас авчраад ажиллуулаад жоохон явахгүй бол одоо бензин тосны чинь зардал өсөөд энэ өртөг өсөх гээд байна шүү дээ. Тэгээд хямд дээр нь авчраад, заавал ч үгүй ингээд нэг хэдэн цаас нэмээд байхгүй ингээд жоохон юмнуудаа явуулмаар байх юм.

2 дугаарт Аялал жуулчлалын сайд чинь хэн болж байгаа билээ, Алдаржавхлан билүү? Энэ онгоцны түлшний.../минут дуусав/

С.Бямбацогт: Эрдэнэбүрэн гишүүний асуулт нэмэлт 1 минут тодруулж асууя.

Р.Эрдэнэбүрэн: Онгоцны түлшний үнэ нэмэгдсэнээс болоод аялал жуулчлал хол явахаа больж байна гэж ийм судалгаа гарч байна. Дотооддоо юм уу, маш ойрхон газар л явдаг ийм юм руу орж байна. Наад энэ Хятад жуулчны визээ яриад, зоригтой тэгээд явахгүй бол өөр бидэн рүү хол газраас жуулчин ирэх тийм юм байхгүй болж байна шүү энэ зун. Энийгээ ингээд зоригтой хийгээд явах хэрэгтэй. Тэгээд хөрөнгө оруулалт эд нар хэцүү болсон, энэ том төслүүдээ яадаг юм зогсоож барьдаг юм уу, яадаг юм ингээд явахгүй үнэхээр маш их цаг алдлаа. Тэгээд бараг маргаашаас бензиний үнэ нэмэгдэж эхэлнэ. Тэгээд АН руу битгий дайраад байгаарай, өөрсдөөсөө буруугаа хайгаарай. Шинээр байгуулагдаж байгаа ЗГ-т амжилт хүсье.

С.Бямбацогт: Гадаад ажиллах хүчинтэй холбоотой Аубакир сайд чухал асуудал хөндөж байна. Та энэ дээр хийх юм уу, хийхгүй юм уу гэдгээ нэг хариулчих. Монгол Улсад ажиллах хүчин байхгүй, гадаадад хямд ажиллах хүч байгаад байна.

Энэ дээр ямархуу бодлого явах юм бэ, урьд нь энэ салбар хариуцаж байсан хүний хувьд.

Т.Аубакир: Гаднын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг бид нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай. Мэдээж хэрэг Үндэсний аюулгүй байдлын хүрээнд хүн амд эзлэх хувийн хязгаарлалт байдаг. Өнгөрсөн ЗГ-ын үед маш эрчимтэй яригдаж байгаа энэ асуудал, өчигдөр хүртэл бид Энхбаяр сайд бид энийг цаашдаа яаж либералчлах вэ. Энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин тэнцүүлэхдээ төлбөр төлдөг шүү дээ, энийг нь чөлөөлөх ямар боломж байна. Бид өнгөрсөн хугацаанд үндэсний бүтээмжийнхээ ерөнхий төлөвлөгөөг хийсэн. Энэ дээр манай Монгол Улсын бүтээмж буурч байгаа гэж гарч байгаа. Энэ маань өөрөө хөдөлмөр эрхлэлт багасаж байна гэсэн үг. Хөдөлмөр эрхлэлт багасахаар зэрэг бүтээмж буурна, бүтээмж буурахаар ДНБ-д нөлөөлдөг. Тийм учраас бид энийг дахиж хууль, эрх зүйн орчныг нь шинэчилж оруулж ирэх төлөвлөгөө боловсруулж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Дэлгэрсайхан сайд онгоцны түлштэй холбоотой.

Б.Дэлгэрсайхан: Эрдэнэбүрэн гишүүний ярьж байгаатай санал нэг байна. Тэгээд яах вэ энэ аялал жуулчлалтай холбоотойгоор манай нисэхийн салбарт ийм, бид 4 аймгийн нисэх онгоцны буудлыг яг аялал жуулчлалын улирлын үед түр боомт нээгээд, Өмнөговийн Гурвансайхан.../минут дуусав/

С.Бямбацогт: Дэлгэрсайхан гишүүнд минут өгье.

Б.Дэлгэрсайхан: Хөвсгөлийн Мөрөн, Ховдын Ховд, Өлгийн Өлгий онгоцны буудал гээд 4 онгоцны буудал шууд олон улсын нисэх түр боомтыг нээгээд, аялал жуулчдаа шууд гаднаас энэ 4 аймагт шууд буулгаж байгаа юм. Ингэж байж жуулчдын зардлыг багасгаж, аль болохоор илүү их жуулчин авах бололцоо нээж өгч байгаа. Тийм учраас аялал жуулчлал дээр бид ингээд хамтраад, илүү их зардал хэмнэх энэ бүх бололцоог нисэхийн салбарт гаргаж өгнө гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Болормаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ, Э.Болормаа. Энхбатын Болормаа.

Э.Болормаа: Учрал Ерөнхий сайд таны ахалж буй ЗГ-ын тэргүүлэх зорилт бол ОТ-н өгөөжийг Монголын талд нэмэгдүүлэх гэж би бодож байна. Занданшатар Ерөнхий сайд өөрийн хүсэлтээр ажлаа өгсний маргаашаас нь л Рио Тинто огцруулсан юм байна гэдэг ийм сошиал найруулга явсан. 7 жил тутам ганцхан тохиодог ОТ-н мөлжлөгийн энэ зээлийн хүүг бууруулах хэлэлцээрийн эхний боломж нь 2018 онд байсан. Тэр үед ажлын хэсгийг Гомбожавын Занданшатар ахалж байсан. Хэлэлцээр үр дүнд хүрээгүй, зээлийн хүү огт буураагүй. 2 дахь боломж нь өнгөрсөн 2025 онд тохиосон. Тэгээд хувь заяаны тохиолоор сонгуульд унасан ч гэсэн Ерөнхий сайд болоод дахиад Гомбожавын Занданшатар гэдэг хүн энэ асуудлыг хариуцсан. Монголчууд бид бүгдээрээ үр дүнд хүрээсэй гэж чин сэтгэлээсээ хүссэн. Даанч хэлэлцээр үр дүнд хүрэлгүй өнөөдөр хүрсэн байна. Тэгээд Занданшатар Ерөнхий сайд өөрөө өргөдлөө өгөөд огцорсон.

Өнөөдөр хэдий Ерөнхий сайд нь өөрчлөгдсөн ч гэсэн хэлэлцээрийн нэг ажлын хэсгийг ахалж байсан Уул уурхайн сайд Дамдинням сайд улиран энэ ЗГ-т орж ирсэн байна. Занданшатар Ерөнхий сайд ажлаа өгсний маргааш нь явагдсан тэр их сошиал мэдээ дунд нэг ноцтой мэдээлэл байсан. Тэр нь юу вэ гэхээр Онтрэ-ийн лицензийг цуцал гэж чиглэл өгсөн. Энийг нь эсэргүүцээд Рио Тинто огцруулсан

байх. Тэгэхээр Дамдинням сайдаас асууя. Танд Онтрэ-ийн лицензийг цуцал гэж Занданшатар Ерөнхий сайд чиглэл өгсөн байсан уу? Тийм бол яагаад энэ үүрэг даалгаврыг нь та биелүүлээгүй байсан юм бэ? ОТ-н сонсголоор Онтрэ компани хууль зөрчиж лицензээ сунгасан, ашиглаж байсан нь ерөөсөө баримтаар нотлогдсон. Тэгэхээр Учрал Ерөнхий сайд та Онтрэ-гийн лицензийг цуцалж чадах уу?

Дэлхийд эдийн засгийн хувьд энэ зэсийн эрэлт улам нэмэгдэж байгаа энэ үед бид Монгол Улсын хуулийг дээдэлдэг, хариуцлагатай хөрөнгө оруулагчдыг олж чадна. Яагаад уул уурхайн үйл ажиллагаа явуулдаггүй Канадын цаасны компани Онтрэ-д Монголын стратегийн ордны лиценз хууль бусаар явж байгаа юм бэ? Энэ бүгдийг бид хянан шалгаад, ОТ-н түр хороо маань Онтрэ, зээлийн хүү бууруулах, бусад асуудлууд дээр ч гэсэн тодорхой чиглэлүүдийг Улсын Их Хурлын тогтоолоор өгсөн. Ерөнхий сайд хэн байх нь хамаагүй, Монгол УИХ Монгол Улсын ЗГ-т өгсөн чиглэлүүд.

Тэгэхээр энэ тогтоолд заасан нэг зүйлийг онцлон хэлье. Энэ тогтоолд энэ тогтоолын хэрэгжилт буюу энэ хэлэлцээрийн явцыг улирал тутам УИХ-д тайлагнах ёстой гэж заасан байгаа. Улирал тутам. Тэгэхээр эхний тайлагнах хугацаа энэ 4 сард, Учрал Ерөнхий сайд таны ахалсан ЗГ энэний эхний тайланг нь энэ 4 сардаа УИХ-аар хэлэлцүүлэх ёстой юм шүү.../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Болормаа гишүүний асуултад хариулъя. Онтрэ-гийн лиценз болон энэ ОТ-той хэлэлцээр хийх ийм, ОТ-н бүлэг ордтой холбоотой хэлэлцээр хийх 3 ажлын хэсэг гараад, ажиллаж байгаа. 3 ажлын хэсгийн удирдамж нууцын зэрэглэлтэй явагддаг учраас тэр удирдамжид байгаа асуудлууд болон хэлэлцээртэй холбоотой асуудлуудыг би танд дэлгэрэнгүй хэлж чадахгүй нь хууль тогтоомжийн хүрээнд. Яагаад вэ гэвэл Монгол Улс өөрөө хөрөнгө оруулагчидтайгаа хэлэлцээр хийж байгаа тактикаа ил зарлаад байх нь зохимжгүй зүйл.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 120 дугаар тогтоолоор өгөгдсөн Онтрэ-гийн лицензийн асуудлыг тусгайлан шалгаж, Монгол Улсад ашигтай байхаар бүх нөхцөл боломжийг судлах үүрэг даалгаврыг Улсын Их Хурлын тогтоолоор өгөгдсөн. Тэр чиглэлд ажиллагаа, ажилбарууд хийгдэж байгаа. Тайланг бид тодорхой түвшинд танилцуулахад бололцоотой.

3 дугаарт 7 жилийн түгжээг авч хаясан. Ялангуяа би ажлын хэсэг ахалж, Жавхлан сайдтайгаа ажлын хэсэг ахалж Рио Тинтотой хийсэн хэлэлцээрийн үр дүнд хэлэлцээрийн протокол зуруулсан. Хэлэлцээрийн протоколоор энэ хэлэлцээрүүд үр дүнд хүртэл үргэлжилнэ нэг. 2 дугаарт 7 жилийн түгжээг харгалзахгүй. Өөрөөр хэлбэл түгжээ байхгүй болсон гэсэн үг. Бид 3 ажлын хэсэг байгаа. Нэг нь Онтрэ-тэй хийх хэлэлцээрийн ажлын хэсэг байна. Онтрэ-тэй хийх хэлэлцээрийн ажлын хэсэг бол яг 1 дүгээрт энэ лицензтэй холбоотой болон бусад бүх асуудлуудыг судлаад, ний нуугүй хэлэхэд тантай яг зарчмын хувьд санал нэг байгаа. Манай улсын энэ лицензийг хууль ёсоор авсан уу, үгүй юу, яагаад эндээс өгөөж хүртэх ёстой юм гэдэг асуудлыг ярьж, тавьж байгаа. 2 дугаар асуудал Онтрэ-гийн энэ лицензийн талбайн үр өгөөжийг авахын тулд шинэ хөрөнгө оруулалтын гэрээ хийх нэг. 2 дугаарт энэ Ораногийн гэрээний суурьтай ижилхэн суурьтай роялти суурьтай гэрээ хийх нь зөв юм гэсэн зарчмын байр суурьтайгаар явж байгаа.

Менежментийн төлбөртэй холбоотой ажлын хэсэг байна миний ахалж байгаа ажлын хэсэг. Менежментийн төлбөртэй холбоотой ажлын хэсэг дээр УИХ-аас өгөгдсөн үүрэг даалгавар болон Монгол Улсын ЗГ-аас баталж өгсөн удирдамжийн хүрээнд бүрэн хүрэхэд тун ойрхон байгаа. Саяхан ЗГ огцрох өдөр Рио Тинтогоос сүүлийн хариу ирсэн байна. Одоо тэгээд шинэ ЗГ дээр бид ярилцаад, дахиад энийгээ дүгнэнэ. Менежментийн төлбөртэй холбоотой ажлын хэсэг бол Сангийн сайд ахлаад явж байсан. Одоо Ерөнхий сайд өөрөө ахлуулах хүмүүсээ шийдэх байх. Ингээд шинэ захирамж гараад, хэлэлцээр үргэлжилнэ.

С.Бямбацогт: Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Дамдинням сайдын хариултад нөгөө энэ сайд хариуцах байх, тэр сайд хариуцах байх гэж мэдээж яг бүрэн тангараг өргөөгүй байгаа учир энийг хэлж байна л даа. Тэгэхээр Учрал Ерөнхий сайд би бол танд зөвхөн энэ ОТ-н хэлэлцээрийг хариуцсан бараг сайдтай болооч гэмээр байна. Бусад бүх ажлаас нь чөлөөлөөд, нэг сайдаар, бараг нэг Шадар сайдаараа энэ ажлыг хариуцуулаач. Монгол Улсын гадаад өрийн 50 хувь нь ганц энэ төсөл дээр байгаа шүү дээ. Бид өдөрт 14 тэрбум төгрөгийг зээлийн хүүд зарцуулж байна гэж байгаа юм чинь энэ нэг сайд дангаараа хариуцвал зүйтэй шүү гэж би хэлмээр байгаа юм. Тэгээд сая Дамдинням сайдын хариулт бол хүндэтгэлтэй хандаж байна. Хэлэлцээр гэдэг өмнөх ЗГ шиг нэг тийм попрод, нэг хэдэн зүйл хэлчхээд монтажлаад, рийл тавьдаг зүйл биш. Мэдээж мэргэжлийн баг хийх ёстой, энэ мэргэжлийн багийг бүрдүүлээрэй гэж хүсмээр байна. Тэгээд энэ дээр амжилт гаргаарай гэж чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.

С.Бямбацогт: Өмнөх ЗГ чинь Дамдинням сайд чинь өөрөө шүү дээ. Номинчимэг гишүүн асуултаа асууя, саналаа хэлье.

О.Номинчимэг: Өнөөдөр олон улсад нөхцөл байдал ямар байгааг бид бүгдээрээ мэдэж байгаа. Аль ч тивийн, ямар ч улс байсан энэ дэгдэж байгаа нөхцөл байдлаас болоод нөлөөлөлд орж байгааг бид бүгдээрээ хүлээн зөвшөөрч байгаа. Монгол Улс ч гэсэн энд нөлөөлж байгаа. Тэгээд энэ нөхцөл байдалд улс төр мэдээж дотроо халж болно. Улс төрийн намууд ч гэсэн дотроо галтай байж болно. Гэхдээ ямар ч тохиолдолд түймэр гарсан үед бид хамтдаа нэг зүгт гадна талдаа бол тийм байх ёстой. Тэгж байж бид туурга тусгаар Монгол Улсынхаа эрх ашгийг хамгаалж чадна.

Өнөөдөр ингээд харахад манай сөрөг хүчнийхэн, ялангуяа АН-ынхан маань энийг бас нэг тодрох бүхий л боломжоо ашиглаж байна гэж харж байна. Тэгээд түрүүн гишүүдийн үгэнд дурдаж байна. Мах килограмм нь 30 мянган төгрөг болчихсон байхад та нарын хэн дуугарсан юм бэ гээд загнаж байх шиг байна. Улс төрийн шийдвэр тэнд гарч байхад энд төрийн ажил бас явж л байсан. Махны үнэ килограмм нь 30 мянга болчихжээ. Дотуур байранд амьдарч байгаа 6300 төгрөгөөр өдрийн 3 хоол идэж байгаа хүүхдүүдийн чинь хоол, шим тэжээл, ерөнхий боловсролын сургуульд идэж байгаа хоолны чинь шим тэжээл хүрэхээ болилоо, энийг нэмэгдүүлье гээд Өргөдлийн байнгын хороон дээр бид энийгээ яриад л сууж байсан.

Тэгэхээр цөмөөрөө одоо нэг зүйл ерөөсөө хамтдаа бүгдээрээ ойлгох хэрэгтэй байна. Ард түмэн бидэнд энэ төр барих эрхийг энэ 126, 68 биш шүү дээ, 126 хүнд өгчхөөд, шилжүүлчхээд яаж ажиллахыг нь хараад сууж байгаа, ямар үр дүн гаргах юм, яаж биднийг төлөөлөх юм. Төлөөлж байгаа нь 68 биш, 126 гэдгийг 1 дүгээрт бид ойлгомоор байна. Тэгээд гадаад нөхцөл байдал ийм үед яг л бид нэг цул байж,

Монгол төрийн бодлого ан цавтай биш, атгасан гар шиг байдаг баймаар байна. Тэгэхээр энэ үед, энэ хэцүү үед бид хувь тоглолтуудаа багасгамаар байна. Сошиал дээрх улс төрийн оноо авах юмаа түр жоохон хойш нь болгомоор байна. Энийгээ азнаад Монголоо гэсэн сэтгэлээр нэг хамтдаа нэг тийшээгээ хараад, үр дүн гаргасан, ард иргэдийнхээ амьдралд, тусгаар улсынхаа энэ байдалд нэмэрлэх энэ ажлуудыг хамтдаа хийе гэдгийг энэ чуулганд сууж байгаа энэ хүмүүстээ уриалмаар байна. Хүсмээр байна. Тэгэхгүй бол бид ингээд эв нэгдэлгүй, энд тэнд сошиал попролт нь ихсээд яваад байвал Монголын улс төрийн үнэхээр моралийн ялзралд ороход ойрхон байна гэж харж байгаа.

Сайд нарын хувьд амаргүй үед ажиллаж байгаа гэдгээ мэдээд, өөрсдөө энэ Ерөнхий сайдын урилгыг авч ажиллаж байгаа байх гэж, ажиллахаар болж байгаа гэж бодож байна. Тийм учраас авсан шигээ сайн ажиллаарай гэж хэлмээр байна. Тэгээд тэнцэж чадахгүй авсан шигээ өгч сураад, хариуцлага хүлээгээрэй гэж хэлмээр байна.

Нэг зүйл ХЗДХ-ийн сайдаар томилогдох хүнд захимаар байна. 2024-өөс 28 оны 3Г-ын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон нэг чухал хуулийн шинэчлэл энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль байгаа юм. Тэгээд өмнөх Хууль зүйн сайд Энхбаяр сайдтай ярьж байгаад энэ хууль өргөн баригдсан хууль маань дутуу дулимаг байна, шинэчлэл болж орж чадахгүй байна гэдгийг нь татуулаад 100 гаруй хуудастай нарийн процессжсон хуулийг ХЗДХЯ-ан дээр бэлдүүлсэн. Тэгээд энэ хууль маш чухал хууль. Хувийн эрх зүйн шинэчлэл, шударга ёс гэж ярьж байгаа бол шүүх нь шүүхийнхээ шийдвэрийг гаргаад, үр өгөөж, шударга ёс нь яг иргэд дээрээ очдог явдалд энэ хууль хамгийн том шинэчлэл болох юм шүү. Тэгэхээр та бас энэ хууль дээр маш их анхаарч ажиллаарай. 6 сарын 10-нд УИХ дээр парламент дээр бид олон улсын экспертүүдийг авчраад, яг энэ хуулиар хэлэлцүүлэг хийхээр бэлдсэн байгаа. Тэрнээс өмнө УИХ-д энэ хуулиа өргөн мэдүүлээрэй гэдгийг хүсэх байна.

2 дугаарт Иргэний хуулийн хэрэгжилтэд томоохон үнэлгээ, дүгнэлт хийсэн ажлыг парламентаас хийсэн. Тэгээд хувийн эрх зүйн шинэчлэлийг хийхээр Ерөнхий сайд ч гэсэн, ХЗДХ-ийн сайдад нэр дэвшиж байгаа нэр дэвшигч маань ч гэсэн хэлж байна.../минут дуусав/

С.Бямбацогт: Номинчимэг гишүүн асуултаа гүйцээж асууя, нэмэлт минут.

О.Номинчимэг: Хууль, шинэчлэл хийнэ гэдэг маань бүгдээрээ хууль гаргаад шийдчихдэг юм биш. Бид юу нь болохгүй байна, яагаад болохгүй байна гэдгийг үнэлэлт, дүгнэлт өгч байж цаашаагаа явах ёстой. Тэгэхээр хуулийн хэрэгжилт дээр та анхаарна гэж хэллээ. Энэ хувийн шинэчлэлийн ерөөсөө суурь бол өмчийн харилцаа, гэрээний харилцаа байгаа. Тэгээд Арилжааны хууль гэдгийг гаргаад бид бүгдээрээ эдийн засгийн эрх чөлөөнд хүрчихнэ гэсэн юм бол байхгүй. Юу нь болохгүй байна гэдгээсээ үнэлэлт, дүгнэлт өгч байж, цаашаа явах ёстой юм шүү. Тэгээд энэ дээр томоохон судалгааны ажил цаашид ч гэсэн олон улсын экспертүүдтэй харьцуулсан судалгаа хийгээд бид УИХ дээр явж байгаа. Энэ тал дээр та харж, энэ эрх зүйн чөлөөлөлтийн буюу хувийн эрх зүйн шинэчлэл дээрээ анхаарна байх гэж найдаж байна. Учрал сайдын бүрдүүлж байгаа баг бүрэлдэхүүнд бүгдэд нь ажлын өндөр амжилт хүсье. Иргэдийнхээ амьдралд бодит өөрчлөлт авчирсан, хурдтай ажиллах баг бүрдэж байгаа гэдэгт итгэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Нарантуяа-Нара гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Манай ёслолынхон бэлэн биз? Ёслолынхон үүний дараа.

М.Нарантуяа-Нара: Улс төрийг ч үнэхээр айхтар хийдэг юм байна, тэгээд зүйл бүрээр хийдэг юм байна, зүй бусаар ч хийдэг юм байна, бүгдээрээ сайн харж байгаа. Тэгээд Ерөнхий сайд маань яг улс орноо бодсон шийдвэр гаргав уу, улс төрөө бодсон шийдвэр гаргав уу гэдгийг хэн бүхэн хараад өөр өөрсдийнхөө дүгнэлтийг хийж байгаа байх гэж бодож байна. Одоогоос ердөө дөрөвхөн сарын дараа дэлхийн 197 улс орнуудын 10 мянга гаруй элч төлөөлөгчид Монгол Улсад цуглаад, дэлхийн цөлжилтийн эсрэг COP17 хурал болох гэж байгаа. Тэгээд энэнд бэлдэх хугацаа байгаа юм уу? Манай намын дарга бол хөөрхий ёстой элдвээр хэлэгдээд, энэ Байгаль орчны яамны сайд болсон цагаасаа хойш хоёргүй сэтгэлээр ханцуй шамлаад COP17-д маш чадахаараа хичээж бэлдэж байсан.

Энэ дээр би нэг зүйлийг онцолж хэлье. Иргэний Зориг ногоон нам муудаа Засгаас гарсан биш шүү. Харин Иргэний Зориг ногоон намын ачаар гишүүн болчихоод, Иргэний Зориг ногоон намын эгэл жирийн гишүүдийн хүч, нөр их хичээл зүтгэл, итгэл үнэмшил, үзэл баримтлал, үүх түүхийн ачаар гишүүн болчихоод, өнөөдөр намынхаа эсрэг, намын бодлогын эсрэг, намын гишүүдийн хүсэл эрмэлзлийн эсрэг намыг Засагт авахгүй байх тухай бичиг хууль бус намын бланк ашиглаж, Ерөнхий сайдад өгсөн бичгээр манай нам Засгаас гарсан байгааг манай намын гишүүд мэдэж аваасай гэж бодож байна. Мөн түүнчлэн Ерөнхий сайдад ийм хууль бус юмаар бичгийг ингэж юу яаж хүлээж авсанд нь харамсаж байна. Тэр ч тэгээд яах вэ.

Учралд хэлэхэд залуу хүн ер нь тэгээд замын эхэнд урвагчтай ханьсвал замын төгсгөлд гашуун байх вий. Чингис хаан бүх түүхэнд гардаг ганц л үздэггүй байсан юм бол урвагч байсан шүү. Тэгээд аман дээрээ авлигатай тэмцэнэ гэж байгаа ч үнэндээ тэмцэхгүй байна гэдэг чинь кабинетын сонголтоос чинь бас илэрхий харагдаж байна. Жишээлбэл АТГ дээр гомдол мэдүүлэг нь баримт нотолгоотойгоо оччихсон байгаа энэ Б.Энхбаяр сайд болох гэж байна шүү дээ. Энэ хүн ингээд заавал ингээд засаг төрд ингээд байгаад, ингээд сайд, сайд болоод явах ёстой юм уу?

Энэ Монгол төрийн сайдын алтан халбага зуугаад төрчихсөн эрхмүүд, энэ дээдсийн заяанд төрчихсөн эрхмүүд гэж байдаг юм байна. Тэгээд Батшугар гишүүн Эрүүл мэндийн сайдыг магадгүй сайн хийж магадгүй л дээ. Гэхдээ та Цахим яамыг 9 сар удирдахдаа, жишээлбэл цахим дээр яг Монголын өсвөр насны хүүхдүүд бүгд цахимаар хүчирхийлүүлж тийм ээ, маш их bully-д өртөж, цахимын маш том эрсдэл үүсэж байхад та хаана байсан бэ, та энэ яаманд ямар манлайлал, ямар өөрчлөлтийг авчрав? Тийм болоод одоо та яагаад Эрүүл мэндийн сайд болж чадна гэж бодоод явж байна. Тэгээд 1 зүйлийг бас хэлмээр санагдаж байна. Монголын төрд, төр өртэй нэг эрхэм байна Намбарын Энхбаяр гуай. Нэгэн цагт авлигын загалмайлан эцэг гээд оймс нь гозолзуулаад ачигдаж л байсан. Одоо тэгээд хүүхэд нь ингээд салбар салбарын сайдыг ингээд аваад л явдаг, энэ өртэй юм уу Монголын төр? Тэгээд өчнөөн олон эрүүл мэндийн салбарын, магадгүй сайн менежер гээд тэгж л байна. Тэгээд дахиад шал өөр салбар ингээд авах гээд явж байна. Энэ дээр хариулт авмаар байна.

Харин Цахим хөгжлийн яаманд Номин сайдыг очиж байгаад би бүүр баяр хүргэчихье. Хүмүүс нэг их попрод байх шиг байна. Би харин баяр хүргэе. Та Соёлын яамны сайд байхдаа тэр өсвөр насныхны хөгжил, чөлөөт цагийн төлөө маш

сайн судалгааг гаргаад, тэрнийхээ дагуу хуулиа батлуулаад, тэгээд нөгөө төсөв чинь унаж байсан тэр ажлаа одоо та Цахим дээр бүүр сайн хийж өгөөрэй гэж би танд захимаар байна.

Энэ Хууль зүйн сайд чинь өнгөрсөн 9 сарын хугацаанд 1 ч иргэний хууль зүйн, хууль, эрх зүйн тулгамдсан асуудлын талаар яриагүй. Харин эрх мэдэлтнүүдийн бөмбөг болж явсаар байгаад ирсэн. Одоо та.../минут дуусав/

С.Бямбацогт: Нарантуяа-Нара гишүүнд 1 минут.

М.Нарантуяа-Нара: Хууль зүйн сайд одоо иргэдийнхээ өмнө тулгамдсан байгаа хууль, эрх зүйн асуудалд маш сайн анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Эцэст нь хэлэхэд муу нэртэй, луу данстай хүмүүс рүү дайраад попроод, гишүүд ингээд дайрахаар тэд нар ингээд сайн хүн болчихдог гээд андуураад байх шиг байна зарим хүмүүс. Тийм юм байхгүй. Ерөнхий сайд хурдыг маш сайн эрхэмлэж байх шиг байна. Тэр зүйтэй. Гэхдээ бушуу туулай борвиндоо баастай гэж үг байдгийг маш сайн санаарай. Гүйцэтгэл, чанар дээрээ алдах вий. Нөгөө талаар Туулын хурдны замын асуудал одоо ноцтой хөндөгдөж байна. Гэхдээ энд бас олон жил яригдаж ирсэн, олон жил төлөвлөгдөж ирсэн энэ ажлыг өнөөдөр хийх зоригтой хүн нь хэнхэг, хэрүүлч Нямбаатар байж байгаа нь бас магадгүй энэ Нямбаатарыгаа та бусад бүлэглэлийн болон чин сэтгэлээсээ ч хүмүүс тэмцэж тэмцэж байгаа байх, зорилтот бүлгийн хүмүүс ч байгаа. Эд нарын үгэнд ороод та хотын даргаа өөрчилчихвөл энэ урьд хожид түүхэнд Нямбаатарыг үнэхээр хийж бүтээж.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь тэгээд сайн л бол муу, муу л бол сайн гэдэг улс төржилт хэрэггүй цаашдаа. Тийм учраас би асуудалтайгаа л нүүр тулъя гэж байгаа юм. Цаашид хүн ярихгүй, цаашид тэр улс төрийн намуудтай зөрчилдөж маргалдаж хоосон улс төржилт хийрэхлээр асуудлыг авч гарахгүй. Тийм учраас улс орныхоо төлөө ирж байгаа энэ сорилт бэрхшээлийг, эдийн засгийн хүндрэлийн үед авч гарахын төлөө эвлэлдэн нэгдэж, тэр асуудлыг давж гарах хэрэгтэй. Энэ бензин шатахууны үнэ, энэ Ойрх Дорнодод үүссэн мөргөлдөөн чинь биднийг улс орныхоо төлөө, ард иргэдийнхээ төлөө нэгдэж нийлэх, хамтарч ажиллах руу шахаж байна шүү дээ. Тийм учраас энэ Монголын асуудал болсон. Энэ дэлхийн асуудал.

Тэгэхээр энэ тодорхойгүй яваад байсан байдал чинь тодорхой болоод ирлээ. Тийм учраас манай парламентыг бүрдүүлж байгаа 5 нам, эвслийг би хамтарч ажиллахыг урьж байна. Сая Нарантуяа-Нара гишүүн хэллээ. Батбаатар даргыг элдвээр хэлээд гэж, би ёстой элдвээр хэлдэггүй. Харин ч ЗГ-т хамтарч ажиллаж, хамгаалж, дэмжиж ирж ирсэн. Цаашдаа ч гэсэн энэ салбарыг аваад явах ийм нам, намыг төлөөлж байгаа дарга л гэж ойлгож байсан. Харин элдвээр хэлээд байсан нь та болон тэгээд дотроо л гэж би ойлгосон шүү дээ. Тэрнээс Батбаатар даргыг чинь би бүүр байнга хамгаалдаг байсан шүү дээ. тийм. Та нар дотооддоо үүссэн асуудал байсан учраас бид танай намын дотоод асуудлыг аль нь зөв, бурууг дүгнэх тийм субъект огт биш.

2-т Үндсэн хуулиар олгогдсон Ерөнхий сайдын бүрэн эрх учраас би урдаа байгаа замыг хэнтэй хамт туулах вэ гэдгээ өөрөө шийднэ. Гол нь үр дүнгээрээ хэмжүүлнэ. Дээрээс нь би нам дотроо хэнтэйгээ ажиллах вэ, хэнтэйгээ ажиллахгүй

вэ гэдгээ өөрөө шийднэ. Та бол саналаа хэлж болно. Тэгээд би саналуудыг чинь ойлголоо. Тэгэхээр гол нь бүгдээрээ үр дүнгийн төлөө явъя, цаашаа улс төржилт хийрхлээс холдож, хамтдаа асуудлыг шийдэхийн төлөө явъя гэж Иргэний Зориг намынхандаа уриалж байна. Тэгээд хамтраад ажиллая. Одоо улс төрийн тогтвортой байдал хамгийн их чухал байна. Тэгээд энэ тогтвортой байдлын төлөө нэгдэж, нийлж хамтарч ажиллахыг нийт нам, эвслүүддээ уриалж байна.

Цаашид бид томоохон сорилтын өмнө бүгдээрээ нийлж ажиллах ч цаг үе ирж магадгүй. Улс орныхоо төлөө бүгдээрээ нийлж ажиллачхаж болно шүү дээ. Тийм цаг үе ч ирж магадгүй шүү. Солонгос гэхэд л emergency mode гээд тэр чинь бүүр ийм онцгой горимд шилжчихээд байна шүү дээ. Бид ч гэсэн цаг үе биднээс тийм сорилтыг шаардвал бид нэгдээд ажиллах ёстой. Асуудлыг хамтдаа л даван туулах ёстой. Бидний энэ дотор үүсээд байгаа тэр жижиг сажиг сандал суудлын маргаан одоо бол хойш нь тавьж, санал шийдлээ ярьдаг болъё. Тийм л бодолтой байгаа. Би үнэнээ ярьдаг байна, нөхцөл байдлаа бүрэн дүгнэнэ, нуух хаах зүйл байхгүй, нээлттэй та бүхэнтэйгээ харилцана гэдгийг хэлье. Гишүүддээ баярлалаа.

С.Бямбацогт: Нарантуяа-Нара гишүүн тодруулга 1 минут.

М.Нарантуяа-Нара: Ерөнхий сайд миний асуултыг буруу ойлгочихсон юм шиг байна. Би таныг манай намын даргыг элдэвлэдэг гэж хэлээгүй л дээ. Ер нь би ч өөрөө тэр зарчмын шаардлага тавьдаг. Харин би танаас асуусан юм бол Б.Энхбаяр гээд гишүүн чинь АТГ-т хэрэг үүсгэгдээд шалгагдаж байгаа хүн мөн үү, биш шүү? Энэ хүн таны ЗГ-т зайлшгүй байхгүй бол болохгүй юм уу гэдэг ийм асуултыг тавьсан байгаа?

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулчих уу, ЗГХЭГ-ын даргад дэвшигч.

Б.Энхбаяр: Ер нь энэ найруулгыг, зохиолыг хэн зохиодог вэ, хэн дүр нь болдог вэ, хэн төлбөртэй хөгжөөдөг вэ, хэн нь хэнээсээ мөнгө авдаг вэ олон юм энэ өдрүүдэд их тодорхой болж байгаа шүү дээ. Тэгээд одоо өөрийгөө битгий яриад бай л даа та. Таны өмнөөс би санаа зовж байна шүү дээ.

С.Бямбацогт: Тодруулга, 2 удаа тодруулчихсан Нарантуяа-Нара гишүүн. 1 авсан билүү? 2 авчихсан уу? 2 авчихсан байна та. Нарантуяа-Нара гишүүн дахиад тодруулчихъя.

М.Нарантуяа-Нара: Та намайг хаанаас, хэнээс, хэдэн төгрөг авсныг та нотлоод одоо хэлчих? Та өнгөрсөн хугацаанд сэтгүүлчдийг доромжлоод, мөнгө гүтгээд нүүрсний хулгайч гээд явж байсан. Илчилнэ гэсэн илчлээгүй. Хүн амины хэрэгт холбогдсон улс төрийн Улсын Их Хурлын гишүүдийг өчнөөн нэрлэсэн, та тэрийгээ нотлоогүй. Одоо намайг хэнээс мөнгө авсан гээд, хэнээс, хаанаас, хэдэн төгрөг авчихсан юм бэ та сайхан батлаад өгөх хэрэгтэй 1-д.

2-т би танаас асуулт асуугаагүй, Ерөнхий сайдаас асуулт асуусан. Энэ хүн АТГ-т шалгагдаж байгаа хүн биш үү 1-д? 2 дугаарт, энэ хүн таны ЗГ-т зайлшгүй байхгүй бол болохгүй тийм эрхэм чухал хүн мөн үү гэж асууж байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: ЗГ-ын гишүүдийг томилоход АТГ-аас урьдчилан сэргийлэх мэдүүлэг авдаг, тэгж байж тэр дүгнэлтийг нь үндэслэж томилж байгаа шүү дээ. Тэгэхээр тийм асуудал байхгүй.

2-т Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хүрээнд ЗГХЭГ-ын дарга буюу хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад Хэрэг эрхлэхийн даргаар Энхбаяр сайд ажиллавал цаашид ЗГ-ын бүтээмжид нэмэртэй. Дээрээс нь өнгөрсөн хугацаанд Өмчийн хууль, Газрын хууль, Баялгийн сангийн хууль гээд олон эрх зүйн орчныг сайжруулах ажилд оролцож байсан. Тийм учраас мэдлэг, мэргэжил, туршлагын хувьд хамгийн их нэмэр болно гэж үзсэн. 2-т авлигын төсөөллийн индексийг ахиулна. Авлигын төсөөллийн индекс 10 байр хойшлоод багаа, энийг ахиулна. Үүнд түүний мэдлэг, ур чадвар шаардлагатай л гэж үзсэн.

С.Бямбацогт: Монгол Улсын Ерөнхий сайдад баярлалаа. Монгол Улсын Ерөнхий Сайд Монгол Улсын Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд ЗГ-ын хамтарч ажиллаж кабинет, ЗГ-ын гишүүдээ танилцуулж дууслаа.

Өнөөдөр анх удаа чуулган хуралдаж байгаа, чуулган даргалж байгаа болохоор аль болох гишүүдээ ёс зүйтэй байхыг нэг их айхтар шаардсангүй. Цаашдаа энэ аливаа асуудал дээр бид асуудал шийдэл, бодит прагматик шүүмжлэл ярьдаг баймаар байгаа. Субъектив бие бие рүүгээ дайрсан, гүтгэсэн, бүдүүлэг, ёс зүйгүй авирласан ааш авир гаргахгүй байхыг цаашдаа бүгдээрээ хүсье.

Чуулган дээр Монголын бүх ард түмэн нээлттэй харж байгаа. Тэгээд бидний хэлсэн үг болгон цаад талд нь, Хууль зүйн сайдад нэр дэвшигч хэлсэн шүү дээ. Энэ гүтгэгчдээр дүүрсэн Их Хурал уу, эсхүл гэмт хэрэгтнээр дүүрсэн Их Хурал уу гэж. Энийг бид өөрсдөөсөө өөрчлөлтийг эхлэх ёстой байх. Энэ талдаа бүгдээрээ цааш цаашдаа, ер нь чуулганы хуралдаан, Байнгын хорооны хуралдаан дээр хэлсэн үгэндээ Их Хурлын гишүүн хариуцлага хүлээхгүй гэдэг ч гэсэн ёс зүйтэй байж, иргэдээ тайван амгалан, бухимдуулахгүй байх, өөрсдөө ёс зүйтэй үг, бүдүүлэг үг, үйлдэл хийхгүй байх талдаа илүү анхаарч ажиллацгаая гэдгийг хэлье.

ЗГ-ын гишүүдээс асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. ЗГ-ын гишүүдийг УИХ-д танилцуулсанд тооцлоо.

2026 оны 4 дүгээр 04-ний өдрийн 01.21 цаг

Одоо 20 минутын дотор ЗГ-ын гишүүд тангаргаа, бэлтгэл, тангараг өргөх бэлтгэл хангагдана. Энэ хооронд ЗГ-ын гишүүд өөр тусгай хөтөлбөртэй байгаа. Тэгээд 20 минут чуулганыг түр завсарлуулъя. Гишүүд танхимдаа сууж байж болно. Тэгээд 20 минутын дараа тангараг өргөх ёслолд Их Хурлын гишүүдээ хүндэтгэлтэй оролцохыг урьж байна. Засгийн газраа тогтвортой ажиллуулах, энэ эдийн засаг хүнд, хямралтай үед шуурхай ажиллуулах, ЗГ-ын шуурхай ажиллах боломжийг бүрдүүлж өгч байгаа гишүүдээ баярлалаа. Идэвхтэй, шөнө орой болсон ч гэсэн сууж байгаа гишүүдээ баярлалаа. 20 минутын дараа чуулган хуралдана. Түр завсарлая.

Хуралдаан 01 цаг 22 минутаас 01 цаг 52 минутад завсарлав.

Дөрөв.Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа

Гишүүдийг чуулганы хуралдааны танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. ЗГ-ын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэхэд бэлэн боллоо. Одоо ирж байгаа гишүүд байгаа юу? ЗГ-ын гишүүд УИХ-д тангараг өргөнө. Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал таныг Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна уу хэмээн индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн дөрөв дэх хэсэг, Монгол Улсын ЗГ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу Монгол Улсын Ерөнхий сайд миний бие онцгой бүрэн эрхийнхээ дагуу ЗГ-ын гишүүнээр томилох захирамж гаргаж, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар Жадамбын Энхбаярыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар Тогмидын Доржхандыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар Нямтайширын Номтойбаярыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргаар Баттөмөрийн Энхбаярыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гадаад харилцааны сайдаар Батмөнхийн Батцэцэгийг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Сангийн сайдаар Загджавын Мэндсайханыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Сайнбуянгийн Амарсайханыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар Гонгорын Дамдиннямыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Дамбын Батлутыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар Цэндийн Сандаг-Очирыг, Монгол улсын ЗГ-ын гишүүн, Боловсролын сайдаар Лувсанцэрэнгийн Энх-Амгаланг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдаар Тилеуханы Аубакирыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Зам, тээврийн сайдаар Борхүүгийн Дэлгэрсайханыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдаар Жуковын Алдаржавхланг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар Энхтайваны Бат-Амгаланг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар Цагаанхүүгийн Идэрбатыг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаар Чинбатын Номинг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрчим хүчний сайдаар Бадрахын Найдалааг, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Энхбаярын Батшугарыг тус тус томиллоо.

Манай ЗГ нийт 19 гишүүний бүрэлдэхүүнтэй. Үүнээс МАН-аас 16 сайд, ХҮН намаас 2 сайд, Үндэсний эвслээс 1 сайд тус тус томилогдон ажиллана. ЗГ-ын гишүүдийн 79 хувь нь өмнө нь ЗГ-ын бүрэлдэхүүнд ажиллаж байсан туршлагатай бол ЗГ-ын гишүүдийн үлдсэн 21 хувь нь анх удаа томилогдож байна.

Дэлхийн геополитикийн хурцадмал байдлын улмаас түлш шатахуун, энергийн нийлүүлэлт тасалдаж, үнэ нь 2 дахин нугаран өсөж, хомсдол нүүрлэж, инфляц, үнийн хөөргөдөл үүсэж, дэлхийн улс орнууд онц байдал тогтоосон онцгой цаг үед та бүхнийг Монгол Улсын ЗГ-ын гишүүнээр томиллоо. Бүх юмны суурь үнэ болдог 100 хувь импортын хараат байдалтай түлш шатахууны үнийн огцом өсөлт инфляцыг хөөргөдөх, цалин орлогыг үнэгүйдүүлэх, валютын урсгалыг гадагшлуулах, экспортын гол салбар уул уурхай, тээвэр, үйл ажиллагааны зардлыг нэмэх зэрэг ноцтой эрсдэлийг дагуулж байна. Түлш шатахууны үнийг барих боломжгүй гэдэг үнэнээ дахин хэлээд, гагцхүү тасалдал хомсдол үүсгэхгүйн төлөө хичээн ажиллах болно.

Монгол Улс дэлхийг нөмөрсөн цар тахлын үеийг туулсан шигээ түлш, шатахуун, эрчим хүчний хямралыг сөрөх цаг эхэллээ. Ерөнхий сайдын онцгой бүрэн эрхийнхээ дагуу ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо дараах 2 үндэслэлийг харгалзан үзлээ. Бидэнд сандал суудал биш, санал шийдэл хэрэгтэй. Нүүдэл суудал, байр сав, албан бланк, тамга тэмдэг солих нь хэдэн арван тэрбум болно. Хэдэн сайд цөөллөө гээд мөнгө хэмнэх биш, илүү төлнө. Нэг сайд цомхотгоход дагаад төрийн албан хаагчид ажил төрөлгүй болно. Шүүхийн олон зуун хэрэг маргаан үүснэ. Татвар төлөгчдийн мөнгөөр хохирлыг нь барагдуулна. Төсөв, мөнгө, эд хөрөнгө дунд нь үрэгдэж, завшигдах, тамга тэмдэг солигдох гэх мэт 2 өдрийн алга ташилтын төлөө цаг, мөнгө үрмээргүй байна. Цаг, мөнгө алдмааргүй байна.

Түлш, шатахууны үнэ, хомсдол бол эдийн засгийн дайны байдал, байгаа хүчээрээ шууд оръё. Хийдэл, давхардал, илүүдэл давхцалд иж бүрэн чиг үүргийн шинжилгээ хийж, 7 хэмжиж 1 огтлоод оновчлох болно. Судлан тооцоолж үзэхэд одоогоор 3 мянга гаруй сул орон тоо байна. Үүнийг бөглөх шаардлагагүй. Энэ 26 яам татан буулгасантай адил хэмнэлт болох болно. Бусад зардлыг тооцохгүй, зөвхөн цалингийн сан жилд 7,4 тэрбум төгрөг болно.

Сайдын алба бол эрх мэдэл гэхээсээ илүү өндөр үүрэг хариуцлага. Салбартайгаа цоо шинээр дадлагажигч шиг танилцахгүй, танин мэдэхүйн дамжаанд суух шаардлагагүй мэдлэг, туршлагыг харгалзан авч үзлээ. Хурд гүйцэж ажиллах, галтай ч гашуун шийдвэр гаргах, асуудлыг шийдэл болгох, хариуцсан салбараа манлайлан удирдан зохион байгуулах чадвартай эсэхийг тооцож үзлээ. Олон нам, эвсэл сонирхлын бүлгээс бүрдсэн УИХ хүчтэй сөрөг хүчинтэй нөхцөлд ЗГ-ын тогтвортой байдал нэн чухал гэж үзсэн бүрэлдэхүүн гэдгийг нуугаад байх юм байхгүй шууд хэлье. Түлш шатахуун, тог цахилгааны тасалдал аюул болоод байхад төр засгийн ажил тасалдаж болохгүй. Бидэнд гацаа биш, гарц хэрэгтэй байна. ЗГ-ын гишүүдээс 1 дүгээрт ажлын гүйцэтгэлийн хариуцлага, 2 дугаарт ёс зүйн хариуцлага нэхэж ажиллана.

Бид дэлхийг өөрчлөхгүй ч, дэлхий биднийг өөрчлөхгүйг үргэлж санаж үйл хэргээрээ эх оронч байж, эвтэй, хүчтэй, эрс шийдэмгий, илүү хурдтай ажиллах ёстой. Ирээдүй цаг дээр биш, энэ цаг дээр ажил асуудлаа ярьж ажиллана. Эргэлзээ дагуулсан асуудалд өртсөн бол хууль шүүхийн байгууллагаар гэм буруутай эсэхээ шалгуулах шаардлагыг тавих болно.

Төсвийн тодотгол хүлээлгүйгээр ЗГ энэ өдрөөс эхлэн хэмнэлтийн горимд бүрэн шилжиж, өөрөөсөө хамаарах бүхнийг хийж хэрэгжүүлэх болно. Төрийн сангаа удирдаж, байгаа хөрөнгө нөөцөө зүй зохистой зарцуулах, томилгоо, хурал зөвлөгөөн, тавилга хэрэгсэл зэрэг хэрэгцээ шаардлагагүй илүү зардлыг таслан зогсоож, татвар төлөгчдийн хөлс хөдөлмөр шингэсэн төгрөг бүрийг гамнаж хэмнэхэд онцгой анхаарна. Эрх чөлөөний нар Монгол хүн бүрийг ивээж, эрх чөлөөт тусгаар Монгол Улс мандан бадрах болтугай.

С.Бямбацогт: Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танд баярлалаа. ЗГ-ын гишүүд тангараг өргөх ёслолын ажиллагаа эхэлье ЗГ-ын гишүүд нэгдсэн хуралдааны танхимын голд байрлалаа эзэлнэ үү.

ЗГ-ын гишүүд тангаргийг хамтдаа өргөх бөгөөд насаар хамгийн ахмад гишүүн тангаргийг уншиж, нөгөө гишүүд давтан хэлнэ. ЗГ-ын гишүүд тангаргаа өргөнө үү.

Б.Дэлгэрсайхан: Монгол Улсын Засгийн гишүүн би,

Бусад Засгийн газрын гишүүд: Монгол Улсын Засгийн газрын гишүүн би,

Б.Дэлгэрсайхан: Улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн,

Бусад Засгийн газрын гишүүд: Улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн,

Б.Дэлгэрсайхан: Төрт ёс,

Бусад Засгийн газрын гишүүд: Төрт ёс,

Б.Дэлгэрсайхан: Түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж,

Бусад Засгийн газрын гишүүд: Түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж,

Б.Дэлгэрсайхан: Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж,

Бусад Засгийн газрын гишүүд: Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж,

Б.Дэлгэрсайхан: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж,

Бусад Засгийн газрын гишүүд: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж,

Б.Дэлгэрсайхан: Төрийн хуулийг биелүүлэх ажлыг, төр, ард түмэн,

Бусад Засгийн газрын гишүүд: Төрийн хуулийг биелүүлэх ажлыг төр, ард түмэн,

Б.Дэлгэрсайхан: Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж,

Бусад Засгийн газрын гишүүд: Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж,

Б.Дэлгэрсайхан: Засгийн газрын гишүүний үүргээ,

Бусад Засгийн газрын гишүүд: Засгийн газрын гишүүний үүргээ,

Б.Дэлгэрсайхан: Чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Бусад Засгийн газрын гишүүд: Чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Б.Дэлгэрсайхан: Миний бие энэ тангаргаасаа няцвал,

Бусад Засгийн газрын гишүүд: Миний бие энэ тангаргаасаа няцвал,

Б.Дэлгэрсайхан: Хуулийн хариуцлага хүлээнэ.

Бусад Засгийн газрын гишүүд: Хуулийн хариуцлага хүлээнэ.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо ЗГ-ын гишүүд Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, хүндэтгэл үзүүлнэ. ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллын дагуу ЗГ-ын гишүүдийг нэг нэгээр нь дуудаж, Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урих тул та бүхэн тус тус суудлаа эзэлнэ үү. Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урья.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Нямтайширын Номтойбаяр таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Сайнбуянгийн Амарсайхан таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Цэндийн Сандаг-Очир таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Боловсролын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Тилеуханы Аубакир таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Жуковын Алдаржавхлан таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Цагаанхүүгийн Идэрбат таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Чинбатын Номин таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрчим хүчний сайд Бадрахын Найдалаа таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Эрүүл мэндийн сайд Энхбаярын Батшугар таныг Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд тангараг өргөлөө. Та бүхэндээ баяр хүргэж, ажлын амжилт хүсье. Тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

02.23 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Сайхан амарцгаагаарай.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА